

5. Аж үйлдвэрийн салбар тус бүрээр нь авч үзсэн бүс нутгийн хөгжлийн стратегийн санал

Энэ бүлэгт, 2-р бүлэгт авч хэлэлцсэн салбар тус бүрийн асуудал дээр тулгуурлан, цаашид ямар арга хэмжээ авах, эсвэл хөгжлийн нөөц бололцоог хэрхэн бодитоор хэрэгжих бодлого болгох талаар санал дэвшүүлж байна. Саналын тухайд Монгол улсын дунд болон урт хугацааны таамаглалд тогтвортой хөгжлийн сценарийг үндэс болгож байгаа бөгөөд түүнчлэн Японы хувийн хэвшил болон Засгийн газрын хамтын ажиллагааны бололцоог харгалзан үзсэн болно.

5.1 Өсөх ирээдүйтэй аж үйлдвэрийг хөгжүүлэх, аж үйлдвэрийн стратеги

(1) Аж үйлдвэрийн суурь бэхжүүлэх чиг хандлага

2-р бүлэгт дурдсанчлан, уул уурхайн салбараас хэт хараат, үйлдвэрлэлийн суурь эмзэг бөгөөд импортоос ихээхэн хамааралтай аж үйлдвэрийн бүтэц, далайд гарцгүйгээс тээврийн зардал их, харьцангуй жижиг зах зээл зэрэг тулгамдаж буй асуудал тодорхой байгаа. Мөн, аж үйлдвэрийн салбарын хувьд хүний нөөцийн хөгжил, тогтвортой байдал, технологийн шинэчлэл, санхүүгийн дэмжлэг зэрэг хэрэгцээ их. Эдгээрээс үзэхэд, цаашид "тогтвортой", "стратегитай", түүнчлэн, тэднийг дэмжих "нэгдсэн цогц" байр суурьнаас аж үйлдвэрийн үндэс суурийг бэхжүүлэх, хөгжүүлэх нь чухал асуудал билээ.

1) Тогтвортой аж үйлдвэрийн суурийг бэхжүүлэх

Эдийн засгийн үйл ажиллагааг дэмжих үндсэн аж үйлдвэрийн салбарын хувьд, юун түүрүүнд "импортыг орлох" бүтээгдэхүүн үйлдвэрлэлд илүү хүч чармайлт гарган ажиллах хэрэгтэй. Дэлхийн Худалдааны Байгууллага (ДХБ), чөлөөт худалдааны гэрээ хэлэлцээр зэрэг хөгжих орчинд импортыг орлох дотоодын бүтээгдэхүүнийг хамгаалах арга замаар бус үр ашигтай технологи нэвтрүүлсэн, логистикийн сүлжээг бий болгосон, нийлүүлэлтийн гинжин хэлхээний суурь, өрсөлдөх орчинг бүрдүүлсэн гэх мэт аж үйлдвэрийн үйл ажиллагааг идэвхижүүлэн дэмжсэн хэлбэрээр хандах хэрэгтэй. Ялангуяа тэргүүлэн хөгжүүлэх хэд хэдэн салбарыг дор дурдав.

- Барилгын материал, уул уурхай, ХАА багаж хэрэгсэл, үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж зэрэг тогтмол нийлүүлэлтээс эхлэн тус бүрийн тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг үйлдвэрлэх хэмжээнд хүртэл аж үйлдвэрийн суурийг бэхжүүлэх
- Импортын бүтээгдэхүүн өргөн хэрэглээний бараа (гэр ахуйн цахилгаан бараа гм) ны сэлбэг нийлүүлэлтээс өргөн хэрэглээний бараа үйлдвэрлэх хэмжээний аж үйлдвэрийн суурийг бэхжүүлэх

2) Стратеги аж үйлдвэрийн суурийг бэхжүүлэх

Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого, болон аж үйлдвэрийн бодит байдлаас харахад Монгол улсын хувьд эрдэс баялагаас гадна мал аж ахуйн гаралтай түүхий эд чухал аж үйлдвэрийн түүхий эд баялаг бөгөөд эдгээр салбарын олон улсын зах зээлд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх шаардлагатай. Түүнчлэн стратеги салбарыг хөгжүүлснээр дотоодын нийлүүлэлтийн гинжин хэлхээг бэхжүүлж, аж үйлдвэрийг төрөлжүүлэх, орон нутгийн хөгжилд чухал хувь нэмэртэй. Аж үйлдвэрийн суурийг бэхжүүлснээр дараах үр дүн гарах боломжтой.

- Ноос, ноолуур, арьс шир зэрэг мал аж ахуйн харьцангуй ашигтай үйлдвэрүүдэд технологи, чанарыг сайжруулах, шинэ бүтээгдэхүүн бий болгох, анхан шатны боловсруулалтаас эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл хүртэлх бүтээмжийг дээшлүүлэх, чанарын хяналтыг сайжруулах, гадаадын компанитай технологийн хамтын ажиллагааны эхлэл тавин улмаар хөрөнгө оруулалтыг татах, бизнесийн хамтын ажиллагааг өргөжүүлэх зэргээр аж үйлдвэрийн суурийг бэхжүүлэх
- Мал аж ахуйн салбарын хөгжлөөс үүдэн хүнсний боловсруулалтын салбарт шинэ бүтээгдэхүүн бий болгох (Омега 7, пласента, гэрийн тэжээвэр амьтны хоол гэх мэт) аялал жуулчлалтай холбосон шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэх (ноос, ноолуур, арьс шир)
- Уул уурхайн боловсруулах салбарын хөгжлөөр, эрчим хүчийг дотооддоо үйлдвэрлэн, дотоодын хэрэгцээг ханган орон нутгийн хөгжил болон орон нутгийн бүтээн байгуулалттай уялдсан аж үйлдвэрийн суурийг бэхжүүлэх (орон нутагт үйлдвэрлэсэн эрчим хүчийг орон нутагтаа хэрэглэх)

3) Аж үйлдвэрийн суурийг цогцоор бэхжүүлэх

Аж үйлдвэрийн дэд бүтэц, үндэс суурийн хувьд хөрөнгө оруулалтын стратеги болон хамтын ажиллагааг дээрх тогтвортой аж үйлдвэрийн суурьтай уялдуулах асуудал чухал. Аж үйлдвэрийн бүтээн байгуулалт талаас харахад технологи, хүний нөөц зэрэг тал дээр илүү анхаарч, аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх бодлоготой уялдуулсан хөгжлийг бодолцон, дээрх аж үйлдвэрийн суурьт шаардагдах хөрөнгө оруулалтын орчин, өрсөлдөх орчинг бүрдүүлэх ажлыг идэвхижүүлэх хэрэгтэй. Аж үйлдвэрийн бодлогод тусгасаны дагуу хууль эрх зүйн орчинг сайжруулах асуудал эхний хэмжээнд хийгдэх ёстой боловч, ялангуяа тэргүүлэх дэс дарааллын хувьд аж үйлдвэрийн салбар нийтийн технологийн шинэчлэлтэй уялдсан хөрөнгө оруулалтын хэрэгцээ, их хэмжээгээр үйлдвэрлэн зардлаа хэмнэх тогтолцоонд шилжих шаардлагатай байна.

- Дэвшилтэт технологи нэвтрүүлэхэд шаардагдах санхүүгийн тогтолцоог боловсронгуй болгох (ЖДҮ-ийн технологийн шинэчлэл хийх дэмжлэг)
- Жижиг болон бичил үйлдвэрийг төвлөрүүлэх, нэгдсэн тогтолцоонд оруулах < хоршоо, кластер >

(2) Бүс нутгийн цогц хөгжил талаас аж үйлдвэрийн хөгжлийн чиг хандлага

Нийт улс орныг цогц байдлаар хөгжүүлэхэд бүс нутаг, хотыг бүхэлд нь хамарсан бодлого, хэрэгжилт чухал боловч аж үйлдвэрийн хөгжил талаас бүх орон нутгийн онцлогийг тусгасан аж үйлдвэрийн хөгжилд илүү түлхүү анхаарах хэрэгтэй гэж үзэж байна. Цаашилбал, салбар тус бүрийн асуудалд хандахад, бүс нутгийн тус тусын аж үйлдвэрийн салбарын чиг хандлагыг авч хэлэлцэх хэрэгтэй бөгөөд, нийт улсын хэмжээнд эдгээр нь харилцан бие биенээ нөхсөн, харилцан ашигтай байх үндэс суурийг бэхжүүлэх шаардлагатай. Энэхүү судалгааны хамрах хүрээ болох үндсэн 4 бүс нутгийн хувьд, орон нутгийн газар дээрх судалгаанд тулгуурлан дараах байдлаар аж үйлдвэрийн хөгжлийн байр суурьнаас бүс нутгийн хөгжлийн чиг хандлагыг тодорхойлж байна. Гэхдээ эдгээр нь анхан шатны судалгааны үр дүнд үндэслэсэн дүгнэлт тул, цаашид төрөөс аж үйлдвэрийн салбарт баримтлах бодлоготой уялдуулан, дэлгэрэнгүй судалгаа шинжилгээнд тулгуурлан илүү баяжуулж, засаж сайжруулах хэрэгтэй.

1) Хойд бүс нутаг

Уул уурхайг дагавар хотын хэрэгцээнд нийцсэн аж үйлдвэрийн төрөлжилтийн стратеги

¹-ийг санал болгож байна. Улаанбаатарын зах зээлээс гадна, орон нутгийн Дархан, Эрдэнэтийн зах зээлийг тээвэрлэлт төдийгүй нэгдсэн борлуулалтын тогтолцоог бий болгох явдал зайлшгүй шаардлагатай. Одоогоор худалдаа голчилсон Чөлөөт Худалдааны Бүс (FTZ)-ийн үйл ажиллагааг бэхжүүлснээр (худалдааны төв төдийгүй, уул уурхайн боловсруулах үйлдвэр, хүнсний боловсруулах үйлдвэр зэргийг оруулах) ОХУ-руу зах зээлээ тэлэх (Дархан, Эрдэнэт, аж үйлдвэрийн паркыг ашиглах), Улаанбаатарын боомт хотын үйл ажиллагааг бэхжүүлэх хэрэгтэй.

2) Өмнө бүс нутаг

Сайншанд хот орчимд усны эх үүсвэр бий болгох асуудал хүнд үйлдвэрийн салбарыг хөгжүүлэхэд гол хүндрэлтэй асуудал болоод байгаа. Аж үйлдвэрийн паркийн төсөөлөлд хэт баригдалгүй тодорхой аж үйлдвэрийн стратегийг нэвтрүүлэн (ХАА-н тоног төхөөрөмж үйлдвэрлэх хөнгөн үйлдвэр зэрэг), бие даасан аялал жуулчлалын хөгжлөөр дамжуулан аялал жуулчлалтай уялдсан аж

¹ Эрдэнэт хотын уул уурхайн Нүүдэлчин групп гурилын үйлдвэрлэл эхэлсэн, уул уурхайн тэсэргээний бөмбөлөг үйлдвэрлэдэг Ора Металл шүүлтүүр хийх болсон гэх мэт.

үйлдвэрийн хөгжил, Замын-Үүдээс ирэх хөдөлмөр эрхлэгчдэд зориулсан арга хэмжээ (зам, барилга, байр) аж үйлдвэрт ашигтай үр дүнг бий болгох зэрэг бодит хөгжлийн төлөвлөгөө болон бүс нутгийн аж үйлдвэрийн хөгжлийн бодлогыг дахин боловсруулах ажил хийгдэх ёстой.

3) Зүүн бүс нутаг

Орон нутгийн давуу талыг ашиглан, Чойбалсан хотыг түшиглэн ХАА гаралтай бүтээгдэхүүний боловсруулах үйлдвэрийн тулгуур төв болгон хөгжүүлэх нөөц бололцоо ихтэй гэж үзэж байна². Халх голын ай сав газар, улаан буудай, гурвалжин будаа зэргийг тариалах тариалангийн хөгжил болон түүнд тулгуурласан гурилын үйлдвэрийг хөгжүүлэх чиг хандлага байж болно. Гэхдээ аж үйлдвэрийн бодлогод уул уурхай, төмөрлөгийн салбарын хөрөнгө оруулалтыг дэмжих чиг хандлага тусгагдан, илүү нарийн баталгаа хэрэгтэй бөгөөд Чингис хоттой аж үйлдвэрийн хамтын ажиллагаа явуулах боломжийг бодолцох нь чухал.

4) Улаанбаатарын бүс нутаг

Дунд шатлалын үйлдвэрийг дэмжих бодлогоор дамжуулан аж үйлдвэрийг төрөлжүүлэх бодлого, стратегиас төрөн гарсан дараагийн үеийн аваргыг бэлдэх асуудал чухал. Тухайлбал, санхүүгийн стратеги тогтолцоо нэвтрүүлэн Налайх, Багануур зэрэг дагуул хотуудад нүүрсний шингэрүүлсэн түлш гаргах авах химийн бүтээгдэхүүний салбарыг хөгжүүлэх хэрэгтэй. Мөн иймэрхүү арга хэмжээ болон Багануур дүүргийн аж үйлдвэрийн паркийн төсөл (төлөвлөгөө) (Томоохон групп компани : MCS группын димител эфир (нүүрсийг шингэрүүлэх), ЖДҮ : ноосон, эсгий дулаалгын материал үйлдвэрлэл, мод боловсруулах, сүү, цагаан идээ боловсруулах зэрэг боломж бий) тэй уялдуулан амжилттай хэрэгжсэн төслийг туршлага болгон, бусад бүс нутгийн аж үйлдвэрийн хөгжил, аж үйлдвэрийн паркийн хөгжлийн загвар болгон хөгжүүлэх хэрэгтэй.

(3) Хөгжлийн тэнхлэгийн аж үйлдвэрийн хөгжлийн чиг хандлага

Энэхүү судалгааны гол үзэл баримтлал болох “Эдийн засгийн корридор, тэнхлэгийн хөгжил”-ийн талаас аж үйлдвэрийн хөгжлийн чиг хандлагыг, нутгийн хойд хэсгийн хөндлөн тэнхлэгийн ногоон корридортой уялдах ХАА болон ХАА боловсруулах салбар, өмнөд хэсгийн ашигт малтмалын тэнхлэгтэй уялдах уул уурхайн боловсруулах салбарын аж үйлдвэрийн хөгжлийн стратегийг боловсруулах шаардлагатай (Хөгжлийн корридор болон аж үйлдвэрийн орон зайн хамаарлын талаар зураг 4.5.5-с харна уу).

1) Хөндлөн тэнхлэгийн хөгжлийн корридор (ногоон корридор)

² Гурвалжин будааг, Халх голын орчимд хэдэн мянган га д тариалж, Япон улс руу экспортлож эхэлсэн.

Аж үйлдвэрийн салбарын эцсийн бүтээгдэхүүний урсгал эхний ээлжинд Улаанбаатар хот, түүний дараа хөрш орнуудтай холбогдоно. ХАА болон салбарын тодорхой хөгжлийн чиг хандлагын талаар санал дэвшүүлж, дараах бүсчилсэн, шаталсан хөгжлийн зорих боломжтой.

< Корридорын хөгжил >

- Аж үйлдвэрийн парк төлөвлөгдөж буй Ховд-Эрдэнэт,-Дархан,-УБ маршрут (ойролцоох ХАА-н үйлдвэрлэл, технологийн парк болон холбогдох туслах замын хэрэгцээ чухал)
- Төлөвлөгдөж буй Халх голын ХАА бүс нутагтай зэргэлдээ орших Чойбалсан хотоос -Чингис-Багануур-Налайх-УБ маршрут
- Зүүн бүсийн цорын ганц эхний шатанд хэрэгжихээр төлөвлөлтөнд орсон ХАА-н үйлдвэрлэл, технологийн парк байрлах Эрдэнэцагаан сумаас Чингис, Багануур, Налайх, УБ маршрут

< Хот, хөдөө орон нутгийн хөгжил >

- Хатгал, Тосонцэнгэл, Эрдэнэмандал, Эрдэнэцагаан сумдыг төвлөрсөн байдлаар үйл ажиллагааг бэхжүүлэх
- Хутаг-Өндөр, Жаргалант, Мандал, Баянчандмань сум болон Эрдэнэт, Дарханы аж үйлдвэрийн паркийн уялдаа холбоог бэхжүүлэх (боловсруулах үйл явцыг хуваарилах зэргээр тэргүүлэх дарааллыг тодорхой болгох)
- Багануур, Чингис 2 хотын хот байгуулалтын төлөвлөлт, аж үйлдвэрийг хөгжүүлэх төлөвлөгөөнд аж үйлдвэрийг хөгжүүлэх тэргүүлэх чиглэлийг тодотгон, дэмжих
- Хөдөө орон нутгийн хот байгуулалт болон тухайн бүс нутгийн аж үйлдвэрийн хөгжлийн төлөвлөгөөг харилцан авч хэлэлцэх (Эрдэнэт, Дархан, Багануур : ялангуяа Багануур хот Зүүн бүсийн хотуудын харилцаанд голлох чухал үүрэгтэй)

2) Босоо тэнхлэгийн хөгжлийн коридор

- Уул уурхайн салбарын хувьд Замын-Үүдээс БНХАУ руу урсгал (гэхдээ өнөөг хүртэлх Сайншандын байр суурийг дахин авч хэлэлцэх шаардлагатай) Энэхүү хотыг холбосон төлөвлөгөө болох Зүүн бүсийн төмөр замын төслийн хэрэгжилтийн талаар дахин хэлэлцэх хэрэгтэй. Уул уурхайн нөөц баялаг Гашуунсухайт, Замын-Үүдээс тус бүр шууд БНХАУ руу гардаг. (Сайншанд хотыг дамжин өнгөрөх цэгээс Замын-Үүдийн хамтын ажиллагаагаар аж үйлдвэрийн бүс нутаг болгох).
- Богино болон дунд хугацаан дахь Сайншанд аж үйлдвэрийн паркийн хөгжлийг дахин нягтлах : Хүнд үйлдвэрлэлээс хөнгөн үйлдвэр, худалдаа

үйлчилгээний төв, Замын-Үүд боомтын логистикийн төв болгон өргөжүүлэх бололцоо бий эсэхийг судлах шаардлагатай.

- Хойд хилийн Сүхбаатар хот ОХУ-с хүнсний импорт (Алтанбулаг чөлөөт бүс дээр худалдааны төв хөгжиж буй), түүхий эдийн экспорт (хөндлөн тэнхлэгтэй холбогдоно), Зүүн хилийн Замын-Үүд боомт (Чөлөөт бүсэд 27 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулах саналаа тавьсан) БНХАУ-аас өргөн хэрэглээний бараа, хагас боловсруулсан түүхий эд импортлоно (Чөлөөт бүсийн боловсруулах бүтээгдэхүүн УБ хотын зах зээл, БНХАУ-ын зах зээлд аль аль руу нь гарна, харьцангуй УБ зах зээлд илүү чиглэгдсэн байх хандлагатай), ажиллах хүчний урсгалын төв болно. Ачаа тээврийн урсгалын төрлөөс шалтгаалан хөгжлийн корридорыг бэхжүүлэх хэрэгтэй.
- УВ-Даланзадгад аж үйлдвэрийн хамтын ажиллагааны боломжийг авч хэлэлцэх хэрэгтэй (голд нь орших Мандалговийн байр суурийг тодруулах шаардлагатай). Оюутолгой, Таван толгойн төсөл, боломжийн хирээр эрчим хүчийг дотооддоо үйлдвэрлэн, дотоодын хэрэгцээг хангах загвар төслийг хот төлөвлөлтэй хослуулан зүүн бүсийн хот байгуулалтын боломж, далд нөөцийг олон талаас нь бодолцох хэрэгтэй (ОТ,ТТ-той дэд бүтцийг уялдуулна).

(4) Аж үйлдвэрийн хөгжлийн стратеги (Аж үйлдвэрийг хөгжлүүлэх санал)

Өмнөх 2 бүлэгт дурдсан аж үйлдвэрийн салбарын тулгамдаж буй асуудал болон дээрх үзэл бодол, чиг хандлагыг тусган аж үйлдвэрийн хөгжилд дараах 4 салбарын төрөлжүүлэх дэмжлэг болгон 7 санал дэвшүүлж байна.

(1) ХАА-н салбарын Монгол хувилбарын 6 шатлалт аж үйлдвэрлэлийг хөгжүүлэх

【Зөвлөмж 1】 : Монгол улсад өрсөлдөх чадвар бүхий ХАА гаралтай түүхий эд ашигласан хүнсний боловсруулах салбарыг хөгжүүлэхэд үзүүлэх дэмжлэг

【Зөвлөмж 2】 : ХАА-н үйлдвэрлэл, технологийн паркийн (Agro-Industry Technology Park) боловсруулах үйлдвэр нэвтрүүлэн төрөлжүүлэх, зах зээлийн ханш тогтооход дэмжлэг үзүүлэх

(2) Стратегийн салбарт олноор үйлдвэрлэн зардал хэмнэх, нэмүү өртөг шингээх, нийлүүлэлтийн гинжин хэлхээг хөгжүүлэх замаар төрөлжүүлэх (жижиг, дунд үйлдвэрлэл хөгжүүлэх стратеги)

【Зөвлөмж 3】 : Нийлүүлэлтийн гинжин хэлхээг бэхжүүлэх, жижиг дунд үйлдвэрийг дэмжих

【Зөвлөмж 4】 : Төвлөрүүлэн хөгжүүлэн, шинэлэг технологи нэвтрүүлснээр нэмүү өртөг шингээх, олон улсын нийлүүлэлтийн гинжин хэлхээнд холбогдоход дэмжлэг үзүүлэх

【Зөвлөмж 5】 : Аж үйлдвэрийн нөөц баялгад нэмүү өртөг шингээх аж үйлдвэрийн хэрэглээний бүтээгдэхүүн бий болгоход чиглэсэн дэмжлэг

(3) Эрчим хүчийг дотооддоо үйлдвэрлэн дотооддоо хэрэглэх замаар хөнгөн үйлдвэр, боловсруулах үйлдвэрийг төрөлжүүлэх

【Зөвлөмж 6】 : Эрчим хүчид түшиглэн орон нутгийн хөгжүүлэхэд чиглэсэн аж үйлдвэрийн хөгжилд дэмжлэг үзүүлэх

(4) Одоо буй аж үйлдвэрийн нөөцийг дахин сэргээх замаар аж үйлдвэрийг дэмжих

【Зөвлөмж 7】 : Технологийн талаарх мэдээлэл авахад дэмжлэг үзүүлэх, байгаа тоног төхөөрөмж, байгууламжийг ашиглахад үзүүлэх дэмжлэг

1) ХАА-н салбарын Монгол хувилбарын 6 шатлалт үйлдвэрлэлийг хөгжүүлэн аж үйлдвэрийг төрөлжүүлэх

ХАА-н 6 шатлалт аж үйлдвэржилт нь Япон улсаас гаралтай бөгөөд анхан шатны аж үйлдвэрт газар тариалан, 2 дахь шатны боловсруулах салбар, 3 дугаар шатны худалдаа үйлчилгээ зэргийг уялдуулан хөгжүүлснээр шинэ бизнес, ажлын байр, орлогын эх үүсвэрийг бий болгох зорилготой. 6 шатлалтын 6 нь 1-3 шатны нийлбэр юм.

Японы 6 шатлалт үйлдвэрлэлд ХАА эрхлэгчид боловсруулалтаас борлуулалт хүртэл бүх үе шатыг өөрсдөө хийдэг хэдий ч Монгол улсад ялангуяа МАА, сүүн фермийн салбарт “нүүдэлчин” ахуйд түшиглэсэн уламжлалт мал аж ахуйн хэлбэрийг хадгалсан хэвээр 2 шатлалт аж үйлдвэрийг хөгжүүлэх нь хүндрэлтэй бөгөөд бэлтгэн нийлүүлэлтийн шат болон 2 дахь шатны (боловсруулалт) үйлдвэрлэлийг үр дүнтэй хослуулан, мал аж ахуй, фермийн салбарыг боловсруулах салбартай харилцан ашигтай байдлаар хэрхэн уялдуулан вэ гэдэгт гол анхаарлыг хандуулах хэрэгтэй. Мөн, 6 шатлалт аж үйлдвэрлэлийн үндсэн утга нь ХАА салбар эрхлэгчид голлох үүрэг гүйцэтгэгч байдаг боловч, Монголд энэхүү арга хэмжээгээр аж үйлдвэрлэлийн төрөлжүүлэх асуудалтай холбох утгаар нь Монгол хувилбарын 6 шатлалт аж үйлдвэрлэл гэж хэлж болно.

【Зөвлөмж 1】 : Монгол улсад өрсөлдөх чадвар бүхий ХАА-н гаралтай түүхий эд ашигласан хүнсний боловсруулах салбарыг хөгжүүлэхэд үзүүлэх дэмжлэг

ХАА хөгжүүлэх үүднээс дараах хөгжлийн саналыг дэвшүүлж байгаа ба ингэснээр Монгол хувилбарын 6 шатлалт үйлдвэрлэлийн салбарыг эхлүүлэн, хөгжүүлэх боломжтой юм.

- чацаргана, ингэний сүүнээс Омега 7 (тос: ханаагүй тосны хүчил) 3)

³ Сүүлийн жилүүдэд эрүүл хоол хүнс, гоо сайхны бүтээгдэхүүн зэрэгт ихээр ашиглах болсон.

- Малын эхэсээс пласента ханд гарган авах, бүтээгдэхүүн үйлдвэрлэх
- Мах болон зайдас, гэрийн тэжээвэр амьтны хоол зэрэг боловсруулсан бүтээгдэхүүн
- Улаан буудай, гурвалжин будааны бүтээгдэхүүн

Эдгээр нь чацаргана шиг (тариалалтаас боловсруулалт болон борлуулах шат хүртлээ хөгжсөн), ХАА-н үйлдвэрлэгч талаас 6 шатлалт үйлдвэрлэлд хөл тавьсан салбар, пласента шиг (боловсруулах үйлдвэр эрхлэгчид өөрсдөө бэлтгэн нийлүүлэх тогтолцоо бий болгосон жишээ), боловсруулагч, үйлдвэрлэгч талаас гаргасан хандлага, мөн улаан буудай, гурвалжин буудай шиг (гурилын үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалтаар дамжуулан гурилын үйлдвэрлэлийн салбарт орсон), 2 талаас гаргасан хандлага бий. ХАА болон аж үйлдвэрлэлийн салбар аль альнаас 6 шатлалт аж үйлдвэрлэлийг бий болгоход чиглэсэн хамтын ажиллагаанд дэмжлэг үзүүлэх (шинэ тогтолцоог бий болгох) , түүнчлэн олон улсын нийлүүлэлтийн гинжин хэлхээнд холбогдох арга хэмжээг төлөвлөх ажлыг бодолцох явдал чухал билээ.

【Зөвлөмж 2】 : ХАА-н үйлдвэрлэл, технологийн паркийн (Agro-Industry Technology Park) боловсруулах үйлдвэр нэвтрүүлэн төрөлжүүлэх, зах зээлийн ханш тогтооход дэмжлэг үзүүлэх

Хуучин Аж үйлдвэрийн яамнаас⁴ ХАА-н үйлдвэрлэл, технологийн паркад МАА (мах, махан бүтээгдэхүүн), сүү, сүүн бүтээгдэхүүн, арьс шир, ноос ноолуур, хүнсний ногоо зэрэг тус бүрийн анхан шатны боловсруулалтыг төвлөрүүлснээр эдийн засгийн үр дүнг нэмэгдүүлэх бодлого боловсруулсан байгаа хэдий ч, энэхүү шатнаас тус бүрийн боловсруулалтын шатыг төрөлжүүлэх боломжийг эрэлхийлэх асуудал чухал.

Мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний боловсруулалтын тухайд, махны зориулалтын боловсруулалт, боловсруулсан махан бүтээгдэхүүний боловсруулалт бий. Мөн боловсруулан махан бүтээгдэхүүний хувьд ч, эцсийн бүтээгдэхүүнээс шалтгаалан боловсруулалтын шатлалаас хамааран боловсруулалтын арга технологи өөрчлөгдөнө. Парк дээр аль шатны боловсруулалт хүртэл хийх вэ гэдгээс тухайн паркийн аж үйлдвэрийг төрөлжүүлэх эхлэл тавигдана. Эсвэл, зөвхөн махны үйлдвэрлэл төдийгүй зайдасны цех, гэрийн тэжээвэр амьтны хоол, гоо сайхны бүтээгдэхүүний түүхий эдийн (пласента) цех зэргийг нэг газар төвлөрүүлэх боломж бий. Төвлөрүүлэх нөөц бололцоо болон хэлбэр, цаашдын

⁴ Шинэ ЗГ-ын бүтцээр, хуучин Аж үйлдвэрийн яамны бүтцийн нэг хэсэг Үндэсний хөгжлийн газар (ҮХГ)г шилжсэн. Агуулгыг дараах “ХАА үйлдвэрлэл, технологийн парк байгуулах төсөл”, iii) Шинэ ЗГ байгуулагдсаны дараах чиг хандлага” хэсгийг харна уу.

нийлүүлэлтийн гинжин хэлхээнд үр дүнтэй холбох механизмыг бий болгох хэрэгтэй.

ХАА-н үйлдвэрлэл, технологийн парк байгуулах төсөл

(i) ХАА-н үйлдвэрлэл, технологийн парк байгуулах төсөл

Аж үйлдвэрийн яамны гол урдаа барих бодлого болгон хэрэгжүүлэхээр төлөвлөж буй “ХАА-н үйлдвэрлэл, технологийн парк”-ийг улсын хэмжээнд 40 газарт бүтээн байгуулах ба ХАА-н бүтээгдэхүүнийг нэгтгэн боловсруулах баазыг байгуулж, нэмүү өртөг шингэсэн ХАА бүтээгдэхүүнийг үйлдвэрлэхийн зэрэгцээ, орон нутагт ажлын байрыг бий болгох зорилготой юм. “ХАА-н үйлдвэрлэл, технологийн парк” төслийн санал нь Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлогод тусгагдан 62015 оны 6 сард УИХ-аар батлагдсан. 2016 оны 4 сарын байдлаар тэргүүлэх ач холбогдол бүхий 16 байршлыг сонгон төлөвлөгөө боловсруулж буй (Зураг 5.3.1).


Энэхүү ХАА-н үйлдвэрлэл, технологийн парк нь эцсийн байдлаар (мах, арьс шир боловсруулалт, хүнсний ногоо, сүү сүүн бүтээгдэхүүн) 4 төрлийн боловсруулах үйлдвэрээс гадна судалгаа шинжилгээний төв байгуулахаар үндсэн төлөвлөгөөнд оруулсан байна. Тухайн орон нутгийн бүтээгдэхүүнийг зах зээлтэй холбох, ханган нийлүүлэлтийн тогтолцоог үе шатлалтайгаар өргөжүүлэх замаар эрсдлийг багасгах хэдий ч сумдын захиргаа болон Аж үйлдвэрийн яамны стратегиас дараах үе шатлалтайгаар хэрэгжүүлэх нь тодорхой болсон.

Phase 1 Бэлтгэн нийлүүлэх = зах зээлээ олох

Phase 2 Энгийн боловсруулалт

Phase 3 Нэмүү өртөг шингэсэн боловсруулалт

Жишээлбэл, 1-р үе шатанд малчдаас түүхий эд бэлтгэн нийлүүлэлт хийх худалдааны цэг болох үндсэн суурийг бий болгоно. Ноос ноолуур зэрэг малын гаралтай түүхий эдийг аван, савлах, боох, илгээх, мах бэлтгэн нийлүүлэх тохиолдолд малыг тэжээлээр бордон таргалуулсны дараа бэлтгэн боловсруулан, арьс ширийг мөн хагас боловсруулалт хийнэ. 2-р үе шатанд ноос, ноолуурыг угаах болон дулаалгын материал болгон боловсруулах, малыг тарга хүч авхуулах, мах хадгалах хугацааг бодолцон бэлтгэн нийлүүлэх хугацааг тохируулах зэрэг үйл ажиллагаа явуулна. 3-р үе шатанд нэхмэл бүтээгдэхүүнийг бэлэн хувцас болон бусад хэрэгцээнд зориулан боловсруулах, хүнсний махыг хиам, зайдас, лаазалсан бүтээгдэхүүн зэрэг нэмүү өртөг шингээсэн бүтээгдэхүүн болгон боловсруулна. Бодит байдал дээр боловсруулах үйлдвэр барихад эдийн засгийн үндэслэл, тус тусын байршлын зах зээл, боломжит эрэлтийг судлахаас гадна менежментийн стратегиас шалтгаалах зүйлүүд олон, хөрөнгө оруулагч болон бизнес эрхлэгчдийн шийдвэрийг харахаас өөр аргагүй асуудал их, ХАА эрхлэгч, фермер болон хөрөнгө оруулагч оролцогч талуудын нягт хамтын ажиллагаа ихээхэн чухал юм.



нь тухайн орон нутгийн бүтээгдэхүүнд нэмүү өртөг шингээн сайжруулах асуудлыг нэн тэргүүний үүрэг болгох хэрэгтэй.

Дэд бүтцийг сайжруулах нь 1-р үе шатанд зах зээлээ олоход маш чухал юм. Ялангуяа улсын чанартай төв авто замаас алслагдсан ХАА-н үйлдвэрлэл, технологийн паркийн хувьд төв зам хүрэх туслах замыг хурдтай явах боломжтой болгон сайжруулах, тэмдэг тэмдэглэгээ хийх, ус зайлуулах шугам тавих зэргийг хийх зайлшгүй шаардлагатай. 2-р үе шатанд тээвэрлэлт нэмэгдэхтэй уялдуулан, өндөр чанарын салаа зам тавих, зам тавих стандартыг сайжруулах шаардлагатай гэж үзэж байна. 3-р шатанд түүхий эдийн боловсруулалтаас нэмүү өртөг шингээсэн бүтээгдэхүүн боловсруулах явц, үйлдвэрлэлтэй уялдуулан байгаль орчинд ээлтэй буюу эрчим хүчний шугам хоолой зэрэг дэд бүтцийн хүчин чадлыг сайжруулах хэрэгтэй .

Хүснэгт 5.1.1 ХАА-н үйлдвэрлэл, технологийн парк байгуулах төсөл (санал)

Үе шат	Үйл ажиллагаа	Дэд бүтэц
1 үе шат Бэлтгэн нийлүүлэлтийн дэмжлэг	Зах зээлийн мэдээллийг нэгтгэх систем, нядалгаа, мал, мах бэлтгэл, бусад бүтээгдэхүүн болон хагас боловсруулсан бүтээгдэхүүн хадгалах	Туслах замыг сайжруулах, цахилгаан дамжуулах шугамыг холбох, дулаан хангамжийг холбох
2 үе шат Энгийн боловсруулалт	Давуу ашигтай бүтээгдэхүүнд нэмүү өртөг шингээн сайжруулах = Энгийн боловсруулалт	Бохир усыг дахин ашиглах систем, туслах замын бүтээн байгуулалт
3 үе шат Нэмүү өртөг шингээн боловсруулах	Бүтээгдэхүүнийг зориулалтаар нь ангилан боловсруулах	Биомасс, хог хаягдал, байгальд ээлтэй цахилгаан станц, дулаан хангамж

Эх сурвалж: ЖАЙКА-ийн судалгааны баг

(iii) Шинэ Засгийн газар байгуулагдсаны дараах чиг хандлага

2016 оны 10 сарын байдлаар, ХАА үйлдвэрлэл, технологийн паркийн төсөл нь хуучин Аж үйлдвэрийн яамнаас шинээр байгуулагдсан Үндэсний Хөгжлийн Газарт шилжсэн байна. Үндэсний хөгжлийн газар энэхүү төслийг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төслийн (томоохон төсөл⁵) жагсаалтанд тусган, өөрсдөө хариуцан хэрэгжүүлэх хандлагатай байна. Үндсэн агуулга, зорилго нь

⁵ Хөрөнгө оруулалтын тухай хууль, ЗГ ын бүтцийн тухай хуулиар, улсын бүтээн байгуулалтын төсөл дотор, 500 тэрбум төгрөгөөс дээш төслийг улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн (PIF) төсөл хэмээн Үндэсний хөгжлийн газар хариуцан хэрэгжүүлнэ. 500 тэрбум төгрөгөөс дээш төслийг Мега төсөл хэмээн, ТТ, ОТ төсөл зэрэг, одоогоор 29 төсөл байна.

хуучин Аж үйлдвэрийн яамны төлөвлөгөө тэр чигээр ижил байгаа хэдий ч өнөөг хүртэл концессын гэрээгээр хийхээр төлөвлөж байснаа өөрчилж, анхны төлөвлөлтийн үеийн ”Дэд бүтцийн бүтээн байгуулалтыг улсын төсвөөр хэрэгжүүлж, паркийн менежментийг хувийн хэвшилд даалгана” гэсэн үндсэн зарчимд буцаж шилжсэн. Мөн орон нутгийн хөгжлийн санаас⁶ (ойр.50 тэрбум төгрөг) хөрөнгө оруулалт авах боломж хайх, улсын хөрөнгө оруулалтын төслийн жагсаалтын эхэнд байгаа тул улсаас төсөв гаргах найдлага байгаа гэж үзэж байна.

Одоогоор, Эрдэнэмандал, Хутаг-Өндөр, Баянчандмань зэрэг байршилд сум, аймгийн засаг захиргаа, хувийн хэвшлийн санаачлагаар паркийн үйл ажиллагааг эхлүүлэх сонирхолтой газрууд бий. Үндэсний хөгжлийн газар иймэрхүү нөхцөл байдлыг харгалзан үзэж, стратегийн байршилд буй аймаг болон орон нутгийн санаачлага бүхий байршлийг эрэмбэ тогтоох бодлоготой байна. Түүнчлэн, Японы технологи, загварыг нэвтрүүлж, үр дүнтэй ашиглах, Японы хувийн хэвшилтэй хамтран ажиллах тал дээр өндөр сонирхолтой, нэгдсэн технологийн дэмжлэг, туслалцааны боломжийн талаар санал тавьж байгаа.

Үндэсний хөгжлийн газар 40 байршлын ХАА үйлдвэрлэл, технологийн паркийн төслийн хөрөнгө оруулалтыг ойролцоогоор 30 тэрбум ам. доллар гэж тооцоолж байна.

2) Стратегийн салбарт олноор үйлдвэрлэн зардал хэмнэх, нэмүү өртөг шингээх, нийлүүлэлтийн гинжин хэлхээг хөгжүүлэх замаар төрөлжүүлэх (жигжиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих стратеги)

25 жилийн турш үргэлжилсэн гадны донор байгууллагуудын тусламж, дэмжлэгээр (1997 оноос хойш Японы Засгийн газраас Говь комбинатад үзүүлсэн тусламж, 2005 оноос 2007 оны USAID брэнд бүтээгдэхүүн бий болгоход үзүүлсэн дэмжлэг) ноос, ноолуурын салбар хир хэмжээндээ хөгжиж ирсэн хэдий ч Монголын харьцангуй ашигтай нөөц баялагыг дээд хэмжээнд хүртэл нь ашиглаж чадаагүй. Дэлхийд ноолуур үйлдвэрлэлтээр 2-рт ордог Монгол улсын тухай ойлголтыг олон улсын зах зээлд өргөн, энэ салбар тэргүүн эгнээнд уул уурхай (ашигт малтмал) гаас бусад салбарын аж үйлдвэрийг төрөлжүүлэх үйлсэд хувь нэмэр оруулах хэрэгтэй. Дотооддоо эхний 7-д орох компаниуд нэгдэн, салбарын хамтын ажиллагааг хөгжүүлэн өндөр зэрэглэлийн чанартай, өндөр нэмүү өртөгтэй бүтээгдэхүүн бий болгож үйлдвэрлэхийн зэрэгцээ салбарын үйлдвэрлэлийн бүтээмжийг дээшлүүлэх шаардлагатай. Түүхий эдийг түүхийгээр нь гадагш экспортлох асуудлыг эрс багасгаж, дотооддоо нэмүү өртөг шингээх тогтолцоог бэхжүүлэх хэрэгтэй.

⁶ Дэлхийн банкнаас хэрэгжүүлж буй Sustainable Livelihood Project (Phase II,III) төслийн дэмжлэг авах боломжтой.

【Зөвлөмж 3】 : Нийлүүлэлтийн гинжин хэлхээг бэхжүүлэх, жижиг дунд үйлдвэрийг дэмжих

Нийлүүлэлтийн гинжин хэлхээнд хагас боловсруулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэх үе шатлал бүрт ижил ажил үүргийн хуваарьтай ажиллагсадын тоог нэмэгдүүлэх бололцоотой орчинг бүрдүүлж, аливаа эрсдэлийг хянан, үйлдвэрлэлийн бүтээмжийг дээшлүүлэх арга хэмжээг авах шаардлагатай байдаг.

Одоогоор Монголд жилд 5,000-8,000 тонн ноолуур (түүхий ноос) үйлдвэрлэгддэг хэдий ч түүний 60 орчим хувь нь БНХАУ голдуу гадагшаа (ченжийн тусламжтай) экспортлогддог. Ойролцоогоор 90 компани ноолуурын үйлдвэрлэл эрхэлдэг хэдий ч түүний 15 нь ноос ангилан ялгах дамжлагаас эцсийн бүтээгдэхүүн хүртэл үйлдвэрлэдэг, тоног төхөөрөмж болон ажилчдын тоо тохиромжтой хэмжээнд байгаа. Утас ээрэх дамжлага хүртэл явуулах бололцоотой 23 компани, эцсийн бүтээгдэхүүн хүртэл хийдэг 49 компани байна. Нэмүү өртөг шингээлгүй түүхий эдээ гадагш экспортлох нь эдийн засгийн боломжоо тэр хирээр алдаж байна гэсэн үг юм. Мөн сүүлийн жилүүдэд, Японы хувцасны үйлдвэрлэгчдийн эрэлт хэрэгцээг хангах хэмжээний бараа бүтээмж, технологи чанарын шаардлагад хүрэлгүй, эцсийн байдлаар өөр улсад зах зээлээ алдах нөхцөл байдал ажиглагдаж байна.


Цаашид, нийт салбарын хэмжээнд илүү их бүтээмжтэй, чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэх шаардлага байгаа бөгөөд түүний тулд үйлдвэрлэлийн бүхий л үе шатлал хийх хүчин чадалтай томоохон аж ахуйн нэгжийн чанар, стандарт, технологийг салбар нийтийн чанар стандарт, норм болгон нэвтрүүлэх ажлыг яаравчлах хэрэгтэй байна. Түүний дараа дунд шатлалын үйлдвэрлэл явуулдаг аж ахуйн нэгжийн сургалт, эцсийн бүтээгдэхүүн хүртэл үйлдвэрлэл явуулдаг аж ахуйн нэгжтэй аж үйлдвэрийн стратегийн ач холбогдол бүхий салбар болгох хэмжээнд хамтын ажиллагааг бататган (боломжийн хирээр хуваарилалтын систем⁷ бий болгох), салбарын стандарт болон технологи шинэчлэлтээр бүтээмж, чанарыг дээшлүүлэх шаардлагатай байна.

Түүхий эд бэлтгэл, анхан шатны боловсруулалтад шинээр орж ирж буй аж ахуйн нэгж (анхан шатны боловсруулалт хийгдсэн түүхий эдийг гадагш экспортлох) болон шинэлэг бүтээгдэхүүн үйлдвэрлэн төрөлжсөн үйл ажиллагаа явуулж эхэлж буй аж ахуйн нэгж (ноосон дулаалгын материал үйлдвэрлэгч) зэрэг олон янзын хувилбар харагдаж байгаа, зөвхөн үйлдвэрлэл төдийгүй ЖДҮ-ийн гарааны бизнесийг дэмжих тал дээр ч гүнзгий холбогдоно гэж үзэж байна. Мөн энэхүү асуудал дээр ЖАЙКА-аас хэрэгжүүлж буй ЖДҮ нарт зориулагдсан 2 шатлалт

⁷ Тайвань улсын мэдээлэл технологийн салбарын хөгжлийн түүхэнд, гадаадаас их хэмжээний захиалга аван, олон тооны жижиг дунд үйлдвэрүүд хамтран ижил чанарын бүтээгдэхүүн үйлдвэрлэж чадсанаар, нийт салбарын хөгжилд чухал хувь нэмэр үзүүлсэн жишээ байдагчлан, Монголын хувьд чухал нөөц баялаг болох ноос, ноолуур, арьс ширний салбарт иймэрхүү орчинг бүрдүүлэх боломжтой гэж үзэж байна.

зээлийн төлөвлөгдөж буй 3 дахь үед “Японы технологи ашигласан тохиолдолд тусгай нөхцөл” оруулахыг хэлэлцэх боломжтой хэдий ч, энэхүү саналын агуулгын талаар дэлгэрэнгүй судалгаа, төлөвлөлт хийх шаардлагатай.

Horizontal development of supply chain in the strategic sector.



Эх сурвалж : ЖАЙКА-ийн судалгааны баг

Зураг 5.1.2 Стратегийн салбар дахь нийлүүлэлтийн гинжин хэлхээний хөгжил

【Зөвлөмж 4】 : Төвлөрүүлэн хөгжүүлэн, шинэлэг технологи нэвтрүүлснээр нэмүү өртөг шингээх, олон улсын нийлүүлэлтийн гинжин хэлхээнд холбогдоход дэмжлэг үзүүлэх

ЖДҮ-ийг дэмжих кластераар хөгжүүлэх эхний шатанд ямар байдлаар үр ашигтай аж үйлдвэрийн төвлөрлийг дэмжих талаар авах арга хэмжээг хэлэлцэх шаардлагатай. Мөн томоохон аж ахуйн нэгж, олон улсын нийлүүлэлтийн гинжин хэлхээтэй холбох ажлыг үр дүнтэй болгохын тулд, технологи нэвтрүүлэх ажил үр дүнтэй хэдий ч гадаадаас технологи нэвтрүүлэхийн тулд хөрөнгө оруулалт хүлээн авах тухайн улсын аж үйлдвэрлэл нь нийтэд танигдсан аж үйлдвэрийн төвлөрөлтэй байх шаардлагатай. Аж үйлдвэрийн төвлөрөл нь эдийн засгийн цар хүрээтэй аж үйлдвэрлэл, бүтээмж, үр ашгийг дээшлүүлэхэд нөлөөлөхөөс гадна, гадаадад нэр таниулах замаар хамтын ажиллагааг (өөрөөр хэлбэл нийлүүлэгчийн гинжин хэлхээ болон аж ауй нэгж руу холбож өгөх) хөнгөвчлөхөд чухал үүрэгтэй. Тийм ч учраас ихэвчлэн кластераар хөгжүүлэх чиг хандлага болон аж үйлдвэрийн парк (“ХАА үйлдвэр технологийн парк” зэрэг) нь шууд утгаараа иймэрхүү аж үйлдвэрийн төвлөрлөөр олон нийтэд танигдахад чухал үүрэгтэй аргачлал гэж ойлгох нь зүйтэй.

Монголын ноос, ноолуурын салбарт хүний нөөцийн хүрэлцээний асуудал хүндрэлтэй байна. Ялангуяа “мэргэшсэн” хэмжээнд арга технологи эзэмшсэн мэргэжилтэн дутмаг, утас ээрэх, сүлжих технологийн ноу-хау чухал байгааг 2-р бүлэгт дурдсан. Мөн бүтээгдэхүүний төрлийг олшруулах, өндөр нэмүү өртөг шингээх хэрэгцээнд утас ээрэх, сүлжих технологийг дээшлүүлэх зайлшгүй хэрэгтэй. Иймэрхүү тал дээр Японд сургалтанд хамруулах маягаар технологийн дэмжлэг авах хүсэлт их байдаг. Томоохон компаниуд өөрсдийн хүчин чадлаар дэвшилтэт технологи нэвтрүүлэн амжилтанд хүрсэн жишээ олон байдаг⁸ хэдий ч, стратегийн салбар болгоход дэмжлэг болох механизм талаас ялангуяа хөрөнгийн чадвар (мэдээллийн чадвар) хязгаарлагдмал ЖДҮ-рүү чиглэсэн дэмжлэг хүлээгдэж байна

Шууд технологийн дэмжлэг үзүүлэх механизм байж болох ч, хүний нөөцийг бэлдэх, хүний нөөцийн хамтын ажиллагаа (сургалт зохион байгуулах), технологийн дамжуулах зэргээр цаашдын бодит бизнесээ өргөжүүлэх чухал. Түүний тулд EBRD хэрэгжүүлж буй EGP (Enterprise Growth Programme⁹) технологийн талаарх мэдээлэл солилцох, хооронд нь холбох механизм байдаг ч, нэг алхам ахин, хөгжингүй орнуудын (FDI) нийлүүлэлтийн гинжин хэлхээнд тухайн стратеги салбарыг уялдуулан холбох ажлыг багцаар нь багтаасан дэмжлэг, бодлого¹⁰ боловсруулах шаардлагатай.

Гэхдээ, тухайн стратеги салбарт томоохон компаний аж ахуйн нэгжүүд дэвшилтэт технологи нэвтрүүлсэн компани гэдгээр танигдах хэдий ч, ЖДҮ-ийн хувьд хамтрагч гэдэг утгаар хүлээн авахад хүндрэлтэй. Түүнчлэн, дэмжих бодлогод ЖДҮ-ийн түвшинд үр дүнтэй кластерийг хөгжүүлэх талаас бодлогын цар хүрээнд, салбар доторх хамтын ажиллагааг өргөжүүлэх, гадаадын хөрөнгө оруулалттай компаниудад танигдах, мэдээлэл нэмэгдүүлэх зэргээр технологи дамжуулах, нутагшуулах ажлыг эхлүүлэх явдал чухал. Мөн иймэрхүү арга хэмжээнд, дээрх “санал 3” дээр тавьсанчлан аль болох ажил үүргийг хуваарилж үйлдвэрлэлийн бүтээмж, үр дүнг дээшлүүлэн, хоёр талын хамтын ажиллагааг

⁸ Жишээ нь, томоохон Говь компанид Тоттори мужийн Тоттори Нанкай компаний технологиор, Вакаяма мужийн Шима сэйкид сүлжмэл бүтээгдэхүүн бэлдэх шатлалаар дамжуулж, өөрсдийн бүтээгдэхүүний түвшинг дээшлүүлж, одоо эдгээр технологи, тоног төхөөрөмж нэвтрүүлэн, өөрсдөө ээрмэл, сүлжмэл хийж эхэлсэн. (Шима сэйкигийн сүлжмэлийн машиныг Говь компани тэргүүтэй салбарын томоохон аж ахуйн нэгжүүд ихээхэн ашигладаг төдийгүй, улам эрэлт ихэссээр байна.) Мөн түүнээс гадна ноолууран пальто оёх технологи нэвтрүүлэхээр Фүжи хотын сургалтанд 3 жил дараалан хамрагдсан байна. Сор кашмерийн хувьд (салбартаа 4-т ордог) Айчи мужийн Нанкай никке (Япон сүлжмэл ХХК) группээс захилга авснаар шинэ технологи нэвтрүүлэн, хамтын ажиллагаа өрнүүлж байна. (Ярилцлага судалгаанаас)

⁹ Хуучин ТАМ (Turn Around Management) Хөгжиж буй орнуудад хэрэгцээтэй технологийн хэрэгцээнд, хөгжингүй орнуудын технологи эзэмшдэг компаниудтай хамтын ажиллагааг дэмжих замаар, хөгжиж буй орнуудын технологи, зах зээлийг өргөтгөх, хөгжингүй орнуудын гадаад дахь салбаруудын санхүүгийн хэрэглүүрийг өргөжүүлэх хэрэглүүр, харилцан ашигтай харилцааг дэмжих механизм.

¹⁰ Тухайлбал, AusAid хэрэгжүүлдэг CAVAC механизм шиг, хувийн хэвшлийн салбарт технологи нэвтрүүлэх, хооронд нь холбох, VCD, санхүүгийн дэмжлэг зэргийг цогцоор нь хүргэх бодлогоос санаа авч болох юм. Түүнчлэн одоо хэлэлцэгдэж байгаа ЖАЙКА-ийн ЖДҮ-ийн 2 шатлалт хөнгөлөлттэй зээлийн 3 дугаар шатанд “Япон технологийг нэвтрүүлэх тусгай нөхцөл” ашиглах зэрэг санхүүгийн дэмжлэгийг бодолцож болно.

өргөжүүлэх явдал үр ашигтай. Энэхүү санал, зөвлөмжийн хувьд ч, хэрэгжилтийн шатанд сайтар судлан, нягталсны үндсэн дээр төлөвлөлт хийх шаардлагатай.

【Зөвлөмж 5】 : Аж үйлдвэрийн нөөц баялгад нэмүү өртөг шингээх аж үйлдвэрийн хэрэглээний бүтээгдэхүүн бий болгоход чиглэсэн дэмжлэг

Одоогоор ноосны салбарт дулаалгын материал үйлдвэрлэх зэргээр барилгын салбар болон бусад салбарт орох хандлага гарч байна. Үүнээс гадна, арьс ширний салбарын тухайд, автомашины руль, тансаг зэрэглэлийн автомашины салон, суудлын бүрээс зэрэг бүтээгдэхүүний зах зээлд анхаарал хандуулж эхлээд байна. Өнөөг хүртэлх, бэлэн хувцас, өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн дээр аж үйлдвэрийн хэрэглээний бараа бүтээгдэхүүн (материал, сэлбэг хэрэгсэл) зэрэг бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг өргөжүүлэх нь салбарын хөгжлийн чухал түлхүүр болно. Япон улстай байгуулсан ЭЗТХ-тэй холбогдуулан Японы аж ахуйн нэгжийн эрэлт хэрэгцээг судлан, шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэлд дэмжлэг үзүүлэхэд дөхөм болж байна.

3) Эрчим хүчийг дотооддоо үйлдвэрлэн дотооддоо хэрэглэх замаар хөнгөн аж үйлдвэр, боловсруулах үйлдвэрийг төрөлжүүлэ

【Зөвлөмж 6】 : Эрчим хүчид түшиглэн орон нутгийн хөгжүүлэхэд чиглэсэн аж үйлдвэрийн хөгжилд дэмжлэг үзүүлэх

Энэхүү зөвлөмжийн хувьд уул уурхайн салбартай хамтран зохицуулалт хийх шаардлагатай бөгөөд аж үйлдвэрийг хөгжүүлэх стратеги салбар болох уул уурхайн боловсруулах салбарт CBM/UCM ашиглах талаар яригдаж байгаа. Эдгээр нь экспортлох болон алслагдсан нутаг руу хүргэхэд эдийн засгийн хувьд давуу тал гарахгүй байх тохиолдолд ч, эрчим хүч импортлодог Монгол орны хувьд эхний хэмжээнд эрчим хүчийг дотооддоо үйлдвэрлэн, дотооддоо хэрэглэх (орон нутагт) зорилгоор, эрчим хүчний хөгжилд түшиглэсэн орон нутгийн хөгжлийг нягтлан, дунд болон урт хугацааны эрчим хүчний салбартай хамтарсан хүлэмж, хүнсний ногооны үйлдвэрийн дулаалга, худалдаа, засвар үйлчилгээний газар, сэлбэг үйлдвэрлэлийг дэмжих зэргээр орон нутгийн аж үйлдвэрийн салбарыг хөгжүүлэхэд чиглүүлэх боломжтой. Сүүлийн жилүүдэд хөгжлийн хурд удаашралтай буй орон нутгийн хотын “уул уурхай дагасан хөгжил”-ийг уул уурхайн боловсруулах салбарыг орон нутгийн хөгжилтэй уялдуулан хөгжүүлэх боломж, дэмжих бодлогыг авч хэлэлцэх хэрэгтэй гэж үзэж байна.

4) Одоо буй аж үйлдвэрийн нөөцийг дахин сэргээх замаар аж үйлдвэрийг дэмжих

【Зөвлөмж 7】 : Технологийн талаарх мэдээлэл авахад дэмжлэг үзүүлэх, одоо байгаа тоног төхөөрөмж, байгууламжийг ашиглахад үзүүлэх дэмжлэг

Стратеги салбар төдийгүй нийт аж үйлдвэрийн салбарын хөгжилд, технологийн мэдээлэл хүргэх, албан ёсны тогтолцоонд стратеги бодлого боловсруулах (тоног төхөөрөмж шинэчлэх, хүний нөөц нэмэгдүүлэх), аж үйлдвэрийн нуугдмал капиталын бодит байдал болон хөрөнгө оруулалтын бодлогын уялдаа, гадаад дотоодын зах зээл бий болгох гэсэн үндсэн суурийг бэхжүүлэх асуудал хэрэгцээтэй бөгөөд илүү тодорхой бодит байдал, хэрэгцээнд тулгуурласан үр ашигтай дэмжлэгийн тогтолцоог бий болгох явдал чухал ач холбогдолтой.


Аж үйлдвэрийн технологийн судалгаа, шинжилгээ, баталгаа гаргадаг улсын судалгааны хүрээлэн нийтдээ 23 байдаг. Хэд хэдэн судалгааны хүрээлэнгийн хувьд судалгааны үр дүн болох шинэлэг технологийг аж үйлдвэрт нэвтрүүлж, тодорхой үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж шинээр бүтээн, үйлдвэрлэлд нэвтрүүлэн, инкубаторын үйлчилгээ үзүүлдэг лабораториуд ч бий. Гэвч аж үйлдвэрийн салбарыханы хувьд энэ талаар сайтар танигдаагүй, бүрэн дүүрэн ашиглагддаггүй. Мөн төсвийн хүрэлцээнээс шалтгаалан хүн хүч, тоног төхөөрөмж, үйл ажиллагааны хүрээ хязгаарлагдан, аж үйлдвэрийн салбартай хамтран ажиллах, барилга байгууламж ашиглалт дээшлүүлэх тал дээр дэмжлэг хэрэгтэй.

Түүнчлэн социалист нийгмийн үед ашиглалтанд орсон томоохон үйлдвэрийн газрууд шинэ зах зээл олж чадаагүйн улмаас үйл ажиллагаагаа зогсоох байдалд хүрээд байгаа талаар 2-р бүлэгт дурдсан. Улаанбаатар хотод байдаг Чех улсын тусламжаар байгуулагдсан Нолго төмрийн завод (Эрдэнэт үйлдвэрийн 2 дахь том үйлдвэрт дурдсан. У-р сараас үйл ажиллагаагаа түр зогсоож байна. Уул уурхайн салбарын тоног төхөөрөмжид шаардлагатай сэлбэг, хэрэгсэл зэрэг хангалттай хэмжээний түвшний техник хэрэгсэл тоноглогдсон байгаа хэдий ч, гадны хөрөнгө оруулалттай уул уурхайн салбарт тоног төхөөрөмжийн сэлбэг, хэрэгсэл, засвар үйлчилгээг өөрсдийн группын маршрутаар хангах хандлагатай, шинээр тухайн бизнест хөл тавихад хүндрэлтэй. Тухайн салбарын сэлбэг нийлүүлэлт БНХАУ-тай олон жилийн тусгай гэрээ хэлцэлтэй гэсэн яриа ч байдаг байна. Хөрөнгө оруулагч талтай хуучин ашиглагдаж байсан үйлдвэр, тоног төхөөрөмжийн талаарх мэдээлэл, хамтран ажиллах боломж, нийлүүлэлтийн гинжин хэлхээнд үзүүлэх дэмжлэг болон тогтолцоо, системн хувьд илүү шудрага өрсөлдөх орчин бий болгох тал дээр хэлэлцэн дэмжлэг авах шаардлагатай.

5.2 ХАА үйлдвэрлэлийг хөгжүүлэх

(1) МАА салбар

Цаашид мал аж ахуйн салбарыг сайжруулахын тулд өмнөх бүлэгт дурдсан мал аж ахуйн салбарын асуудал буюу **(1) Малын огцом өсөлт болон тархалтын тэнцвэргүй байдал (хэт төвлөрөл, хэт өсөлт) (2) Зудын бэлтгэл хангалтгүй хийдэг малчдын өсөлт (3) Шүлхий өвчнөөс шалтгаалах их хэмжээний эдийн засгийн алдагдал** зэргийг шийдвэрлэх арга замын талаар судалгааны багаас дэвшүүлж буй санааг дурдана. Юуны өмнө хөгжлийн ерөнхий ойлголтын цар хүрээг зураг 5.2.1-т тусгав. Энэ нь 2015 оны 6 сарын 18 (Пүрэв)-т Улаанбаатар хотод зохион хөдөө аж ахуйн салбарын мэргэжилтний зөвлөлийн хурлаар¹¹ хэлэлцэгдэж санал нэгдсэн зүйл болно



Эх сурвалж : ЖАЙКА-ийн судалгааны баг

Зураг 5.2.1 Монголын мал аж ахуйн салбарын хөгжлийн ерөнхий тогтолцооны хүрээ

Энэ хүрээнд хамгийн чухал бөгөөд анхаарал татсан зүйл нь “эрчимжүүлэх” гэдэг орчин үеийн мал аж ахуйн арга барил болон “бэлчээрийн” гэх уламжлалт мал маллах арга ухаан гэх өөр хоорондоо харилцан эсрэг энэхүү 2 арга барилыг хамтад нь хэлэлцэж байгаа явдал юм. Гэхдээ эдгээр нь огт хослуулах боломжгүй аргачлал биш бөгөөд үүнийг Монголын онцлогт тохируулан хосломол мал аж ахуй хэлбэр бий болгох юм. Энэ талаар тодорхой санал дээр нарийвчлан тусгана, ерөнхийдөө тус тусдаа бэлчээрийн мал аж ахуй эрхлэж буй малчдыг нэгтгэж

¹¹ ХАА-н салбарын мэргэжилтний зөвлөлийн тухай, 2-р бүлгийн 8 хэсэгт “Монгол дахь мэргэжилтний зөвлөл” хуралдаан зохион байгуулсан тухай хэлэлцүүлгийн агуулгын талаар тодорхой дурдсан.

эрчимжүүлсэн мал аж ахуй хөгжүүлэх бус улсын хэмжээнд эсвэл бүс нутгийн хэмжээнд эрчимжүүлсэн мал аж ахуй, уламжлалт мал аж ахуйн арга ухааны харилцан ашигтай талыг бий болгох гэсэн утгыг илэрхийлнэ. Үүнд хамгийн ойр жишээ нь Булган аймагт үхрийн ферм эрхэлдэг Канадын иргэний жишээ юм. Тэрээр үхрийг мах бэлтгэл, нядалгаанд оруулахын өмнөх хэдэн сарын хугацаанд өөрийн ферм дээр өндөр тэжээллэг чанар бүхий тэжээлээр мал тэжээж махны чанарыг сайжруулах тал дээр анхаарч ажиллан түүний дараа Улаанбаатар хотын ресторан болон махны дэлгүүрт зах зээлээс дээгүүр үнээр худалдаалдаг. Гол нь үхрээ жирийн малчдаас худалдаж авдаг. Иймэрхүү үйл ажиллагаатай уялдан малчид тал нутагт хамгийн их зохицсон уламжлалт мал аж ахуйгаа үргэлжлүүлэнгээ эрчимжүүлсэн мал аж ахуйн эргэлтэнд оролцох боломжтой. Нөгөөтэйгүүр, хөгжлийн ерөнхий ойлголтыг цэгцлэхийн хамт тодорхой ямар хэсгийг сайжруулах шаардлагатай талаар ХАА-н мэргэжилтэний зөвлөл, судалгаанд хамрагдсан холбогдох байгууллага, мэргэжилтнүүдээс лавласан болно. Энэхүү бодит байдалд үндэслэсэн саналыг хүснэгт нь 5.2.1 нэгтгэсэн. Хүснэгтээс логистик болон тээвэр цаашилбал үйлдвэрлэлийн хэлбэр гэх мэт нэгдлийн үеийн системийг бий болгох шаардлагатай гэх санал олон байгаа нь харагдаж байна. Эдгээрийг санал дээр өргөн хүрээтэйгээр тусгагдах болно.

Хүснэгт 5.2.1 Мал аж ахуйн хөгжилд шаардлагатай хүчин зүйл

Судалгаа авсан газар	эрчимжсэн МАА	тээвэр, агуулах	үйлдвэржүүлэлт	хоршоо үүсгэх	экспорт нэмэгдүүлэх	үүлдэр сайжруулах	Тэжээл үйлд.	Технологи нэвтрүүлэх
Яам, тамгийн газар	◎	◎		◎	◎	◎	◎	◎
Судалгаа, ш/у-ны байгууллага, их дээд сургууль	◎					◎	◎	
ХАА хоршоо	◎	◎						◎
Махны холбоо	◎	◎	◎	◎	◎	◎	◎	
Ноосны холбоо		◎	◎	◎	◎	◎		
Арьс ширний холбоо		◎	◎	◎	◎	◎		
Мал үржүүлгийн холбоо	◎	◎	◎		◎	◎		
Сүү судлал ш/у холбоо	◎	◎	◎					
Махны үйлдвэр, компани	◎	◎	◎		◎	× ¹²		
Сүү, сүү бүтээгдэхүүн компани	◎	◎	◎	◎	◎	◎	◎	◎
Малчид		◎					◎	◎

тайлбар : дээрх хүчин зүйлсийн тухайд ярилцлага авах үед ярилцагчийн зүгээс дурдагдсан зүйл дээр 「◎」 гэмдэглэсэн. Гэхдээ 「◎」 гэмдэглэгдээгүй хэсэг нь ярианд дурдагдаагүй л болохоос, 「хэрэгцээгүй」 гэсэн утга биш. Эх сурвалж : ЖАЙКА- ийн судалгааны баг

¹²Махны холбооны дэд тэргүүний зүгээс уулзалтын үеэр, “үүлдэр сайжруулснаар, Монгол малын ген устах аюултай тул эсэргүүцэж байна” гэж хэлсэн. Гэхдээ энэ нь Монголын онцлогт үүлдэрийг хадгалан үлдэх талыг бодолцсон аргаар явуулах хэрэгтэй, Монголын шилмэл үүлдэрийн оронд өөр үүлдэр оруулах тал дээр эсэргүүцэж байгаа асуудал гэдгийг ярилцлагын явцад ойлгосон. Энэхүү асуудлыг сайтар ойлгож хэрэгжүүлэх нь зүйтэй.

Дараах санааг дэвшүүлэхийн өмнө Монголын тал нутагт мал аж ахуйн салбарыг сайжруулах аргачлал болгон бусад улсад ашиглагддаг арга хэлбэрийг сонгох нь төдийлөн үр дүн гарахгүй гэдгийг онцгойлон дурдах хэрэгтэй. Үүнийг суурь мэдээлэл (Хавсралт 2.6.1)-д олон удаа дурдсан байгаа. Бэлчээрийн хяналт зохицуулалтын журам, малын тоо толгойг хязгаарлахтай холбоотой журам, газрын хувьчлал болон суурьшил гэх мэтийг өнөөг хүртэл туршиж ирсэн боловч төдийлөн үр дүн гараагүй. Тиймээс дараах дэвшүүлж буй бүх санаанд энэхүү асуудлыг сайтар анхаарч үзсэн болно.

1) Эрүүл зах зээлийг бий болгох

Эрүүл зах зээл бий болгоход шаардагдах зүйл нь өмнө дурдсан Монголын онцлогт тохирсон хосломол хэлбэрийн мал аж ахуйг бий болгох бөгөөд эрчимжсэн мал аж ахуйг үр ашигтай болгох, тогтвортой бэлчээрийн мал аж ахуй бүхий мал аж ахуйн үйлдвэрлэлийн систем юм. Аль аль нь үйлдвэржүүлэлтийн үндсэн хэсэг эсвэл тойрог бий болгох хэсэг нь эрчимжсэн мал аж ахуйн бүтэцтэй түүний дотор нь малд гаршсан малчид багтана гэсэн бүтэцтэй юм

(i) Эдийн засгийн тусгай бүс (ХАА үйлдвэрлэл, технологийн парк)

Энэ нь Аж үйлдвэрийн яамнаас төлөвлөж буй "ХАА үйлдвэрлэл, технологийн парк" (5.4 хэсэг) болон Монголын Засгийн газраас хэрэгжүүлж буй "Эдийн засгийн чөлөөт бүс"-ийн бодлоготой дүйцэх санаа юм. Өөрөөр хэлбэл, тодорхой бүс нутагт өндөр бүтээмж бүхий үйлдвэрлэлийн тогтолцоог бий болгон, тээвэрлэлт борлуулалтыг нэг дор шийдэхээс гадна гадаад худалдааг татварын бодлогоор дэмжих бодлого юм. ХАА салбарын хөгжлийн хувьд эдийн засгийн тусгай бүсэд дараах хүчин зүйлс шаардлагатай.

- **Газар тариалан мал аж ахуйн хосломол эргэлт бүхий үйлдвэрлэлийн систем:** Тусгай бүсэд мал аж ахуй (үхэр болон хонь голлох) газар тариалан (улаан буудай, овъёос, (тэжээлийн ургамал)) эрхэлж, малаас гарах бордоог тариан талбайд ашиглаж гурилын үйлдвэрлэлийн хаягдал улаан буудайг тэжээл болгон малаа тэжээх гэсэн тойрог юм. Гэхдээ малыг үндсэндээ жирийн малчдаас авна.
- **Комбинат маягийн боловсруулалт, үйлдвэрлэл:** Малын нядалгаа, боловсруулалт, хадгалалтаас эхлээд тээвэрлэлт хүртэлх бүхий л үйл ажиллагааг эдийн засгийн тусгай бүсэд нэгтгэж бүтээмжийг нэмэгдүүлнэ.
- **Тодорхой халдварт өвчнөөс тусгаарлагдсан тусгай бүс:** Энэ нь тусгай бүсийн хамгийн том онцлог тал юм. Тодорхой халдварт өвчин ялангуяа шүлхий өвчний хяналтыг олон улсын түвшинд нийцсэн арга хэлбэрээр

хэрэгжүүлж улмаар бүсийг халдваргүй бүс болгоно. Жишээлбэл, Африкийн Намиби улсын жишээн дээр авч үзэхэд, мөн л Монгол улстай адил шүлхий өвчин их дэгддэг улс байсан бөгөөд халдвар гарсан бүс нутгийг мал эмнэлгийн хориг гэж нэрлэгдэх хашаагаар хүрээлсэн байдаг байна. Энэ хашааны өндөр ойролцоогоор 2 метр, модон хийцтэй, урт нь 1,200 км хүрнэ. Үүгээр халдваргүй бүс болон халдварт бүс тусгаарлагдан, малын хөл хорионд хяналт тавигдах тул энэхүү эдийн засгийн бүсэд бэлтгэгдсэн мах нь экспортлох боломжтой барааны төрөл болно. Мэдээж малчдаас мал авах үед ч хорио цээрийн шалгалт шаардлагатай. Энэ санаа нь суурь мэдээлэл (Хавсралт 2.6.1.)¹³-д дурьдагдсан бөгөөд Монгол, Хятад, Орос 3 улсын хооронд хэлэлцэгдэж буй “Шүлхий өвчнөөс тусгаарлах бүс”-ийн агуулгатай адил юм.

Эдийн засгийн тусгай бүсийн талаар товч дурдлаа. Энд онцлох зүйл нь ийм хэлбэрийн тусгай бүсийг дотооддоо бүс нутаг бүрт стратегитай олон тоогоор байгуулах нь зүйтэй. Ингэж байж малчин болон малын төвлөрөлийн асуудлыг шийднэ. Хамгийн чухал нь улсын аль ч бүс нутагт амьдарч байгаа малчид энэхүү үйлдвэрлэлийн эргэлтэнд оролцох боломжтойгоор зохион байгуулах явдал юм.

(ii) ХАА технологийг дахин сэргээх санаа

Хуучны нэгдлийн үеийн хөдөө аж ахуйн ашигладаг байсан технологи мэдлэг дотор цаашид Монгол улсад хэрэгцээтэй зүйлийг дахин сэргээх гэсэн санаа юм. Өмнө нь дурдсанчлан нэгдлийн үеийн тогтолцоонд мал аж ахуйн салбарт ашигтай тал олон байсан. Мал аж ахуйн салбарт дахин сэргээх нь зүйтэй гэж үзэж буй салбарыг доор дурдлаа.

- **Сүүн ферм:** Үндсэн мэдээлэлд 2.5 дурдсанчлан¹⁴ сүүн ферм нь нэгдлийн үед хөгжсөн аж үйлдвэрийн нэг билээ. Одоо малчдын тоо өссөн байгаа хэдий ч дотоодын хэрэгцээг бүрэн хангах чадахгүй, импортоос хараат хэвээр байна. Түүнчлэн сүү, сүүн бүтээгдэхүүний хувьд барааны нэр төрөл олшруулах хэрэгтэй, эхэ тал дээр ч мөн учир дутагдалтай байна. Иймд сүүн фермийн салбарыг дахин сэргээх нь чухал шаардлагатай бөгөөд улсаас энэ салбарыг бэхжүүлэх ажлыг нэн тэргүүнд хийх хэрэгтэй гэж үзэж байна. Гэхдээ энэхүү сүүний фермийг дахин сэргээх төлөвлөгөөнд малчдын байр суурь нь эдийн засгийн тусгай бүсийн талаар дурдсанаас өөр байх шаардлагатай. Одоогийн уламжлалт нүүдлийн маллагаа учир дутагдалтай. Энэ тухайд үндсэн

¹³ Хавсралт 2.6.1: МАА-д сурисан үндсэн мэдээлэл, 2) улсын малын халдаргүйжүүлэлтийн талаарах судалгаа, улсын хил орчимын малын халдваргүйүүлэх тогтолцооны бодит байдалын талаар хавсралтаас харна уу.

¹⁴ Хавсралт 5.2.1: Монголын МАА холбогдох мэдээлэл, Томоохон сүүн фермийн мэдээний эмхэтгэл

мэдээлэлд¹⁵ танилцуулсан хагас нүүдлийн хагас эрчимжсэн маягийн Монфреш үйлдвэрийн аргачлалаас санаа авч болно. Аж үйлдвэрийн хувьд сүүн ферм дээр хамгийн түрүүнд анхаарвал зохих асуудал бол өдөр бүр шинэ саасан сүү нийлүүлэх процесс байгаа цагт өөрсдийн хэрэглээнээс бусдыг уламжлалт аргаар боловсруулна гэдэг боломжгүй. Энэ нь сүүн ферм хотын ойролцоо хөгжиж ирсэнтэй ч ихээхэн холбоотой гэж хэлж болно. Иймд энэ асуудлыг бодолцсон сүүн фермийн бүтцийг бий болгож чадвал Улаанбаатар хот зэрэг хотын ойролцоо амьдардаг малчдад тулгарч буй асуудал, өөрөөр хэлбэл бэлчээрийн доройтол болон малын тоо толгойг өсгөхөд анхаарлаа хандуулдаг буруу эргэлтээс гарч чадах юм.

- **Тэжээлийн үйлдвэрлэл:** Өмнө нь дурьдсанчлан нэгдлийн үед тэжээлийн үйлдвэрлэл идэвхитэй явагддаг байсан бөгөөд ялангуяа хадлан бэлтгэж нөөцөлдөг байсан нь зудын аюулаас урьдчилан сэргийлэхэд голлох үүрэгтэй байсан. Цаашлаад өндөр тэжээллэг чанар бүхий тэжээлийн тариалалт нийт Монгол улсын сүүний үйлдвэрлэлийн салбарын хөгжилд ч нэн шаардлагатай юм. Тиймээс энэхүү салбарын хөгжил нь мал аж ахуйн хөгжилд маш чухал нөлөөтэй юм.

(iii) Шинэ нэмүү өртгийн гинжин хэлхээ үүсгэх

Энэхүү санааны гол үндэс нь “холбох” гэсэн санаа юм. Өөрөөр хэлбэл одоо бараг үнэ цэнэгүй байгаа зүйлийг тодорхой хэмжээгээр боловсруулж бизнес болгон өөрчилж гэсэн санаа юм. Монгол улс Япон улсад хийсэн судалгаа, мөн тус бүрийн салбараас авсан мэдээллээс үзэхэд дараах түүхий эдүүдэд тодорхой хэмжээний боловсруулалт хийж чадвал бизнес болох бүрэн боломжтой гэж үзэж байна.

- **Тэжээвэр амьтны хоол:** Монголд хонь болон ямааны тоо толгой их боловч эдгээрийг бүрэн үр дүнтэй ашигласан бизнесийн загвар байхгүй. Японы хэд хэдэн гэрийн тэжээвэр амьтны хоол үйлдвэрлэдэг компанитай уулзаж ярилцахад гэрийн тэжээвэр амьтны хоол үйлдвэрлэхэд хонины махны хэрэгцээ их мөн зууш болгон үхэр болон хонины туурай эрэлттэй бүтээгдэхүүн гэдгийг онцолж байсан юм. Мөн, ялангуяа Японд жижиг биетэй нохой их тэжээх болсонтой холбоотойгоор малын шийр туурай дундаас хонины шийр нь хэмжээгээрээ хамгийн тохиромжтой юм. Харин Монголд хонины туурай нь бусад хэсгийн хамтаар бараг ашиглагддаггүй.(зураг 5.2.2-1) Үүнийг хэн нэгэн анхааралдаа авч ажил болгож чадвал шинэ бизнес бий болгох боломтой гэж үзэж байна.

¹⁵ Хавсралт 5.2.1: Дээрэхтэй адил

Одоогоор зөвхөн адууны мах хэдий ч Японд тэжээвэр амьтны хоол экспортолдог жижиг дунд үйлдвэр бий болсоор байна.(Зураг 5.2.2-2)



1: Хонины шийр



2: Хатааж боловсруулсан адууны туурай (OFE)

Эх сурвалж : ЖАЙКА-ийн судалгааны баг

Зураг 5.2.2 Монгол малын туурай зэргийн боловсруулалт

- **Пласента (эхэс) :** Эхэсийн тухайд ч энэ удаад уулзалт хийсэн компанийн (Япон) зүгээс өгсөн мэдээллээр Япон улс дахь дотоодын эрэлт нэмэгдэж жилийн 30 тэрбум иений зах зээлтэй болсон байна. Хэрэглээ нь эм бэлдмэл, гоо сайхан эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүн гэх зэрэг бөгөөд Японд¹⁶ ихэнхдээ адуу, гахайн эхэсийг ашигладаг боловч бусад улсуудад хонины эхэс ч ашиглагддаг. Одоогийн байдлаар түүхий эдийн дотоодын хэрэгцээгээ хангаж дийлэхгүй байгаа учир Японд импортын гахайн эхэсийг ашиглаж байгаа тухай дурьдаж байлаа. Нөгөөтэйгүүр Монголд адуу болон хонины эхэс ашиглагддаггүй хаягддаг. Эхэсийг хэрхэн бэлтгэн нийлүүлэх мөн боловсруулалтын¹⁷ асуудлыг шийдэж чадвал бизнес болох боломжтой юм.
- **Ноос:** Ноос ашигласан нэмүү өртгийн гинжин хэлхээний тухайд энэхүү судалгаагаар танилцуулах хамгийн ирээдүйтэй бизнес хэмээн үзэж байгаа зүйл бол ноосыг барилгын дулаалгын материалд ашиглах явдал юм. Японы нэгэн компаниас өмнө нь Монголын ноос ашигласан барилгын материалын үйлдвэрлэлийг туршиж үзсэн боловч эцсийн дүндээ амжилтгүй болсон тухай сонссон. Гэвч шалтгаан нь ноосонд бус ноос угаах технологи муу байсантай холбоотой юм. Тиймээс ноос угаах технологийг Япон улсын стандартад нийцүүлж чадвал бизнес хийх боломжтой гэж үзэж байна.

¹⁶ Үхрийн галзуу өвчин (BSE) үүдэн үхрийн эхэсийг Японд огт ашигладаггүй.

¹⁷ Эхэсийн боловсруулалтын талаар Qualitas компаниас лавлахад хуурай боловсруулах арга эсвэл хандлах гэсэн 2 арга байдаг. Аль ч тохиолдолд тодорхой хэмжээний хөрөнгө оруулалт хэрэгтэй.

2) Үндсэн технологийн дэд бүтцийг сайжруулах

Өмнөх хэсэгт шууд эдийн засгийн үр ашиг бий болгож чадахуйц санаачлагад тулгуурлан зах зээл голчилсон санаа дэвшүүлсэн. Учир нь эрүүл, тогтвортой эдийн засгийн үр ашиг бий болгох нь үйлдвэрлэгчийн хувьд хамгийн чухал зүйл юм. Гэвч нөгөөтэйгүүр өнөөгийн Монголын мал аж ахуйн бодит байдал дээр энэ нь дангаараа хурдан хугацаанд ашиг олохгүй хэдий ч үйлдвэрлэлийн үндэс суурьт шийдэх олон чухал асуудал байна. Иймд үндсэн технологийн дэд бүтэцтэй холбогдох санал зөвлөмжийг дэвшүүлж байна.

(i) Малчдад зориулсан алсын зайн сургалт

Монгол улс цаашдаа ч уламжлалт тогтвортой бэлчээрийн мал аж ахуйд суурилан хөгжино. Гэхдээ энэ нь бэлчээрийн мал аж ахуй бусад орчин үеийн технологи, мэдлэгээс суралцах шаардлагагүй гэсэн үг огт биш юм. Харин ч өнөөг хүртэл зөвхөн уламжлалт арга хэлбэрээр аж ахуй эрхэлж байсан малчид урьд өмнө туршиж байгаагүй технологи, мэдээллийг олж суралцах хэрэгтэй. Үүний төлөөлөл болгож өмнө нь дурдсан дэлхийн цаг агаарын өөрчлөлттэй холбогдох байгаль орчны боловсрол болон зах зээлийн мэдээлэл түүнчлэн мал маллагаанд эм бэлдмэлийн зохистой хэрэглээ гэх мэт суралцах зүйл олон. Саяхныг хүртэл Монголын малчдын нүүдэллэн явах, холбоо харилцаа муутайгаас болж бусад улс орон шиг мал аж ахуй эрхлэх арга барилыг дэлгэрүүлэх өөрөөр хэлбэл хэсэг бүлгийг хамруулан нэгдсэн байдлаар технологийг дэлгэрүүлэх нь тун хүндрэлтэй байсан. Гэсэн хэдий ч орчин үеийн малчдад телевиз, радио гэх зэрэг мэдээллийн хэрэгсэл өргөн хэрэглэгддэг¹⁸ тул эдгээрийг ашиглан алсын зайны сургалт явуулах боломжтой болсон учир үр дүнтэйгээр ашиглах нь зүйтэй гэж үзэж байна.¹⁹

¹⁸ 2013оны байдлаар, малчин өрхийн телевизийн хэрэглээ 74% (Монголын Статистикийн эмхэтгэл)

¹⁹ Монгол улсын олон нийтийн үндэсний радио телевизээр цацагддаг малчдад зориулагдсан “Малчин” нэвтрүүлэг байдаг ба иймэрхүү сургалтын нэвтрүүлгийг ихэсгэх нь бас нэгэн арга юм.

**Хүснэгт 5.2.2 Мэдээлэл сурталчилгааны хөтөлбөрийн
сэдвийн агуулга (Зөвлөмж)**

Уламжлалт сэдэв (ердийн МАА)		Сэдэвчилсэн сургалт	
Малын тэжээл: 1) Бэлчээрийн шим тэжээлийн сургалт, 2) Зуднаас урьдчилан сэргийлэх (хашаа хороо барих, хадлан бэлтгэх, өвөлжөө зэрэг)	Бэлчээрийн менежмент: 1)Бэлчээрийн сэлгээний талаах ойлголт, 2)Тэжээллэг өвсийг ялгах арга, 3) Бэлчээрийн хүчин чадал даац, 4) Бордоо нэвтрүүлэх зэрэг	Экологийн боловсрол: 1) Цаг уурын өөрчлөлт болон дэлхийн дулаарал 2) Хээр талын цөлжилт, хуурайшилт зэрэг	Цаг агаар газар зүйн мэдээлэл: 1) бүс нутгийн хур тунадас, цагагаарын мэдээ, 2) Өвлийн цаг агаар, зуд, гамшгийн тухай мэдээлэл, 3) Бэлчээрийн тухай мэдээлэл зэрэг
Малын халдваргүйжүүлэлт : 1) Вакцинжуулалт, 2) эмийн хэрэглээний стандарт, 3) Бараа татах үеийн ойлголт ²⁰ зэрэг	МАА арчилгаа: 1) стресс, бүтээмж, 2) Хашаа доторх малын тоо, 3.)Нядалгааны арга, махны чанарын өөрчлөлт зэрэг.	Зах зээлийн мэдээлэл: 1) улс орон даяарх хэд хэдэн зах зээлийн арилжааны үнэ ханшийн мэдээлэл, 2) МАА бүтээгдэхүүн экспортын мэдээ, мэдээлэлийг түгээх	• Бусад: Бүс нутаг бүрийн мэдээлэл, харилцаа холбоо, зам тээврийн талаарх мэдээлэл

Эх сурвалж: ЖАЙКА-ийн судалгааны баг

(ii) Малын чанарыг сайжруулах төлөвлөгөө (ямаа, саалийн үнээ):

Монголын тал хээрийн мал нь он удаан жилийн турш байгалийн ширүүн орчинд дасан зохицсон мал сүрэг бөгөөд энэ нь маш том давуу тал мөн. Гэвч нөгөөтэйгүүр ашиг шимийн гарц илэрхий бага байдаг. Цаашид ашиг шимийн гарцыг нэмэгдүүлэх нь зүйтэй гэдэг нь хүснэгт 5.3.1-с тодорхой харагдаж байна. Дээр дурдсан дасан зохицсон гэх давуу талыг цаашид ч тогтвортой хадгалан, ашиг шимийн гарцыг сайжруулах шаардлагатай болох ба ялангуяа сайжруулах шаардлага хамгийн ихтэй нь ямаа болон саалийн үнээ юм. Жишээ нь ямааг ноолуур авахын тулд тоо толгойг нь өсгөдөг талаар өмнө нь тэмдэглэсэн тиймээс тоо толгойг нь нэмэгдүүлэхгүйгээр ашигтай байх чиглэлээр сайжруулах нь зүйтэй. Энэ утгаараа Монголын ямаанд сүүлийн жилүүдэд шилж үржүүлэг явуулаагүй учир ноолуурын чанартай холбоотой удмын өөрчлөлт ихтэй гэсэн илтгэл байсан. (Restall, 2001²¹ Nomura, 2009²²) Энэ нь харьцангуй хялбар шилэх үйл явцаар ямааны чанарыг сайжруулах боломжтойг харуулж байна. Ингэснээр Монголын ямааны өсөлтийг бууруулах боломж бий болох бөгөөд тун үр дүнтэй технологийн дэд бүтцийн төлөвлөгөө гэж үзэж байна.

²⁰ Сүүлийн жилүүдэд малчид вакцин, антибиотик зэрэг хүчтэй эм тариаг ихээр хэрэглэх болсон бөгөөд вакцин хийснээс хойших баримтлах ёстой хугацааг баримтлахгүй мах бэлтгэх тохиолдлууд ихээр гарч байгаа. Хавсралт 2.6.1: Монголын МАА холбогдох мэдээлэл, 2. Дотоодын мал амьтны эрүүл ахуйн талаарах судалгаа, хөдөө орон нутгийн мал амьтны эрүүл мэндийн тогтолцоо бодит байдал (вакцин тарилгын байдал)-ын хэсгээс харна уу. Эдгээр асуудлуудаас хархад малчидыг мэдээлэл сурталчилгааг хийх шаардлагатай.

²¹ Restall, B. J. 2001. USAID cashmere breeding program evaluation; Mongolia. USAID.

²² Номура. 2009. Ази дахь ямааны генийг судлахуй. Шинэ бодит шинжлэх ухаан сэтгүүл 9: 3-5.

(iii) Худаг сайжруулах төлөвлөгөө

Нэгдэл задарснаас хойш, ашиглалт хангалтгүй худгийн тоо олширч, малын тоо толгой хэт өссөн тул энэ асуудал туйлын чухал. Түүнчлэн, энэхүү төлөвлөгөөг хэрэгжүүлснээр, газрын гүний усны тогтвортой ашиглалт, хяналтын арга барилыг бий болгох асуудлыг давхар шийдэх боломжтой. Монгол улс нэг хүнд ногдох усны хэрэглээ жилд 10,000 m³ гэсэн өндөр хэрэглээтэй, өргөн уудам нутаг дэвсгэр болон хүн ам цөөн тул усны нөөц баялаг ихтэй мэт боловч, бодит байдалд хэрэглэгдэх усны хэмжээ тун бага хязгаарлагдмал байдалтай байдаг²³. Хэт хуурай Монголд жилийн дундаж хур тунадасны хэмжээ 220 мм төдий л байдаг, түүний 90% нь ууршиж алга болдог байна. Үлдсэн 10% ийг гол мөрөн, нуур зэрэг гадаргын усанд 6.3%, гүний усанд 3.7% гэж хувааж үзэж болох ч гадаргын усны гол мөрөнд шингэсэн усны ихэнхи нь цутгалаа даган хил даван хөрш орнууд луу урсах хэмжээ их, дотоодод үлдэх хэрэглээний усны хэмжээ нь хур тунадасны зөвхөн 3-4% байдаг²⁴. Гэхдээ, гол мөрөн, нуурууд жилийн хагасд нь хөлдүү байдаг тул ашиглах боломжгүй. Иймд Монголд хүн, малын аль аль нь гүний уснаас хараат байдалтай, хүн амын 99% нь гүний усыг хэрэглээндээ ашиглаж байна²⁵. Гэтэл гүний ус мөн адил орон нутгаас шалтгаалан усны хэмжээ болон чанар харилцан адилгүй, нарийн судалгааг дараагийн судалгаанд найдан орхисон судалгаа олон (2007²⁶ ; 2013²⁷) , үүнээс үзэхэд үр дүнтэй, тогтвортой ашиглалтыг хянах тухай хууль батлуулах хэрэгтэй. Өмнө дурдсанчлан, Монгол улсын нутаг дэвсгэрийн 80% нь хээр тал, энэ байдал нүүдлийн мал аж ахуйг сууриа болгосон малчдад малын тэжээл талаас гайхалтай нөхцөл боловч, малаа услах усны нөөц талаас үзэхэд энэ байдал эсрэгээрээ байна. Өөрөөр хэлбэл, дотоодын дийлэнх усны нөөц (ойрол. 70%) нь нийт гадаргын ойролцоогоор 30%-д төвлөрсөн байдалтай байгаа бөгөөд, цаашилбал гүний усны чанар говийн бүс зэрэг минерал болон минерал давслаг бодис ихээр агуулсан чулуужсан ус ихтэй, унданд тохиромжгүй²⁸. Бодит байдалд тогтмол ашиглагдах хээр талын хэмжээ цаашид буурах хандлагатай, эдгээрээс үзсэн ч тогтвортой ашиглалтыг хянах тухай хууль болон худаг тохижуулах төсөл маш ихээр шаардагдаж байна.

²³ Ministry of Environment and Green Development. 2013. Integrated water management plan: Mongolia. Ministry of Environment and Green Development. Mongolia.

²⁴ Altansukh, N. 1995. Mongolia: country report to the FAO international technical conference on plant genetic resources. FAO.

²⁵ Ministry of Environment and Green Development. 2013. *Op. cit.*

²⁶ Барилгын технологийн хүрээлэн, Олон улсын судалгаа хамтын ажиллагааны нийгэмлэг, Тоёо хөгжлийн консалтант, Барилгын технологийн олон улсын хүрээлэн . 2007. 2006 оны хөгжиж буй улсуудын хүрээлэн буй орчныг хамгаалах дэмжлэг төслийн урьдчилсан бодит боломжийн судалгаа : [Монгол улс, Хэрлэн голын урсгалыг өөрчлөх талаарх судалгаа].

²⁷ Ministry of Environment and Green Development. 2013. *Op. cit.*

²⁸ Janchivdorj, L. 2012. Ground water governance in Mongolia. International regional consultation on groundwater governance in Asia and the Pacific region.

(iv) **Шүлхийн вакцин үйлдвэрлэл**

Монгол улсад шүлхий өвчний хяналт чухал асуудал бөгөөд, шүлхийн вакцин энэ өвчинтэй тэмцэх гол арга хэрэгсэл юм. Гэтэл Монголд одоогийн байдлаар шүлхийн вакцин үйлдвэрлэх боломжтой үйлдвэр алга. Өөрөөр хэлбэл, импортоор авч хэрэглэдэг. ОХУ аас импорлодог бөгөөд 1 хайрцаг нь 1,100М төг (≈ 0.55 ам.дол) байна. 1 хайрцаг нь 1 үхэр, хонь ямаа бол 4 толгойн тун бөгөөд, энэ үнэ нь их үнэтэй биш ч, Монгол шиг олон малтай, шүлхий шиг сэрөвар ихтэй, олон төрлийн вакцин шаардлагатай халдварт өвчин их гардаг тохиолдолд, дотооддоо үйлдвэрлэж чаддаг байх нь давуу талтай гэдэг нь тодорхой билээ. Энэ асуудлаар Монголын малын эмч нарын холбоотой ярилцахад, холбооны ерөнхийлөгч "Аль болох хурдан дотооддоо вакцин үйлдвэрлэх тоног төхөөрөмжтэй болох хэрэгтэй" гэж байсан.

3) **Бизнесийн нөөц бололцоо**

Доор дурдсан зүйлүүд, бүгд судалгааны явцад уулзаж ярилцсан Монголын талын мэргэжилтэн, холбогдох хүмүүсээс гаргасан шинэ санаанууд юм. Үүн дотор аль хэдийн хийж туршсан, саад бэрхшээлтэй тулгарсан эсвэл урд нь зах зээлд байр суурь эзэлж байсан нь ч бий, эдгээр нь бүгд арга барилаас шалтгаалан, "**шинэ нэмүү өртгийн гинжин хэлхээг бий болгох**" той уялдуулан хөгжүүлэх боломжтой тул, судалгааны явцад тодруулсан зүйл дээрээ тулгуурлан хэдэн санал зөвлөмж дэвшүүлж байна.

(i) **Халал мах**

Энэхүү бүтээгдэхүүний талаар Махны холбоо болон мах үйлдвэрлэгч нартай санал солилцох боломж олдсон. Социалист нийгэм задарсны дараа, Монголын махны экспорын хэмжээ буурсан хэдий ч Ойрхи дундад зэрэг хонины махны эрэлт хэрэгцээ ихтэй ислам шашинтны бүс нутаг руу хийдэг экспорт үргэлжиж байсан байна. Үүнд, Иран луу гаргадаг махны хэмжээ хамгийн их, 2010 онд 2000 тонн гаруй хонины мах экспортлосон байна²⁹. Түүнчлэн махны үйлдвэрт "Монголд ч ислам шашинтай казак үндэстэн амьдардаг, манай үйлдвэрт ч казак ажилчид байдаг болохоор халал аргаар мах боловсруулах боломжтой" гэж байсан. Гэвч тээврийн зардал өссөнөөс гадна экспорт, импортын бүрдүүлэлт хүндрэлтэй болсноос шалтгаалан 2013 оноос хойш бараг гаргаагүй байна. Гэхдээ Монголын хувьд хонь, ямааны махны зах зээлээ олно гэдэг нь малын тоо толгойг хэт өсгөхөөс сэргийлэх үүднээс ч туйлын үр ашигтай тул халал махны экспортыг нэмэгдүүлэх хэрэгтэй. Жишээлбэл, Японд ердийн Япончуудын хонь, ямааны махны хэрэглээ бага ч, өнгөрсөн жил Японд амьдарч буй ислам шашинтаны тоо

²⁹ Монголын Гаалийн Ерөнхий газрын статистик мэдээлэл

өсөж, Японд ислам шашинтны зах зээл 54 тэрбум иен байгаа тухай судалгаа гарсан байна³⁰. Тиймд энэхүү Япон дахь ислам шашны зах зээлийг онилсон бизнес хийх боломжтой гэж үзэж байна.

(ii) **Арьс шир, нэхмэл (ноолуур, сарлаг болон тэмээний ноос)**

Энэ удаагийн судалгаагаар, Монголын арьс ширний холбоо, Ноосны холбоо, Ноос, ноолуурын холбооны удирдлагуудтай удаа дараалан уулзаж ярилцсан, бүгд л экспортыг нэмэгдүүлэх хүсэлтэй байгаа илэрхийлсэн. Үүнд, ноолуур нь ямааны аж ахуйн тогтолцоо болон тоо толгойн өсөлт өсөлттэй холбоотой асуудал олон боловч түүхий эдийн хувьд аль хэдийнэ зах зээлээ олсон бүтээгдэхүүн болно. Гэвч арьс шир болон бусад нэхмэлийн хувьд хараахан зах зээлээ олж авч чадаагүй байдалтай байна. Сарлаг болон тэмээний ноос ховор үнэ цэнэтэй зүйл учир малчдын гар дээрээс авах хонины ноосны үнэтэй харьцуулбал харьцангуй өндөр үнэтэй байдаг³¹ мөн гарт мэдрэгдэх байдал болон гадаад үзэмж нь ч онцлог учир бусад бүтээгдэхүүнтэй харьцуулахад боломж өндөртэй бүтээгдэхүүн (зураг 5.2.3) хэмээн үзэж байна.



3: Сарлагийн ноос (ноосны холбоо)



4: Тэмээний ноос (Ноосны холбоо)

Эх сурвалж : ЖАЙКА-ийн судалгааны баг

Зураг 5.2.3 Сарлаг болон тэмээний ноос

(iii) **Яс, цус, өөх, гэдэс дотор, өтөг бууц**

Эдгээр бүтээгдэхүүний талаарх саналууд дийлэнхдээ махны үйлдвэр болон мах бэлтгэлийн газруудаас гаргасан зүйл болно. Аль ч бүтээгдэхүүний хувьд их хэмжээгээр гардаг боловч үр ашигтайгаар ашиглаж байгаа гэж хэлж болохооргүй байдалтай байна. Мөн Монголын худалдаа аж үйлдвэрийн танхимын хэлж байгаагаар ялангуяа цус болон гэдэс дотрыг ашиглах тухайд

³⁰ Танака, 2014. Өргөжин тэлж буй халалын зах зээлийн өнөөгийн байдал, Brand Research Institute, Inc.

³¹ Нэг килограмм тутмын үнэ нь хонь 800-900 төг. ($\approx 0.40 \sim 0.45$ ам.доллар), сарлаг 1500 төг. (≈ 7.5 ам.доллар), тэмээ 6000-7000 төг ($\approx 3.0 \sim 3.5$ ам.доллар) гэсэн ханштай. Ноолуурын 2015 оны дундаж ханш 65.000 төг (32 ам.доллар). (Ноосон бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн холбооны мэдээлэл)

тэжээлийн зориулалтаар дахин ашиглаж болох эсэх талаар санал гарсан. Нөгөөтэйгүүр эдгээр түүхий эдүүдэд зах зээлийн үнэ цэнэ байгаа эсэх дээр мэдээлэл цуглуулахад ясны хувьд барилгын материалд ашиглах (Adam, 2002³²), өтөг бууцны хувьд сүүлийн жилүүдэд хүүхдийн багтраа өвчин болон ургамлын гаралтай харшлын эсрэг үр дүнтэй гэгдэж байна (May *et al*, 2012³³; Schuijs *et al*, 2015³⁴). Өөх нь Монголд давуу тал бүхий шинж чанар байгаа бөгөөд бизнес болгож хөгжүүлэх боломжтой юм. Монгол болон төв Азид тархсан хонь нь Япон хүмүүсийн дасал болсон мярнууснаас өөр төрөл бөгөөд өөхөн сүүлт болон илүү нугаламтай хонины төрөлд багтдаг. Энэ хонь нь нэртэйгээ адилаар сүүл, ууцандаа өөх ихээр хуримтлуулдаг нь онцлогтой хонь юм (Зураг 5.3.5-6). Малчид эртнээс энэхүү өөхийг хоол хүнсэндээ хэрэглэхээс гадна саван зэрэгт ашигладаг байсан гэдэг. Сүүлийн үеийн тайлангаар энэхүү өөх нь артерийн судасны хатуурлаас урьдчилан сэргийлэх үйлчилгээтэй гэсэн мэдээлэл хүртэл байна. (Цүнода 2010³⁵). Улмаар эрүүл мэнддээ ихээр анхаардаг Япон хүний хувьд ч хэрэглэх үнэ цэнэ өндөр гэж үзэж байна.



5: Өөхөн сүүлт хонь



6: Өөхөн сүүлт хонины мах

Эх сурвалж : ЖАЙКА-ийн судалгааны баг

Зураг 5.2.4 Хонины өөх

(iv) Казейн:

Казейн нь сүүнд агуулагдах хатуу уурагны нэг төрөл бөгөөд сүүн дахь уургийн ихэнхийг эзлэх бөгөөд бидний өдөр тутам хэрэглэдэг бяслаг, тарагны үндсэн найрлага хэсэг юм. Энэхүү казейныг будагт ашиглагддаг бөгөөд гол түүхий эд нь үхрийн сүүнд агуулагддаг. Энэ удаагийн Монгол

³² Adam, D. 2002. Controversial animal feed builds concrete career in construction. *Nature* **418**: 807.

³³ May, S., Romberger, D. R., and Poole, J. A. 2012. Respiratory Health Effects of Large Animal Farming Environment. *J Toxicol Environ Health B Crit Rev* **15**: 524–541.

³⁴ Schuijs, M. J., Willart, M. A., Vergote, K., Gras, D., Deswarte, K., Ege, M. J., Madeira, F. B., Beyaert, R., Loo, G., Bracher, F., Mutius, E., Chanez, P., Lambrecht, B. N., and Hammad. H. 2015. Farm dust and endotoxin protect against allergy through A20 induction in lung epithelial cells. *Science* **349**: 1106-1110.

³⁵ Цүнода 2010 он, Малын үүлдэр, угсааг сайжруулалтын дэлхийн түүх, бүлэг: Мал/Хонь, редактор Шёода Ёичи, Юүшёкан хэвлэл

дахь судалгаагаар энэхүү сэдвийг хөндсөн нь Японы хөрөнгө оруулалттай компани байсан юм. Японд казейныг хэвлэлийн будагт ашигладаг бөгөөд дотоодын хэрэгцээний үхрийн сүүний дийлэнхийг хүнсэнд хэрэглэдэг учир нийлүүлэлтийг гадаадын импортонд тулгуурлаж байна. Одоогоор Австрали, Шинэ Зеланд, Нидерланд, Франц голлох үйлдвэрлэгч орон юм. Үнэ өндөр буюу нэг тонн нь 7.000-10.000 ам доллар хүрдэг бүтээгдэхүүн бөгөөд тус компани шинэ түүхий эд нийлүүлэлтийн зах зээл нээхийн тулд Монголд судалгаа хийсэн байна. Гэвч Монголын казейн нь тус бүр өнгө харилцан адилгүй, бүтээгдэхүүний үнэ цэнэ бага гэж үзсэн байна. Гэсэн хэдий ч казейны шинэ нийлүүлэлтийн орон хэрэгцээтэй хэвээр байгаа гэсэн тайлбар өгсөн юм. Тиймээс цаашдаа сүүний чанарыг сайжруулах асуудлыг шийдэж чадахуйц сүүний үйлдвэрлэлийн салбарыг хөгжүүлж чадвал түүнийг дагаж чанар жигдрэх учир дахин Монголд шинэ бизнес бий болох боломжтой.

(v) **Сүү сүүн бүтээгдэхүүн (сарлаг, ингэний сүү)** ³⁶

Монголын сүү судлалын шинжлэх ухааны холбооны тэргүүн энэ талаар хэлэхдээ Монгол үхэр бэлчээрээр маллагаатай учир сүү нь цэвэр байгалийн, оригинал бүтээгдэхүүн болохоор үнэ цэнэтэй байдаг. Тэр дундаа сарлаг болон ингэний сүү ховор, үнийн хувьд ч үнээний сүүтэй харьцуулахад үнэтэй байдаг. Сүү судлал шинжлэх ухааны холбоо нь сүүний худалдаа эрхэлдэг ба малчдаас сүүгээ нийлүүлж зуны улиралд сүүний үнэ нэг литр тутамд 400 төгрөг (≈ 0.2 ам.доллар), сарлаг 700 төгрөг (≈ 0.35 ам.доллар), ингэний сүү 2000 төгрөг (≈ 1 ам.доллар) байдаг. Мөн ямааны сүү нь үнээний сүүнээс өндөр үнэтэй байдаг ба нэг литр нь 600 төгрөг (≈ 0.3 ам.доллар) байдаг. Монголд ажиллах хугацаандаа ингэний хоормог ууж үзэхэд маш исгэлэн амттай, уухад амар санагдаагүй ч Монголчууд ингэний хоормогийг эрүүл мэндэд тустай гэж хэрэглэдэг. Магадгүй энэ өнцгөөс нь харж туршиж үзэж болох талтай.

(vi) **Монголын таван хошуу малаас бусад аж ахуйн боломж (гахай, тахиан аж ахуй)**

Монголд таван хошуу малаас бусад аж ахуйн эзлэх хэмжээ маш бага. Гэхдээ хот суурин газрын өндөг болон гахайн махны хэрэгцээ их учир гахай, тахиан аж ахуй бодитойгоор хөгжиж байна. Эдгээр аж ахуй дотор тус судалгаанаас дэвшүүлж буй “Эдийн засгийн тусгай бүс”-д зохицох үйл ажиллагааны хэмжээ, бүтэц зохион байгуулалттай газрууд байгаа, иймэрхүү байгууллагатай технологийн тал дээр хамтран ажиллах боломжийг судлах хэрэгтэй (Зураг 5.2.5-ын 7.8). Мөн жижиг хэмжээтэй ч хот суурин газрын

³⁶ Хувийн томоохон сүүний фермерүүдийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг хавсралт 5.2.1: Монголын МАА тухай нөхцөл байдлын мэдээ, Томоохон фермерийн мэдээний нэгтгэлийн хэсгийг харна уу.

ойролцоо шинэ аж ахуйн загварууд бий болсоор байна. Монголын зүүн захын аймаг болох Чойбалсан хотод хот суурин газрын жижиг хэлбэрийн гахайн аж ахуй, бөднө шувууны өндөгний аж ахуй үйл ажиллагаа явуулж байгаа. (Зураг 5.2.5-ын 9.10). Ийм төрлийн аж ахуй нь хот суурин газрын суурьшмал амьдарлыг сонгосон малчид эрхлэх боломжтойгоос гаднах маллах амьтныг төрөлжүүлэхэд анхаарч үзэх ёстой зүйлийн нэг юм.³⁷



7: Орчин үеийн том хэмжээний өндөгний чиглэлийн шувуун ферм



8: Гахайн ферм



9: Бага оврын гахайн ферм



10: Бөднө шувууны өндөг

Эх үүсвэр: ЖАЙКА-ийн судалгааны баг

Зураг 5.2.5 Таван хошуу малаас бусад аж ахуй

(2) Газар тариалан, боловсруулах салбар

Газар тариалан, боловсруулах салбарын хөгжилд "Монгол маягийн шинэ хүнсний нэмүү өртгийн гинжин хэлхээ бий болгох"ыг санал болгон, дараах байдлаар бүсчилсэн хөгжлийн стратегийг зөвлөмж болгож байна.

【Зөвлөмж 1】 Ганд тэсвэртэй улаан буудайн сорт бий болгох, үржүүлж, нэвтрүүлэх

【Зөвлөмж 2】 Тариалангийн үйлдвэрлэлийн бүтээмжийг нэмэгдүүлж, чанарыг сайжруулах (улаан буудай болон хүнсний ногооны тариалалт)

【Зөвлөмж 3】 Усалгааны систем сайжруулах

³⁷ Дэлгэрэнгүй мэдээллийг хавсралт 5.2.1: Монголын МАА тухай нөхцөл байдлын мэдээ, тухайн бүс нутагт тохирсон Монголын таван хошуу мал бусад аж ахуйн тухай мэдээний нэгтгэлийн хэсгээс харна уу.

【Зөвлөмж 4】 ХАА-н агро технологийг дахин сэргээх (зах зээлийн эдийн засагт шилжихээс өмнөх газар тариалангийн технологийг сэргээх)

【Зөвлөмж 5】 Агро бизнесийг сэргээж (экспортын чиг баримжаатай), газар нутгийн онцлогт тохирсон таримал ургамлыг тарьж, орон нутгийн хөгжлийг дэмжих



Эх сурвалж: ЖАЙКА-ийн судалгааны баг

Зураг 5.2.6 Монгол маягийн хүнсний нэмүү өртгийн гинжин хэлхээ

1) 【Зөвлөмж 1】 Ганд тэсвэртэй улаан буудай сорт бий болгох, үржүүлэх, нэвтрүүлэх

2015 оны 5-аас 7 дугаар сарын хооронд хур тунадас бага орсноос болж ган болсон. Ган болсон шалтгааныг өвс ногооны гарц өмнөх жилүүдээс эрс багасаж, үр тарианы болц оройтсоноос гадна Монголын уур амьсгалд тохирохгүй импортын үр тариалснаас болсон гэж үзэж болох юм. Өнгөрсөн онд 389,300 га-д тариалалт хийж 265,000 тонн ургац хурааж авсан нь өмнөх оныхоос 46 хувь буурсан үзүүлэлт юм. Ийнхүү дотоодын гурилын нийлүүлэлт буурсан тул дотоодын хэрэгцээний 30 хувийг эзлэх 100,000 тонн гурил ОХУ-аас импортлох болсон байна. Эдгээр нөхцөл байдлаас үзэхэд цаашид Монголын уур амьсгалд тохирсон ганд тэсвэртэй шилдэг буудайн сортын үр гарган авч, түүнийгээ үржүүлж, тариаланчдыг сайн үрээр хангах тогтолцоог бий болгох шаардлагатай байна.



Эх сурвалж : ЖАЙКА-ийн судалгааны баг

Зураг 5.2.7 Улаан буудайн тариалалтын талбай (2015 он)


2) 【Зөвлөмж 2】 Тариалангийн үйлдвэрлэлийн бүтээмжийг нэмэгдүүлж, чанарыг сайжруулах (улаан буудай, хүнсний ногооны тариалалт)

Улаан буудайн ургацын хэмжээ цаг агаарын өөрчлөлтөнд эмзэг, ган зэрэг гамшигт өртөхөд хялбар, ган болоход ургацын хэмжээ буурдаг байна. Байгалийн усалгаатай тариалангийн талбайд үр суулгах, ургац хураахаас бусад үед шаардлагатай арчилгааг хийдэггүй байдалтай байна. Иймд усны нөөцийг ашиглаж бүтээмж, чанарыг сайжруулахаас гадна тариалалтын явцад хянах хяналтын технологийг нэвтрүүлэх шаардлагатай байна

Хүнсний ногооны тариалалтад шинэ тоног төхөөрөмж, технологи нэвтрүүлж бүтээмж, чанарыг сайжруулах хэрэгтэй байна.

3) 【санал 3】 Усалгааны систем сайжруулах

Монголын бүхий л нутаг дэвсгэрийг хамарсан жилийн дундаж хур тунадасны хэмжээ 280 мм байдаг. Газар тариалангийн голлох нутгуудаар ч жилдээ дунджаар 400-500 мм хур тунадас ордог. Гэтэл усалгаатай тариалалт эрхлэх боломжтой талбайн хэмжээ нийтдээ 52,000 га байдаг нь ган болох эрсдэл өндөр улсын хувьд тун бага үзүүлэлт бөгөөд даруй яаралтай арга хэмжээ авах шаардлагатай. 2010 оноос “Ус” үндэсний хөтөлбөрийг усалгаатай тариаланг хөгжүүлэх зорилгоор хэрэгжүүлж байгаа бөгөөд хөтөлбөрийн хүрээнд усалгаатай тариалалт эрхлэх боломжтой тариалангийн талбайг нэмэгдүүлэх арга хэмжээ авч усалгаатай талбайн хэмжээг 2016 онд 80,000 га, 2020 онд 100,000 га хүргэх зорилттой ажиллаж байна. Тариалангийн аж ахуйг хөгжүүлж усалгаатай талбайн хэмжээг нэмэгдүүлэх улсын төлөвлөгөөг харгалзан усалгаатай тариаланг эрчимтэй хөгжүүлэх шаардлагатай байна.



Эх сурвалж : “Strengthening Integrated Water Resources Management in Mongolia” 2012

Эх сурвалж : Газрын харилцаа, геодези зураг зүйн газар

Зураг 5.2.8 Усны нөөц хэмжээ

Зураг 5.2.9 Газар тариалан хөгжүүлэх төлөвлөгөөтэй газар

Зураг 5.2.8 болон 5.2.9-т хур тунадасны хэмжээ болон газар тариалан хөгжүүлэх төлөвлөгөөтэй газруудыг дээрх зурагт харуулсан. Хур тунадасны хэмжээ ихтэй нутгуудад газар тариалан түлхүү хөгжих хандлагатай байна

Тариаланг эрчимтэй хөгжүүлэх төлөвлөгөөний дагуу улсаас сонгосон нутаг дэвсгэрт зарим аж ахуйн нэгж услалтын байгууламж шинээр байгуулах эсвэл засварлахаар төлөвлөж буйг дараах зураг 5.2.10-т тусгав.



Эх сурвалж : ХХААЯ, Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийн газрын мэдээлэлд тулгуурлан ЖАЙКА-ийн судалгааны баг боловруулав

Зураг 5.2.10 Усалгаат байгууламж хөгжүүлэх санал болгох санал

4) **【Зөвлөмж 4】** Агро технологийг сэргээх (Зах зээлийн эдийн засагт шилжихээс өмнөх газар тариалангийн технологийг сэргээх)

Зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд шилжихээс өмнө улсын эрдэм шинжилгээний байгууллага, сангийн аж ахуйд туршин хэрэгжүүлж байсан шинэ технологи санаачлах судалгааны туршлага нь зах зээлд орсноос хойш тасарсан билээ. Эдгээр үр ашигтай технологийг дахин нягталж бүс нутгийн онцлогт тохирсон нутгийн онцлогт бүтээгдэхүүн тариалалтад ашиглах хэрэгтэй байна. Үүнийг ялангуяа, импортыг орлох газар тариалангийн бүтээгдэхүүн тариалахад ашиглах нь зүйтэй.



Эх сурвалж : ЖАЙКА-ийн судалгааны баг

Зураг 5.2.11 Агро технологийг сэргээх

5) **【Зөвлөмж 5】** Агро бизнесийг сэргээх (экспортын чиг баримжаатай) нутгийн онцлогт бүтээгдэхүүн тариалах, гарал үүслийг тодорхойлох замаар орон нутгийн хөгжлийг дэмжих

Нутгийн онцлогт бүтээгдэхүүн болгох бизнесийн боломж өндөртөйд 1) Чацаргана, 2) Байгалийн цэвэр зөгийн бал, 3) Чихэр өвс (үндэс,) , 4) Гурвалжин будаа

Ялангуяа, чацаргана болон зөгийн балын тухайд Монгол Японы эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр (ЕРА) батлагдсанаар, гаалийн татвараас чөлөөлөгдөх бараа бүтээгдэхүүний жагсаалтанд орсон бөгөөд, дотоодын хэрэгцээг хангахын сацуу экспортлох бүрэн боломжтой бүтээгдэхүүн юм.



Эх сурвалж : ЖАЙКА-ийн судалгааны баг

Зура 5.2.12 Бизнесийн боломжтой бүтээгдэхүүнүүд

Тухайлбал Япон улсад гурвалжин будааны дотоодын нийт үйлдвэрлэлтийн хэмжээ 33,000 тонн, импортын хэмжээ 95,000 тонн байдаг бол нийт дотоодын хэрэглээ нь 141,000 тонн байдаг. 2013 онд дотоодын үйлдвэрлэлээр дотоодоо хангасан байдал 23% байсан. Импортлогч улсуудаас дурдвал Хятад 80%, Америк 7%, Канад 3% байна. Хятад улсаас импортын хамаарал өндөр байгаа хэдий ч, нэг улсаас хамааралд орох нь цөөхөн улсын импортын хамааралд байдаг гурвалжин будаагаар хангах систем нь дотоодын хэрэгцээгээ хангахад ихээхэн тогтворгүй байдалд байгаа. Монгол улс нь шинэ импортлогч болон нийлүүлэгч орон болно гэж найдаж байгаа.

Бизнесийн боломжтой 4 бүтээгдэхүүний “онцлог”, ”Японы зах зээлийн өнөөгийн байдал”, “боломжит бизнесийн санаа”, “Анхаарах зүйл, хориг цээр”-ийн талаар дор хүснэгт 5.2.2 дурдав.

Хүснэгт 5.2.3 Бизнесийн боломжтой 4 бүтээгдэхүүний онцлог, хориг цээр

	Чацаргана	Байгалийн зөгийн бал	Чихэр өвс	Гурвалжин будаа
Онцлог	Боловсорсон жимсэнд олон төрлийн витамин эрдэс бодис амино хүчил зэрэг шим тэжээлээр баялаг, мөн антиоксидант үйлчилгээтэй.	Балт ургамлаар баялаг, дээд чанарын, тал хэрийн байгалиас гарган авсан зөгийн балны бүтээгдэхүүн үнэ цэнэтэй.	Антитассив (ханиадны эм), Анальгин (Өвчин намдаагч), Антипассмодик (саажилтын эсрэг эм)(тайвшруулагч) хор тайлагч зэрэг уламжлалт эмийн найрлаганд ордог чухал эмийн ургамал	Шим тэжээлээр баялаг эрүүл мэндийн хүнс юм.
Монгол улсын бодлого	“Чацаргана хөтөлбөр” (I Шат) : 2010-2012 он (II Шат) 2013~2016 он	Зөгийн бал үндэсний хөтөлбөр (төслийн санал)	Байхгүй	Байхгүй
ЕРА: Татварын хнгөлөлт	Шууд болон үе шатлалтайгаар татварыг бууруулах Шинэ жимс, ургамлын гаралтай тосны төрөл (татварын хөнгөлөлт 5-15 жил) хөлдөөсөн жимс, ханд, чанамал, царцаамаг, жүүс зэрэг.	Татварын хөнгөлөлттэй: Хөнгөлөлтийн хэмжээ 1тн (эхний жил) 1,5тн (зургаа дахь жил) татварын хувь хэмжээ: 12,8% (50% хөнгөлнө)	Зорилтог бүтээгдэхүүнд хамрагдахгүй	Зорилтог бүтээгдэхүүнд хамрагдахгүй
Японы зах зээлийн потенциал	30-40 сая иен, хятад чацаргана 20 сая иен. Япон улсад жүүс 70-80%, тос 10-15%, гоо сайхны бүтээгдэхүүн 5%	Дотоодын түгээлтийн хэмжээ 42000 тн. Дотоод дахь дотоодын бал үйлдвэрлэлийн хэмжээ 2800 тн байдаг ба импортын балны хэмжээ ойролцоогоор 39000 тн. Импортын бал нийлүүлэгч Хятад 77%, Аргентин 8%, Канад 6%, Мьянмар 3% байдаг. 2013 он	Эрэлт жилд 1500 тн орчим (230 сая иен) . Чихэр өвсийг Японд тариалдаггүй ба Хятадын импорт 70% дээш. Япон эмийн журамд найрлаган дахь глицерины хэмжээ 2,5%-с дээш байх шаардлагатай гэж заасан байдаг.	Дотоодын үйлдвэрлэлийн хэмжээ 33000 тн. Импортын хэмжээ 95000 тн. Хэрэглээний хэмжээ 141000 тн орчим : 2013 оны дотоодын зах зээлээ хангах 23%, Импортологч орон Хятад, 80%, Америк 7% Канад 3% орчим
Боломжжит бизнесийн санаа	Японы зах зээл дахь маркетингийг сайжруулж, экспортын хэмжээг нэмэгдүүлэх зорилготой.	Дотоодын эрэлт ханасан (импортын) Жуулчдад зориулсан бэлэг/ брэнд бүтээгдхүүн болгон экспортлох импорт орлох	Цаашид тариалалтын технологийг сайжруулж экспортлох.	Улаан буудайн төрөл болгон тариалалтын хэмжээг нэмэгдүүлэн Япон улс руу экспортлох
Анхаарах зүйл, хориг цээр	Монгол чацарганыг хятадын чацарганатай харьцуулахад чанар сайтай боловч, маркетинг муу.	Үйлдвэрлэлтийн явцад гардаг хачиг, зэрэг өвчнөөс урьдчилан сэргийлэх	Байгалийн чихэр өвсний экспорт хориотой. (Тариалсан чихэр өвс экспортлох боломжтой.)	Монголоос Япон руу экспортлох маршрут тодорхойгүй.

Эх сурвалж : ЖАЙКА-ийн судалгааны баг

(3) Хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний (шинэ хүнсний бүтээгдэхүүн) зах зээл бий болгох

Социализмын үед төлөвлөгөөт эдийн засагт суурилсан тогтвортой зах зээл, нийгмийн хангамж баталгаа зэргээг ХАА-н салбарыг дэмжсээр ирсэн. Харин зах зээлийн эдийн засагт шилжсэнээр нэгдэл задарч нэгдлийн мал хувьчлагдсан. ЭЗХТЗ-ын тогтвортой зах зээл нуран унаснаар ХАА-н салбарыг түшиглэж байсан хөдөө орон нутаг ядуурал газар авсан.

Энэхүү туршлагаас харахад жижиг хэмжээний ХАА-н бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн орлогыг сайжруулахын тулд ургац хураалтын хэмжээг нэгтгэх группын ургац хураалт, мөн хамтын холбоо (нэгдэл) хэлбэрийн ургац хураалт зэрэг тогтоцлоо шаардлагатай гэж үзэж байна.

1) ХАА-н бүтээгдэхүүн зах зээлийн тогтолцоо (шинэ хүнсний бүтээгдэхүүн)

Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг ченж нартай тохиролцон наймаалцах тогтолцооноос олон нийтэд нээлттэйгээр тохиролцон борлуулах боломжтой зах зээлийн системийг нэвтрүүлэх шаардлагатай. Шинэ хүнсний бүтээгдэхүүнийг³⁸ зохистой худалдаа, үйлдвэрлэлт, тээвэрлэлтийг хөнгөвчилөх замаар шинэ хүнсний бүтээгдэхүүний үнийг тогтвортой байлгах зорилготой юм.

(i) Биржийн захын үүрэг, үйл ажиллагаа

Биржийн зах нь дараах үүрэг³⁹, үйл ажиллагаа явуулах хэрэгтэй.

- Бэлтгэн нийлүүлэлт, бараа эргэлт : Бөөний худалдаа эрхлэгчид нийт орон нутгаас бэлтгэгдсэн түүхий эд, барааг дундын агентаар дамжуулан хэсэгчлэн жижиглэнгийн худалдаанд нийлүүлнэ (их хэмжээтэй бараа бүтээгдэхүүнээс бага хэмжээний бараа бүтээгдэхүүнийг шуурхай, найдвартай нийлүүлэх)
- Барааны ханш тогтоох : бөөний худалдаа эрхлэгчдийн ”бирж”-д олон тооны агент оролцсоноор өрсөлдөөний зарчмын дагуу нийлүүлэлтэд нийцсэн, шударга, шуурхай үнэлгээнд тулгуурласан ил тод, оновчтой ханшийг тогтооно
- Үнэ тогтоох: Үйлдвэрлэгчийг барааг түргэн хугацаанд мөнгө болгох (борлуулатын үнэ ханшийг хурдан хугацаанд бодитоор тогтоох)

(ii) Шинэ хүнсний бүтээгдэхүүний зах зээлийн стандарт бий болгох

Шинэ хүнсний бүтээгдэхүүний бараа эргэлтийн асуудал

- Монгол улсад, хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний хадгалалтын нөхцөл муу, холоос тээвэрлэх хүндрэлтэй тул өөрийн хэрэгцээг хангах эсвэл бүс нутгаар хангах хэлбэр дийлэнх болдог
- Хүнсний бүтээгдэхүүний үнэ ханшид томоохон өөрчлөлт гарах буюу үнийн өсөлт нийгмийн асуудал болох бөгөөд, бараа эргэлтийн ”оновчтой байдал”, үнэ ханшийг шударга, ил тод байдлаар тогтоох асуудал зайлшгүй

³⁸ “шинэ хүнсний бүтээгдэхүүн”гэдэгт, хүнсний ногоо, жимс, загас, мах, махан бүтээгдэхүүн зэрэг шинэ хүнсний бүтээгдэхүүнээс гадна хэрэглэгчдийн өдөр тутмын хэрэглээнд нийлүүлдэг хүнсний болон ХАА гаралтай бүтээгдэхүүн орно

³⁹ Зах зээлийн тухай хуулиас

шаардлагатай болж байгаа юм

- Хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний зах зээлийн бүсийг өргөтгөхөд бүтээгдэхүүнийг төрөлжүүлэх, өөргөтгөх зэрэг худалдааны чиглэлийн хөдөө аж ахуйг хөгжүүлэх, гол үйлдвэрлэгч нутгийг бий болгох, тээвэрлэлтийн систем, агуулах зоорьны байгууламжийг сайжруулах ажил шаардлагатай байна.

Тогтвортой нийлүүлэлтийн зах зээлийг улс даяар бүрдүүлэх хэрэгцээ

- Шинэлэг хүнсний бүтээгдэхүүнийг тогтвортой нийлүүлэх, үнэ ханшийг тогтвортой байлгахад бүс нутгаар хязгаарлагддаг зах зээлээс нийт улс орныг хамарсан зах зээл болгон өргөжүүлэх явдал зайлшгүй шаардлагатай
- Нийт улс орон даяар нэгдсэн зах зээлийн арилжааны үнэ тогтоохын тулд, хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний чанар, стандарт зайлшгүй шаардлагатай.
- Стандарт, норм тус бүрээрх үнэ ханшийг нийт улс орон даяар зарлан, хөдөө аж ахуйн зах зээл бий болох болно

Хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнийг стандартжуулах

- Зах зээлийн хамрах бүс нутгийг тухайн орон нутгаас нийт орон даяар болгон тэлж, "тогтсон нэгдмэл зах зээл" томрох тусам, стандарт чухал асуудал болно. Газар тариалангийн бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд ургац хураасны дараа ангилж, стандартжуулах хэрэгтэй. Газар тариалангийн тариалалтын явц байгалийн нөхцөл байдлаас шууд хамааралтай тул чанарыг нэг тогтсон хэмжээнд барина гэдэг боломжгүй ба худалдаа хийхэд чанар болон хэмжээнд тулгуурласан "нэгдсэн байдал" хэрэгтэй. Түүнчлэн хадгалалт, агуулахын боломжоос шалтгаалан түргэн шуурхай тээвэрлэн, зах зээлд нийлүүлэх шаардлагатай
- Хадгалалт, агуулахын боломжоос шалтгаалан түргэн шуурхай тээвэрлэн, зах зээлд нийлүүлэх шаардлагатай.
- Зэрэглэл тогтоосноор үнэ ханш тогтоох болон шилдэг сорт нэвтрүүлэх ажил идэвхжинэ. Япон улсад зэрэглэл шинжилгээ болон зэрэглэлд хамрагдан хэрэглэгчдээс өндөр "итгэл" хүлээсэн стандартын бүтээгдэхүүн нь бусад зах зээл дээрх шинжилгээнд хамрагдаагүй, стандартын бус нэрийн бараанаас харьцангуй илүү үнээр худалдаалагдан, үйлдвэрлэгч орон нутаг хоорондын өрсөлдөөн ширүүсч улмаар шилмэл сорт нэвтрүүлэх

зэрэг эерэг өөрчлөлт их гарсан.

Зах зээлийн нийтийн өмчит менежмент

- Бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлтэнд бичил үйлдвэрлэгчдийг хамруулах, зах зээл дэхь худалдааны шимтгэлийг зохистой болгох, худалдаалах үнэ ханшийг ил тод зарлах зэргээр шудрага өрсөлдөөний зарчим тогтоох, худалдааны шуурхай шийдвэр гаргах функц бий болгох зэрэг нэвтрүүлэх.
- Дээр дурдсан үйл ажиллагааг тогтвортой явуулахын тулд, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэр байгуулан менежментийг хувийн аж ахуйн нэгжид хариуцуулах нь зохистой.

2) Хөдөө аж ахуйн судалгааны хүрээлэн байгуулах

ХАА-н салбарын хувьд үүлдэр, сорт сайжруулах нь бүтээгдэхүүний амт чанар, ургацын хэмжээ, өвчин болон халуун хүйтэнд тэсвэртэй байх зэрэг үйлдвэрлэгч болон хэрэглэгчдийн хүсэн хүлээсэн шинэлэг онцлогтой сорт, үүлдэр гаргаж авах явдал юм. Япон улсын хувьд, Мэйжигийн үеэс шинэ сорт, үүлдэр сайжруулах ажил хийгдэж эхэлсэн. Энэхүү зуу гаруй жилийн турш хуримтлагдсан туршлага, орон даяар орон нутгийн онцлогт бүтээгдэхүүнийг бий болгохын зэрэгцээ дэлхийд гайхагдах амттай бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг болсон билээ.

Монгол улсын судалгаа, шинжилгээний байгууллагууд БСШУЯ-д харъяалагддаг тул судалгаанд гол анхааралаа хандуулан, бодит үйлдвэрлэлд хэрэглэгдэх нь ховор. ХААн салбарыг хөгжүүлэхийн тулд ХХААЯ-ны харьяа судалгааны хүрээлэн байгуулан, бүс нутаг тус бүрт салбар байгуулан, судалгаа, шинжилгээний үр дүнг орон нутаг, бүс нутгийн ХАА эрхлэгчдэд түгээх хэрэгтэй юм.

ХАА судалгааны хүрээлэн дараах 6 гол зорилготой.

- ХАА үйлдвэрлэлийн шинэ сорт, үүлдэр бий болгоно.
- Үр ашигтай үйлдвэрлэлийн технологи хөгжүүлнэ.
- ХАА бүтээгдэхүүний чанарыг алдагдуулахгүй байх технологи бий болгоно.
- Хортон шавьжаас сэргийлэх, өвчинд тэсвэртэй болгох технологи хөгжүүлнэ.
- Өвс хадлан ихтэй, үржил шим сайтай газар боловсруулах технологи бий болгоно.
- Шинээр нээсэн технологийг ХАА эрхлэгчдэд түгээнэ.


5.3 Уул уурхайн гаралтай үйлдвэрлэлийг хөгжүүлэх

(1) Үндсэн санаа

Нүүрсний хувьд, нийт үйлдвэрлэсэн нүүрсний ойролцоогоор 30 хувийг дотоодын хэрэгцээнд ашиглаж байгаа бөгөөд цаашдаа том оврын дулааны цахилгаан станц барих төлөвлөгөө байгаа тул энэхүү хэрэгцээ улам өсөх хандлагатай байна. Бусад уул уурхайн бүтээгдэхүүний хувьд ихэвчлэн экспортод гаргадаг. Жишээ нь, зэсийн хайлш болон төмрийн баяжмалыг нэмүү өртөг шингээж, эдгээртэй холбоотой бусад үйлдвэрлэлийг хөгжүүлэх бодлого барьсан ч дотоодын хэрэгцээ хязгаарлагдмал. Энэ нь дотоодын бусад боловсруулах үйлдвэр хөгжих түлхэц болж чадахгүй байх талтай. Мөн эцсийн бүтээгдэхүүн болох зэс, төмрийн экспортод тээвэрлэлтийн зардал болон экспортлох багтай харилцагч олох нь хүндрэлтэй асуудал юм. Улмаар цаашдаа дотоодын хэрэгцээ нэмэгдэх хандлагатай байгаа нүүрсийг ашиглан нэмүү өртгийн гинжин хэлхээг бий болгох нь аж үйлдвэрийн холбогдох салбарын хөгжилд стратегийн хувьд чухал ач холбогдолтой.

Зураг 5.3.1 нүүрс ашигласан нэмүү өртгийн гинжин хэлхээг бүдүүвчээр харууллаа. Энэ хэлхээ 3 үндсэн бүрэлдэхүүнтэй. Үүнд:

- Нүүрс баяжуулах үйлдвэр байгуулснаар нэмүү өртөг шингээх, хаягдлыг дахин ашиглах нь
- Нүүрснээс хий гаргах, нүүрс шингэрүүлэх үйлдвэр байгуулан эрчим хүчийг төрөлжүүлэх, химийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх
- CBM/UCG ашигласан орон нутгийн эрчим хүч хангамжийн тогтолцоог бүрдүүлэх



Эх сурвалж: ЖАЙКА-ийн судалгааны баг

Зураг 5.3.1 Нүүрс ашиглан нэмүү өртгийн гинжин хэлхээ бий болгох

Эдгээр саналын агуулгыг “Мянганы хөгжлийн зорилтод тулгуурласан Үндэсний хөгжлийн цогц бодлого” дээр үндэслэн 2014 оны 1 сард УИХ-аар батлагдсан “Ашигт малтмалын нөөцийг хөгжүүлэх бодлого /2014-2025/-ын үндсэн чиглэл болон салбар тус бүрийн зааварчилгаатай уялдуулсан⁴⁰.


(2) Нүүрс баяжуулах үйлдвэр байгуулснаар нэмүү өртөг шингээх, хаягдлыг дахин ашиглах нь

Одоогоор түүхийгээр экспортолж буй нүүрсийг баяжуулснаар экспортын ханш 25-40% нэмэгдэхээс гадна бүтээгдэхүүний чанар дээшилж шинээр харилцагч олоход дөхөмтэй. Улмаар тээвэрлэлтийн зардлыг хямдруулах боломжийг бий болгоно. Гэвч нүүрсийг баяжуулах явцад ердийн түүхий нүүрсний 20 гаруй хувь нь хаягдал болдог бөгөөд одоогоор ашиглах технологи байхгүй байна. Цаашдаа барихаар төлөвлөж буй баяжуулах станц бүрэн хэмжээгээрээ ажиллаж эхэлбэл 10 сая тонн ердийн нүүрс олборлох боломжтой болно. Мөн ийнхүү олборлосон нүүрсээ ашиглах салбарыг бий болгох нь чухал ач холбогдолтой. Ердийн нүүрсийг ашиглах дулааны цахилгаан станц барих нь Өмнөговийн эрчим хүчний нөхцөл байдал, БНХАУ-аас эрчим хүчний хувьд хараат байгаа байдлыг шийдвэрлэхэд сайнаар нөлөөлнө. Мөн ирээдүйд илүүдэл цахилгааныг экспортлох боломж бүрдэж болох юм. Тавантолгойд барихаар төлөвлөж буй 600мв-ын цахилгаан станцын хувьд, ойролцоогоор 3 сая тонн ердийн нүүрс ашиглах тооцоо бий.

Нүүрс баяжуулахад их хэмжээний ус хэрэглэдэг. Өмнөговь зэрэг усны нөөц дутмаг нутагт хуурай аргаар нүүрсийг баяжуулах технологийг ашиглах нь зохимжтой. Гэхдээ том хэмжээний баяжуулах байгууламжийг ашиглаж байгаагүй, нунтаг нүүрсийг боловсруулах технологи хараахан нэвтрүүлээгүй зэргийг харгалзан үзвэл эхлээд туршилт хэлбэрээр хуурай аргаар нүүрс баяжуулах станц байгуулан, технологийг нутагшуулж аажим аажмаар үйлдвэрлэлд нэвтрүүлэх шаардлагатай. Японы хуурай аргаар нүүрс баяжуулах технологийн туршилтыг NEDO хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.


Дотоодын хэрэгцээнд ашиглах хүрэн нүүрс, битумтай тослог нүүрсийг хуурай, хатаах аргаар баяжуулснаар, СНР/НОВ болон хий гаргах, шингэрүүлэх станцад нийлүүлэх бүтээгдэхүүний чанар тогтворжиж, илүү өндөр зэрэглэлийн нүүрс нийлүүлэх боломжийг бүрдүүлнэ. Мөн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөг багасгахад ихээхэн хувь нэмэр үзүүлнэ.

⁴⁰ 2 бүлэг 5 хэсэг Бүс нутгийн нэгдсэн хөгжлийн талаарх бодлого, төслийн мэдээллээс харна уу.



Эх сурвалж : ЖАЙКА-ийн судалгааны баг

Зураг 5.3.2 Хүрэн нүүрс, битумтай тослог нүүрсийг баяжуулах явц



Эх сурвалж : Эрдэнэс ТаванТолгой ХХК

Зураг 5.3.3 БНХАУ руу шилжүүлж ачих үеийн нүүрсний үнийн өөрчлөлт (юань)

(3) Нүүрс хийжүүлэх, нүүрс шингэрүүлэх үйлдвэр байгуулан эрчим хүчийг төрөлжүүлэн химийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх

Нүүрс хийжүүлэх, шингэрүүлэх аргаар гарган авах түлшний үйлдвэрлэл, нийлүүлэлт нь өнөөгийн байдлаар Орос улсаас импортлогдож байгаа нефтийн бүтээгдэхүүнийг орлоод зогсохгүй, эрчим хүчний дотоодын хэрэгцээг хангах байдлыг нэмэгдүүлж, импортын зардлыг бууруулахад хувь нэмрээ оруулах болно. Үүнээс гадна дагавар бүтээгдэхүүнээр керосин, химийн бордоо үйлдвэрлэснээр экспортын бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх, өргөн хүрээтэй химийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх суурийг тавихад хувь нэмэр оруулна.

Мөн Улаанбаатар зэрэг томоохон хотуудад бүтээгдэхүүний агууламж доогуур нүүрс ашиглаж байгаагаас үүдэлтэй агаарын бохирдлыг шийдвэрлэх нь нэн тэргүүний асуудлын нэг болоод байгаа билээ. Нүүрс хийжүүлэх, шингэрүүлэх аргаар байгальд ээлтэй түлшээр хангах гинжин хэлхээ нь байгаль орчны бодлогын хувьд ихээхэн үр нөлөөтэй юм.

Зураг 5.5.4-т нүүрс хийжүүлэх, шингэрүүлэх үйл ажиллагааны бүдүүвчийг үзүүлээ. Дотоодын хэрэгцээнд зориулан үйлдвэрлэх хүрэн нүүрсийг ашигласан тохиолдолд Syngas-аас метанол үйлдвэрлэх явцыг дамжин диметил эфир /DME/ болон бинзен үйлдвэрлэнэ. Судлаачдын тооцоогоор, 4 сая тонн хүрэн нүүрснээс 600 мянган тонн DME болон 200 мянган тонн бинзен үйлдвэрлэж чадна. DME нь


пропантай нэгэн адил ердийн темпартурт нам даралтаар /25 °C、 0.62 MPa/ шингэрүүлдэг, бортогт хийж тээвэрлэдгээрээ давуу талтай ба шатах явцдаа хүхрийн исэл болон макро бодис үүсдэггүй тул ялангуяа БНХАУ зэрэг улсад нүүрсний оронд ихээр хэрэглэгдэж эхлээд байна.

Мөн пропантай хослуулан хэрэглэснээр, пропан газанд ашигладаг дэд бүтэц, хийн зуухыг ашиглаж болох давуу талтай⁴¹. Засгийн газар DME-г томоохон суурин газрын ойролцоох гэр хороололд халаалт, гал тогооны зориулалтаар бүтээгдэхүүний агууламж доогуур нүүрсний оронд хэрэглэж эхлэх ажил хийгдэж байна. Энэ байдалд үндэслэн Энержи Ресурс компани мөнгөн тэтгэмж ашиглан DME-д зориулсан халаалтын хэрэгслийг гэр хорооллын айл өрхүүдэд олгож, туршилтын журмаар БНХАУ-аас DME-г импортлож байна. Мөн хувийн хэвшлийн зарим нэг аж ахуйн нэгж нүүрснээс хий гаргах, шингэрүүлэх үйлдвэр байгуулж эхлээд байгаа бөгөөд Солонгосын Posco компани MCS компанитай хамтран хүрэн нүүрс үйлдвэрлэдэг Багануурын нүүрсний уурхайн ойролцоо Багануур Энержи компанийг байгуулсан. Үүнээс гадна МАКСо., Tsetsens Mines LLC、 Ger Mon Gas LLC зэрэг аж ахуйн нэгж нүүрс хийжүүлэх, шингэрүүлж бинзен гм шингэн түлш үйлвэрлэх төслийн төлөвлөгөө⁴² бий.

Нөгөө талаар, экспортод зориулсан хүрэн нүүрсний баяжмалаас гаргаж авах ердийн нүүрсийг сууриа болгосон тохиолдолд, Syngas-аас FT процессийг дамжин газрын тос болон керосин үйлдвэрлэнэ. Мөн аммиак нийлэгжүүлэх процессийн үр дүнд химийн бордоо үйлдвэрлэж болох юм. Энэ тохиолдолд, 4 сая тонн ердийн нүүрснээс 500 мянган тонн газрын тос, 200 мянган тонн керосин, 300 мянган тонн аммиак үйлдвэрлэх болно. Дизель нь уул уурхайн машин техникт өргөнөөр хэрэглэгддэг. Том хэмжээний уурхай олонтой Өмнөговийн бүс нутагт хангалттай хэмжээний эрэлт байгаа нь харагдаж байна. Хийжүүлэх, нүүрс шингэрүүлэх үйлдвэрт үйлдвэрлэх шатахуун, химийн бүтээгдэхүүний төрөл, хэмжээг цаашдаа эрэлт хэрэгцээ, үнийн өөрчлөлтийг харгалзан үзэж шийдвэрлэх шаардлагатай.

⁴¹ LP газ төв, Ахуйн хэрэглээний төхөөрөмжийн шаталтын туршилт, <http://www.lpgc.or.jp/corporate/dme/dl/tori01.pdf>

⁴² МРАМ тай хийсэн ярилцлага судалгаанаас



Эх сурвалж : ЖАЙКА- ийн судалгааны баг

Зураг 5.3.4 Нүүрс хийжүүлэх, шингэрүүлэх явц

NEDO /Японы Шинэ эрчим хүч, үйлдвэрлэлийн технологи хөгжүүлэх байгууллага/ нь 2011 онд “Монголд нүүрснээс байгальд ээлтэй шатахуун үйлдвэрлэх төсөл боловсруулах талаарх судалгаа”-г хийсэн⁴³. Энэ судалгаанд, хүрэн нүүрс хийжүүлэх ялгарах синтетик хий (Syngas)-ийг ашиглан метаноль, DME болон бензин үйлдвэрлэх үйлдвэрийн эдийн засгийн үр нөлөөний талаар, мөн 1 сая тонн коксийн зуухнаас гарах хуурай хийн чанарыг сайжруулж метанол болон DME үйлдвэрлэх үйлдвэрийн эдийн засгийн нөлөөний талаар тус тус дүгнэлт хийсэн байна. Дүгнэлтийн үр дүнгийн хураангуйг хүснэгт 5.3.1-д үзүүллээ. Үүнээс харахад хүрэн нүүрсийг гол түүхий эдээ болгож хийжүүлэх, шингэрүүлэх үйлдвэр эдийн засгийн хувьд ихээхэн үр ашигтай болох нь харагдаж байна.

⁴³ NEDO; Олон улсын эрчим хүчний хэрэглээний үр ашигтай холбогдох технологи, тогтолцооны батлах, суурь үйл ажиллагаа. Нүүрсийг үр ашигтай ашиглах системийг бүрдүүлэх судалгааны ажил, Монголд нүүрснээс байгальд ээлтэй шатахуун үйлдвэрлэх төсөл боловсруулах талаарх судалгаа, тайлан, 2012 оны 3 сар

Хүснэгт 5.3.1 NEDO, Нүүрснээс байгальд ээлтэй шатахуун үйлдвэрлэх ТЭЗҮ судалгааны үр дүнгийн хураангуй

	Нүүрс хийжүүлэх схем	Хуурай хийн чанарыг сайжруулах схем
Байршил	Багануурын нүүрсний уурхайн ойролцоо	ӨмнөговьУHG нүүрсний уурхайн ойролцоо
Станцын хүчин чадал		
Түүхий эд/ мян тн/жил	2,080 (ус 45%)	1 сая тонн коксын зуухны хийн нийт хэмжээ
Метаноль үйлдвэрлэл/ мян тн/жил	720	140
DME үйлдвэрлэл/ мян тн/жил	100	100
Бензин үйлдвэрлэл/ мян тн/жил	271	-
Ерөнхий барилгын зардал, MUSD	ойролцоогоор 1,600	ойролцоогоор 460
Ерөнхий тээврийн зардал, MUSD/жил	ойролцоогоор 106	ойролцоогоор 45
Борлуулалтын тооцоо, MUSD/жил	399 дээш	74 дээш
IRR(ROI)	5.5~13.4	Мөнгөн гүйлгээний эргэлт муу
Үнэлгээ	Эдийн засгийн хувьд ашигтай байх магадлал өндөр	Эдийн засгийн хувьд хүндрэлтэй

Эх сурвалж : NEDO

Багануур Энержи компаний төлөвлөж буй нүүрс хийжүүлэх, шингэрүүлэх төслийн агуулгыг хүснэгт 5.3.2-т үзүүлээ⁴⁴. Энэ төслийн талаар Канад болон Хятадын инженерийн компаниуд FS-г хийсэн бөгөөд 2 компанийн гаргасан үр дүнгээс харахад нийт хөрөнгө оруулах мөнгөн дүн ойролцоо байна⁴⁵.

⁴⁴ MCS International Co. Ltd., web page : <http://international.mcs.mn/eng/pages/Oxford%20business%20group>

⁴⁵ Baganuur Energy Co.

Хүснэгт 5.3.2 Багануур Энержи компаний нүүрс хийжүүлэх, шингэрүүлэх үйлдвэрийн төсөл

Төслийн захиалагч	Багануур Энержи ХК (BECO)
Голлох үйл ажиллагаа	Монгол нүүрснээс шингэн түлш үйлдвэрлэх Улаанбаатар хотын агаарын бохирдлыг багасгах байгальд ээлтэй түлшний үйлдвэрлэл
Төслийн байршил	Улаанбаатар хот, Багануур
Хөрөнгө оруулалтын нийт хэмжээ	2 тэрбум USD
Үйлдвэрлэлийн хүчин чадал	Хийн тос 450,000 тн/жил Бензин 90,000 тн/жил DME 100,000 тн/жил

Эх сурвалж : MCS International Co. Ltd.

Худалдааны зориулалтын байгууламж барих, үйлдвэрлэл явуулахад их хэмжээний хөрөнгө оруулалт, нүүрс хийжүүлэх, шингэрүүлэхтэй холбоотой химийн үйл ажиллагааг удирдах олон тооны мэргэжилтэн бэлдэх шаардлагатай. Гадаадын тусламж дэмжлэгээр байгууламж барьсан ч шууд худалдааны зориулалтаар тогтвортой үйл ажиллагаа явуулахад хүндрэлтэй. Иймээс эхний ээлжинд засгийн газрын удирдлагын доор олон улсын дэмжлэгтэйгээр бага оврын туршилтын үйлдвэр байгуулан технилогийг нутагшуулах мэргэжилтэй бэлтгэх зэрэг ажлуудыг хэрэгжүүлэн үе шатлалтайгаар худалдаалах цар хүрээнд хүртэл өргөжүүлэх нь ирээдүйн химийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх талаас харсан ч зөв алхам юм.


(4) CBM/UCG ашиглаж орон нутгийн эрчим хүч хангамжийн тогтолцоог бүрдүүлэх нь

Судалгааны шатанд буй CBM /нүүрсний давхаргад байх метан хийг гаргах/ болон нүүрс хийжүүлэх UCG-г ашиглан орон нутгийн голлох эрчим хүчний хангамжийн тогтолцоог бүрдүүлснээр дотоодын эрчим хүчний нөөц бололцоог бүрэн ашиглаж, бүс нутгийн тогтвортой хөгжилд дорвитой хувь нэмэр оруулна.

CBM/UCG-г ашигласан энэхүү систем /график 5.5/ нь, орон нутгийн нөөцийг үр дүнтэй ашиглаж эрчим хүчийг дотооддоо үйлдвэрлэн ашиглах замаар цахилгааны алдагдал болон тээврийн зардлыг бууруулж орон нутгийн хөгжилд эерэгээр нөлөөлнө. Энэхүү загвар нь, цахилгаан, дулааны сүлжээ болон нягтруулсан байгалийн хийн /CNG/ сүлжээнээс бүрдэх ба цахилгааны сүлжээ нь CBM/UCG-г дулааны станцад цахилгаанаар солин, орон сууцны хороолол, олон нийтийн байгууламж, худалдаа арилжааны байгууламж, үйлдвэрийн газар зэрэг хэрэглэгчдэд нийлүүлнэ. Мөн цахилгаан үүсгүүрийг хослуулснаар эрчим

хүчний үйлдвэрийн ойролцоох газарт дулаан нийлүүлэх боломжтой болно. CBM/UCG эрчим хүч нь зохицуулалт хийхэд хялбар, нар, салхины эрчим хүч зэрэг сэргээгдэх эрчим хүчнээс гарах цахилгааныг нийлүүлэн цаг агаар, цагийн байдлаас хамааран цахилгааны хангамжийг өөрчлөн нөхөж болох юм. CO₂-ийг цуглуулах нь зардал өндөртэй боловч, харьцангуй том хэмжээний эрчим хүчний үйлдвэрт хийх бололцоотой, нүүрсний давхаргад даралт үзүүлэх болон бэхжүүлэн CBM-ийг нэмж үйлдвэрлэх боломжтойгоос гадна тэг ялгаралтын эрчим хүч үйлдвэрлэж болох юм.

CNG сүлжээ нь, шахмал CBM-г хоолой болон өндөр даралтын бортогонд савлан хэрэглэгчдэд нийлүүлнэ. Цахилгаан, дулааны эрэлт ихтэй орон сууцны хороолол, олон нийтийн байгууламж, үйлдвэрийн газруудад хийн хөдөлгүүр болон түлшний зай зэргээр ажиллах хосолсон байгууламжийн шатахуун болгож, бусад автомашин, үйлдвэрийн зориулалттай техник, ХАА-н техникийн түлш, халаагуурын түлш болгох ашиглаж болох юм.




Эх сурвалж : NPO Газар доорх нөөцийн инновацын сүлжээ

Зураг 5.3.5 CBM/UCG ашигласан орон нутгийн эрчим хүч хангамжийн системийн бүдүүвч зураг

Зураг 5.3.6-т үзүүлсэнчлэн Монгол улсын CBM нөөцийн 90% орчим нь битумэн болон өндөр чанарын битумэн нүүрсний ордууд байдаг⁴⁶. Эдгээрийг харгалзан үзвэл CBM-ийг ашиглан орон нутгийг эрчим хүчээр хангах системийг хэрэглэх

⁴⁶ Mongolian Nature and Environment Consortium (MNEC): Coal Mine Methane (CMM) Resource Assessment and Emissions Inventory Development in Mongolia, May 2014


боломжтой юм. Тухайн орон нутагт битум болон өндөр чанарын битум хүрэн нүүрсний ордтой бол хэрэгжүүлэхэд боломж ихтэй. Зураг 5.3.7-д томоохон нүүрсний ордууд болон гүний хэмжээгээр ялган СВМ-ийн нөөцийн хэмжээг харуулав⁴⁷. Тус зурагнаас өмнөд бүсийн “Саусгоби”, баруун бүсийн “Транс Алтай”, “ Монгол Алтай”, “Хархираа”, Хойд бүсийн “Орхон сэлэнгэ”, зүүн бүсийн “Тамсаг” зэрэг нүүрсний орд газруудын ихэнх нь СВМ-ийн нөөц ихтэй болохыг харж болно. Мөн нүүрсний гүн давхаргаас цэвэр түлш гаргаж авах технологи найдвартай. Улаанбаатар хотын ойроцоох хүрэн нүүрсийг эрчим хүчний эх үүсвэр болгон ашиглаж буй бүс нутгийг хамруулан СВМ-ийг хөгжүүлэх ирээдүйтэй орон нутаг ихэснэ. СВМ-ийг бодитоор хөгжүүлэн тус орон нутгийн эрчим хүчний эх үүсвэр болгон ашиглавал СВМ-ийн агууламж болон нүүрсний судал, гүний түвшин зэргийн судалгаа хийх, СВМ-ийг үйлдвэрлэлийн хэмжээ болон хугацааг үнэлэх шаардлагатай. Гэсэн хэдий ч нүүрсний давхаргын нөөц нь хэт гүн олборлолт хийхэд хэцүү орон нутаг, байгаль орчны байдлаас шалтгаалан нүүрсний олборлолт хийх боломжгүй орон нутагт нүүрсний судлаас цэвэр байгалийн хийн эрчим хүчийг гарган авах технологийг нэвтрүүлэх нь ирээдүйтэй юм.



Эх сурвалж: NMEC

Зураг 5.3.6 Монгол улсын нүүрсний зэрэглэл СВМ нөөцийн хувь хэвьжээ

⁴⁷ Chimiddorj: Coal Resources in Mongolia and Some Probably Potential Areas for Coalbed Methane, 1988



Эх сурвалж: NMEC

Зураг 5.3.7 Монгол улсын нүүрсний орд газрын тархац, давхаргын гүний CBM нөөцийн хувь хэмжээ

CBM-ийн үйлдвэрлэлийн цооногоос 1 өдөрт үйлдвэрлэх хэмжээ нь, нүүрсний давхаргын гүн, хийн хэмжээ, хийн шингэлтийн хувь риакц, дуусгах арга технологи, хоорондын зай зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалах бөгөөд ерөнхийдөө хэдэн зуун м³-аас хэдэн мянган м³ байдаг. CBM-ийн гаргах дулааны хэмжээг 36 MJ/м³ гэж үзвэл, 1 өдөрт дундажаар 1,000 м³ CBM үйлдвэрлэх цооног ойролцоогоор 150kW-ийн цахилгааны бүтээмж 35 %-тай хийн цахилгаан үүсгүүрийг ажиллуулж чадна. Мөн CBM 1 м³-ийн цахилгааны хэмжээ 1л дизелийн ялгаруулах хэмжээтэй бараг ижил учраас 1 өдөрт 1,000 м³ хэмжээтэй CBM -г, CNG болгон хэрэглэхэд 1,000 л газрын тосоор орлуулж болно. Орон нутгийн эрчим хүчний хангамжийн системийн CBM үйлдвэрлэх цооногийн тоо, үйлдвэрлэлийн цооногийн CBM үйлдвэрлэх хүчин чадал ба орон нутгийн эрчим хүчний эрэлттэй шууд хамааралтай. Орон нутгийн эрчим хүчний хэрэгцээний төрлөөс хамааран шаардлагатай цахилгаан үүсгүүр, CNG зориулалтын компрессор зэрэг тоног төхөөрөмжийг хослуулан зохион бүтээж болно.

Мөн CBM 1 м³-ийн цахилгааны хэмжээ 1л дизелийн ялгаруулах хэмжээтэй бараг ижил учраас 1 өдөрт 1,000 м³ хэмжээтэй CBM -г, CNG болгон хэрэглэхэд 1,000 л газрын тосоор орлуулж болно. Орон нутгийн эрчим хүчний хангамжийн системийн CBM үйлдвэрлэх цооногийн тоо, үйлдвэрлэлийн цооногийн CBM үйлдвэрлэх хүчин чадал ба орон нутгийн эрчим хүчний эрэлттэй шууд хамааралтай. Орон нутгийн эрчим хүчний хэрэгцээний төрлөөс хамааран шаардлагатай цахилгаан үүсгүүр, CNG зориулалтын компрессор зэрэг тоног төхөөрөмжийг хослуулан зохион бүтээж болно. UCG-гийн хувьд, шингэн

түлшний оронд ашиглахын тулд, метаны урвал эсвэл GTL процессийг дамжих үйлдвэрлэлийн байгууламж шаардлагатай болно. Бодит байдал дээр том оврын систем байхгүй тохиолдолд эдийн засгийн үр ашиг төдийлөн гарахгүй. Иймээс UCG-г ашиглан орон нутгийг эрчим хүчээр хангахын тулд бага илчлэгтэй хийг ашигласан эрчим хүчний үүсгүүртэй хослуулах шаардлагатай болох юм.


Ихэвчлэн, эрчим хүчний хангамжийн тогтолцооны хувьд том оврын систем илүү эдийн засгийн үр ашигтай байдаг. Бидний танилцуулж буй системийн хувьд орон нутагтаа эрчим хүч үйлдвэрлэж, ашиглах зорилготой. Монгол улсын өнөөгийн байдлыг харгалзан үзвэл, цахилгааны тооцооны хувьд хэдэн мэгаваттын бага оврын систем шаардагдах юм. Энэ тохиолдолд эрчим хүчний үнэ харьцангуй өндөр тусна. Эрчим хүчний хангамжийн системийг нэвтрүүлэхтэй холбоотой CBM болон UCG нөөцийн хэмжээний үнэлгээ зэрэг нарийн ТЭЗҮ шаардлагатай болно. Мөн эдийн засгийн үр ашгийн тооцоо, тархмал эрчим хүчийг хослуулан хэрэглэхийн ач холбогдол, эрчим хүчийг төрөлжүүлэхийн давуу тал, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн үнэлгээ ч зайлшгүй шаардлагатай.



Зүүн : Тусгаарлагч, усны танк
Баруун : цооногийн хушуу, насос
Насосд суурьлуулсан хийн мотор

Эх сурвалж : <http://blogs.crikey.com.au/>

Зураг 5.3.8 CBM үйлдвэрлэлийн төхөөрөмжийн жишээ (Австрали)



Эх сурвалж : Газар доорх инноваци сүлжээ

Зураг 5.3.9 CNG хангамж, ашиглалтын бүдүүвч зураг

(5) ДЦС ялгарах хаягдал үнсийг ашиглах нь

Дулааны цахилгаан станцаас гарах нүүрсний хаягдал зарим нэг станцыг эс тооцвол огт ашиглагдалгүй, задгай овоолж орхигдсон байдаг. Хогийн цэг байгуулах нь хүндрэлтэй мөн тээвэрлэлтийн зардал гм шийдвэрлэх асуудал их байдаг. Цаашдаа том оврын дулааны цахилгаан станц байгуулах хэд хэдэн төлөвлөгөө байгаа тул их хэмжээний хаягдал үнс гарах нь тодорхой юм. Нүүрс нь чухал баялгийн нэг бөгөөд Япон улсад 1 жилд ялгардаг 13 сая тонн хаягдал үнсний 97%-гоос дээш хувийг цемент үйлдвэрлэл, барилгын салбарт үр ашигтай хэрэглэдэг⁴⁸.

Зарим их сургууль нүүрсний хаягдал үнсийг барилгын материалд ашиглах судалгааг туршилтаар хийж байгаа⁴⁹ч, үнсийг ашиглах арга нь цемент үйлдвэрлэл, барилгын салбар, барилгын материал, ХАА-н салбар, олборлосон газарт буцааж булах, ус цэвэрлэх байгууламж зэрэг олон янз байдаг тул Японы технологийг нэвтрүүлэх боломжтой.


(6) Орон нутгийн онцлог

Зураг 2.6.22-т /нүүрсний ордын тархалт/ үзүүлсэнчлэн, Монгол улсын баруун бүсээс өмнөд хэсэг хүртэл битумтай нүүрсний, төвийн бүсээс хойд ба зүүн бүс хүртэл битумтай тослог нүүрс, хүрэн нүүрсний нөөц ихтэй. Улмаар олборлосон ба баяжуулсан нүүрсний тээвэрлэлтийн зайг аль болох багасгах үүднээс Өмнөговийн бүс нутагт ердийн нүүрс /битумт нүүрсийг баяжуулах завсрын бүтээгдэхүүн/ ашиглан уул уурхайн салбар болон эргэн тойрны орон нутагт эрчих хүч нийлүүлэх загварыг, Улаанбаатарыг төвөө болгосон эртнээс битумтай тослог нүүрс хүрэн нүүрс хэрэглэж заншсан бүсэд эдгээрийг ашиглан байгальд ээлтэй түлш нийлүүлэх загвар системийг бий болгоно.

Мөн, алсын зайны цахилгаан дамжуулалт ба дизель цахилгаан станцаас цахилгаанаа авч буй орон нутаг, дулааны хангамжид ашиглах нүүрсний тээвэрлэлтийн зардал өндөртэй, хөрш зэргэлдээ бүсийн нүүрсний нөөцөөс хараат орон нутагт CBM, чулуун UCG-гаас гаргаж авах Syngas-г ашиглах тархмал загвар системийг бий болгоно.

⁴⁸ JCOAL ; <http://www.jcoal.or.jp/coaldb/tech/coalash/>

⁴⁹ School of Technology in Darkhan, Mongolian University of Science and Technology



Эх сурвалж : ЖАЙКА-ийн судалгааны баг

Зураг 5.3.10 Орон нутгийн нүүрсний ордод түшиглэсэн үйлдвэрлэлийг хөгжүүлэх стратеги

(7) Төмөр замын бүтээн байгуулалт

Нүүрс ашигласан гинжин хэлхээг ашигтай функц болгохын тулд нүүрсний компанийн “эрүүл менежмент” хамгаас чухал. 2012 оноос хойш БНХАУ-д экспортолдог нүүрсний хэмжээ багасан, үнэ унасан. Үүнээ зэрэгцээ дэд бүтцийн байгууламжийн хоцрогдлоос үүдэлтэй тээвэрлэлтийн зардал өндөр байгаа нь нүүрсний компаниудад ихээхэн дарамт болж байна. Экспортод зориулсан түүхий нүүрсний ихэнхийг Таван толгойгоос Гашуун сухайтын хилийн боомт хүртэл 250 км шороон замаар хүнд даацын машинаар зөөвөрлөдөг. Тэндээсээ дахин өөр машинаар БНХАУ-ын хилийг даван Ганц мод боомт хүртэл тээвэрлэнэ. Ганц модоос БНХАУ-ын төмөр замд нүүрс ачигдана.Эдгээр дамжлагыг дайран тээвэрлэлтийн хөлс 1 тонн нь 27 ам.доллар болдог байна⁵⁰. Энэ нь Австралиас хэдэн мянган км усан онгоцоор тээвэрлэснээс 3 дахин үнэтэй тусаж байна. 2011 онд ММС хатуу хучилттай зам тавьж дотоодын тээвэрлэлтийн зардлыг бууруулж чадсан ч хил давснаас хойшхи тээвэрлэлтийн зардлыг бууруулах асуудлыг харахан шийдвэрлэж чадаагүй байна. Мөн шороон замаар тээвэрлэлт хийж байгаа нь байгаль орчинд сөргөөр нөлөөлж байна.

Таван толгойгоос Гашуун сухайтын чиглэлд төмөр зам барих тухай 2010 оны УИХ-аар батлагдаж үндэсний төмөр зам, тээврийн бодлого болон 1,800 км-ийн урттай маш чухал (Ухаа худаг-Гашуун сухайт, Ухаа худаг- Таван толгой-Сайн

⁵⁰ Erdenes TT ; Overview of Tavantolgoi Project, 2015

шанд-Баруун-Урт-Хөөт-Чойбалсан-Эрэнцав, Хөөт-Бичигт, Хөөт-Нөмрөг) төмөр замын бүтээн байгуулалтын нэг хэсэг юм. Анхны төлөвлөгөөгөөр төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг 5 тэрбум 200 сая ам долларын өртөгтөйгөөр⁵¹ 2016 онд дуусгахаар төлөвлөж байсан. 2012 онд Засгийн газрын шийдвэрээр өмнийн төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлсэн байна. Монголын төмөр замын BOT гэрээнд тусгай ажлын хэсгийг томилон (SPV)-с санхүүжилтийг хийж зам тавих ажлыг хийхээр төлөвлөж байсан. Ерөнхий гүйцэтгэгчээр Samsung C&T компани зам тавих ажлыг гүйцэтгэхээр болсон боловч⁵², тусгай зөвшөөрлийг буцаан авснаар Монголын төмөр зам ТӨК нь “Чингис бонд”-оос 3 тэрбум ам доллар авч ажлыг эхлүүлсэн. Судалгааны үеэр үндсэн ажлын 87% -ийг хийж дууссан гэж мэдэгдэл хийсэн хэдий ч гүүр болон замын цариг тавих ажил хийгдээгүй⁵³ ажлын явц ихээр хоцрох байдалтай байгаа. Энэхүү чиглэлийн төмөр замыг БНХАУ-ын нарийн царигтайгаар тавихаар шийдэгдсэн ба “Чайна Шинхуа энерги” компаний тавьсан БНХАУ-ын нутаг дахь төмөр замын уулзвар хүртэл замыг холбон тавигдснаар тээврийн зардал их хэмжээгээр багасах бөгөөд экспортын өрсөлдөх чадвар нэмэгдэхээс гадна БНХАУ-тай тээврийн хэлэлцээрийг хийснээр БНХАУ-ыг усан боомтуудаар Монголын нүүрсийг гуравдагч улсруу экспортлох гарц нэмэгдэнэ.



Эх сурвалж : Зам Тээврийн Хөгжлийн Яам

Зураг 5.3.11 Монголын нүүрсний үйлдвэрлэлийн хөгжилд хувь нэмэр оруулах төмөр замын бүтээн байгуулалт

(8) Уул уурхайгаас хараат бус орон нутгийн хөгжил

Нүүрсний уурхай болон бусад төрлийн уурхай орон нутагт бий болоход тэнд ажиллагсад суурьшиж амьдрах болдог. Тодорхой хугацаанд барилга, хоолны газар, жижиглэнгийн худалдааны эрэлт нэмэгдэж, мөн боловсрол, эрүүл мэнд, цахилгаан, усны хангамж зэрэг дэд бүтэцтэй холбоотой бүтээн байгуулалт хийгддэг. Гэвч баялгийн нөөц дуусахад ажиллагсад шилжин, орон нутагт үлдсэн дэд бүтэцтэй холбоотой засвар үйлчилгээ төсвийн дарамт болдог. Энэ асуудалтай Япон улс ч мөн адил тулгарч байсан билээ. Уул уурхайн хөгжил болон орон нутгийн тогтвортой хөгжлийг уялдуулах нь тийм ч амархан шийдвэрлэх асуудал

⁵¹ Ministry of Road and Transportation, Railway developments of Mongolia, June 2014

⁵² Ministry of Road and Transportation, Railway developments of Mongolia, June 2014

⁵³ Invest Mongolia Agency, New Railroad Project, Invest in Mongolia 2015

биш юм. Гэвч уул уурхайг хөгжүүлэхтэй зэрэгцүүлэн алсын хараатай орон нутгийн хөгжлийн хөтөлбөрийг зохиох нь чухал ач холбогдолтой.

Өмнөговьд уурхайд ажиллагсад амьдрах орчин, дэд бүтэц дутагдалтай тул суурьшуулж чадахгүй байна. Ажиллагсад гэр бүлээ орхин, гэр, кямпын хооронд ирж очин 2 нутагтан шиг амьдарч байна. Эдгээр жишээний хувьд, уул уурхайн компанаас хараат “уурхайн хот” бий болгохгүйгээр хэд хэдэн аж ахуйн нэгж хамтран орон нутгийг бүхэлд нь хамарсан төв сууринг бий болгох үзэл баримтлал шаардлагатай. Уул уурхайгаас олон ашиг, дэд бүтэц зэрэг хишгийг ХАА, үйлдвэрлэл, аялал жуулчлалын нөөц болгон өргөн хүрээтэй дахин хуваарилах явдал чухал юм. Жишээ нь, олборлолтын дараа үе шатлалтайгаар нөхөн сэргээлтийг хийхдээ ХАА-н зориулалтаар ашиглахаар эхнээс нь төлөвлөж үүнд тохирсон технологийг /газрыг сэргээх, хөрсний үршил шимийг нэмэгдүүлэх гм/ нэвтрүүлснээр ХАА-н хөгжилд хувь нэмрээ оруулна.

Орхон аймгийн төв болох Эрдэнэт хот Эрдэнэтийн уурхайд түшиглэсэн хот болон хөгжиж ирсэн бөгөөд одоогоор хүн ам нь 90,000-д хүрээд байгаа Монголын 2 дахь том хотын нэг юм. Хэдэн жилийн өмнө уурхайн нөөц шавхагдах аюул нүүрлэсэн ч хайгуулын ажиллагааны үр дүнд шинэ орд илрэн уурхайн нас 30-40⁵⁴ жилээр нэмэгдсэн. Ирээдүйд уурхай хаагдах үеийг тооцоолон орон нутгийн аж ахуйн нэгжүүд хамтран одоогийн дэд бүтэц болон уурхайтай холбоотой үйлдвэрлэлийг ашиглах логистик төв байгуулан уурхайгаас хараат бус хот байгуулалтыг төлөвлөж эхлээд байна.



Эх сурвалж : Wikimedia Commons

Зураг 5.3.12 Эрдэнэт хот болон Эрдэнэтийн уурхай

⁵⁴ Эрдэнэт үйлдвэр ХХК

5.4 Аялал жуулчлалын салбарын хөгжил


(1) Монгол улсын аялал жуулчлалын салбарын имижийг тодотгох

2.9 бүлэгт дурдсанчлан, Монгол улсын аялал жуулчлалын салбарын хөгжилд дутагдалтай байгаа асуудал бол төрөөс баримталж буй бодлогын хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний тэргүүлэх дараалал тодорхой бус байгаагаас гадна түүнийг тодорхойлох холбогдох байгууллага, мэргэжилтэн хооронд нэгдсэн хөгжлийн имиж дутагдаж байгаа явдал юм. Зураг 2.9.1-д үзүүлснээр, Монголын аялал жуулчлалыг хөгжүүлэхийн тулд өнөөг хүртэл олон төрлийн үйл ажиллагаа явуулж ирсэн бөгөөд цаашид боломжийн хирээр эдгээр үйл ажиллагаагаа эрчимжүүлэхийн зэрэгцээ хөгжлийн имижээ тодорхойлох нь зүйтэй. 2015 онд зохион байгуулагдсан олон улсын аялал жуулчлалын томоохон загвар хот болох ITB Берлинд БОАЖЯ-наас “ MONGOLIA – Nomadic by Nature” –г уриа болгон оролцсон. Улмаар, энэхүү уриа нь БОАЖЯ-наас Монголын аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх уриа болж байна. Тус судалгааны дүнд ч нүүдлийн соёл иргэншил бол байгальтай зохицон оршин тогтнох үзэл санааг илэрхийлэх Монголын өвөрмөц соёл хэмээн онцолж байна. Мөн өмнө дурдсанчлан, Монголын биет бус соёлын өв олон улсад маш өндрөөр үнэлэгддэг. Эдгээр дээр үндэслэн “Нүүдлийн өв соёл” (Nomadic) -ийг түлхүүр үг болгон имиж бүрдүүлэн нийтэд таниулж, төрийн бодлогын хэрэгжүүлэх үйл ажиллагааны дэс дараалалыг тодорхой болгож, аялал жуулчлалын хөгжилтэй уялдуулан, аялал жуулчлалыг үр ашигтай, тогтвортойгоор хөгжүүлэхийг санал болгож байна.

1) Түлхүүр үгнээс холбогдсон аялал жуулчлалын хөгжлийн стратеги

Зөвхөн “Nomadic” гэсэн түлхүүр үгээр хөгжлийн имижийг бүрдүүлнэ гэдэг учир дутагдалтай. Нүүдлийн соёл иргэншлийг аялал жуулчлалын хөгжилтэй холбон, нүүдлийн-аялал жуулчлалыг (Nomadic Tourism) бий болгосноор хөгжлийн имижийг тодорхойлохын хамт аялал жуулчлалын хөгжлийн олон төрлийн төсөл, хөтөлбөртэй уялдуулан аялал жуулчлалыг стратегитэй хөгжүүлэх боломжтой болно. Тайлангийн 2.9 бүлэгт дурдсанчлан, Монгол улсын аялал жуулчлалын салбарын тэргүүлэх салбарт бизнес аялал жуулчлалыг хөгжүүлэх, амралт аялал жуулчлалын байгаль болон соёлын нөөцийг хамгаалах гэсэн 2 хүчин зүйл багтах ба, “Нүүдлийн соёл” гэсэн түлхүүр үг нь бизнес аялал жуулчлал болон амралт аялал жуулчлалыг холбох гүүр болсноор хөрөнгө санхүү зэрэг асуудлууд ч хамрагдан уялдаж, эдгээр тэргүүлэх салбарын асуудлыг илүү үр дүнтэй, ашигтайгаар шийдэх боломж нээгдэнэ. Зураг 5.6.1-т дэвшүүлж буй саналыг бүдүүвчлэн үзүүлж байна. Энэхүү аялал жуулчлалын хөгжлийн стратегийг амжилттай хэрэгжүүлэхийн тулд хэвлэл мэдээллийн хэрэгсэл, сошиал медиа зэрэг хувь хүнд хүрэх хүрээг аль болох тэлж, нийтэд хүртээмжтэй байх стратеги маркетинг авч хэрэгжүүлэх хэрэгтэй. Зөвхөн зочломтгой байгаад

зогсохгүй, гадаадын жуулчдад Монголын ард түмний Монгол өв соёлын бахархалыг ойлгож мэдрүүлэхүйц нутгийн ард иргэдийн сэтгэлгээг өөрчлөх шаардлага гарч ирнэ.



Эх сурвалж : ЖАЙКА-ийн судалгааны баг

Зураг 5.4.1 Аялал жуулчлалын имижийг тодорхойлох хөгжлийн стратеги

2) Аялал жуулчлалын хөгжлийн үр ашгийг тодорхойлох

Нүүдлийн аялал жуулчлал Nomadic Tourism ТОГТВОРТОЙГООР хөгжүүлэхэд зураг 5.4.2-т харуулсан нийгэм-соёл, эдийн засаг, байгаль орчинд ээлтэй байдлаар цогцоор нь хөгжүүлэх шаардлагатай учраас нүүдлийн соёлыг ашигласан аялал жуулчлалын хөгжил авч ирэх боломжтой үр ашгийг тодорхой болгох нь чухал. Ингэхдээ үр ашгийг аль болох тоон үзүүлэлтээр тодорхойлсноор холбогдох хүмүүс хоорондын зорилтоо танилцуулах, хэрэгжилтэнд чиглэсэн хөшүүрэг болохоос гадна, аялал жуулчлалын стратеги хөгжил, мартетингийн хэрэгжилттэй шууд холбогдох боломжтой болно.



Эх сурвалж : ЖАЙКА-ийн судалгааны баг

Зураг 5.4.2 Аялал жуулчлалын хөгжлийн үр ашгийн жишээ

Хүснэгт 5.4.1-т Улаанбаатар хотод зочид буудал шинээр байгуулснаар гарах эдийн засгийн ашгийн тооцоог харуулж байна. 2015 онд үйл ажиллагаагаа эхлүүлсэн Шангрила зочид буудал болон өдгөө баригдаж байгаа болон баригдахаар төлөвлөгдөж буй 4 том зочид буудал, нийт 5 зочид буудлыг авч үзэхэд ДНБ-ийг 0.14%-иар өсгөж байгаа ашигтай байгаа бөгөөд, жилийн борлуулалтын нийт мөнгөн дүн ойролцоогоор 100 сая 8000 доллар болно гэж таамаглаж байна.

Хүснэгт 5.4.1 УБ дахь томоохон зочид буудлуудын эдийн засгийн үр ашг (дээд: тоймлон гаргасан үр дүн, доод: зочид буудлын барилга байгууламжийн цар хүрээ

	2014*	ЭЗ-ийн үр дүн	
Total Economic Contribution	US\$382.1mil.	+US\$16.4mil.	таамаг:
Percentage of GDP	3.2%	+0.14%	Буудлын өрөө, хурлын танхимын ашиглалтын дундаж : 60%
Employment % of Total Workforce	1.4%	+0.12%	Ашиг : Зочны өрөө 5%, хурлын танхим 25%
Indirect Employment	2.8%	+0.25%	

	Number of Rooms	Number of Beds	function capacity person	No. of Employees person
Shangrila	290	580	854	370
Radison	200	400	589	255
Holiday inn	200	400	589	255
Shareton	200	400	589	255
City Tower	320	640	942	408
total	1,210	2,420	3,563	1,544

Жич : Radisson, Holiday Inn, Sheraton өрөөний тоо ойролцоо

Эх сурвалж : ЖАЙКА-ийн судалгааны баг

Аялал жуулчлалын салбарын ДНБ-д эзлэх хувийн талаар хүснэгт 5.4.2-ын өнөөгийн байдлыг 1-т харуулж байна. Дэлхийн Аялал Жуулчлал, Аялал Жуулчлалын Зөвлөл (World Travel and Tourism Council: WTTC)-аас гаргасан үнэлгээг ихэвчлэн ашигладаг бөгөөд, энэхүү судалгааны тооцооллын дүнд ашиглагдаж буй гадаадын жуулчдын зарлагыг 2014 оны гадаадын жуулчдын тоо (392844хүн)-нд хувааж үзвэл, 1 хүнд ноогдох зарлагын дүн нь 221 доллар гэх нилээд бага мөнгөн дүн болж байна. Тиймээс, бодит байдлыг 2-т үзүүлж байгаачлан 2015 оны явуулсан асуулга судалгаанд үндэслэн 1 хүнд ноогдох зарлагын хэмжээг дахин тооцож үзвэл, ДНБ-д эзлэх хувь 1 дахин их буюу 6.6 хувь болно. Дээр дурдсан “Аялал Жуулчлалыг Хөгжүүлэх Үндэсний Хөтөлбөр”-ийн эхэн хэсэгт тооцооллын үндэслэл нь тодорхой тайлбаргүй байсан боловч, 2015 оны байдлаар аялал жуулчлалын салбарын ДНБ-д эзлэх хувь 5.3% гэж тэмдэглэгдсэн байснаас үзэхэд, бодит байдал дээр аялал жуулчлалын салбарын ДНБ-ий хувь 5-6% орчим гэж таамаглаж байна. Хүснэгт 5.4.3-нь олон талын таамагт тулгуурласан тойм тооцоо бөгөөд “Найрсаг Улаанбаатар” хөтөлбөрт тусгагдаж байгаа Монголд ирэх жуулчдын тоог 2020 он гэхэд 2 сая, 2030 он гэхэд 5 сая болгон нэмэгдүүлнэ гэсэн төлөвлөгөө хэрэгжсэн тохиолдолд аялал жуулчлалын салбарын ДНБ-ний харьцаа хэрхэн өөрчлөгдөх талаар туршилтын журмаар тооцоолон гаргасан дүн юм. 2.9-д дурдсанчлан, жуулчдын тоог ийнхүү нэмэгдүүлэх ажлыг хэрэгжүүлэхийн тулд онгоцны буудал зэрэг олон салбарын дэд бүтцийг сайжруулах хэрэгтэй болно. Нөгөөтэйгүүр, энэхүү таамаглал тооцоог гаргаснаар 2030 он гэхэд аялал жуулчлалын салбарыг өнөөгийн уул уурхайн салбар (ДНБ-ний харьцаа 18%)-тай адил гол үйлдвэрлэлийн салбар болгон хөгжүүлнэ гэсэн төлөвлөгөө төлөвлөлт холбогдох байгууллага, албан тушаалтнуудын дунд ил тод болж, хэрэгцээ шаардлагатай арга хэмжээ явагдаж байгаа эсэхийг дахин тодруулах боломжтой.

Хүснэгт 5.4.2 Аялал жуулчлалын салбарын ДНБ эзлэх хувь (өнөөгийн байдал)

Бодит байдал 1 (WTTC тооцоо, 2014) Бодит байдал 2 (WTTC мэдээллийн зарим хэсгийн зассан тооцоо)

ДНБ (100 сая доллар)	109	ДНБ (100 сая доллар)	109
Аялал жуулчлалын салбараас орж ирэх шүүд орлого (100 сая доллар)	1.74	Гадаад жуулчдын 1 хүнд ноогдох Монгол дахь	1,173
Дотоодын болон гадаадын жуулчдаас орж ирэх шүүд орлого (100 сая доллар)	0.87	Жилийн гадаадын жуулчдын тоо	392,844
Шууд орлогоос шалтгаалах ДНБ-д эзлэх хувь	1.6%	Гадаадын жуулчдаас орж ирэх шууд орлого (100 сая доллар)	4.61
Аялал жуулчлалын салбараас орж ирэх нийт орлого (шууд+шууд бус; 100 сая доллар)	3.48	Аялал жуулчлалын салбараас орж ирэх шууд орлого	5.47
Нийт орлогоос шалтгаалах ДНБ-д эзлэх хувь	3.2%	Шууд орлогоос шалтгаалах ДНБ-д эзлэх хувь	5.0%
		Аялал жуулчлалын салбараас орж ирэх нийт орлого (шууд+шууд бус: 100 сая доллар)	7.21
		Нийт орлогоос шалтгаалах ДНБ-ний харьцаа	6.6%

Эх сурвалж: WTTC 2014, Tourism Survey 2015, Үндэсний Статистикийн Хороо

*Жич: 1.173 (2015 онд явуулсан анкет судалгаанаас үзвэл, бие даан аялагчийн зарлагын дундаж (1.526 ам.дол) болон багц аялалд оролцогч жуулчдын зарлагын дундаж (2.383 ам.дол) нийт дундаж дүн (1.995 ам. дол)-гийн 60%)

Хүснэгт 5.4.3 “Найрсаг Улаанбаатар” хөтөлбөрт дэвшүүлж буй хүлээж авах гадаадын жуулчдын зорилтот тоонд тулгуурласан ДНБ-ний харьцааны таамаг тооцоолол

	2020	2030
ДНБ (жилийн өсөлтийн хувь: 8%, 100 сая)	173	374
Гадаадын жуулчдын 1 хүнд ноогдох Монгол	1,200	1,400
Жилийн гадаадын жуулчдын тоо	2,000,000	5,000,000
Гадаадын жуулчдаас орж ирэх шууд орлого	24.00	70.00
Аялал жуулчлалын салбараас орж ирэх шууд	24.87	70.87
Шууд орлогоос шалтгаалах ДНБ-д эзлэх хувь	14.3%	18.9%
Аялал жуулчлалын салбараас орж ирэх нийт орлого (шууд+шууд бус: 100 сая ам.дол)	26.61	72.61
Нийт орлогоос шалтгаалах ДНБ-ий харьцаа	15.4%	19.4%

Таамаглал :

- Жилийн дундаж ДНБ-ний өсөлт 8%
- Дотоодын жуулчнаас орж ирэх шууд орлого, аялал жуулчлалын салбарын шууд бус орлого нь 2014 онтой адил мөнгөн дүн (консерватив таамаглалын

Эх сурвалж: WTTC 2014, Tourism Survey 2015, ЖАЙКА-ийн Судалгааны баг

(2) Бизнес аялал жуулчлалыг хөгжүүлэх

2.9 бүлэгт дурдсанчлан, бизнес аялал жуулчлалыг хөгжүүлэхэд дутагдаж буй гол асуудал нь Улаанбаатар хотод жуулчдыг татах шинж чанар дутагдаж байгаа

бөгөөд, Улаанбаатар хотыг нүүдлийн соёл иргэншил болон холбогдох үйлдвэрлэлийг дэлхийд таниулах тулгуур төв болгох зорилтыг дэвшүүлж түүнд хүрэхийн тулд доор дурдсан 2 хүчин зүйлээр аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэхийг санал болгож байна.

1) МИСЕ-ийн хөгжил

МИСЕ-ийн жуулчдын зардал энгийн жуулчдаас бараг 6 дахин их байдаг гэсэн тооцоо⁵⁵ байдаг ба, эдийн засагт үзүүлэх нөлөөлөл нь их байдагтай холбогдуулан, зураг 5.4.1-т “Нүүдлийн соёл иргэншил” гэсэн утга санааг илэрхийлж буй бизнес жуулчин ба амралт аялал жуулчлалын жуулчдын холбох гүүр болох үүргийг МИСЕ-ийн жуулчид гүйцэтгэж чадвал, гарах үр ашиг нь их юм. Тухайлбал, Горхи Тэрэлж БЦГ болон Хустай БЦГ гэх мэт Улаанбаатар нийслэл хоттой ойр орших аялал жуулчлалын бүс нутаг, нийслэл хот доторх зочид буудлуудын хоорондын харилцааг нягтруулж, амралтын өдрүүдээр байгаль болон нүүдлийн соёлтой танилцах тогтолцоог бий болгох, түүнчлэн ажлын өдрийн оройн цагаар зугаатай өнгөрүүлж болохуйц жүжиг, концерт, загварын шоу гэх зэргийн соёлын арга хэмжээг хөгжүүлэх зэргийг дурдаж болно. Энэхүү соёлын арга хэмжээ нь цаашилбал тухайн салбарын үйлдвэрлэлийн холбогдох учраас хамтад нь эрчимтэйгээр хөгжүүлэх шаардлагатай. Мөн, хөрөнгө санхүүгийн талаас бизнес аялал жуулчлал болон амралт аялал жуулчлалын нягт холбоо чухал учраас МИСЕ-ийг хөгжүүлснээр хүртэх боломжтой үр ашгийг байгаль болон соёлын баялгийг хамгаалахад ашиглаж болохуйц харилцан уялдаатай Cross-Subsidy-ыг хэрэгжүүлэхийн тулд хууль эрхзүйн орчинг сайжруулах хэрэгтэй.

2) Нүүдэлчдийн соёлын төв хот найрсаг, зочломтгой

Найрсаг, зочломтгой (Hospitality) байдлыг дээшлүүлэхэд, өмнө дурдсанчлан байгаль орчин, соёлын үнэ цэнэ болон аялал жуулчлалын хөгжлөөс үүдэн гарах үр ашгийн хүртээмжээр нутгийн иргэдийн сэтгэлгээг өөрчлөхийн зэрэгцээ, аялал жуулчлалын байгууллагуудын үйлчилгээг сайжруулах, дэд бүтцийг хөгжүүлэх шаардлагатай. Аялал жуулчлалын салбарын үйлчилгээг сайжруулахын тухайд 2.9-д дурдсанчлан, холбогдох мэргэжилтнүүд Япон улсаас технологийн дэмжлэг туслалцаа авах хүсэлтэй байгаагаас үзвэл цаашид эрчимтэйгээр, бодит тусламжийн бодлого боловсруулахын зэрэгцээ, Япон улсын аялал жуулчлалын хууль, олон улсын аялал жуулчлал, зочид буудлын тухай хууль дүрэмтэй адил аялал жуулчлалын үйлчилгээний чанарыг баталгаажуулах хууль эрхзүйн орчны тогтолцоог нэвтрүүлэх шаардлагатай байна. Дэд бүтцийг сайжруулах тал дээр Улаанбаатар хотыг бүхэлд нь “Нүүдлийн соёл иргэншил”-сэдэв бүхий загвар, дизайныг нисэх онгоцны буудал гэх мэт олон нийтийн барилга байгууламж, тэмдэг тэмдэглэгээ зэрэгт нэвтрүүлж, ресторан болон зочид буудал шинээр

⁵⁵ “Current Situation of Mongolian Tourism” presented by MEGDT at IFNAT conference 2015

бариад зогсохгүй, хоолны цэс болон арга хэмжээгээр дамжуулан албан ажлын зорилгоор ирсэн бизнес жуулчдын нүүдлийн соёлтой танилцах боломжийг хангах ажилд идэвхийлэх нь зүйтэй


(3) Байгаль, соёлын өвийг хамгаалах

2.9 бүлэгт дурдсанчлан, байгаль болон соёлын нөөц баялгийг хамгаалахад тулгарч буй томоохон асуудал бол төсвийн хүрэлцээгүй байдал болон хүний нөөцийн дутагдал бөгөөд, БОНХАЖЯ-аас удирдан явуулж буй одоогийн хамгаалалтын тогтолцоо хангалтгүй байгаа юм. Энэхүү асуудлыг үндсээр нь шийдвэрлэхийн тулд улс болон аймгийн удирдах шатны байгууллагуудын дээрээс доош чиглэсэн хамгаалалтын бодлого шийдвэрээс, орон нутгийн зүгээс буюу доороос дээш чиглэсэн хамгаалалт руу (from bottom up to top down) шилжих хэрэгтэй. Ингэхдээ орон нутаг бүр тус тусдаа үйл ажиллагаа явуулахаасаа илүүтэйгээр газарзүйн болон экосистемийн онцлогоор ижил төстэй ТХГН хоорондын уялдаа холбоог бэхжүүлж, аялал жуулчлалын кластерийг байгуулах нь илүү үр дүнтэй хамгаалалтын хэлбэр болох боломжтой тул бие даасан, тогтвортой аялал жуулчлалын кластерийг байгуулах зорилт тавьж, дараах асуудлыг анхаарсан хамгаалалтын арга хэлбэрүүдийг хэрэгжүүлэхийг санал болгон дэвшүүлж байна.

1) Аялал жуулчлалын кластерийн бие даасан байдлыг дэмжих хэрэгжүүлэх тогтолцоог бий болгох, хууль эрх зүйн орчинг бэхжүүлэх

Доороос дээшээ чиглэсэн (from bottom up to top down) гэнэтийн шилжилт хийх боломжгүй төдийгүй, доороос дээшээ чиглэсэн шийдвэр гаргах тогтолцоонд шилжлээ гэхэд, салбар хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас нэгдсэн удирдлага, хяналт хийх шаардлагатай тул, БОНХАЖЯ-ны холбогдох хүмүүстэй зөвшилдөх, хэрэгцээ шаардлагад тохируулан сургалт зохион байгуулан, улсын хэмжээний урт хугацааны байгаль орчин, соёлын өв дурсгалыг хамгаалах чиг хандлагыг тодорхойлох хэрэгтэй. Нөгөөтэйгүүр, бэлчээрийн даац хэтрэлт, хог хаягдлын асуудал зэрэг нэн даруй шийдвэрлэвэл зохих асуудалтай ТХГН-ууд олон байгаа тул асуудлыг шийдвэрлэхэд шаардагдах аймаг орон нутгийн газар нутгийн удирдлагаар хязгаарлахгүй цогц байдлаар сайжруулах тогтвортой удирдлагын тогтолцоог бий болгон, доороос дээш чиглэсэн кластерийг хөгжүүлэх стратеги төлөвлөгөөг боловсруулж, аймаг болон улсад санал дэвшүүлэх явдал чухал юм. Энэхүү үйл ажиллагааг хэрэгжүүлэхийн тулд, орон нутгийн аялал жуулчлалаар орлого олж байгаа Улаанбаатар хотын аж ахуйн нэгжүүдийг тухайн аялал жуулчлалын бүс нутагт татвар төлдөг болгох тогтолцоо болон ТХГН өөрөө өөрийгөө санхүүжүүлэх, захиран зарцуулах чөлөөт байдлыг бий болгох тогтолцоо зэрэг аялал жуулчлалын кластерийн бие даасан байдлыг дэмжих хууль эрхзүйн орчинг сайжруулах шаардлагатай байна. Зураг 5.4.3 дээр

аялал жуулчлалын кластерийг байгуулах жишээ харуулж байгаа бөгөөд эдгээр нь бүхий л аялал жуулчлалын кластерт байгаль, соёлын нөөц баялгийг хамгаалах үйл ажиллагааг адил түвшинд хэрэгжүүлэх боломжгүй учраас, хөндлөн (зүүнээс баруун тийш чиглэсэн), босоо (урдаас хойшоо чиглэсэн) гэсэн эдийн засгийн корридор дагуу шат дамжлагатай хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулж, дэс дарааллыг тодорхойлсны үндсэн дээр хэрэгжүүлэх явдал чухал юм. Гэхдээ зураг 5.4.3-д 1-р үеэс эхлээд дурдагдаагүй байгаа зүүн болон баруун бүсийн тухайд авч үзэхэд тухайлбал, зүүн бүсийн Дорнод аймагт Солонгос, Хятад, Оростой хамтран хэрэгжүүлж буй “Түмэн голын санаачлага” (Greater Tumen Initiative)-ын явцын байдлаас шалтгаалж хэрэгжилтийн хугацаа нь хурдсах боломжтой учраас, хил залгаа улс гүрэнтэйгээ харилцах харилцаагаа бодолцон, төлөвлөгөөг уян хатнаар засаж сайжруулан хэрэгжүүлэх шаардлагатай.



1-н шат аялал жуулчлалын хөгжлийн кластер (санал)

Эх сурвалж : WWF Mongolia, Administration of Land Affairs, Geodesy and Cartography, UNESCO website, Ramsar Site Information Services, The Alliance of Religions and Conservation, ЖАЙКА судалгааны баг

Зураг 5.4.3 Аялал жуулчлалын кластер байгуулах жишээ

2) Нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлал (СВТ) хөгжүүлэх

Доороос дээш чиглэсэн шийдвэр гаргах тогтолцоогоор байгаль, соёлын нөөц баялгийг хамгаалах гэдэг нь, нутгийн иргэд байгаль соёлын нөөц баялгийг тогтвортойгоор ашиглан, хамгаалах гэсэн үйл ажиллагаатай нэг цогц . Түүний тулд, нутгийн иргэд тухайн бүс нутгийн байгаль, соёлын нөөц баялгийг сайтар ухамсарлаж, үнэ цэнийг харилцан ойлголцох нь чухал ач холбогдолтой боловч, үнэ цэнэ гэдэг нь дотор нь байгаа хүнд мэдрэгдэхгүй байх явдал олонтаа байдаг тул, нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлал (СВТ) хөгжүүлж, гадны жуулчдыг идэвхитэй хүлээн авч, тэдгээрээр дамжуулан байгаль, соёлын үнэ

цэнийг дахин ойлгож ухамсарлах болно. Мөн, тухайн орон нутгийн малчдын нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалд оролцох оролцоо нь Монголын аялал жуулчлалыг хөгжүүлэхэд хэрэгтэй хэмээн үзэж буй нүүдлийн соёл аялал жуулчлал (Nomadic Tourism)-ын хөгжилд хувь нэмрээ оруулахаас гадна, үүнээс улбаалах бизнесийн үйл ажиллагааны үр ашгаар амьжиргааны түвшин дээшлэх, бэлчээрийн даац хэтрэлтийг бууруулах зэрэг үр дүн гарна гэж тус судалгааны багаас үзэж байна.

3) Бусад аж үйлдвэрлэлийн салбартай хамтран эко хот байгуулах

Байгаль, соёлын нөөц баялгийг тогтвортой хамгаалах, ашиглах хоёрыг хослуулан хэрэгжүүлэхийн тулд, аялал жуулчлалын кластерийн дотоод бүс ба кластер хоорондын бусад салбар (ХАА, зам тээвэр, эрчим хүч, хог хаягдал гэх мэт)-ын бодлогод анхаарал хандуулан, холбоотой ажиллаж, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг багасгахыг зорих нь зүйтэй. Аялал жуулчлалын кластерт Өмнөговь шиг уул уурхай хөгжиж буй хоттой кластер ч байдаг тул эдгээр хотуудад ирээдүйд бизнес аялал жуулчлалыг хөгжүүлэх нөөц бололцоо байгааг бодолцон байгаль дэлхийтэйгээ салшгүй холбоотой оршин буй нүүдлийн соёл иргэншлийн үзэл санаан дээр сэргээгдэх эрчим хүч болон нүүрсийг хийжүүлэх гэх зэрэг хамгийн сүүлийн үеийн технологийг ашиглан уламжлан үлдэж, эко хот байгуулахыг зорих нь маш чухал.


4) Хил дамнасан аялал жуулчлалыг хөгжүүлэх нь

2014 онд Монгол болон ОХУ 2 улсын хооронд визгүйгээр зорчих боломжтой болсноос хойш ОХУ-тай хил залгаа оршдог Сэлэнгэ аймгийн Сүхбаатар хот болон Хөвсгөл аймгийн Хөвсгөл далайн хойд хэсэгт ОХУ-аас ирэх жуулчдын тоо 1 дахин нэмэгдээд байгаа бөгөөд, ОХУ-руу аялах Монголчуудын тоо ч эрс нэмэгдэж байна. Энэхүү хил дамнасан аялал жуулчлалыг хөгжүүлэн, Хөвсгөл далай болон Сэлэнгэ аймгийн Сүхбаатар хотын Сэлэнгэ мөрөн орчмын байгалийн үзэсгэлэнт газрыг тохижуулах, хамгаалах ажлыг эрчимтэйгээр өрнүүлэх нь чухал юм. Өнөөгийн байдлаар БНХАУ-ын ӨМӨЗО-той аялал жуулчлалын салбарын хамтын ажиллагаа сайжирч байгаа тул, БНХАУ руу визгүйгээр аялахад чиглэсэн зохицуулалт хийгдэж байна. Улмаар, Өмнөговь аймгийн Шивээхүрэнгийн уул уурхайн салбарынхан зөвхөн нэвтрэх боломж бүхий хилийн боомтыг жуулчдад нээлттэй болгох талаар БНХАУ-ын талтай хэлэлцээр хийж буй бүс нутгууд ч байгаа. ӨМӨЗО-той аялал жуулчлалын чиглэлээр хамтран ажиллах нөөц бололцоо их байгаагаас үзвэл хамтын ажиллагаа цаашид улам эрчимжих төлөвтэй байна. Хилийн бүс гэдэг нь хил залгаа орших улс гүрнээс газрын замаар хил нэвтрэх гадаадын жуулчид анхлан танилцах бүс нутаг байдаг учраас нүүдлийн соёлын илэрхийлэл болсон байгаль,

соёлын нөөц баялагийг хайрлан хамгаалж, түүнийг ашиглан үйл ажиллагаа явуулах нь зүйтэй.

(4) Зам харилцааг сайжруулах

2.9 бүлэгт дурдсанчлан зам, харилцаа сайтар хөгжөөгүй байгаан улмаас, оргил үе болох зуны улиралд аялал жуулчлалыг хөгжүүлэх боломжийг алдсаар байна. Зам, харилцаа холбоог сайжруулснаар аялал жуулчлалыг хөгжүүлэх боломж, бололцоог нэмэгдүүлнэ. Зураг 5.4.3 бол аялал жуулчлалын хөгжлийн боломжийг нэмэгдүүлэхэд шаардлагатай аялал жуулчлалын стратеги хөгжлийн тоймыг зургаар илэрхийлж байгаа хувилбар юм. Зурагт үзүүлж байгаачлан, зам харилцааг сайжруулснаар, зуны улиралд Монголд ирэх жуулчдын тоог нэмэгдүүлнэ. Нөгөөтэйгүүр өвлийн улиралд MICE-аар эхлүүлэх бизнес аялал жуулчлалыг хөгжүүлэх, улирлын хамааралгүйгээр бүтэн жилийн турш жуулчдын тоог нэмэгдүүлэн, тогтворжуулахыг тооцоолсон байдлаар харуулж байна. Энэхүү улирлын хамааралгүйгээр жуулчны тоог нэмэгдүүлсэнээр нислэгийн тоо өсөх, аялал жуулчлалын салбарын хүний нөөцийн тогтвортой ажлын байрыг бий болгох боломжтой болно.



Эх сурвалж : Үндэсний Статистикийн Хороо, ЖАЙКА-ийн судалгааны баг

Зураг 5.4.4 Аялал жуулчлалын салбарын боломжийг нэмэгдүүлэх аялал жуулчлалын стратеги хөгжлийн зарчим

Зорилтыг биелүүлэхэд шаардлагатай зам, харилцаа холбоог сайжруулахад хэрэгжүүлэх гол арга хэмжээний талаарх саналыг дараах байдлаар дэвшүүлж байна

- Агаарын тээврийг чөлөөлснөөр зуны улирлын нислэгийн тоо нэмэгдэх

- Гадаадын жуулчдын нийтийн тээврийн хэрэгслийг ашиглахтай холбогдуулан онгоц, төмөр зам, авто машиныг харилцан дамжин суухыг хялбарчилсан зам тээврийн төвлөрсөн байгууламжийг байгуулах
- Агаарын замын дотоодын нислэг болон төмөр замаар зорчих зорчигчдын тоог нэмэгдүүлэхийн тулд холбогч үүрэг бүхий маркетинг болон онлайн билетийн үйлчилгээг хүртээмжтэй болгох;
- Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд дэд бүтэц (авто зам, онгоцны буудал гэх мэт) -ийг сайжруулах
- Тав тухтай аялах зам тээвэр болон худалдаа үйлчилгээний байгууламжийг байгуулах (Зам дагуух үйлчилгээний газар буюу мичи но эки гэх мэт)

Эдгээр арга хэмжээг хэрэгжүүлснээр ТХГН-ийн доторх болон гаднах бүсийн зам, харилцаа холбоо сайжирч, ТХГН хоорондын хамтын ажиллагааг бэхжүүлээд зогсохгүй, аялал жуулчлалын кластерийг өргөжүүлэхэд ч хувь нэмэр оруулна.

(5) Аялал жуулчлалыг хөгжүүлэхэд шаардагдах хөгжлийн төлөвлөгөө, технологийг нэвтрүүлэх

2.9 бүлэгт дурдсанчлан Монгол улс 1998 оноос 1999 онд ЖАЙКА-аас хэрэгжүүлсэн ”Монгол улсын аялал жуулчлалын хөгжлийн төлөвлөгөөний судалгаа “ тай хамтран Аялал жуулчлалын мастер төлөвлөгөөг боловсруулан олон төрлийн аялал жуулчлалын хөгжлийн төслүүд хэрэгжүүлж байгаа. Хэдийнээ батлагдсан 2025 оныг зорилтот жилээ болгон тавьсан аялал жуулчлалыг хөгжүүлэх хөтөлбөрөөс харахад, 1999 онд батлагдсан аялал жуулчлалын мастер төлөвлөгөөг дахин шинэчлэн боловсруулах хэрэгцээ бага байгаа хэдий ч тодотгох хэрэгцээ байгаа нь илт юм. Нөгөөтэйгүүр, Монгол улсын аялал жуулчлалын хөгжил, дэвшилд шаардагдаж байгаа зүйл бол өмнө дурдсанчлан, салбарын холбогдох хүмүүс санал нэгдсэн хөгжлийн үзэл баримтлал (цогц, стратеги бодлого) ыг тодорхойлох үйл ажиллагааны төлөвлөгөө, хөтөлбөр болон үүнээс гадна тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэхийн тулд нэн даруй хэрэгжүүлэх боломжтой төлөвлөгөө юм. Тэргүүлэх салбар болох бизнес аялал жуулчлалын хөгжил, байгаль орчин, соёлын өв баялагийг хамгаалах, зам харилцааг сайжруулах зэрэг төлөвлөгөөг боловсруулах, тодотгох ажлуудад Япон улсын засгийн газар болон Японы хувийн хэвشلүүдийн технологи нэвтрүүлэх хэрэгцээ өндөр байгаа гэж үзэж байна. Ялангуяа Япон улсын зүгээс хамтран ажиллах бололцоотой салбарыг дор дурдав.

- Үйлчилгээний салбар (үйлчилгээний салбарын ажилтны сургалтын систем, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг бататгах хууль эрхзүйн орчинг бэхжүүлэх)

- Барилгын салбар (зам харилцаа, дэд бүтцийг сайжруулахад хэрэгцээтэй тохиромжтой технологи нэвтрүүлэх)
- Байгаль орчны салбар (ТХГН-ийн үйл ажиллагааны менежментын аргачлал, тогтолцоог нэвтрүүлэх гм)

Түүнчлэн энэхүү судалгааны зүгээс аялал жуулчлалын салбарт цаашид ЖАЙКА ийн дэмжлэг, хамтын ажиллагаа шаардлагатай гэж үзэж буй төслийн саналыг дараах байдлаар тодорхойлж байна.

- Тогтвортой аялал жуулчлалыг дэмжих зорилгоор аялал жуулчлалын газрын зураг боловсруулах (Аялал жуулчлалын дэд бүтцийг (Байгаль орчны стандарт, аюулгүй байдал, стандарт, үйлчилгээний стандарт, шалгуур, гэх мэт) хөгжүүлэх, бизнесийн аялал жуулчлалаас орсон орлогыг байгаль орчин, соёлын өвийг ханмгаалах үйл ажиллагаанд зарцуулах тогтвортой хамгаалах санг бий болгох талаар холбогдох хууль тогтоомжийг боловсруулах зэрэг хамрагдна.
- ТХГН-ийн менежментийн төлөвлөгөө боловсруулах, удирдлага менежментийн чадавхийг дээшлүүлэх
- Тусгай хамгаалалтын газрын хог хаягдал, цэвэрлэх байгууламжийн төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх чадавхийг сайжруулах

Аялал жуулчлалын кластер хөгжлийн стратеги төлөвлөгөө (эко хотын төлөвлөлтийг хамруулсан) боловсруулах, хэрэгжүүлэх чадавхийг бэхжүүлэх.

- Нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалыг хөгжүүлэх төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх чадавхийг бэхжүүлэх
- Хил дамнасан аялал жуулчлалыг хөгжүүлэх төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх чадавхийг бэхжүүлэх
- Хүний нөөцийг хөгжүүлэх төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх чадавхийг бэхжүүлэх

Дээрх төслийн саналд, улсын (салбар хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, холбогдох яам, тамгын газар) болон аялал жуулчлалын кластерийн хэмжээ (ТХГН, аймаг, орон нутаг) тус бүрт хөгжлийн чиг хандлага болон хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэхэд нэгдсэн цогц дэмжлэг, хамтын ажиллагаа шаардлагатай байгаа юм. Энэхүү хэрэгцээнд тохирсон урт хугацааны хамтын ажиллагаа явуулж байж, боловсруулагдсан төлөвлөгөө бодитоор хэрэгжих бөгөөд шаардлагатай чадавхи, технологи нэвтрүүлж, Монгол улсын тогтвортой аялал жуулчлалын хөгжил дэвшил баталгаажих чухал ач холбогдолтой юм.

5.5 Ажиллагаа сайтай ачаа тээвэрлэлтийн (логистик) сүлжээ бий болгох

(1) Авто зам

Автозамын сүлжээг сайжруулахад өртөг багатай, хөлдөлтөөс сэргийлсэн зэрэг Японы зүгээс нэвтрүүлэх боломжтой технологиос гадна одоо байгаа технологио ашиглан ассет менежментийн систем, ITS өндөр түвшний зам тээврийн систем, түүнчлэн Японоос гаралтай Мичиноэки буюу зам дагуух байгууламжийн сүлжээ зэрэг ачаа тээвэрлэлтийн үндсэн суурь болсон үр ашигтай, автозамын бүтээн байгуулалт хэрэгтэй.


1) Японы зам барих технологийг ашиглах

(i) Элсэн шуудайн технологи

Ажиллагаа сайтай ачаа тээвэрлэлтийн (логистик) сүлжээ бий болгоход, хамгийн саад учруулж байгаа зүйл нь томоохон хотууд, ялангуяа Улаанбаатар луу тээвэрлэх тээврийн зардал болон цаг хугацааны асуудал юм. Тиймээс орон нутгийн тусгай зориулалтын замыг сайжруулах шаардлагатай. Гэвч, орон нутгийн замын тээврийн хэмжээ маш бага ба, энгийн зэрэглэлийн замын хувьд эдийн засгийн талаас нь авч үзвэл тохиромжгүй байх талтай.

Тиймээс, бага зардлаар зам барих технологи гэж санал болгож буй элсэн шуудайн технологи гэдэг нь шуудайтай элсээр газрыг бүхэлд нь хучиж хаалт хийснээр дотор нь чихэж хийсэн ширхэг хоорондын даралт, шүргэлтийн хүч ихсэнээр бетонтой адил хэмжээний тэсвэрлэх хүчин чадал нэмэгдүүлэхийн зэрэгцээгээр ус зайлуулах хүчин чадлыг ч нэмэгдүүлэх арга юм (зураг 5.5.1). Энэхүү элсэн шуудайн арга нь Япон болон Америк, мөн Бангладеш, Кень, Уганда гэх зэрэг хөгжиж буй оронд ч гэсэн ашиглагдаж байгаа бөгөөд, 2000 гаруй амжилттай хэрэгжсэн жишээнүүд байгаа билээ. Цаашид, Монгол улсад тохирох эсэх талаар өвлийн улиралд замын далан хөлдөх гэх зэргийн асуудал байдаг тул хүйтэнд тэсвэртэй эсэх туршилт, стандартын талаар судлах шаардлагатай.

Монгол улсад ашиглах боломжтой элсэн шуудайн технологийг ашигласан малын хашааны барилгын жишээг хавсралт 5.5.1 хавсаргав.



Эх сурвалж : <http://www.soilbag.com>

Зураг 5.5.1 Элсэн шуудайн технологи болон ашигласан жишээ

(ii) Гадаргыг нөхөн сэргээх арга буюу замын гадаргын засвар үйлчилгээ

Гадаргыг нөхөн сэргээх арга буюу замын гадаргуугийн засвар үйлчилгээ нь зураг 5.5.2-т үзүүлж байгаачлан, гадаргууг халаагч машинаар хатуу хучилттай байгаа замын гадаргууг халааж, халаагч машины хойд талд суурилуулсан төхөөрөмж (Spring Tyne)–өөр гадаргууны өнгөн хэсгийг 2 см орчим хуулан хусаж, тэгээд шинээр асфальтан зам тавигч машинаар шинэ давхаргыг үүсгэх зуурмагаар зузаан нь 2 см орчим болохуйцаар тараан хучиж индүүдэн, шахагдаж хатуурсан нөхөн сэргээсэн давхарга болон шинэ давхарга гэсэн 2 давхаргаас бүрдсэн бүтэцтэй болно.



Эх сурвалж : Ohshima, Yoshihito “Japan’s Current Pavement Technology”

Зураг 5.5.2 Гадаргыг нөхөн сэргээх арга буюу замын гадаргууны засвар үйлчилгээ

Уг аргын онцлог нь халаасан хатуу хучмал замыг хусаж аваад, өнгөн давхаргын материал болгож дахин ашигладаг учраас, тухайн газраас хаягдал


материал бараг гардаггүй. Асфальтаар дахин хатуу хучихтай харьцуулахад CO₂-ын ялгарах хэмжээ 30 хувиар буурч, өртгийн тал дээр ч гэсэн 20-30 хувиар хямд тусдаг зэрэг давуу талуудыг дурдаж болно.

**(iii) The PEC (the Cold area Enhanced Pavement) аргачлал G хувилбар :
хөлдөлтөөс сэргийлэх технологи**

Зураг 5.5.3 харуулж байгаачлан хатуу хучилттай замын гадарга хэсэгт ховил гарган, тэрхүү ховил руу резин, хөлдөлтөөс сэргийлэх бодис буюу уретан давирхайнаас бүрдсэн хөлдөлтөөс сэргийлэх материалыг суулгадаг бөгөөд илүү их гулгаа үүсдэг доорхи газруудад ашиглавал зохимжтой технологи юм.

- Уулан дундах нарны тусгал муутай зам, гүүр
- Замын гадаргуун өөрчлөлт ихтэй тунелийн орох гарах хаалга
- Авто машин хурд хасах болон зогсох шаардлагатай бүхий огцом эргэлт, 4 замын уулзвар, төмөр замын гарам, налуу газар

Онцлог шинж чанар нь хөлдөлтөөс сэргийлэн бодисын хэмжээ багасч, цас арилгах ажлын үр дүнг сайжруулна. Өвлийн улиралд хийгдэх замын гадаргууны засвар үйлчилгээний ажлыг хөнгөвчлөх, хөлдөлтөөс сэргийлэх материалд харимхай чанар агуулагдаж байдаг ба, давхиж буй машины ачааны хүндийн жингээс шалтгаалаад замын гадарга дээр тогтсон мөстсөн давхаргыг буталж, хөлдөлтийг зогсоодог байна.



Зураг 5.5.3 Запек аргачлалын хувилбар G хучилтын жишээ

2) Ассет менежментийн тогтолцоог бүрдүүлэх

USAID-ын Мянганы хөгжлийн сангаас хэрэгжүүлж буй гол авто замыг хатуу хучилттай болгох ажил явагдсаар байгаа ба, улсын чанартай замын сүлжээг сайжруулах ажил дуусах шатандаа явж байна. Нөгөөтэйгүүр, гол авто замын засвар үйлчилгээний асуудлын тухайд Монгол орны эрс тэс уур амьсгалтай тул засвар үйлчилгээний тогтолцоог бий болгох нь маш чухал. Төсөв хүрэлцээгүйн улмаас тогтмол засвар үйлчилгээ хийгддэггүй одоогийн тогтолцоо хэвээр үргэлжилвэл хэдхэн жилийн дотор хаа сайгүй зам элэгдэж эхлэнэ.

Иймэрхүү засвар үйлчилгээний төсөв хөрөнгөний хүрэлцээгүй нөхцөлд ассет менежментийн тогтолцоо чухал үүрэг гүйцэтгэнэ. Ассет менежментийн тогтолцоо гэдэг нь зам, гүүр зэрэг дэд бүтцийн салбарт хөрөнгө мөнгө, хүний нөөц, төсвийг үр ашигтай удирдан зарцуулахын тулд боловсруулагдсан шинэлэг

технологи бөгөөд, цаасан мэдээллээс электрон мэдээлэл рүү шилжсэнээр мэдээлэл болон ноухау хуримтлуулан, удирдах боломжтой болдог. Нийтэд өргөнөөр хэрэглэгдэж буй ассет менежментийн программ хангамж болох HIMS нь дараах хүрээнд ашиглагдана.

- Замын байдлыг хянах систем
- Хатуу хучилтыг хянах систем
- Өдөр тутмын зам арчилгааг хянах систем
- Гүүрний менежментийн систем
- Төслийн мониторинг буюу үнэлгээний систем
- Ассет үнэлгээний систем (AVS)
- Зам тээврийн ослын мэдээллийн систем
- Тээврийн мэдээллийн систем
- Хүрээлэн буй орчин болон нийгмийн мэдээллийн систем

Ассет менежмент гэдэг нь өргөн хүрээг хамруулж, Зам тээврийн яам болон бусад холбогдох байгууллагуудын одоогийн аргачлалд тулгуурлан ИТ (мэдээллийн технологи) –ийг ашиглаж, засвар үйлчилгээний талаарх бодлогыг шийдвэрлэх арга хэрэгсэл юм. Хэрэв, олон улсын стандартын программ хангамж өндөр үнэтэй байгаа тохиолдолд дээрх үйлдлүүдийн заримыг нь багтааж, хямд төсөр үнээр Монголд тохирсон системийг бий болгох ч боломжтой.

Монгол улсын Зам тээврийн яамны Авто замын газарт өнгөрсөн хугацаанд “Азийн хөгжлийн банк”-ны техникийн хамтын ажиллагааны төслийн хүрээнд dTIMS гэдэг Шинэ Зеланд улсын программ хангамжийг нэвтрүүлэх ажлыг 2011-2012 оны хооронд хийгдсэн ба мэдээллийн бааз, сервер болох төлөвлөгөөтэй байсан хэдий ч Засгийн газрын мэдээллийн төвийн ажил дуусаагүй, замын мэдээллийн нууцлал мөн тухайн технологийг хариуцсан ажилтан нь ажлаасаа гарсан зэрэг асуудлуудаас шалтгаалан “Ассет менежментийн систем” нь ажиллахгүй байгаа.

3) ITS-ийн хэрэглээ

Монгол улсын цөөн хүн ам, тээврийн хэмжээ, өвлийн эрс тэс уур амьсгал зэрэг тусгай нөхцөлд үйл ажиллагаагаа явуулдаг зам тээврийн салбарыг хөгжүүлэхийн тулд, автозамын салбарт ITS–ийг үр дүнтэй ашиглах нь зүйтэй. Ялангуяа даац хэтрүүлсэн машиныг автоматаар илрүүлэн арга хэмжээ авах (автоматаар ачааг хэмжих), замын нэвтрэх хураамжны цахим төлбөрийн систем, ачааны машины хяналтын систем гэх зэрэг замын салбарын тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэхэд ихээхэн хувь нэмэр оруулна гэж үзэж байна. Ялангуяа RFID (радио

давтамжаар тодорхойлох ухаалаг тээврийн систем Radio Frequency Identification) чипийг ашиглах аргачлал нь харьцангуй хямд төсөр өртөгтэй ба, хөгжиж буй орнууд олонтоо ашигладаг.

(i) Даац хэтрүүлсэн авто машины хяналт болон авах арга хэмжээ

2014 оны байдлаар Монгол улс дахь нийт ачааны машины тоо 96.581 бөгөөд RFID-аар ачааны машины бүртгэл болон хяналтыг явуулахад харьцангуй хялбар юм. Эдгээр үйлдлийг багтаасан RFID унших төхөөрөмжийг суурилуулсан автомат ачааны машины хяналтын пост (зураг 5.7.4)-ыг байгуулж, даац хэтрүүлсэн ачааны машинд сүүлд нь ачааны машин эзэмшигч торгууль ноогдуулах тогтолцоог бий болгоно.




Эх сурвалж : http://www.imagicsolution.com/Unattended_Weighbridge_System.php

Зураг 5.5.4 Ачааны машины хяналтын автомат пост

Ачааны машины хяналтын пост заавал хүнгүй байх шаардлагагүй ч, Монголын нөхцөлд ачаа тээврийн хэмжээ бага, ажиллах хүчний дутагдал, эрс тэс уур амьсгал зэрэг хүчин зүйлсийг бодолцон авч үзвэл, автоматжуулах нь зүйтэй. Төлөвлөж байгаагаар Монгол улсад нийт 4 байдаг хяналтын ажилтан бүхий ачаа хэмжих постыг цаашид зураг 5.5.5-д үзүүсэнчлэн зам дагуух 70-80 орчим газарт автомат ачааны машин нэвтрэн өнгөрүүлэх газар болгон өргөжүүлж, хураамжийн орлогыг замын засвар үйлчилгээнд зарцуулах боломжтой болно. Гэвч, хэрэгжүүлэхийн тулд хууль эрхзүйн орчинг бүрдүүлэх шаардлагатай ба, ялангуяа хяналт тавих үүрэг бүхий

Замын Цагдаагийн Газар, ЗТЯ, Зам Тээвэр Хөгжлийн Төв хоорондын хамтын ажиллагааны тогтолцоог бий болгох явдал зайлшгүй шаардлагатай юм.



Эх сурвалж : ЖАЙКА Судалгааны баг (Зам тээвэр хөгжлийн төвийн мэдээлэлд тулгуурлав)


Зураг 5.5.5 Ачааны машины хяналтын автомат пост байгуулах байршил (санал)

(ii) Замын хураамжийн цахим систем

Монголд аймгийн төвүүд рүү орох хаалган дээр хураамж төлөх пост байрладаг, бусад аймаг орон нутгаас ирж байгаа автомашинаас нэвтрэх хураамж авдаг тогтолцоотой боловч, бодит байдал дээр нэвтрэх тээврийн хэрэгсэл цөөн, хүний нөөцийн дутагдал, эрс тэс уур амьсгалтэй зэрэг учир шалтгаануудаас улбаалаад зүй зохистойгоор нэвтрэх хураамж авч чадахгүй байгаа газрууд олон. Тиймээс авто машин (2014 оны байдлаар нийт 437.677 машин)-д RFID чипийг суурилуулж, цахим төлбөрийн системийг бий болгох хэрэгтэй. Ингэснээр, хөдөлмөрийн зардалыг хэмнэн, улсын чанартай зам болон орон нутгийн чанартай замын засвар үйлчилгээг явуулах санхүүгийн эх үүсвэрийг бүрдүүлэх боломжтой болно. Замын постыг автоматжуулахтай холбогдуулаад анхан шатны зардал зарцуулагдах боловч, цаашид хураамжаас тогтмол орлого орж ирнэ гэж үзэж байна.

Таамгаар бол, Монгол улсад одоо байгаа 16 аймагт байрлах постон дээр нэмээд зураг 5.7.6-д үзүүсэнчлэн 21 аймгийн төвд тус бүр 2 газар байгуулна гэж тооцож үзвэл 42 газарт цахим постыг байгуулж, хураамжийн орлого замын засвар үйлчилгээнд зарцуулагдах боломжтой болно. Гэвч, автомат ачааны машины хяналтын посттой нэгэн адил хэрэгжүүлэхэд хууль эрхзүйн

орчинг бүрдүүлэх хэрэгтэй бөгөөд ялангуяа хяналт шалгалтын ажиллагааг явуулах Замын Цагдаагийн Газар, ЗТЯ, Зам Тээвэр Хөгжлийн Төвийн хамтын ажиллагаа зайлшгүй шаардлагатай юм.



Эх сурвалж : ЖАЙКА- ийн судалгааны баг


Зураг 5.5.6 Цахим пост байрлуулах байршлын зураг (санал)

(iii) Ачааны машины байршил тогтоох хяналтын систем

Мөн нэгэн адил RFID-ыг суурилуулсан автомашин нь дээр дурдсан замын пост болон автомат ачааны машины хяналтын пост, улмаар бусад RFID-ыг уншуулах цэгийг дайран өнгөрснөөр автомашины ихэнхэд нь мониторинг явуулах боломжтой болно. Ялангуяа, ачааны машинг болон хот хоорондын автобусын байршлыг хянахад ашиглаж болно. Мөн энгийн автомашины цахим замын постоор дайран өнгөрсөн мэдээллийг ашиглан Монгол улсын эхлэл төгсгөл цэг болон тээврийн урсгалыг баримжаалах боломжтой болох бөгөөд энэхүү мэдээлэл нь цаашид зам төлөвлөлт төдийгүй эдийн засгийн хөгжлийн бусад олон салбарт ашиглагдах боломжтой болно.

(iv) Монгол улсын тээврийн салбарт RFID нэвтрүүлэхэд тулгарах асуудал

Автозамын салбарт цахим зам (дамжин өнгөрсний хураамж), ачааны машины байршил тогтоох систем, ачаа даац хэтрэлтийг хянах автомат пүү зэрэг RFID үр дүнтэй ашиглах нь мэдээлэл технологийн системийн ITS бэхжүүлэх хүрээнд нэвтрүүлэн, төмөр замын салбарт мөн вагоны хяналт болон дэд бүтцийн засвар үйлчилгээ, түүнчлэн логистикийн төвийн нийлүүлэлтийн гинжин хэлхээний хяналт (Зураг 5.7.7) зэрэг өргөн хүрээнд ашиглах бололцоотой.



Эх сурвалж : http://www.satcomlimited.com/system_integration.html

Зураг 5.5.7 RFID нийлүүлэлтийн гинжин хэлхээний хяналтын систем


Нөгөөтэйгүүр, бодит амьдрал дээр RFID ашиглалтыг нэвтрүүлэхэд, зам тээврийн салбарын хувьд хууль эрхзүйн орчинг шинэчлэн бүрдүүлэх хэрэгтэйгээс гадна хувийн мэдээлэлд халдах, хувь хүний мэдээлэл алдагдан буруу зүйлд ашиглагдахаас сэргийлэх арга хэмжээ авах шаардлагатай зэрэг хэд хэдэн асуудал бий. Мөн эхний хөрөнгө оруулалтын зардал өндөр, олон улсад хэрэглэх боломжтой давтамжийн бүс, ялангуяа хөрш орнуудтай тээвэрлэлт хийхэд ижил стандартын систем нэвтрүүлэх шаардлагатай. Түүнчлэн технологийн хувьд ч RFID чипийг уншиж тайлах хэмжилтийн нарийвчлал олон янз, түүнээс шалтгаалан чип уншуулахад цаг алдах зэрэг асуудал тулгарах нь олонтаа бий. Тэр дундаа метал болон шингэн зүйл нь RFID чип уншихад хамгийн их хүндрэлтэй тул, тухайн хэрэглээнд зохицуулан олон янзаар туршилт хийх хэрэгтэй.

4) Монгол хувилбарын "Мичино эки" төсөл

Гол зам дагуу түр амрах зориулалтын барилга байгууламж, үйлчилгээний газар байхгүй Монгол улсад авто замаар зорчих бүхий л зорчигчдод зориулсан зам дагуух үйлчилгээний цэгийг байгуулах нь чухал юм. Японы энгийн зам дагуу түр амарч буудаллах болон орон нутгийн хөгжлийг дэмжих байгууламжийг хамтатган зам дагуух байгууламж болох "Мичи но эки"-ийг барьж байгуулах ажлыг Газар, дэд бүтцийн яамнаас санаачилж, авто замаар зорчигчдод зориулсан "түр амарч буудаллах", орон нутгийн ард иргэдэд зориулсан "мэдээлэл түгээх", мөн Мичино эки-д түшиглэж, тухайн орон нутгийн иргэд хоорондын хамтын ажиллагааг дэмжих "орон нутгийн хамтын ажиллагаа" гэсэн үндсэн 3 үүрэгтэй үйл ажиллагаа явуулдаг.

Монгол хувилбарын "Мичи но эки" –ийн тухайд авч үзвэл, дээр дурдсан үйл ажиллагаанаас гадна, урт замын ачаа тээвэрлэлтэд зайлшгүй шаардлагатай

машин засварын үйлчилгээ, терминал, хяналтын цэг, ХАА-н гаралтай бүтээгдэхүүний логистик хаб төв, шуудан, ачаа хүргэлтийн төв, улмаар борлуулалтын төвийн үйл ажиллагааг төвлөрүүлж хөгжүүлэх хэрэгтэй. Иймэрхүү үйл ажиллагаатай Монгол хувилбарын “Мичино эки” зайлшгүй хэрэгцээтэй байгууламж болж байгаа бөгөөд, зураг 5.5.8 болон хүснэгт 5.5.1-т харуулснаар хоорондын зай (томоохон хэмжээний байгууламж А: 300 км орчим, дунд зэргийн байгууламж В: 100-150 км орчим, бага хэмжээний байгууламж С: 10 гаруй км)-д тохируулан “Мичино эки”-гийн хамрах цар хүрээ, хэмжээ, байршлыг цогцоор нь шийдэж байгуулах ажил чухал юм.



Эх сурвалж : Азийн Дэд Бүтцийн Судалгааны Хүрээлэн

Зураг 5.5.8 Монгол хувилбарын “Мичино эки” төсөл

Хүснэгт 5.5.1 Мичино эки-гийн цар хүрээгээр ангилсан төлөвлөгөөт газрууд

Ангилал	Газрууд
A1	Улаанбаатар (2 газар), Замын-Үүд
A2	8 аймгийн төв, 1 сумын төв, 3 улсын хилийн тулгуур төв
B1	13 аймгийн төв, 9 улсын хилийн тулгуур төв
B2	17 сумын төв
C	Бусад сумд (ойролцоогоор 300 газар)

Эх сурвалж : Азийн Дэд Бүтцийн Судалгааны Хүрээлэн

(2) Төмөр зам

1) Одоо ашиглагдаж буй төмөр замыг сайжруулах

Төмөр замын салбар дахь чухал асуудал бол, одоогийн ачаа болон зорчигч тээврийн тээвэрлэх багтаамжийг нэмэгдүүлж, цаашдын тээврийн эрэлт хэрэгцээнд тохируулан бэлтгэх асуудал гэж үзэж байна. Ялангуяа, зорчигчдод ая тухтай, ачааны аюулгүй байдлыг ханган саадгүй тээвэрлэхийн тулд, босоо тэнхлэгийн гол замын цариг болон дохиоллын системийг шинэчлэх, огцом эргэлттэй хэсгүүдийн зайг засаж шахах, вагоныг шинэчлэх, тогтмол бөгөөд хурд сайтай болгохын тулд вагоны үйл ажиллагааны хяналтын системийг сайжруулах ажил зайлшгүй шаардлагатай. Хүснэгт 5.5.2-т УБТЗ-ын босоо тэнхлэгийн гол төмөр замыг сайжруулах төлөвлөгөөг харууллаа.

Хүснэгт 5.5.2 Босоо тэнхлэгийн гол төмөр замыг сайжруулах төлөвлөгөө

Үзүүлэлт	Өнөөгийн байдал	2020 оны зорилт
Төмөр замын ангилал	3-р зэрэг	2-р зэрэг
Ачаа даацын багтаамж	21-23 сая тонн	50 сая тонн
Тогтоогдсон хурд	зорчигч- 90 км/ц	зорчигч- 120 км/ц
	ачаа- 80 км/ц	ачаа- 90 км/ц
Үйл ажиллагааны явуулах хурд	46.02 км/ц	55 км/ц
Дундаж хурд	37.38 км/ц	45 км/ц
Вагоны эргэлтийн хувь	4.5 өдөр	2.5 өдөр
Эргэлт хоорондын зайг шахах		Муруйлтын радиус 600м-ээс дооших зай нь царигийг засварлах
Царигийн засвар	Гол зам 5 590 км, салаа зам 320 км-ийг засах шаардлагатай	
Суурь баазыг сайжруулах	1949-1956 онд баригдсан. 194 газар гүүр барих шаардлагатай.	
Терминалын багтаамж	Ярдын урт 850-1250м. Хүлээж авах боломж бүхий вагоны үндсэн тоо нь дутагдалтай. Ялгах өртөө байхгүй.	Ярдыг томсгох
Зүтгүүр	Нийт : 153 вагон	Шинэ зүтгүүр : 75 вагон
	Илчит зүтгүүр: 117 вагон(48 вагон нь 20 гаруй жилийн эдэлгээтэй)	Шинэ илчит галт тэрэг : 50 вагон
	Сэлгээний зүтгүүр: 36 вагон(28 вагон нь 30 гаруй жилийн эдэлгээтэй)	Шинэ сэлгээний зүтгүүр : 25 вагон
Ачааны вагон	Нийт : 2673 вагон(1361 нь 25 жил гаруй болсон)	Шинэ ачааны вагон : 4000вагон, хөргүүртэй ачааны вагон 100 вагон
Зорчигч вагон	Нийт : 325 вагон (186 нь 25 жил гаруй)	Шинэ ачааны вагон : 72 вагон, дизель 6 вагон

Эх сурвалж: УБТЗ

2) Шинэ төмөр замын бүтээн байгуулалт

Ялангуяа, урдаас хойш чиглэсэн босоо тэнхлэгийн гол замын тээвэрлэлтэнд саад учруулж буй Улаанбаатар-Мааньт хоорондох замын тухайд авч үзвэл, эргэлт ихтэй зам болон болон энхэл донхолын талаар авах арга хэмжээ нь хязгаарлагдмал байгаа учраас, Азийн Хөгжлийн Банкнаас дэмжигдэж буй Богд

Хаан төмөр зам (Зураг 5.5.9)-ын бүтээн байгуулалт чухал ач холбогдолтой. Богд Хаан төмөр замын төсөл нь огцом эргэлт ихтэй ачааны багтаамжийн дутагдлыг нөхөж, улмаар транзит ачаа болон аюултай ачаа барааг тойруу замаар явах үйлдэлтэй болгох болно. Түүнчлэн, холгүй баригдаж буй шинэ онгоцны буудал (2017 оны 6 сард ашиглалтанд орох төлөвлөгөөтэй) болон логистик төвтэй холбогдох төмөр зам болохын хувьд холимог тээвэрлэлт хийх боломжтой байхаар төлөвлөх нь чухал.



Эх сурвалж : Зам Тээврийн Яам

Зураг 5.5.9 Богд Хаан төмөр замын төслийн төлөвлөлт

Түүнээс гадна, төмөр замын төлөвлөлтүүдээс далангийн барилгын ажлын 50%-нь хэдийнэ дуусч, бодитоор ажил болж урагшилж байгаа Таван Толгой-Гашуун Сухайт хоорондын замын бүтээн байгуулалтыг дуусгах (5.5.10) ажил нэн тэргүүнд тавигдаж байна. Энэхүү маршрут нь БНХАУ-тай адил стандартын царигтай байх бөгөөд ачаа шилжүүлэлтгүй тээвэрлэлт явуулах боломжтой болно.



Эх сурвалж : МТЗ

Зураг 5.5.10 Тавантолгой –Гашуунсухайт чиглэлийн шинэ төмөр зам

3) Төмөр замын системд олон улсын стандарт нэвтрүүлэх

Монголын Төмөр Зам явуулж байгаа үйл ажиллагаандаа түшиглэн одоогийн замыг хамруулан олон тооны төмөр замын байгууллагуудын төмөр замын удирдлагын тогтолцооны хууль эрхзүйн орчин, олон улсын стандартыг хангасан төмөр замын дохиоллын систем, хяналт, мэдээллийн системийг бий болгох шаардлагатай. Монгол улсын ЗТЯ-ны Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын технологи судалгааны хэлтсийн харьяа “Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв” байгуулагдаад байгаа бөгөөд төмөр замын гармыг алсаас удирдах боломжтой болж байна. Үүнд түшиглэн цаашид автомат хөдөлгөөний удирдлага болон хяналтын системийг бий болгож, автоматаар сэлгэх төхөөрөмжийг суурилуулж, улмаар галт тэрэгний мэдээллийн системийг бүрдүүлэх гэх зэргээр шинэлэг технологийг нэвтрүүлэх шаардлагатай. Мөн, ачаа тээврийн вагоны байршлыг хянах, холбогдох техник эд ангийн засвар үйлчилгээ зорчигч тээврийн вагоны удирдлагын хяналт гэх зэрэгт өмнө дурдсан RFID чипийг үр ашигтайгаар ашиглах явдалд найдлага тавьж байна.

Мөн, ачаа тээврийн вагоны байршил тогтоон хянах, холбогдох техник эд ангийн засвар үйлчилгээ зорчигч тээврийн вагоны удирдлагын мониторинг зэрэгт өмнө дурдсан RFID чипийг үр ашигтайгаар ашиглах явдалд найдлага тавьж байна.

(3) Агаарын тээвэр

Агаарын тээврийн салбарын тухайд хөгжлийн бололцоо бүрдүүлэх нөхцөл бол олон улсын томоохон онгоцны буудлуудтай өрсөлдөж хаб онгоцны буудал болохыг ямар ч улсын хувьд зорилтоо болгодог. Монгол Улсын агаарын тээврийн салбарын өнөөгийн байдлаас үзэхэд хаб онгоцны буудал болох боломжтой бөгөөд, Монгол улс нь Евро Азийн эх газарт оршиж буй газарзүйн байрлал, ялангуяа Улаанбаатараас баруун тийш 3,000-5,000км-ийн хооронд орших Төв Азийн хөгжиж буй орнуудын хотуудтай холбогдох гарцыг тооцоолон авч үзвэл, зураг 5.5.11-т үзүүлж байгааг Токио, Сөүл, Бээжин гэх зэрэг зүүн Азийг, эдгээр лүү агаарын шууд нислэггүй Төв Ази болон Баруун Азийн хотуудтай Улаанбаатар хотоор дамжин хамгийн богино зайд холбох нислэгийг хийх боломжтой маршрут биелэлээ олж, цаашид хаб онгоцны буудал болох боломж бүрэн дүүрэн байгаа билээ.



Эх сурвалж : ЖАЙКА-ийн судалгааны баг (суурь зураг <http://www.miat.com/pagecontent.php?pageId=11&lang=en>)

Зураг 5.5.11 Улаанбаатар хот төвтэй агаарын тээврийн сүлжээ

Агаарын тээврийн салбарын хөгжлийн бодлогын хувьд шинэлэг санаа биш хэдий ч нээлттэй агаарын бодлогыг баримталж, олон улсын зорчигч, ачаа тээврийн зах зээлийн хяналтыг уян хатан болгож, агаарын тээврийн нислэгийн тоог нэмэгдүүлэн зорчигч болон ачаа тээврийн эрэлт хэрэгцээг нэмэгдүүлэх явдал чухал. Тэр дундаа ачаа тээвэрлэлтийг хөгжүүлэхийн тулд Улаанбаатар хотын Чингис хаан онгоцны буудлын жижиг ачааны терминалыг өргөтгөж томруулах, боловсруулагдаагүй хүнсний бүтээгдэхүүн болон харьцангуй овор жин багатай өндөр үнэтэй бүтээгдэхүүнийг олон улс болон дотоодод тээвэрлэх системийг нэвтрүүлэх хэрэгтэй. Гэвч ачааг агаарын замаар тээвэрлэх үйлдвэрлэлийн эрэлт


хэрэгцээ төдийлөн бага биш хэдий ч аль улсад жилд хэдэн нислэг, хэр хэмжээний даацтай ачаа тээвэрлэх вэ зэргийг бодолцон нислэгийн тоог хир хэмжээнд нэмэгдүүлэх талаарх тооцоо тодорхой бус байгаа учраас үйлдвэрлэлийн салбарт санал асуулга хийх зэргээр нарийн тодорхой судалгаа хэрэгтэй байна. Түүнчлэн, агаарын зорчигч тээврийн хувьд авч үзвэл, транзит нислэгийг оруулаад аялал жуулчлал болон бизнесийн жуулчдын эрэлт хэрэгцээг тодорхой болгох шаардлагатай байна.

(4) Олон улсын зах зээлд ойртох, логистикийн салбарыг хөгжүүлэх

1) Олон улсын логистик

Олон улсын логистикийн коридор хэмээгдэж буй Монгол улс, ялангуяа Улаанбаатараас 3-дагч оронтой холбогдох боомт руу чиглэсэн гол олон улсын төмөр замын харилцаа холбоо буюу БНХАУ-ын маршрут (Улаанбаатар – Замын-Үүд-Тяньжин) болон ОХУ-ын маршрут (Улаанбаатар-Сүхбаатар-Наушки-Находка)-ыг зураг 5.5.12-г үзүүлж байна. БНХАУ-ын маршрут нь ОХУ-ын маршруттай харьцуулахад зай нь богино (ОХУ-ын маршрутын талаас бага), илүү хямд өртөг бүхий тээврийн зардал (ОХУ-ын маршрутын 1/3-ээс бага)-тай, орлуулах хувилбар буюу ачааны машин, мөн харьцангуй саадгүй гааль, ачаа хянах боломж гэх зэрэг ашигтай талууд олон учраас, одоогийн байдлаар том хэмжээний олон тооны ачаа БНХАУ-аар дамжин Тяньжин (зарим хэсэг нь Шанхай)-ы боомт хүртэл тээвэрлэгдэж байна.

Гэвч, БНХАУ-ын маршрутаас бүгд ачаа тээвэр хараат байх нь эрсдэлтэй учраас орлох маршрутаар ОХУ-ын маршрутыг ашиглахад бэлэн байдалд байлгах нь зүйтэй юм. Улмаар, МТЗ ОХУ-тай адилхан өргөн царигтай учраас, хил дээр ачаа шилжүүлэн ачих шаардлагагүй болох ба, боомт хүртэл зарцуулагдах өдөр нь БНХАУ-ын маршруттай бараг өөрчлөгдөхгүй (10 өдөр). Өргөн царигтай тул багтаамж сайтай ачааны вагон ашиглаж болох гэх зэргээр ОХУ-ын маршрутыг ашиглах давуу талууд бий. Энэ мэтээр 2 гол маршрутыг ашигласнаар 3-дагч орон руу чиглэсэн тогтмол логистикийн үйлчилгээг бий болгох боломжтой болно.



Эх сурвалж : ЖАЙКА-ийн судалгааны баг (Зам Тээврийн Яамны мэдээлэлд тулгуурлав)

Зураг 5.5.12 Улаанбаатараас гарах гол олон улсын төмөр замын сүлжээ

Мөн Монгол улстай адил эх газрын улсуудын хамгийн ойрхон ачаа нийлүүлэлтийн боомт хүртлэх TEU (өөрөөр хэлбэл 20 тохой чингэлэг) болон 1 километр тутам дах тээврийн зардлын харьцуулалтыг хүснэгт 5.5.3-аар үзүүлж байна. Монголд хамгийн ойр боомт (Тяньжин) хүртэлх тээврийн зардал бусад эх газрын улстай харьцуулахад үнэтэй. Энэ нь БНХАУ-ын талын тээврийн зардал өндөр төдийгүй, УБТЗ-ын дотоодын төмөр замын тээвэрлэлтийн зардал өндөр байгаатай холбоотой бөгөөд, УБТЗ-нь Монгол Оросын хувь нийлүүлсэн хамтарсан байгууллага учраас Монголын тал дангаар тээврийн зардлыг багасгах боломжгүй юм.


Хүснэгт 5.5.3 Эх газрын хамгийн ойрхон боомт хүртлэх тээврийн зардлын харьцуулалт

Хэмжигдэхүүн	Алма-Ата, Казакстан	Ташкент, Узбекстан	Душанбек, Тажикстан	Бишкек, БНКУ	УБ, Монгол экспорт	УБ, Монгол Импорт
Далайн боомт хүртлэх хамгийн ойр зай (км)	3,380	2,720	2,040	3,100	1,700	1,700
Үнэ / TEU / км (ам.доллар)	0.37	0.35	0.59	0.34	0.61	0.87

Эх сурвалж: Монголын Логистикийн Холбоо

Түүнчлэн, 40 тохой чингэлэг тутамд Азийн томоохон хотуудаас Япон (Ёкохама боомт) руу экспортлох үнийн харьцуулалтыг зураг 5.5.13-т үзүүлж байна. Улаанбаатар хот нь Манила, Сэбү, Ханой зэрэг хотоос Ёкохама хүртэлх зайтай

бараг ижил зайтай боловч, Улаанбаатар хотоос Япон улс хүртлэх экспортын зардал нь эх газраар дайрч өнгөрөх учир бусад Азийн томоохон хотуудаас экспортлох үнэтэй харьцуулахад маш өндөр өртөгтэй болж байна



Эх сурвалж : Comparison of investment cost in metropolitan cities of Asia and Oceania

Зураг 5.5.13 440 тохой чингэлгийг Япон руу экспортлох тээврийн зардал (Ёкохама боомт хүртлэх) харьцуулалт

Энэ мэтчилэн Монгол улсаас Япон болон бусад 3-дагч орон руу бараа бүтээгдэхүүн экспортлоход өндөр тээврийн зардлын асуудлыг шийдвэрлэх боломж хомс байгаа хэдий ч, Монгол улсын олон улсын логистикийг хөгжүүлэхэд шийдвэрлүүштэй асуудлыг дараах байдлаар дурдаж болно.

- (i) Боомт хүртэлх тээвэрлэлт болон логистикийн маршрутыг бий болгох, транзит ачаа тээвэртэй холбоотой хөрш орнуудтай хамтын ажиллагааны гэрээ хэлэлцээрийг хийх.
- (ii) Хөрш орнуудын хамтын ажиллагааны үр дүнд хил орчмын гаалийн системийг сайжруулах, зарцуулах цагийг багасгах (бичиг баримтыг нэгтгэх, хөнгөвчлөх, цахимжуулах)
- (iii) Дотоодын тээврийн логистикийн чанар (хурд, тээвэрлэлтийн технологи, зардал)-ыг сайжруулах.

Эдгээрээс (i) болон (ii) -ыг шийдвэрлэхэд гадны орноос тусламж дэмжлэг авах шаардлагатай авч, (iii) буюу дотоодын тээврийн асуудлыг дотооддоо шийдвэрлэх боломжтой гэж үзэж байна.

2) Дотоодын логистик

Тогтсон логистикийн сүлжээгүй Монгол улсад ХАА-н гаралтай бүтээгдэхүүний үнэнд тээврийн зардал төдийгүй бүтээгдэхүүн бэлтгэн нийлүүлэлтийн зардлын эзлэх хувь хэмжээ маш их байдаг. Түүнээс гадна, зуучлагч компаний зардал, алсын зайнаас тээвэрлэгдэх боловсруулаагүй бүтээгдэхүүн муудаж хаягдал бүтээгдэхүүн болох гэх зэргийн зардал ч ордог гэж үзэж байна. Ялангуяа, боловсруулаагүй бүтээгдэхүүний тухайд авч үзвэл, ердийн температураар тээвэрлэх үед ууршилтаас үүдэх нэгж хүндийн жинд ногдох борлуулалтын үнийн өсөлтийн асуудал байдаг.

Тиймээс, Монгол орныг бүхэлд нь хамрах тээвэрлэлтийн систем (хөргүүртэй тээвэр орно)-ийг бий болгох ажлыг түргэвчлэх хэрэгтэй. Тухайлбал, зураг 5.5.14-т үзүүлж байгаачлан тусдаа салангид байгаа бараа бүтээгдэхүүнийг бэлтгэн нийлүүлэлтийн газруудыг нэгдсэн төвд төвлөрүүлж, хадгалалтын зоорь бүхий бүтээгдэхүүний хаб төвийг орон нутаг тус бүрт байгуулж, улмаар (бүтээгдэхүүний төрлөөс шалтгаална) нийт тээврийн зардлыг хамгийн бага түвшинд байлгах газарт логистик төвийг байгуулах шаардлагатай. Улмаар дээр дурдсан бүтээгдэхүүн бэлтгэн нийлүүлэлтийн хаб төв, логистик төвтэй болон хэрэглээний бүс болон хилийн экспорт, импортын тулгуур төвтэй холбох тээврийн системийг байгуулж, хөгжүүлэх нь зүйтэй.



Эх сурвалж : Азийн Дэд Бүтцийн Судалгааны Институт

Зураг 5.5.14 Дотоодын логистик: Мах, махан бүтээгдэхүүн бэлтгэн нийлүүлэлтийн жишээ

Ялангуяа, дээр дурдсан орон нутгийн бүтээгдэхүүн бэлтгэн нийлүүлэлтийн хаб төвд анхан шатны боловсруулалт болон шинжилгээ явуулснаар бүтээгдэхүүнд нэмүү өртөг шингээн, тээвэрлэлтийн системийн үр ашиг, бүс нутгийн үйлдвэрлэлийн хөгжилд ч хувь нэмэр оруулна. Зураг дээрх CAS гэдэг нь cell alive system-г илэрхийлж байгаа бөгөөд, хүйтэнд хүнсний бүтээгдэхүүний хөлдөлт гэсэлтээс үүдэх амт чанар муудахаас сэргийлэх боломжтой хөргүүрийн технологи бөгөөд шинэхэн, дөнгөж хийсэн мэт “амт”-ыг удаан хугацаанд хадгалах боломжтой болгосноор нэмүү өртөг шингээх технологи юм. CAS-ын хэрэгцээний талаархи судалгааг хийх, нэвтрүүлэх бололцоог судлах шаардлагатай.

Мөн, эдгээр бүтээгдэхүүнийг бэлтгэн нийлүүлж, боловсруулж, хадгалж, тээвэрлэх, түгээлтийн тулгуур төвийг өмнө дурдсан Монгол хувилбарын “Мичино-эки”-тэй хослуулан барьж, түр амрах, хооллож ундлах, машин тэрэгний засвар үйлчилгээ төдийгүй, орчмын бүс нутгийн бараа бүтээгдэхүүний худалдаа, бүс нутгийн өдөр тутмын зайлшгүй хэрэгцээт бүтээгдэхүүнийг ханган нийлүүлэх тулгуур төв, боловсрол соёлын байгууллагын үүргийг гүйцэтгэх гэсэн ашигтай тал ч байгаа.

Улмаар, ачаа тээврийн хяналтын үүрэг бүхий логистик болон холимог ачаа тээврийн системийг бий болгох нь чухал. Тиймээс, одоогийн байдлаар салангид байгаа төмөр зам, авто зам, агаарын тээврийн хууль тогтоомжийг цогц болгож, нийт ачаа тээвэр болон зорчигч тээврийн байгууллагын эрх ашигт нийцсэн, тээврийн хяналт удирдлагын цогц хууль эрхзүйн зохицуулалт хийх хэрэгтэй. Мөн өмнө дурдсан RFID чипийг ачаа бүрд суурилуулснаар хяналтын үйл ажиллагааг явуулах боломжтой болно.


Монголын дотоодын логистикийн дэд бүтцийн хөгжилд нэн тэргүүнд тавигдах ажиллах ёстой Улаанбаатар, Замын-Үүдийн логистик төвийг байгуулах талаар дор тухайлан авч үзье.

(i) Улаанбаатар логистикийн төвийн төлөвлөлт

Улаанбаатар хотод одоогийн байдлаар Монгол улсын нийт ачааны бараг 90 хувь нь төвлөрөөд байгаа бөгөөд, ачаа чингэлэг хадгалах цэг хот дотор нийт 10 газар тархсан байдалтай байна. Байгууламж болон техник эд анги тоног төхөөрөмж хуучирч элэгдсэн байгаагаас үр ашиг багатай байгаа ба, ачаа цэгцлэхэд ч удаашралтай байдал үүсч байна. Улмаар баталгаат (хөргүүртэй) агуулах болон CFS (чингэлэгт хольж ачих байгууламж)-ийг нэмж барих асуудал ч нэн яаралтай хэрэгжүүлбэл зохих ажил юм.

Монгол улсын Засгийн газраас Улаанбаатар хотын олон улсын шинэ онгоцны буудлын хажууд шинэ логистик төв байгуулахаар ажиллаж байна (Зураг 5.5.15).

Санхүүжилт нь Азийн Хөгжлийн Банк (ADB) болон Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк (EBRD) болон бусад банкнаас авахаар төлөвлөж байна. Гэвч, энэхүү логистик төв нь нэг удаад янз бүрийн тээврийн хэрэгслийг ашиглах боломжтой байгууламж болохын тулд, Улаанбаатар хотыг тойрох шугам буюу Богд Хаан төмөр зам болон гол замыг сайжруулах хэрэгтэй. Төр хувийн хэвшлийн түншлэлээр байгууламж болон дэд бүтцээ сайжруулж, тодорхой үйл ажиллагаа явуулахын тулд хувийн тээврийн компани аж ахуйн нэгжүүдэд итгэл хүлээлгэн үүрэг болгох шаардлагатай болох юм.



Эх сурвалж : DB International GmbH


Зураг 5.5.15 Улаанбаатар хотын шинэ логистик төвийн төлөвлөлт

Мөн шинэ онгоцны буудалтай зэргэлдээ байгаа газар зүйн нөхцөл байдлыг ашиглаж, харьцангуй залуу бөгөөд өндөр боловсролтой боловсон хүчинг ажиллуулснаар логистик төвийн дотоод гадаад бүсийг чөлөөт худалдааны бус болгож, нэмүү өртгийг шингээсэн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх тулгуур төв болох, агаарын тээврийн салбар дахь зорчигч болон ачааны хэрэгцээг нэмэгдүүлэх гэсэн үр дүн гарна гэдэгт найдаж байна.

(ii) Замын-Үүд логистикийн төвийн төлөвлөлт

Монголын импортын ачааны бараг 70 хувь нь Замын-Үүдийн гаалиар орж ирдгээс гадна, (нүүрснээс бусад) уул уурхайн бүтээгдэхүүн экспортын гол тулгуур төв болж байгаа. Одоогийн төмөр зам (Монголын талын өргөн цариг, Хятадын талын стандарт цариг)-ын зай болон төмөр зам-ачааны машин хоорондын шилжүүлэн ачих байгууламж, уул уурхайн бүтээгдэхүүн бэлтгэн нийлүүлэлтийн байгууламж гэх зэргээр цаашид эрэлт хэрэгцээ нэмэгдэхэд ачааллыг даан ажиллах боломжгүй. Замын-Үүд БНХАУ-тай хиллэдэг хуурай

газрын боомт учраас нөөц бололцоо ихтэй. Замын-Үүдийн логистик төв (Зураг 5.7.16)-ийн талбайн хэмжээ бараг 400 га бөгөөд, түүнээс 50 га нь Азийн Хөгжлийн Банкнаас хэрэгжүүлж байгаа төслийнх бөгөөд, нэг дор олон тээврийн хэрэгслийг ашиглах боломж бүхий чингэлэгийн терминал, гааль хяналтын байгууламж, баталгаат хадгалалтын зоорь, төмөр зам хоорондын болон төмөр замаас ачааны машин хоорондын шилжүүлэн ачих байгууламж баригдахаар төлөвлөгдөж байгаа бөгөөд, 350 га нь хувийн хэвшлийн хариуцан байгуулна.



Эх сурвалж : Монголын Төмөр зам

Зураг 5.5.16 Замын-Үүд логистикийн төвийн төлөвлөгөө

Түүнчлэн БНХАУ-ын Тяньжины Dunzian-д 10 га газрыг түрээслүүлэхээр Монгол болон БНХАУ тохиролцож, Монгол улс руу чиглэсэн ачааны боомт доторх логистик байгууламж гэсэн утгаараа Замын-Үүдийн логистик төвтэй холбож, Монгол улс болон 3-дагч оронтой импорт, экспортын ачаа тээврийн үйл ажиллагааг бэхжүүлэх, мөн ТЭЗҮ-ийн судалгааны шатандаа явж байна. Энэхүү Dunzian логистик төвийг байгуулах, үйл ажиллагааны удирдан явуулах байгууллага бол Монгол БНХАУ-ын хамтарсан аж ахуйн нэгж байх төлөвтэй байгаа, БНХАУ-ын талын тээврийн зардлыг хямдруулах боломжтой гэж үзэж байна.

6 Монгол улсын аж үйлдвэрийн хөгжлийг дэмжих хууль эрх зүйн тогтолцоо, менежментийн тулгамдсан асуудал

Тус бүлэгт, Монгол улсын тогтвортой эдийн засгийн хөгжлийг дэмжих хууль эрх зүй болон засаг захиргааны менежментийн талаарх асуудлыг тоймлон үзнэ. Үүн дээр онцолж үзэх шаардлагатай олон асуудал байгаагаас судалгаанд чухал гэж үзсэн 5 асуудал дээр анхаарал хандуулж байна.

- Орон нутгийн засаг захиргааны чадавхийг бэхжүүлэх
- Орон нутгийн аж үйлдвэрийн салбарыг олон улсын нийлүүлэлтийн гинжин хэлхээнд холбох
- Тариалангийн зориулалтаар газар эзэмших тогтолцоо, хяналтын асуудал
- Худалдаа, хөрөнгө оруулалт, аж үйлдвэрийн бодлогын хүрээнд харилцан уялдаатай хамтран ажиллах шаардлага
- Япон Монголын эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийн (EPA) цар хүрээ, хувийн хэвшилтэй хамтран ажиллах боломж
- Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэх хөгжлийн менежмент

6.1 Нутгийн удирдлагын чадавхийг бэхжүүлэх

Тус судалгаагаар санал болгосон эдийн засгийн коридорын дагуу байрлах тулгуур төвүүдийг хүснэгт 6.1.1-д дурдсан ба хөндлөн ногоон тэнхлэг (зүүн бүс)-д байрлах 2 хот болох Чойбалсан, Чингисээс бусад тэнхлэгийн дагуу орших бүх хотын хүн ам 2000 оноос хойш улсын дунджаас давсан өсөлттэй байсан байна. Орон нутаг дахь нийтийн үйлчилгээг сайжруулж, хэт сийрэгжилт хэт төвлөрөлтийг шийдвэрлэж, нийт нутаг дэвсгэрийг тэнцвэртэйгээр ашиглах үүднээс амьдрах орчныг цогцоор нь бүрдүүлэх нь тэнхлэгээр хөгжүүлэх үзэл санааны нэг чухал тал юм. Тиймээс эдгээр хот, тулгуур төвүүдэд тулгараад буй дэд бүтэц (ус, дулаан хангамжийн систем) хуучирч муудсан, ариутгах татуурга, хатуу хог хаягдлын хяналт зэрэг суурь асуудлуудыг даруй шийдвэрлэх шаардлагатай байна (Эрдэнэтээс бусад). Гэвч орон нутагт дэд бүтцийг хөгжүүлэх эрэлт хэрэгцээ өндөр хэдий ч орон нутаг дахь төлөвлөлтийн чадавхийг бэхжүүлэх шаардлага, санхүүгийн эрэлт улам бүр өсөн нэмэгдэж буй гэсэн 2 асуудал байна.

Хүснэгт 6.1.1 Стратегийн эдийн засгийн корридорыг дэмжих хот суурийн газар

	Аймаг	Тулгуур төв	Хүн ам (2014)	Хүн амын дундаж өсөлт*(2000-2014)
Аж үйлдвэрийн босоо тэнхлэг	Дархан-Уул	Дархан	79,938	1.40%
	Орхон аймаг	Эрдэнэт	88,670	1.99%
	Говьсүмбэр аймаг	Чойр	11,609	1.85%
	Дорноговь аймаг	Сайншанд	22,666	1.54%
Ногоон хэвтээ тэнхлэг	Хэнтий аймаг	Чингис	20,585	0.96%
	Дорнод аймаг	Чойбалсан	41,932	0.32%
	Орхон аймаг	Эрдэнэт	88,670	1.99%
	Дархан-Уул	Дархан	79,938	1.40%
Нийслэл Улаанбаатарын бүс	Улаанбаатар хот	Багануур	28,000**	2.62%**
	Улаанбаатар хот	Налайх	33,000**	2.93%**
	Төв аймаг	Зуунмод	16,094	0.58%
Баялгийн өмнөд тэнхлэг	Өмнөговь аймаг	Даланзадгад	22,187	3.32%
	Дорноговь аймаг	Сайншанд	22,666	1.54%

Тайлбар :* Улсын дундаж (1.20%)-аас давсан өсөлтийг доогуур зураасаар тодотгов. ** нь 2000~2010 оны дундаж
Эх сурвалж: ҮСХ

(1) Орон нутаг дахь төлөвлөлтийн чадавхийг хөгжүүлэх асуудал

Орон нутгийн дэд бүтцийн төлөвлөлтийг судалж үзэхэд Эрдэнэт, Дархан, Чойбалсангаас бусад аймгийн төвүүдэд засаг захиргааны байгууллагад төрөл бүрийн салбарын мэргэжилтнүүдийг ажиллуулах боломж хомс, түүнчлэн тухайн орон нутгийн зөвлөх мэргэжилтэн, инженерүүд цөөн байгаагаас төвөөс баталсан жишиг зураг төслийг тэр хэвээр нь төлөвлөгөө болгон ашиглах тохиолдол ажиглагдсан. Нөгөөтэйгүүр аймгийн төвүүд хоорондоо нэлээд адил төстэй боловч тухайн хотын хүн амын оршин суух бүсийн байршил, цар хэмжээ, байрзүй, усны нөөц зэрэг нөхцлүүд ялгаатай тул эдгээр ялгааг харгалзалгүй төлөвлөснөөр эдийн засгийн хувьд ч засвар үйлчилгээний талаас ч бэрхшээл үүсэх магадлалтай. Инженерийн түвшний нарийн мэргэжлийн боловсон хүчнийг орон нутагт сургах нь одоогийн Монгол улсын засаг захиргааны тогтолцооны хувьд хүндрэлтэй тал байгаа боловч зам, ус хангамж, ариутгах татуургын сүлжээний тохиромжит хувилбарыг олох, төслийн төсвийг зохиох зэрэг төлөвлөлтийн үндсэн чадварыг хөгжүүлэх шаардлага тулгараад байна.

Хот байгуулалтын мэргэжилтнүүдийг жишээ болгон авч үзэхэд, аймаг тус бүрийн газрын харилцаа, барилга хот байгуулалтын албыг 16 ажилтантай байхаар заасан байдаг бол тухайлбал Орхон аймагт албаны дарга, хуульч, нарийн бичиг, мэдээллийн технологи, санхүү хариуцсан ажилтан зэрэг захиргааны хэлтсийн ажилтануудаас гадна Газрын харилцааны хэлтэст 5 мэргэжилтэн, Барилга, хот байгуулалтын хэлтэст 6 мэргэжилтэн байдаг бол Дорнод аймаг (төв Чойбалсан)-ийн 18 мэргэжилтэнээс 3 нь архитектор, 15 нь газар зохион байгуулагч буюу тэнцвэргүй бүтэцтэй байна. Аймгийн

түвшинд хариуцсан ажил үүргийг доорх хүснэгтэд нэгтгэсэн бөгөөд инженерийн чиглэлийн ажил ч байгаагаас харахад Дорнод аймагт инженер байдаггүй байна. Түүнчлэн аймгийн төвд байх сумын хот байгуулалтын төлөвлөгөөний явцыг хавсралт 4.1.1-д дурдсан ба тухайн төлөвлөгөөг боловсруулах ажлыг ч Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар голчлон гүйцэтгэдэг боловч нэг санхүүгийн жилд хийгдэж буй хэрнээ явц нь ихээхэн зөрүүтэй байна. БХБЯ-наас ч орон нутаг дахь төлөвлөгөө боловсруулалтын мэргэжилтэй боловсон хүчин дутмаг байгаа тул ЖАЙКА байгууллагаас дэмжлэг авах хүсэлтэй байгаа талаар дурдаж байсан.

Хүснэгт 6.1.2 Орон нутгийн ГХБХБалбаны бүтэц зохион байгуулалт (Орхон аймаг)

	Газрын харилцааны хэлтэс	Барилга хот байгуулалтын хэлтэс
Ажилтан	<ul style="list-style-type: none"> Хэлтсийн дарга Барилгажсан бүс, уул уурхай, дэд бүтэц, газар сэргээлт хариуцсан GIS-ийн Кадастрын зураг хариуцсан Бэлчээрийн газар хариуцсан 	<ul style="list-style-type: none"> Хэлтсийн дарга Дэд бүтцийн сүлжээ хариуцсан Барилга, технологийн хяналт Орон сууц, нийтийн хангамж Барилгын материал, лаборатори Лабораторийн судлаачид
Үндсэн чиг үүрэг	<ul style="list-style-type: none"> Газрын тухай хуулийн хэрэгжилтийг орон нутагт хангах МУ-ын ЗГ, аймгийн засаг даргын мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх Аймгийн ЗДТГ-ын шийдвэрийг хэрэгжүүлэх Газартай холбоотой мэргэжлийн заавар зөвлөгөө Аймгийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг боловсруулах, аймгийн ИТХ-д танилцуулах, батлуулах Аймгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийн зорилгод санал оруулах Газар эзэмжих эрхийн тендер, сонгон шалгаруулалтыг зохион байгуулах Аймгийн ЗД-ын шийдвэрээр иргэд, хуулийн этгээдтэй газар өмчлөх, эзэмших гэрээ байгуулах, батламж гаргах, гэрээг хянах Газар өмчлөх, эзэмших төлбөрийн гэрээ байгуулах, хянах Газрын тухай хуулийн зөрчлийг анхааруулах, холбогдох байгууллагад мэдээлэх Кадастрын мэдээлийн санг хянах, шинэчлэх, мэдээллээр хангах Газрын тухай хуулийн дагуу кадастрын зураг боловсруулах Иргэдэд газар өмчлөхөд нь дэмжлэг үзүүлэх Газрын татвар ноогдуулах Газрын тухай хуулийг сурталчлах, мэдээллээр хангах Газрын тухай мэдээ, мэдээллийг холбогдох байгууллага (улс)-д танилцуулах 	<ul style="list-style-type: none"> Барилга, дэд бүтэц, нийтийн үйлчилгээний стандарт, норм, дүрмийн хэрэгжилтийг хянах Шинээр болон шинэчлэн барих, өргөтгөх, засварлах ажлын техникийн хяналт Барилга угсралтын ажлын үе шат тус бүрийг хянах Хот байгуулалт, хот суурины урт хугацааны төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулахад санал оруулах, тэдгээрийг хэрэгжүүлэх Гудамж, талбайн нэршил, барилгын дугаарлалт Шинэ барилгын техникийн комиссын бүрэлдэхүүнд оролцох Зураг төслийн компанид эх зураг бэлтгэж өгөх, ерөнхий төлөвлөгөөтэй нийцэж буй эсэхийг хянаж батлах Зураг төсөл, судалгаа, барилга угсралт, барилгын материалын компанийн тусгай зөвшөөрлийг сунгах, хүчингүй болгохтой холбогдсон судалгаа, холбогдох байгууллагад (улсад) өргөн барих Хотын ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр, дэд бүтцийн төлөвлөгөө, төслийг зохиох Барилга, хот байгуулалтын зураг боловсруулах, иргэдийг мэдээллээр хангах Байршилзүйн зураг хийх Зураг төслийн ажлын даалгаврыг боловсруулах Дэд бүтцийн сүлжээний мэдээллийн санг бүрдүүлэх, иргэдийг мэдээллээр хангах Тусгай зөвшөөрөл бүхий хувийн хэвшлийн ААН-ийн үйл ажиллагаанд няналт тавих Тусгай зөвшөөрөл бүхий хувийн хэвшлийн ААН-ээс өгсөн мэдээ мэдээлэл, судалгааг нэгтгэн холбогдох байгууллага (улсад) өргөн барих

Эх сурвалж: Орхон аймгийн ЗДТГ

(2) Орон нутаг дахь санхүүгийн эрэлт, хэрэгцээний өсөлт

Орон нутгийн дэд бүтцийн хэрэгцээ шаардлага өндөр хэдий ч зам, цэвэр бохир усны шугам сүлжээ, эрчим хүч хангамжийн ажлуудаас харахад шаардлагатай санхүүжилтийн хэмжээ нь Японы Засгийн газрын зээл тусламжийн хамтын ажиллагааны төслийн хүрээнд хэрэгжүүлэхэд дэндүү бага байна. Гэвч бодит байдал дээр орон нутагт ийм хөрөнгө бараг байхгүй тул Засгийн газрын төсвийн хуваарилалтаас ихээхэн хамааралтай байдаг нь харагдаж байна. Ийнхүү төвөөс хамааралтай санхүүгийн бүтэцтэй байх нь зөвхөн Монгол улсад ажиглагдаж байгаа зүйл төдийгүй хөгжиж буй орнуудад нийтлэг байдаг үзэгдэл юм. Тиймээс төвөөс

хуваарилдаг нийгмийн хөрөнгийн хуваарилалт нь аль болох санхүүжилт хийхэд хялбар аргаар зохицуулагддаг бөгөөд хэрэгцээ шаардлагыг төдийлөн авч үзэхгүй байх магадлал өндөр байна.

Орон нутгийн бие даасан байдлыг дэмжиж, дээр дурьдсанчлан орон нутгийн төлөвлөлтийн чадавхийг сайжруулахын тулд юуны өмнө хөрөнгө оруулалттай холбоотой өмчлөлийн асуудлыг шийдэх шаардлагатай. Үүнд өөрийгөө санхүүжүүлэх харьцааг нэмэгдүүлэх нь зүйтэй. Өнөөгийн мэдээллийн технологийг ашиглан нэмүү өртгийн албан татвар, борлуулалтын татварын мэдээллийг Point-Of-Sale дээр төвлөрүүлж, татвар хураах, түүнийг хуваарилах замаар орон нутгийн татварын хувийг нэмэгдүүлэх боломжтой юм. Ийнхүү орон нутгийн санхүүгийн тогтолцоог сайжруулах явдал нь орон нутгийн хот байгуулалтыг төлөвлөхөд зайшлгүй шийдэх ёстой асуудал юм.

Монгол улсад бий болж буй хотжилт болон хот суурин газрын байгаль орчны асуудал нь хөдөө орон нутгийн аль ч хотуудад ижилхэн байдлаар өсөн нэмэгдсээр байна. Өөрөөр хэлбэл гэр хороолол нь олон нийтийн байгууламжийг тойрон хүрээлэх маягаар улам бүр хүрээгээ тэлж байна. Хүснэгт 6.1.3 дээр энэхүү судалгаанд хамрагдсан гол хотуудын гэр хорооллын хүн амын харьцаа болон хүйтний улирлын агаарын бохирдлын байдлыг харууллаа. Гол хотуудад хүн амын 50-иас илүү хувь нь гэр хороололд амьдардаг бөгөөд Улаанбаатар хот үүнээс илүү давсан харьцаатай байна. Энэ нь хот төлөвлөлт, хотын дэд бүтцийг хөгжүүлэхэд томоохон бэрхшээл учруулж байгаа юм. Агаарын бохирдлын хэмжээ нь гэр хорооллын хувь их байх тусам их асуудал үүсгэж байна.

Хүснэгт 6.1.3 Судалгаанд хамрагдсан хотын хүн ам, гэрийн харьцаа, агаарын бохирдол

Аймаг	Аймгийн төв	Хүн ам (2014)	Гэр хорооллын хүн амын харьцаа	Агаарын бохирдлын асуудал
Дорнод аймаг	Чойбалсан	41,932	50%	○
Орхон аймаг	Эрдэнэт	88,670	60%	▲
Говьсүмбэр аймаг	Чойр	11,609	40%	—
Хэнтий аймаг	Чингис	20,585	80%	▲
Элаанбаатар хот	Багануур	28,000	60%	—
Улаанхбатар хот	Налайх	33,000	—	—
Дорноговь	Сайншанд	22,666	60%	—
Дархан-уул	Дархан	799,938	40%	—

Эх сурвалж: МСХ, БХБЯ, ЖАЙКА-ийн судалгааны баг, Агаарын бохирдлын асуудал: Аймгуудын захиргааны мэргэжилтэнгүүдээс авсан мэдээлэлд тулгуурлав.

Чойбалсан хот 1987 оноос хойш агаар дахь хүхрийн давхар исэл, азотын давхар ислийн хэмжээг тогтмол хэмжиж ирсэн байна. Хэмжилтийн үр дүнд стандартаас давсан үзүүлэлт ажиглагдаагүй боловч азотын давхар исэл стандартад хэижээнд дөхөж очихуйц

өндөр үзүүлэлттэй байх тохиолдол байдаг байна.

Хүснэгт 6.1.4 Чойбалсан хотын агаар дахь хүхрийн давхар исэл, азотын давхар исэл

	SO ² mg/m ³			NO ² mg/m ³		
	Дундаж	Дээд	Доод	Дундаж	Дээд	Доод
2012	0.013	0.069	0.001	0.019	0.074	0.004
2013	0.009	0.055	0.0	0.018	0.061	0.003
2014	0.009	0.095	0.0	0.019	0.061	0.003
Стандарт (20 минут хэмжихэд)	0.450			0.085		

Эх сурвалж: Дорноговь аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний газар

Хөдөө орон нутгийн байгаль орчны асуудал нь хүйтний улирлын агаарын бохирдлоос гадна хог хаягдлын хяналтын систем, ус хангамжийн систем, бохир усны цэвэрлэх байгууламж, хот суурин газрын дулаан түгээх системийн байгууламж байхгүй, эсвэл байгууламжийн тоног төхөөрөмж хуучирсан гэх зэрэг хоорондоо харилцан адилгүй ч бүгд ижилхэн асуудалтай тулгарч байгаа юм. Зарим хотуудад АХБ, ЕСБХБ-ын дэмжлэгтэйгээр хөдөөгийн хот суурин газруудын дэд бүтцийг сайжруулах төсөл хэрэгжиж байгаа ч засвар үйлчилгээг тухайн орон нутаг өөрсдөө хариуцдаг бөгөөд орон нутгийн засаг захиргаа нь өөрсдийн төсвөөс гаргадаг тул эдгээр олон нийтийн байгууламжийн тогтвортой үйл ажиллагааг хангах үйл ажиллагааны зардал, нөхөн сэргээх төсөв зэрэг хөрөнгө оруулалтын зардлыг даахуйц, санхүүгийн чадавхийг бэхжүүлэх явдал зайлшгүй шаардлагатай байна. Энэ нь орон нутгийн бие даасан байдалтай шууд холбоотой улс төрийн томоохон асуудал ч гэж хэлж болно.

6.2 Орон нутгийн аж үйлдвэр, олон улсын нийлүүлэлтийн гинжин хэлхээнд холбогдох тухай


(1) Гадаадын шууд хөрөнгө оруулалтаар технологи нэвтрүүлэх

Монгол улсын аж үйлдвэрийн хөгжилд эдийн засгийн тогтвортой байдлыг хадгалахын тулд аж үйлдвэрийн тэнцвэргүй бүтэц, зарим бүсэд эдийн засаг хэт төвлөрсөн байдлыг тэнцвэржүүлж, аж үйлдвэрийг төрөлжүүлэх нь чухал асуудал болоод байна. Энэ үүднээс 5-р бүлэгт зорилтот санаа, зөвлөмж дэвшүүлсэн ба илүү өргөн өнцгөөс харвал эдгээр ул үндэс нь аж үйлдвэрийн салбар тус бүрийн тулгуур үйлдвэрлэлийг бий болгон хөгжүүлэх, орон нутгийн аж үйлдвэрийг хөгжүүлэх явдал юм.

Боломжит тулгуур үйлдвэрлэлийг бий болгон хөгжүүлэхэд үйлдвэрлэлийн төвлөрөл буюу кластераар эдийн засгийг өргөжүүлж, үйлдвэрлэлийн бүтээмж, үр ашгийг нэмэгдүүлэх нь чухал. (Ялангуяа бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн салбар сул хөгжсөн Монгол улсын хувьд үйлдвэрлэлийн кластер хөгжил зайлшгүй шаардлагатай.) Улмаар эдгээр төвлөрсөн үйлдвэрлэлийг илүү том нийлүүлэлтийн сүлжээнд холбох шаардлагатай. Одоо Монгол улсад Чөлөөт худалдааны бүс, аж үйлдвэрийн цогцолбор, ХАА-н үйлдвэрлэл, технологийн парк зэрэг дэд бүтцийг бий болгосноор үйлдвэрлэлийн төвлөрөл үүсч эхлээд байна. Тогтолцооны хувьд ч Концессийн тухай хууль (2011 он), Чөлөөт бүсийн тухай хуулийн шинэчилсэн найруулга (2015 он), Аж үйлдвэрлэлийн паркийн тухай хууль (2009 он) зэрэг хууль эрх зүйн орчин бүрдэж эхлэхийн зэрэгцээ ХАА-н үйлдвэрлэл технологийн паркийн тухайд “Аж үйлдвэрийг хөгжүүлэх бодлого”-ын хүрээнд түүнийг байгуулах тогтолцоог бүрдүүлж өгсөн (2015 он). Цаашид эдгээрээс гадна ЖДҮ-ийн тухай хууль (2007 он)-д заасан ЖДҮ-ийг хөгжүүлэх дэмжлэгийн хүрээнд орон нутгийн үйлдвэрлэлийг хөгжүүлж, “Аж үйлдвэрийг хөгжүүлэх бодлого”-д ч заасан кластерийн хөгжлийн үзэл санаа зэрэг оюуны (технологи гм) талыг тулгуур болгосон төвлөрөл, хамтын ажиллагааны стратегийг бодитоор хэрэгжүүлэх нь чухал. Үүний тулд цаашид ч стандартчилал, төрөл бүрийн технологийн удирдамж, төвлөрлийг дэмжих санхүүгийн тогтолцоо, үйлдвэрлэл, эрдэм шинжилгээ, төрийн хамтын ажиллагааг бодитоор хэрэгжүүлэх нь зүйтэй.

Мөн нийлүүлэлтийн гинжин хэлхээнд холбогдох талаар хууль эрх зүйн орчны үндэс суурь нь “Өрсөлдөөний тухай хууль” (2010 он), “Хөрөнгө оруулалтын тухай хууль”-ийн шинэчилсэн найруулга (2013 он) батлагдсанаар бүрдээд байгаа юм. Түүнчлэн “Үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль” (2015 он)-д заасан экспортын баримжаатай үйлдвэрийг хөгжүүлэх, дэмжих арга хэмжээний хүрээнд орон нутгийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх, дэлхий нийтийн нийлүүлэлтийн гинжин хэлхээнд холбогдох ажлыг дэмжих орчин ч бүрдсээр байна. Цаашид хуулийн хэрэгжилтийг хангахын зэрэгцээ нийлүүлэлтийн гинжин хэлхээнд холбогдон аж үйлдвэрийг үр ашигтайгаар хөгжүүлэх, урт хугацаанд ч тогтвортой байх стратегийг хэрэгжүүлэх

шаардлагатай. Тухайлбал, богино хугацаанд үйлдвэрлэлийн кластер төвлөрлөөр дотоодын нийлүүлэлтийн сүлжээг хөгжүүлж, дараа нь (хүн хүчний зардал гэх мэт энгийн харьцуулалт биш) нэмүү өртгийг илүү шингээсэн оюуны өмч (технологи гэх мэт)-д тулгуурласан дэлхий нийтийн нийлүүлэлтийн гинжин хэлхээнд холбогдох (гадны хөрөнгө оруулалттай уялдуулах) ажлыг хийж нийлүүлэлтийн гинжин хэлхээг нутагшуулах замаар зах зээлийг өргөтгөн түүний үр дүнд аж үйлдвэрийн цар хүрээг тэлэх боломжтой.



Эх сурвалж : ЖАЙКА-ийн судалгааны баг

Зураг 6.2.1 Нийлүүлэлтийн гинжин хэлхээнд холбогдох, аж үйлдвэрийг төрөлжүүлэх шат дараалал

6.3 ХАА-н зориултай газар өмчлөх эрх, хяналтын асуудал

(1) Бэлчээр газар, газар тариалангийн газрын өнөөгийн байдал

“Газрын тухай хууль” (2002 оны шинэчилсэн хувилбар) ”Газар өмчлүүлэх тухай хууль” (2003 оны)-нд өмчийн эрхийг дараах байдлаар ангилсан байна

¹.

(i) Газар өмчлөх эрх (ownership)

Тухайн газрыг захиран зарцуулах эрхтэйгээр хуулиар зөвшөөрсөн хүрээнд өөрийн мэдэлд байлгахыг хэлнэ

(ii) Эзэмших эрх (possession)

Газар эзэмших гэрээнд заасан зориулалт нөхцөл болзлын дагуу хуулиар зөвшөөрсөн хүрээнд өөрийн мэдэлд байлгахыг хэлнэ. Эзэмшлийн газрыг ашиглахад (газрын худалдаа эрхлэх боломжгүй) улстай гэрээ байгуулж (тодорхой хугацаанд эзэмших эрх), газар эзэмшүүлэх гэрээний тусгай нөхцөл болзлын дагуу хуулийн зөвшөөрсөн хүрээнд Монгол улсын иргэн, байгууллагад л олгодог. Газрын хуулиар дараах 3 эрх олгогдон.

- 60 жил сунгах боломжтой, нэг удаа хүсэлт гаргахад 40 жил сунгах боломжтой
- Эзэмших эрхтэй газрыг бүхэлд нь болон хэсэгчлэн түрээслэх боломжтой.
- Газрын гэрчилгээг бусад иргэн, аж ахуйн нэгж байгууллагад бэлэглэх болон эрхийг шилжүүлэх боломжтой.

(iii) Газар ашиглах эрх (user right)

Газар өмчлөгч (Төр болон иргэн) болон эзэмшигчтэй байгуулсан гэрээний дагуу газрын аль нэг ашигтай чанарыг хуулиар зөвшөөрсөн хүрээнд ашиглахыг хэлнэ.

ХАА-н газрын тухайд Хүснэгт 6.3.1-г заасны дагуу бэлчээрийн мал аж ахуйд өмчлөх эрх байхгүй, өвөлжөө, хаваржааг өмчлөх тохиолдол байдаг ч, үндсэндээ ашиглах эрхээр хязгаарлагддаг. Харин тариалангийн газар өмчлөх эрхийн хамт 3 эрх нээлттэй байна.


¹ Монголын тухай судалгаа 20-р дугаар”Монгол улсын газрын тухай хуулийн эмхэтгэл” Газрын тухай хууль 2002, Социализмын дараах үеийн малчид, газар өмчлөлийн бодлого, 2008. Хуулийн судалгаа 53-р дугаар, “Монгол улсын нүүдлийн мал аж ахуй, газар өмчлөл” 2015-ыг ашиглан ЖАЙКА-ийн судалгааны баг боловсруулав.

Хүснэгт 6.3.1 Суурин газар, ХАА-н газрын хуваарилалт, өмчийн эрх

Газрын ангилал	Газрын хэлбэр	Ашиглалтын хэлбэр	Өмчийн эрх
Суурин газар(хот, болон бусад суурин газар)	Хот/ тосгон/ бусад Суурины барилга байгууламж/үйлдвэр, уул уурхай дэвсгэр болон эдэлбэр газар	Өрхийн газар/амьдралын газар(газар газрыг хамруулахгүй)	өмчлөх эрх эзэмших эрх ашиглах эрх
ХАА-н газар	Бэлчээрийн газар	Өвөлжөө/ хаваржаа	эзэмших эрх / ашиглах эрх
		зуслан/намаржаа/отрын газар	ашиглах эрх
	Суурин мал аж ахуйн газар		орон нутгийн шийдвэрийг үндэслэнэ
	Хадлангийн газар		эзэмших/ашиглах эрх
	Тариалангийн газар	тариалангийн газар/ уриншилсан газар	өмчлөх эрх эзэмших эрх ашиглах эрх

Эх сурвалж: Социализмын дараа Монгол оронд малчдад хэрэгжүүлсэн газар хувьчлалын бодлого (2008) ЖАЙКА-ийн судалгааны баг

Зураг 6.3.1 дээр ХАА-н зориулттай газрыг ногоон өнгөөр тодотгож харуулсан байна. ХАА-н зориулттай газрын ангилалд багтах газар нь сумдаа бүртгэгдэж, тухайн мэдээлэл нь аймагт ирж, мэдээллийг баталгаажуулсны дараа Газрын харилцаа, геодези, зураг зүйн газарт хүргүүлж нийтийн мэдээллийн санд бүртгэгддэг.



Эх сурвалж : Газрын харилцаа, геодези зураг зүйн газар

Зураг 6.3.1 ХАА-н зориулттай газар

2003 оны Газрын тухай хуульд хөдөө орон нутагт газар эзэмшихэд үр тариа, малын тэжээлийн ургамал тариалах тариалангийн газрын хэмжээ 3,000 га, төмс, хүнсний ногоо болон бусад ургамал тариалах газрын хэмжээ 50 га байхаар баталсан ч 2008 онд уг хуулийг шинэчлэн найруулснаар дээд хязгаарыг дахин шинэчилж үр тариа, тэжээлийн ургамлын тариалангийн талбайг 20,000 га, төмс, хүнсний ногоо болон бусад ургамлын тариалангийн талбай 200 га болгосон байна.

нэ нь уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг компаниуд хэдэн арван мянган га газар эзэмшиж, ашиглах чадвартай болж ХАА-н салбар луу түрж орж ирж ирсэнтэй холбоотой байна. Доорх хүснэгтэд (6.3.2) 2008 онд шинэчилсэн эзэмшлийн газрын ашиглах нөхцлүүдийг харуулсан.

Хүснэгт 6.3.2 Эзэмшлийн газрын ашиглалтын нөхцөл : орон нутаг (аж ахуйн нэгж/иргэн), Улаанбаатар дахь дээд хязгаар (2008 оны шинэчилсэн хувилбар)

Ашиглах нөхцөл	Орон нутаг(аж ахуйн нэгж/ иргэн)	Улаанбаатар
Үр тариа, тэжээлийн ургамлын тариалалт	20,000ha	200ha
Төмс, хүнсний ногоо бусад ургамлын тариалалт	200ha	5ha
Хадлангийн газар	1,500ha	100ha
Дотоодын хэрэгцээний хадлангийн газар	400ha	50ha

Эх сурвалж : Газрын харилцаа, геодези зураг зүйн газар, ЖАЙКА-ийн судалгааны баг

(2) Газар тариалангийн газрын ашиглалттай холбоотой газрын тогтолцооны асуудал

Уламжлалт ёс жаягаар зохицуулагдаж ирсэн бэлчээрийн газрын ашиглалт нь орчин үеийн газар өмчлөл, газар зохион байгуулалтын тогтолцоонд орсоноор төрөл бүрийн асуудлуудтай тулгарах болоод байна. Асуудлуудыг бодитоор гаргаж ирэхийн тулд тариаланчид, засаг захиргааны ажилтан, эрдэмтэн судлаачдаас тодруулж дараах байдлаар багцаллаа.


1) Газар тариалангийн зориулалтаар газар ашиглах тухай

Газар өмчлүүлэх тухай хуулинд газрын дээд хязгаарыг тогтоож өгсөн байдаг, үүний дагуу орон нутаг (сум, аймаг)-т газар тариалан болон бэлчээрийн газрыг ашиглах дээд хэмжээг мөн заасан байдаг. Ялангуяа төв орон нутгуудад (Говьсүмбэр, Дархан-Уул, Дорноговь, Дундговь, Өмнөговь, Сэлэнгэ, Төв аймаг) газар тариалан эрхлэх зориулалтаар ашиглах газар бүгд эзэмших эрхийн дагуу ашиглагдаж байгаа тул дахин шинээр газар эзэмших хүсэлт гаргасан ч газар тариалангийн зориулалтаар ашиглах газар байхгүй байна. Мөн тухайн жилийн газар ашиглалтын төлөвлөгөөнд сумын засаг дарга болон газрын даамлын ашиг тусын сонирхлоор батлагдахгүй байх асуудал гарч ирдэг байна.

2) Бэлчээр газрын бүртгэл, түүний эзэмшилд халдах явдал

Бэлчээр ашиглалтын тухайд Газрын хуулийн 52.2-р зүйлийн заалтад заасны дагуу малчдын баг, хот айлаараа нийтээр ашиглана. Малчид бэлчээрийг ашиглах тухай хүсэлтээ ИТХ-д гаргаж, зөвшөөрвөл тодорхой болзол нөхцөлтэйгээр эзэмшүүлэх боломжтой болно. Хэрэв шилжиж нүүж ирсэн малчид өвөлжөө хаваржааны газар ашиглах тухай хүсэлтээ сумын ИТХ-д гарган хэлэлцүүлж, зөвшөөрвөл газрын даамал газар зохион байгуулалтын төлөвлөгөөндөө тусгаж сумын Засаг даргын захирамжаар эцэслэн шийдвэрлэнэ. Бэлчээрийн нарийн хил хязгаарын талаар уламжлалт аргаар хоорондоо ярилцан хэлэлцэх, амаар тохирох маягаар ашиглах зөвшөөрөл авдаг.

Өвөлжөөг эзэмших эрх нь 1 малчин айлд 0,7 га байдаг бөгөөд тэндээсээ эргэн тойрны 3-5 км-ийн радиус дотор газрыг бэлчээрийн зориулалтаар ашиглаж болно (Хуулийн заалтын дагуу биш, амьдралын хэрэгцээний дагуу). Энэхүү газар нь ойролцоох малчдын эзэмшил газартай давхцах тохиолдол бас гардаг байна. Бусад малчид тухай орон нутагт ирж малаа бэлчээх ийм тохиолдолд тухайн бэлчээр газрын эзэмшигчтэй зөвшилцөж зөвшөөрөл авах шаардлагатай болдог. Бусдын эзэмшлийн газарт малаа бэлчээх тохиолдолд 6 сар хүртэл хугацаанд мэдэгдвэл харьцангуй боломжтой, 8 сараас хойш өвлийн өвс тэжээлээ бэлтгэх, базаах ажилтай давхцдаг тул гаднаас мал оруулахыг төдийлөн сонирхдоггүй байна (Зураг 6.3.2).




Эх сурвалж : Ярилцлагын дүнгээс ЖАЙКА-ийн судалгааны баг боловсруулав

Зураг 6.3.2 Бэлчээр эзэмших эрх, ашиглах хүрээ

3) Газар зүйн онцлог, засаг захиргааны нэгжийн хил хязгаарын зөрүү

Бэлчээрийн мал аж ахуй нь байгалийн аргаар тогтсон уул ус, овоо толгод, тал хөндий гэх мэт газрын хэв маягаар бэлчээрийн хил хязгаарыг тогтоодог байгальтайгаа зохицсон уламжлалтай ажээ. Социализмын үед малаа бэлчээхэд хил хязгаар гэж тогтоодоггүй, цаг агаартаа зохицон орон нутгийн байгалийн онцлогт тохирсон аргаар

малаа маллаадаг байсан бол, өнөө үед нүүдлийн бэлчээр нь засаг захиргааны (сум) нэгжид хуваагдаж зохицуулагддаг болсон байна. Гэвч бодит байдал дээр өвөлжөө болон зуслангийн газар нь нэг сумын нутаг дэвсгэр дотор багтах боломжгүй тохиолдол гардаг. Өнөөгийн байдлаар зуслан болон өвөөлжөөнд тохирсон газрын аль нэг нь л байдаг сум ойролцоогоор 100-гаад байдаг, байгалийн ийм тогтоцтой газар нутаг нь зудын аюулд илүү нэрвэгдэх магадлалтай байна. Орон нутгийн байгалийн онцлогоос хамаараад улирал тус бүрт тохирсон бэлчээрт малаа бэлчээх нь хамгийн тохиромжтой хэдий ч өнөөгийн засаг захиргааны шинэ тогтолцоон дор малаа чөлөөтэй бэлчээх нь ихээхэн хүндрэлтэй болсон байна (Зураг 6.3.3).



Уламжлалт бэлчээрийн хэв маяг

Улирлын онцлогт тохирсон бэлчээр, түүний хил хязгаар

Эх сурвалж : ЖАЙКА-ийн судалгааны баг

Зураг 6.3.3 Газар зүйн онцлог (улирлын онцлогт тохирсон бэлчээр), засаг захиргааны хил хязгаарын зөрүүтэй байдлын талаархи зураг

4) Бэлчээр нутгийн газар зүйн онцлог, малчдын орлогын түвшин


Орон нутгийн байгалийн онцлогт тохирсон бэлчээрийн мал маллагаа хамгийн тохиромжтой ч өнөөгийн үед малчдын орлогоос шалтгаалаад суурьших газар нь янз бүр байх тохиолдол байна (Зураг 6.3.4). Үүнд,

- (i) **Бага орлоготой давхарга:** Малын тоо цөөн, зах зээлтэй ойр газрыг сонгож суурьшдаг. Хөрөнгө санхүү бага тул аль болох хол газар нүүдэлдэггүй, бараг суурин хэв маягаар газар тариалантай хослуулсан мал аж ахуй эрхэлдэг тохиолдол олон бий.
- (ii) **Дунд зэргийн орлоготой давхарга:** Малаа өсгөхийн тулд сайн бэлчээр дагаж зах зээлээсээ хол газар малаа бэлчээж нүүдэллэдэг.
- (iii) **Өндөр орлоготой давхарга:** Бага болон дунд орлоготой малчдын дунд хэсэгт байрладаг бөгөөд, улирлаас шалтгаалан бага болон дунд орлоготой малчдын хооронд ирж очин байрладаг. Хөрөнгөтэй тул хол зам туулах чадвартай, сумын орон нутгаас гарч нүүдэл хийх үед очсон газар нутгийнхаа газар эзэмшигчид

бэлчээр ашигласны төлбөр төлөх, мөн очсон нутаг усны айлтай ураг төрлийн холбоо тогтоох² зэргээр асуудлыг шийдэх тохиолдол ч байдаг.

- (iv) Иймэрхүү маягаар малын бэлчээр газар ашиглахад хөрөнгө мөнгө шаардагдах болсон тул аль болох зах зээлтэй ойр байх сонирхолтой малчдын тоо нэмэгдэж байгаа нь бэлчээрийн даац хэтрэх асуудлын нэг том шалтгаан болсон гэж үзэж болно.

Мөн малчин өрхийн 20-30 насны залуу гишүүд нь ихэвчлэн Улаанбаатар хотод амьдардаг тул, 45-60 насны хөгшчүүл нь үлдэж малаа малладаг байна. Малчдын насжилттай холбоотойгоор хол газар нүүж суух явдал улам бүр багасч, газар зүйн онцлогоос шалтгаалан малаа бэлчээх асуудал ч хүндрэлтэй болж ирж байгаа юм.



Эх сурвалж : ЖАЙКА-ийн судалгааны баг

Зураг 6.3.4 Малчдын орлого, нутгийн байршил хоорондын хамаарал

5) ХАА-н зориулалттай газрын төлөв байдлыг тодорхойлох, хяналттай холбогдох хүндрэлүүд

Газрын хуулийн 58-р зүйл дээр газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны тухай заасан байдаг бөгөөд тус хуулийн 58.9-р заалт дээр тариалангийн газарт газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа хийхэд баримтлах журам, хэрэглэх үзүүлэлтийг “Тариалангийн тухай хууль”-аар зохицуулна гэсэн байдаг. ХАА-тай холбоотой хуулийн 5-р заалтад газар тариалангийн газрын төлөв байдал, чанар, хяналтын мониторингийг 5 жилд 1 удаа явуулахаар хуульчлагдсан байдаг. Гэвч төсвийн хязгаарлагдмал байдлаас болж энэ ажил төлөвлөгөөний дагуу хэрэгжиж чаддаггүй байна. Энэ нь хариуцсан байгууллагын (сум) бэлчээрийн даацын мэдээллийг гаргахад саад учруулдаг тул холбогдох арга хэмжээ авахад оройдтог байна. Бэлчээрийн хяналт, мониторингийн системийг цаашид тогтвортой авч явах нь шийдэх ёстой чухал асуудлуудын нэг зайлшгүй мөн гэж үзэж байна.

² Өөр суманд бүртгэлтэй хэдийн хамаатан саадангийн бэлчээрийн газарт нутаглах хүмүүс их байдаг

6.4 Гадаад худалдаа, хөрөнгө оруулалт, аж үйлдвэрийн бодлогын уялдаа холбооны ач холбогдол

(1) Худалдаа, хөрөнгө оруулалт, аж үйлдвэрийн хөгжлийн бодлогын өнөөгийн байдал

1) Худалдааны бодлого, хоёр улс хоорондын худалдааны хэлэлцээр

Тайлангийн 2, 3-р бүлэгт тайлбарласнаар Монгол улсын худалдааны бүтэц нэг салбараас хэт хамааралтай гажуудсан байдалтай байна. 2014 оны байдлаар экспортын 80%-иас илүү хувийг ашигт малтмал эзэлж, мөн түүний 88% нь БНХАУ-руу экспортлогдож байна. БНХАУ-ын дараагаар Их Британи, түүний дараагаар ОХУ тус тус 6.9%, 1.1% хувийг эзэлж байна. Нөгөө талаар импортын хувьд уул уурхайн бүтээгдэхүүн болон тоног төхөөрөмж, сэлбэг зэрэг аж үйлдвэрийн бүтээгдэхүүн дийлэнх хувийг эзэлж, түүнээс 60%-аас дээш хувийг ОХУ, БНХАУ хоёр улсаас оруулж байна. Мөн Япон улс руу гаргадаг экспорт нь нийт экспортын 0.4 %-иас илүүгүй хувийг эзэлж 6-р байранд орж, импорт нь 7% эзэлж ОХУ, БНХАУ-ын дараагаар буюу 3-р байрт орсон байна.

Ийм нөхцөл дор Монгол улсын худалдааны бодлогыг “Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилгод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого”-д заасны дагуу ашигт малтмал болон малын гаралтай түүхий эд зэрэг анхан шатны гаралтай түүхий эдийн экспорт буюу гажуудсан худалдааны бүтцийг шинэчлэх явдал чухал юм. Тодруулбал экспортын бүтээгдэхүүнийг төрөлжүүлж, өндөр өртөг шингэсэн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх, ялангуяа ашигт малтмал зэрэг анхдагч түүхий эдийн экспортыг бууруулж эцсийн боловсруулсан бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх нь чухал байна. Мөн түүнчлэн импортыг орлох бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжиж, урт хугацааны эдийн засгийн хөгжилд чухал болох “мэдлэгт суурилсан” технологи нэвтрүүлэх, тоног төхөөрөмж, сэлбэгийн импортыг нэмэгдүүлэх нь чухал болоод байна. 2016 оны 2 сард УИХ-аар батлуулсан “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтгал-2030”-д ч мал аж ахуйн боловсруулах үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, боловсруулсан бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх зорилго тавьсан байна.

1997 онд ДХБ-д элсэнээр импортын татвар ихээр буурсан. Монгол улсын гаалийн татвар нь энгийн, хөнгөлөлттэй, нэн тааламжтай тариф гэж ангилагдах бөгөөд Монгол улсын хувьд нэн тааламжтай тариф мөрдөхөөр зөвшилцсөн улс (ДХБ-ын гишүүн Казахстан, Беларусь)-аас гаралтай бүтээгдэхүүнд нэн тааламжтай тариф үйлчилнэ. Эдгээрээс бусад улсаас гаралтай бүтээгдэхүүнд нэн тааламжтай тариваас 2 дахин их, энгийн тариф мөрдөгдөнө. Нэн тааламжтай тариф нь 0%-75% бөгөөд дундажаар 17.3% байдаг. Ихэвчлэн мөрдөгддөг тариф нь 2013 онд гэхэд 0%-25%, дунджаар 5.0% байсан ба ихэвчлэн 5.0%-ийн татвар ноогдуулсан байна. Улаан буудайнд улирлын чанартай 15% татвар ноогдуулдаг.

Энэ тогтолцоо нь нэгдсэн тарифийг баримталсанаар гаалийн бүрдүүлэлтийг хялбарчилж, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг өдөөж өгөх, дотоодын үйлдвэрүүдийг хэт бөөцийлөхөөс сэргийлэх, хямд төсөр импортын барааг дотоодын зах зээлд оруулж ирэх зэрэг зорилготой. Түүнчлэн жижиг дунд үйлдвэрт зориулсан импортын барааг 2011 оны Засгийн газрын тогтоолоор гаалийн татвараас чөлөөлсөн. Харин тарифийн квот болон импортын квот байдаггүй.

Нөгөө талаар экспортын тухайд дотоодын аж үйлдвэрүүдийг дэмжихийн тулд тэмээний ноос, модонд³ татвар оногдуулсан байна. Экспортын бүтээгдэхүүнд урамшуулал олгоогүй ч онцгой албан татвар, хэрэглээний татвараас чөлөөлөх зэрэг хөнгөлттэй арга хэмжээнүүд авч хэрэгжүүлж байна. Мөн экспортын баримжаатай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, гадны шууд хөрөнгө оруулалтыг эрчимжүүлэх, ажлын байр бий болгох, хилийн бүс нутгийн худалдааг хөгжүүлэх зорилгоор “Эдийн Засгийн чөлөөт бүс байгуулах” төсөл хэлэлцэгдэж байна. Одоогийн байдлаар, Замын-үүд, Чойр гэсэн хоёр “Эдийн засгийн чөлөөт бүс”-тэй, Алтанбулаг, Цагааннуурт хоёр “Чөлөөт худалдааны бүс” ажиллаж байна

Экспортыг эрчимжүүлэхэд Засгийн газраас экспортын санхүүжилтийг дэмжих, мэдлэгт суурилсан бүтээгдэхүүн болон үйлчилгээний экспортыг нэмэгдүүлэх зорилгоор “Шинэ зах зээл руу нэвтрэх” асуудлыг хэлэлцэж байна. 2011 онд байгуулагдсан Монгол Улсын Хөгжлийн Банк нь экспортын санхүүжилт, экспортын зээлийн баталгаа, экспортын зээлийн даатгал зэрэг үйлчилгээг үзүүлж байна.

Хоёр улс хоорондын байгуулсан худалдааны гэрээ хэлэлцээрийн хүрээнд Вьетнам, Куба улстай байгуулсан худалдааны хэлэлцээрээс гадна, Америк улстай “Худалдаа болон хөрөнгө оруулалтын хэлэлцээр” байгуулсан байна. Мөн 2013 онд Ази, Номхон далайн худалдааны хэлэлцээр (АНДХХ) буюу (АРТА)-т нэгдэж, 2015 онд анх удаа Эдийн Засгийн түншлэлийн хэлэлцээр (ЕРА)-ийг Япон улстай байгуулсан байна (6.5 хэсгийн тайлбарыг харна уу).

2) Хөрөнгө оруулалтын бодлого

Хөрөнгө оруулалтын бодлогын хүрээнд 1993 онд “Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль” батлагдсан боловч, түүний дараагаар баялгийн үндсэрхэг үзэл дэвэрсэнээр БНХАУ-аас болгоомжилж, 2012 онд стратегийн гол салбар дахь⁴ “Гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах тухай хууль”-иар гадаадын хөрөнгө оруулалтад тавих хяналтыг чангаруулсан байна. Гэвч үүний үр дүнд үр ашиггүй, ил тод бус хөрөнгө оруулалтын орчинд таагүй хандлага үүсч, олон хөрөнгө оруулагчид буцсан байна. 2012 оны “Гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах тухай хууль” -д заасан хувь хөрөнгө оруулагч, гадаадын хөрөнгө оруулалтад тавьсан хязгаарлалтыг цуцалсанаар 2013 онд дахин шинээр хөрөнгө оруулалтын тухай хууль баталж илүү

³ Экспортын татвар: тэмээний ноос /эм/ 200Төг/кг, эр 100Төг/кг, мод 150000Төг/м³

⁴Уул уурхай, мэдээлэл холбоо, банк санхүү, эдгээр 3 салбар.

нээлттэй хөрөнгө оруулалтын нөхцлийг бүрдүүлж, дотоодын болон гадаадын хөрөнгө оруулагчдын хувьд нэгдсэн хууль эрх зүйн орчныг бүрдүүлж чадсан байна. Үүний үр дүнд дотоод гадаад аль ч хөрөнгө оруулагч нар (гадаадын төрийн өмчит компаниас бусад),⁵ Засгийн газрын зөвшөөрөл болон бусад хязгаарлалтгүйгээр хөрөнгө оруулах боломжтой болж, “Гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах тухай хууль”-нд заасан стратегийн салбарт үйл ажиллагаа явуулах аж ахуйн нэгжид тавигддаг байсан Засгийн газрын зөвшөөрлийн бичиг шаардлагагүй болсон байна.

Гэвч гадаадын хөрөнгө оруулагч нар Монголд үйл ажиллагаа явуулахын тулд гадаадын хөрөнгө оруулалттай компанийг байгуулж бүртгүүлэх шаардлагатай бөгөөд гадны хөрөнгө оруулалттай компани нь 25%-иас дээш хувьцааг эзэмшиж, дор хаяж багадаа 100 мянган долларын үндсэн хөрөнгөтэй байхаар заасан байна.

Мөн Ерөнхий сайдын шууд харъяалал дор байсан “Хөрөнгө оруулалтын газар” нь хөрөнгө оруулалтыг эрчимжүүлэх, хязгаарлах асуудлыг хариуцдаг бөгөөд, хөрөнгө оруулагчид мэдээлэл өгөх, компани байгуулахад дэмжлэг үзүүлэх зэргээр хөрөнгө оруулалттай холбоотой бүхий л үйл ажиллагааг хариуцаж явуулдаг байсан. Одоо энэхүү үйл ажиллагаа нь Үндэсний хөгжлийн газарт шилжсэн.

3) Аж үйлдвэрийн хөгжил, худалдаа хөрөнгө оруулалттай хэрхэн холбогдох тухай

Энэхүү тайлангийн 2-р бүлэгт тайлбарласны дагуу, Монгол улсын аж үйлдвэрийн бүтэц нь тодорхой нэг салбар болон аль нэг орон нутгаас хараат байдалтай, харин худалдаа болон хөрөнгө оруулалт нь уул уурхайн аж үйлдвэрээс ихээхэн хамааралтай байдалтай байна. Үүнээс гадна, дотоодын аж ахуйн нэгжүүдийн судалгааны дүнгээс харахад түүхий эдийн импортоос хараат байдал, тээврийн зардал өндөр байдаг зэргээс шалтгаалаад экспортын хязгаарлагдмал байдал нь худалдаа, хөрөнгө оруулалттай ихээхэн хамааралтай асуудал болж байгаа юм. Хүснэгт 6.4.1 дээр аж үйлдвэрийг хөгжүүлэх асуудалд худалдаа, хөрөнгө оруулалттай хэрхэн хамааралтай байгааг нэгтгэж харууллаа.

⁵ Уул уурхай, мэдээлэл холбоо, телевиз радио, банк санхүүгийн холбоотой ажилд 33%-с хувийн хувьцаа эзэмшдэг ААН хамаарна

Хүснэгт 6.4.1 Аж үйлдвэрийг хөгжүүлэх асуудал, худалдаа, хөрөнгө оруулалт хоорондын харилцаа холбоо

Асуудал	Арга хэмжээ	Худалдаа, хөрөнгө оруулалтын хамаарал
Нэг салбараас хараат аж үйлдвэрийн бүтэц	Аж үйлдвэрийг төрөлжүүлэх бодлого, ХАА, уул уурхайн боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлэх	Дотоодын хөрөнгө оруулалт, аж үйлдвэрийн хамтын ажиллагаа, глобал нийлүүлэлтийн сүлжээг өргөжүүлэх, аж үйлдвэрийг төрөлжүүлэх, нэмүү өртөг шингээх зэргээр хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх
Түүхий эдийн импортын хамаарал	Технологи нэвтрүүлэх, импорт орлох бүтээгдэхүүн үйлдвэрлэх, бэлтгэн нийлүүлэлтийн сүлжээ байгуулж, үр ашгийг нэмэгдүүлэх	Глобал нийлүүлэлтийн сүлжээг өргөжүүлэх, өндөр технологи, мэдлэгт суурилсан бүтээгдэхүүн импортлох
Гадны хөрөнгө оруулалтын хязгаарлалт (экспортын өртөг өндөр, эд анги нийлүүлэх),	Аж үйлдвэрийн цогцолбор, мэдээллийн сүлжээг ашиглан тээврийн зардлыг бууруулах	Аж үйлдвэрийн парк, чөлөөт бүс, (Чөлөөт Худалдааны бүс, Чөлөөт Эдийн засгийн бүс) байгуулах
Аж үйлдвэрийн салбарт ажиллах хүний нөөц дутагдалтай	Боловсон хүчин бэлтгэх	Гадны шууд хөрөнгө оруулалтаар дамжуулан ажлын байр бий болгох, боловсон хүчин бэлтгэх
Санхүүжилт олох	Санхүүжилтийн тогтоцоог бүрдүүлэх	Гадаадын хөрөнгө оруулалтын санхүүжилт, Засгийн газрын экспортын дэмжлэг /татвараас чөлөөлөх, экспортыг санхүүжүүлэх/
Нэмүү өртөг шингээх асуудал оройтож байгаа	Боловсон хүчин бэлтгэх, дэвшилтэт технологи оруулах г.м	Гадны шууд хөрөнгө оруулалтаар дамжуулан технологи нэвтрүүлэх, боловсон хүчин бэлтгэх
ХАА, уул уурхайн боловсруулах аж үйлдвэрийг хөгжүүлэх	Аж үйлдвэрийн цогцолбор байгуулах, технологи нэвтрүүлэх	Аж үйлдвэрийн парк, Чөлөөт бүс (Чөлөөт худалдааны бүс, чөлөөт эдийн засгийн бүс) байгуулах

Эх сурвалж: ЖАЙКА-ийн судалгааны баг

Монголын аж үйлдвэрийг хөгжүүлэхийн тулд одоогийн гажуудсан аж үйлдвэрийн бүтцийг төрөлжүүлснээр эдийн засгийн тогтвортой байдал дээшилж, энэ нь эдийн засгийн өсөлтийг хангахад ихээхэн чухал юм. Мөн аж үйдвэрийг төрөлжүүлэх, нэмүү өртөг шингээхийн тулд зөв тогтолцоог бий болгож, хүний нөөц, өндөр технологи, хөрөнгө санхүүг бүрэлдүүлэх нь нэн чухал шаардлагатай асуудал болоод байна.

Худалдаа болон хөрөнгө оруулалтын харилцаа холбооноос аваад үзэхэд аж үйлдвэрийг төрөлжүүлэхэд аж үйлдвэрүүд хоорондын хамтын ажиллагааг улам эрчимжүүлэх, боловсруулах аж үйлдвэр, нэмүү өртөг шингээсэн өндөр аж үйлдвэр хөгжүүлэх нь экспорт импортын барааг улам төрөлжүүлж, нэмүү өртөг бий болгох, хөрөнгө оруулалтын боломжийг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалтын таатай орчинг бий болгож, гадны хөрөнгө оруулалтыг улам нэмэгдүүлэх таатай нөхцөл бүрдэх юм. Нөгөө талаар аж үйлдвэрийг төрөлжүүлэх, нэмүү өртөг шингээхэд дэвшилтэт технологи, шилдэг боловсон хүчин, болон хөрөнгө оруулалт шаардлагатай хэдий ч гадны шууд хөрөнгө оруулалтаар дамжуулан аж үйлдвэрийг хөгжүүлэхэд шаардлагатай өндөр технологи болон хөрөнгөтэй болохоос гадна, боловсон хүчнийг бэлтгэх бодлого зайлшгүй тулгарна. Үүнээс гадна чөлөөт бүс, аж үйлдвэрийн паркийн төсөлтэй уялдуулж аж үйлдвэрийн цогцолбор, тээврийн логистикийн сүлжээг бий болгох нь цаашид нийлүүлэлтийн сүлжээг хөгжүүлэх, аж үйлдвэрийг төрөлжүүлэх, боловсруулах үйлдвэрийг хөгжүүлэх зэрэг аж үйлдвэрийг сэргээхэд нэн чухал юм.

(3) Худалдаа, хөрөнгө оруулалт, аж үйлдвэрийн гурвалсан бодлого

Гадны хөрөнгө оруулалтыг татах нь цаашдын эдийн засгийн хөгжлийн гол түлхүүр нь мөн боловч, үүний тулд гадаадын хөрөнгө оруулагчдын хувьд Монгол улс өөрөө итгэл даахуйц байх явдал юу юунаас илүү чухал юм. Үүний тулд ч худалдаа, хөрөнгө оруулалт, аж үйлдвэрийг хөгжүүлэх бодлого нь хоорондоо уялдаатай байх шаардлагатай бөгөөд, доор дурдсан гурван тулгуур багана чухал үүрэгтэй гэж үзэж байна.

1) Олон улсын түвшинд хамтын ажиллагааг эрчимжүүлэх

Чөлөөт худалдааны бүс, чөлөөт эдийн засгийн бүс, аж үйлдвэрийн паркаар дамжуулан аж үйлдвэрийн цогцолбор болон тээвэр логистикийн төвийг байгуулснаар үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, тээврийн зардлыг бууруулах зэрэг худалдааг эрчимжүүлж, гадны хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.

2) Аж үйлдвэрийг төрөлжүүлэх, нэмүү өртөг бий болгох

Газар тариалан, мал аж ахуй (ноолуур, мах,сүү сүүн бүтээгдэхүүн) болон уул уурхайн боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлж, аж үйлдвэрийг төрөлжүүлэн, нэмүү өртгийг бий болгоно. Мөн аж үйлдвэрийн түүхий эдийн импортын хараат байдлыг өөрчлөхийн тулд, импортыг орлох үйлдвэрлэлийг хөгжүүлэх, тусгай хамгаалалттай газрын хяналтын тогтолцоог бий болгож, зам харилцааг сайжруулснаар аялал жуулчлалыг хөгжүүлнэ. Мөн эдгээрийг хэрэгжүүлэхийн тулд өндөр технологи, чадварлаг боловсон хүчин, санхүүжилт дутмаг байдаг тул аж үйлдвэрийг хөгжүүлэхийн тулд санхүүжилтийн тогтолцоог бий болгож, түүнд хамрагдах нөхцлийг сайжруулах болон боловсон хүчнийг бэлтгэнэ.

3) Гадаадын хөрөнгө оруулалтын орчныг бүрдүүлэх

Гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах хууль эрх зүйн таатай орчныг бүрдүүлж , аж үйлдэрийн парк, чөлөөт эдийн засгийн бүс гэх зэрэг хөрөнгө оруулалтыг эрчимтэй хөгжүүлэх бүс нутгийг тодорхойлж, зам харилцааны сүлжээг сайжруулж бизнесийн таатай орчныг бүрдүүлнэ.



Эх сурвалж : ЖАЙКА-ийн судалгааны баг

Зураг 6.4.2 Худалдаа, хөрөнгө оруулалт, аж үйлдвэрийг хөгжүүлэх гурвалсан бодлого

6.5 Япон Монголын эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийн цар хүрээ, хувийн хэвшилтэй хамтарч ажиллах боломж

(1) Япон Монголын эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийн агуулга

Япон Монголын эдийн засгийн түншлэлийн гэрээ хэлэлцээрийг 2015 оны 2 сард Ч.Сайханбилэг ерөнхий сайдын айлчлалын үеэр гарын үсэг зурсан. 2015 оны 10 сарын 22-нд Монгол улсад уг хэлэлцээр байгуулагдсантай холбоотой хууль гарсан. Япон улсад уг хэлэлцээртэй холбоотой бичиг баримт боловсруулах ажил дууссан тул 2016 оны хавраас хэрэгжиж эхлэх төлөвтэй байна. Япон Монголын хамтарсан энэхүү хэлэлцээр нь дараах 4 ач холбогдолтой хэмээн үзэж байна.

- Худалдааг өргөжүүлэх, эрчим хүч, эрдэс баялгийн салбар дахь хөрөнгө оруулалтын орчинг сайжруулах замаар, Монгол Японы “Стратегийн түншлэл”-ийг улам бэхжүүлнэ.
- Монгол улс эрчим хүч, эрдэс баялаг тогтвортой нийлүүлэх тал дээр хамтран ажиллана (нүүрс, жонш, газрын ховор металл, алт, зэс г.м).
- Ардчилал, зах зээлд шилжсэнээр дунд болон урт хугацааны эдийн засгийн өсөлт мэдрэгдэж буй Монгол улсын эдийн засгийн өсөлтийг Японы эдийн засгийн өсөлттэй дүйцүүлнэ.
- Бараа бүтээгдэхүүний худалдаа, үйлчилгээ, хөрөнгө оруулалт, цахим худалдаа, өрсөлдөөн, оюуны өмч зэрэг ерөнхий дүрэм журмыг багтаасан цогц хэлэлцээр болсон.

1) Гаалийн татвар

- Хэлэлцээр хүчин төгөлдөр болсноос хойш 10 жилийн дотор хоёр орны хоорондын худалдааны дүнгийн 96 %-ийг гаалийн тавараас чөлөөлнө.
- Монгол улс Япон улсын импортын барааны 96 орчим хувийг гаалийн татвараас чөлөөлнө.
- Япон улс Монгол улсын импортын барааг 100 хувь 10 жилийн дотор гаалийн татвараас чөлөөлнө.

2) Японоос Монголын зах зээлд

Япон улсаас Монгол улсад татваргүй экспортын хэмжээ нийт экспортын дүнгийн 1 хувьд хүрээгүй бөгөөд, хэлэлцээр хүчин төгөлдөр болмогц 50 орчим хувь, 10 жилийн дотор 96 орчим хувь хүртэл нэмэгдэнэ.

- Автомашин, автомашины сэлбэг: 4500CC-ээс бага хөдөлгүүрийн багтаамжтай автомашин (үйлдвэрлэгдсэнээс хойш 0-3) гаалийн татвараас чөлөөлөгдөнө. Бусад

автомашин буюу сэлбэг 10 жилийн дотор гаалийн татвараас чөлөөлөгдөнө (нийт экспортын 70 орчим хувь).

- Машин механизм: Барилгын гол машин (бульдозер г.м) гаалийн татвараас 10 жилийн турш шууд буюу шат дараалалтайгаар чөлөөлөгдөнө (Нийт экспортын 20 хувь).
- Тайрсан цэцэг жимс жимсгэнэ, буурцагны жан, цуу зэрэг: Шууд буюу шат дараалалтайгаар чөлөөлөгдөнө.
- Саке ба шёочү: гаалийн татвараас шууд чөлөөлөгдөнө

3) Анхаарал хандуулах гол асуудал

- Уул уурхайн бүтээгдэхүүн: Ихэнх бүтээгдэхүүн шууд буюу 10 жилийн дотор шат дараалалтай чөлөөлөгдөнө.
- Боловсруулсан махан бүтээгдэхүүн: Тодорхой тоон хязгаарлалт дотор (одоогоор хийгдсэн экспорт байхгүй)
- Тэжээвэр амьтны хоол: Шууд буюу 10 жилийн дотор шат дараалалтай гаалийн татвараас чөлөөлөгдөнө (Одоогоор хийгдсэн экспорт байхгүй).

4) Анхаарал хандуулах гол асуудал

Үйлчилгээний худалдаа: Зах зээлд нэвтрэх боломж, нэн тааламжтай үндэсний нөхцөл, ил тод байдал, зэрэг үйлчилгээний худалдааг хөгжүүлэх, ДХБ-ын хэлэлцээрт зааснаас илүү олон салбарыг нээлттэй болгосон.

Цахим худалдаа: Цахим худалдааг дэмжих үүднээс цахим системээр илгээсэн бүтээгдэхүүнд гаалийн татвар ноогдуулахгүй байх, цахим бүтээгдэхүүнийг ялгаварлахгүй байх, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах болно.

Хөрөнгө оруулалт: Одоо буй хөрөнгө оруулалтын хэлэлцээрээс өргөн агуулгатай. Хөрөнгө оруулалтын зөвшөөрөл хүсэх шатанд үндэсний болоод нэн тааламжтай үндэсний нөхцөл, технологийн лицензийн гэрээнд Засгийн газрын оролцоог хориглох, эрчим хүч, эрдэс баялаг зэрэг бүхий л салбарын шудрага, тэнцвэртэй нөхцөл, хөрөнгө оруулагч болон Засгийн газар хоорондын гэрээг чанд сахих үүрэг, үүсэх маргаан, шийдвэрлэх арга зам (ISDS⁶) зэрэг заалт оруулсан.

Бизнесийн орчин бүрдүүлэх: Хоёр орны Засгийн газар, хувийн хэвшлийн болон бусад холбогдох байгууллагыг оролцуулан хөтөлбөрийг хэрэгжүүлэх хоёр орны хувийн хэвшилд зориулсан бизнесийн орчинг бүрдүүлэн, сайжруулах асуудлыг судлах дэд хороо байгуулна. Нөгөө орны хувийн хэвшлийн талаарх гомдол, санал хүлээн авах үүрэгтэй нэгж байгуулна.

⁶ ISD (Investor State Dispute Settlement): Хөрөнгө оруулалтын маргааныг шийдвэрлэх тухай конвенци

Хамтын ажиллагаа: ХАА, ой, усны аж ахуйн үйлдвэрлэл (хүнсний нэмүү өртгийн гинжин хэлхээ зэрэг), жижиг дунд үйлдвэр, аялал жуулчлал, мэдээлэл, харилцаа холбооны технологи, байгаль орчин зэрэг салбарт хамтын ажиллагааг өргөжүүлнэ

(2) Японы компаниудын хөрөнгө оруулалтыг дэмжих

Монгол улс, Япон улс хоёр 1977 онд эдийн засгийн хамтын ажиллагааны хэлэлцээрийг байгуулан, худалдаа эдийн засгийн хамтын ажиллагааг эхлүүлж, түүний хүрээнд “Товь” ноолуурын үйлдвэрийг байгуулсан. Социалист нийгмийн үед, хоёр улсын худалдаа, эдийн засгийн харилцаа нь хязгаарлагдмал байсан боловч, 1990 онд хоёр улсын хооронд худалдааны хэлэлцээр байгуулагдсанаар хамтын ажиллагаа улам бүр өргөжиж ирсэн байна.

Японы Засгийн Газраас Монгол улсад үзүүлж ирсэн зээл тусламж нь, ардчилалыг бэхжүүлэх, шинэ зах зээлийн нийгмийн тогтолцоог бүрэлдүүлэх, өнөөгийн хөгжлийн суурийг бий болгоход чухал үүрэг гүйцэтгэж ирсэн хэмээн Монголын тал үнэлдэг.

Монголын хувийн хэвшлүүд энэхүү Япон Монголын эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр нь аж үйлдвэрийг төрөлжүүлэхэд Япон талын хөрөнгө оруулалт нэмэгдэнэ хэмээн найдлага тавьж байгаа бөгөөд ажлын байр нэмэгдүүлэх, ХАА, уул уурхайн үйлдвэрлэлийг эрчимжүүлэх, хүнсний аюулгүй хангамжийг нэмэгдүүлэхэд тодорхой хувь нэмрээ үзүүлнэ хэмээн найдлага тавьж байна.

Энэхүү судалгаагаар дамжуулан ялангуяа манай улсын хувийн хэвшлийн хүрээнд хамтран ажиллах боломжтой салбаруудыг доор танилцуулья.

- Шинээр өсч буй ХАА, холбогдох аж үйлдвэр болон бизнесийг (өргөн хүрээний ХАА-н үйлдвэрлэл) хөгжүүлэх.
- Ноос, ноолуур гэх зэрэг 1990-2015 он хүртэл буюу 25 жилийн туршилгыг улам хөгжүүлж өндөр зэрэглэлийн боловсруулалт, нэмүү өртөг шингээх, дизайныг сайжруулах, гадаадын шинэ зах зээлийг нээх, борлуулалтын нэгдсэн системийг бий болгох.
- Уламжлалт үйлдвэрлэл, технологийг орчин үеийн дэвшилтэт системтэй уялдуулж шинэ аж үйлдвэрийг хөгжүүлэх
- Японы уламжлалт аж үйлдвэр, орон нутгийн аж үйлдвэртэй хамтрах (орон нутгийн засаг захиргааны хамтын ажиллагааны үндсэн дээр)
- Хүнсний импортыг орлох, дотоодын хэрэгцээг хангах үйлдвэрлэлийн тогтолцоог бий болгох
- Тээвэрлэлт, логистикийн салбарын гадаад харилцааг өргөжүүлж, хөгжүүлэхэд хөрөнгө оруулах

- Японы технологийг нэвтрүүлж үйлдвэрийн тоног төхөөрөмжийг орчин үеийн төвшинд хүргэх, эрчим хүч, байгаль экологийн асуудлыг шийдвэрлэхэд хувь нэмэр оруулах
- Аялал жуулчлалын байгууламж, үйлчилгээнд хөрөнгө оруулалт хийж, холбогдох аж үйлдвэрийг хөгжүүлэх, үйлчилгээг сайжруулахад хамтрах
- Уул уурхайн шинэ аж үйлдвэрийг хөгжүүлэх, (ховор метал, жонш, уран г.м) уул уурхайн холбогдох аж үйлдвэрт хөрөнгө оруулалт хийхэд хамтрах
- Уул уурхайн салбар аж үйлдвэр болон материал хангамжийн үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд хамтарч ажиллах
- Барилга болон үл хөдлөх хөрөнгийн бизнесийг хөгжүүлэхэд хөрөнгө оруулалт хийж хамтрах
- Бусад, жижиг дунд үйлдвэрийн хамтын ажиллагааг эрчимжүүлэх олон төрлийн бизнесийг хөгжүүлэх

(3) Хэрэгжүүлэх боломжтой Япон улсын технологи

Цаашид Монгол улсын хөгжлийг дэмжихэд Япон улсын технологийг нэвтрүүлэх тал дээр ихээхэн найдлага тавьж байна. Ялангуяа нилээн сонирхогдож буй Японы технологи, тогтолцооны талаархи мэдээллийг 6.5.1 хүснэгтэд нэгтгэж үзүүлээ. Жагсаалтад багтаасан технологи нь өмнө нь ямар нэг байдлаар хэрэгжиж байсан, эсвэл төсөл, төлөвлөгөөний шатанд байгаа болон, цаашдаа олон төрлийн технологи нэвтрүүлэх найдлага тавигдаж байна.

Хүснэгт 6.5.1 Нэвтрүүлэх боломжтой Япон улсын технологи

Салбар	Японы технологи
Сэргээгдэх эрчим хүч	Биомассын технологи /метан хий/ хог хаягдлын цахилгаан станц/ эрчим хүч гарган авах цэвэрлэх технологи/ нарны эрчим хүчний станц /салхин станц/ газрын дулааны эрчим хүч/ усан цахилгаан станц
Нүүрсний ашигтай хэрэглээ	Нүүрс баяжуулах-хуурай баяжуулах/ нүүрсний хий, шингэрүүлэх/ нүүрсний давхаргаас метан боловсруулж, ашиглах/ төмөрлөг, коксын үйлдвэр/ бусад ногоон технологи
Шинэ эрчим хүчний технологи	Устөрөгчийн технологи/төмрийн натри
Логистик	Хөргүүр, хөлдөөгч агуулах /CAS систем (Cells Alive-System) /хөргүүртэй тээвэрлэлтийн систем/ олон улсын тээвэрлэлтийн (FRID систем)/ ачаа хүргэлтийн систем
ХАА	Үхрийн махны үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх /малын эрүүл мэндийн хяналт/шүлхийтэй тэмцэх/ арьс ширний үйлдвэрийн технологи/ органик ХАА/ үнэ ханш тогтоох/ ХАА бүтээгдэхүүний стандарт (MAS)/ ХАА үйлдвэрлэгчдийн орлого нэмэгдүүлэх(зах зээлийн систем)
Аялал жуулчлал/байгаль хамгаалал	Тустай хамгаалалттай газрын хяналтыг сайжруулах/ үйлчилгээний ажилтны сургалт, дадлагажуулах тогтолцоо/ үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хангах хууль эрх зүй (аялал жуулчлалын хууль г.м) эко системийн санаачлага
Байгаль орчин	Бэлчээрийн доройтол/гар аргаар алт олборлохыг зогсоох/уул уурхайн нөхөн сэргээлтийн тогтолцоо
Хог хаягдал	Бактерийг бууруулах технологи/ хуванцар савыг дахин боловсруулах технологи/цахилгаан барааг дахин боловсруулах, биомасс дахин ашиглах технологи/ хог шатаах технологи/ хог боловсруулах технологи
Эко	ESCO төсөл/ орон сууцны эрчим хүчний систем HEMS ⁷ /нарны энерги литийн батерей/ ухаалаг технологи
Үйлчилгээ	24 цагийн үйлчилгээний систем(өргөн хэрэглээний барааны түгээх систем)
Эрүүл мэнд	Алсын зайн оношлогооны систем/ PЕM ⁸ г.м дэвшилтэт технологи/ сувилгаа, асаргааны аргачлал/ эмнэлгийн шатлалт систем/ төрөх, хүүхдийн эрүүл мэнд / оношлогоо/ өндөр зэрэглэлийн технологи ⁹ // олон нийтийн эрүүл мэндийг сайжруулах
Боловсрол	Цэцэрлэг, дунд сургуулийн хүрэлцээг нэмэгдүүлэх, ш.у мэргэжлийн ахлах сургуулийн боловсролыг дэмжих г.м
Зам, барилгын технологи	Замын суурь, хучилтын стандарт/ гүүр, туннель/ барилгын чанарын технологи/ угсралтын хяналт/ хүйтэн бүсийн барилгын технологи/ аюулгүй ажиллагаа/ чанарын хяналт/ элсэн шуудайн технологи/
Тээврийн систем	Их хэмжээний тээвэрлэлтийн метросистем (MRT、LRT), автобусны систем (BRT)/ автобусны хөдөлгөөний мэдээллийн систем, ITS (ухаалаг зам тээврийн систем)/ хурдны замынSA · PA/ мэдрэгчтэй IC карт, FeliCa технологи/ Мичино эки/ төмөр замын IT шийдэл (e-RAIL Service)
Үйлдвэрлэл	Үйлдвэрлэлийн зориулалтын робот/ It технологи/ Business Processing Outsourcing
Уул уурхай	Ашигт малтмалын хайгуул /зураглал/ уул уурхайн төлөвлөлт/ олборлолт, тээвэрлэлийг автоматжуулах/ боловсруулах, нэмүү өртөг шингээх/ био шүлтжүүлэг

Эх сурвалж : ЖАЙКА-ийн судалгааны баг

⁷ HEMS (Home Energy Management System): Орон сууцад ашиглах эрчим хүчийг хэмнэх хяналтын систем

⁸ PET (Positron Emission Tomography): (цацраг идэвхит бодис ашигласан хавдрын оношлогооны төрөл, хавдар илрүүлэх нэг аргачлал)

⁹ Барилга байгууламж барих зэрэг хард технологи төдийгүй, Япон маягийн удирдлага, заах арга, хичээлийн хөтөлбөр, үнэлгээний арга зэрэг софт технологийн эрэлт өндөр. Хард технологийн хувьд, одоогийн 2 ээлжээр хичээллэдэг байдлыг арилгах хэрэгтэй.

6.6 Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэх хөгжлийн менежмент

(1) Шинэ бодлого зохицуулалтын шаардлага

2016 оны 2 сард УИХ-аар батлагдсан “Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” нь шинэ Засгийн газрын хөгжлийн үндсэн үзэл баримтлал болсон нь эргэлзээгүй үндэсний хэмжээний томоохон бодлогын нэг юм. Тиймд төрийн бодлого, шийдвэрийг энэхүү үзэл баримтлалтай уялдуулах, эсвэл ахин шинээр шийдвэрлэх нь шинэ Засгийн газарт ноогдсон маш чухал асуудал юм.

2016 оны 10-р сарын байдлаар шинэ Засгийн газар энэхүү тогтвортой хөгжлийн үзэл баримтлал болон мөрийн хөтөлбөрт тулгуурлан бүхий л яам тамгын газар (Улаанбаатар хотын захиргааг хамруулна) нь одоогийн Засгийн газрын томилогдох хугацаанд хэрэгжүүлэх голлох бодлого, төслийг сонгон шалгаруулах үйл ажиллагаа явуулж байгаа ба тэдгээрийг “Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”- т эмхэтгэн оруулсан байна. Монгол улсын Засгийн газрын үндсэн бодлого чиглэл болгон дараах 5 чиглэлийг дэвшүүлж тус бүр нэн тэргүүнд хийх шаардлагатай бодлогын чиг хандлагыг тусгаж өгсөн.

1. Эдийн засгийн хүндрэлийг даван туулах онцгой бодлого
2. Эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах бодлого
3. Нийгмийн бодлого
4. Байгаль орчин, ногоон хөгжлийн бодлого
5. Засаглалын бодлого

Эдгээрээс “1) Эдийн засгийн хүндрэлийг даван туулах онцгой бодлого” болон “2) Эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах бодлого”-той холбогдох үйл ажиллагааны хөтөлбөрийг хүснэгт 6.6.1-т нэгтгэн харуулав. Энэхүү хүснэгтээс харахад голлох зорилтот бодлогын дагуу авах арга хэмжээ нь олон талт бодлогын чиглэл, үйл ажиллагааны хөтөлбөрийг гарган тус тусын зорилгод тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг тусган, үндсэн үзэл баримтлал болгосон байгаа нь харагдана. Гэсэн хэдий ч үйл ажиллагааны чиглэл болон бодлогыг хэрэгжүүлэх уялдаа холбоо болон төсвийн хэрэгцээг харгалзан үзэх, тэргүүлэх дараалал зэргийг нарийвчлан бодолцох хэрэгтэй бөгөөд, эдгээрийг цаашид шинэ Засгийн газрын шийдвэрлэх чухал асуудал гэж үзэж байна.

(2) Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн (MTFF) тодотгол

2014 оноос эхлэн эдийн засгийн өсөлт удааширч, төсвийн тэнцэл алдагдсанаар улсын төсөв хүнд байдалд орсон ба 2015 онд “Төсвийн тогтвортой байдлын тухай хууль” батлагдан гарсан. Үүн дээр тулгуурлан, эдийн засаг хялбар өсөх мөрөөдлийн байдлаас гарж, бодит суурь нөхцлүүдийг сайтар хянаж үзсэний үндсэн дээр 2018 он хүртэл боломжит дунд хугацааны эдийн засгийн өсөлтийн хүрээг (MTFF) баталсан.

Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл нь ойрын хугацаанд бодит эдийн засгийн өсөлтийн таамаглал 4-5% буюу харьцангуй чанга тогтоосон. Үүний зэрэгцээ “Төсвийн тогтвортой байдлын тухай хууль”-д суурилан төсвийн алдагдлын цар хүрээг ДНБ-ийн 2%, 2016 онд 4% болгон бууруулах зорилготой бөгөөд 2018 оны зорилтыг 2%-д хүргэхээр төлөвлөж байгаа. Анхаарал татаж буй “Чингис бонд” зэрэг 2.1 тэрбум ам.долларын их хэмжээний гадаад валютын өрийн эргэн төлөлт 2017он, 2018 оноос эхлэх хэдий ч, энэ оны 4 сард Засгийн газраас 500 сая ам. долларын бонд гарган олон улсын валютын сангаас зээлэх төлөвлөгөөтэй байгаа.

Гэсэн хэдий ч сүүлийн жилүүдэд макро эдийн засгийн нөхцөл байдал улам хүндэрч буй нөхцөл байдалд, шинэ Засгийн газар дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлийг ахин тодотгох ажлыг явуулж байгаа. Үүнтэй зэрэгцэн, тогтвортой хөгжлийн үзэл баримтлал болон Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт, зорилгод хүрэхийн тулд төсвийн томоохон хязгаарлалт хийхээс өөр аргагүй байгаа нь тодорхой болоод байна.

(3) Төсвийг дахин тодотгох 18 сарын төлөвлөгөөнд суурилсан улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр (PIP) боловсруулах хэрэгцээ

Макро эдийн засгийг ахин хэлэлцэх ажилтай уялдуулан Монгол улсын Засгийн газрын төсвийг дахин тодотгох асуудал нь улс төрийн нэгэн асуудал болоод байгаа. Сангийн яам төсвийн тодотголд зориулж эдийн засгийн хүндрэлийг даван туулах, тогтворжуулах “18 сарын төлөвлөгөө”-г боловсруулаад байгаа. 2017 онд нэхэгдэх бондын эргэн төлөлтийн эх үүсвэрийг бий болгох арга замыг тодорхой болгох хэрэгтэй бөгөөд энэхүү төсвийн төлөвлөгөөтэй зэрэгцэн Засгийн газрын хэмжээнд улсын хөрөнгө оруулалтын төсвийн чадавхи шаардлагатай болно.

Үүнтэй холбогдон, Олон улсын валютын сан болон бусад олон улсын байгууллагуудаас хэрхэн дэмжлэг хүлээн авах, түний дараах төсвийн бодлогод ихээхэн нөлөө үзүүлэхүйц чухал шийдвэр гаргах хэрэгтэй болоод байгаа бөгөөд, эдгээрийг харгалзан дунд хугацааны улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг боловсруулах шаардлагатай юм. Дээр дурдсан, шинэ “Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр” нь одоохондоо “Хүслийн жагсаалт” төдий байгаа бөгөөд бодит санхүүгийн хүндрэл дээр тулгуурлан, “үйл ажиллагааны төлөвлөгөө” тусгасан “улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-т үнэлэлт, дүгнэлт өгөх шаардлагатай. Үүнд, Төсөл хөтөлбөрийн агуулгад үнэлэлт дүгнэлт өгч, хэрэгжүүлэх эрэмбэ дарааллыг тойрсон улс төрийн болон яам тамгийн газрын зохицуулалт шаардлагатай.

(4) Хөгжлийн удирдлагын тогтолцооны гол бүрэлдэхүүн болох “Үндэсний хөгжлийн газар”-т тавих хүлээлт

“Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030” болон “Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр 2016-2020” хэрэгжүүлэхтэй холбогдуулан макро эдийн засгийн нөхцөл

байдал болон Засгийн газрын хэмжээнд төсвийн хүндрэлтэй нөхцөл байдал дунд, Засгийн газар нь хэрхэн хэрэгжүүлэх арга хэмжээ авах талаар томоохон асуудалтай тулгараад байна. Иймэрхүү нөхцөл байдал дунд Ерөнхий сайдын шууд харьяалал дор “Үндэсний хөгжлийн газар” шинээр байгуулагдсан нь бодлого зохицуулалтын үйл ажиллагаанд ихээхэн үүрэг гүйцэтгэнэ гэсэн найдлага төрүүлж байгаа юм.

Үндэсний хөгжлийн газар нь хуучин Аж үйлдвэрийн яамны стратеги бодлого төлөвлөлтийн газар болон Хөрөнгө оруулалтын газрын үйл ажиллагааг нэгтгэсэнээс гадна өмнөх засгийн газрын үед шадар сайдын хариуцаж байсан “Мега төсөл”-ийн хэрэгжилт, зохицуулалтыг хариуцахаар болсон. Байгууллагын бүтцийн хувьд 1) Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс 2) Салбарын хөгжлийн бодлого, зохицуулалтын хэлтэс 3) Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлогын хэлтэс 4) Бүртгэл, мэдээлэл, сурталчилгааны хэлтэс 5) Захиргаа удирдлагын хэлтэс гэсэн зохион байгуулалттай. Төр, хувийн хэвшлийн түншлэл (PPP) буюу Концесстай холбогдох засаг захиргаа, зохицуулалтын үйл ажиллагаа нь хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлогын хэсэгт хамаарагдана. Таван толгой, Оюунтолгой гэсэн аль хэдийнэ үйл ажиллагаа нь эхэлсэн уул уурхай томоохон төслүүдийг холбогдох яам нь үргэлжлүүлэн хариуцаж байгаа. Үндэсний хөгжлийн газар нь шинээр хэрэгжүүлэх мега төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд чиглэсэн зохицуулалтын үүрэгт гүйцэтгэнэ.

Үндэсний хөгжлийн газарт найдлага тавигдаж буй зохицуулалтын үйл ажиллагааны дунд анхаарал татаж буй нь “Дунд хугацааны улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр (PIP)” боловсруулах ажил бөгөөд, үр ашигтай улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр боловсруулахын тулд Засгийн газрын төсвийн хүрээг боловсруулах үүрэгтэй Сангийн яамны үйл ажиллагаатай зохицуулалт хийх шаардлагатай. Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр нь үндсэндээ Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр дундаас үр ашигтай нь байх нь тодорхой болсон, тэргүүлэх зэрэглэлийн үйл ажиллагаа (бодлого буюу төсөл) сонгон шалгаруулан, тэдгээрийг боломжит санхүүгийн эх үүсвэрт тусгаж өгөх үүрэгтэй бөгөөд, тэр нь улс төрийн хувьд хүлээн заавшөөрөгдөх хэмжээнд хүрч чадах эсэхээс шалтгаална.

Иймэрхүү чухал үүрэг, хариуцлага хүлээх тул Үндэсний хөгжлийн газрын зохицуулах чадавхийг сайжруулах шаардлагатай бөгөөд нэгдсэн зохицуулалтын үйл ажиллагааг хангахын тулд “Эдийн засаг, төсвийн зөвлөл”-ийг Үндэсний хөгжлийн газарт түшиглэн бий болгохыг санал болгож байна. “Эдийн засаг, төсвийн зөвлөл”-д УИХ-ын Төрийн байгуулалтын байнгын хороо, төрийн албаны туршлагатай мэргэжилтэн, судлаач, эрдэмтэд, хувийн хэвшлийн төлөөллөөс бүрдүүлэн, хэлэлцүүлгийн ил тод, найдвартай байдлыг хангах нь зүйтэй.

(5) Тус судалгааны хөгжлийн корридорын талаарх санал

Тус судалгаанаас санал дэвшүүлж буй Эдийн засгийн хөгжлийн корридорын төсөөлөл нь Монгол улсын хөгжлийн нөөц бололцоонд тулгуурлан, аж үйлдвэрлэлийн өндөр түвшний хөгжлийг зорисон нэмүү өртгийн гинжин хэлхээг үр ашигтай бий болгох орон зайн төлөвлөлтийн үзэл баримтлал бөгөөд, “Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлалд” тусгагдсан бодлогыг орон нутагт хэрэгжүүлэх орон зайн цар хүрээ юм. Түүнчлэн Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөртэй бодлогын хүрээнд зөрүүтэй асуудал байхгүй нь тодорхой болсон.

Эцэст нь Засгийн газрын холбогдох албаны хүмүүсийн тус судалгаанаас дэвшүүлж буй хөгжлийн корридорын талаарх санал, сэтгэгдлийг дор тоймлон хүргэе.

- МОНДЕП судалгаанаас боловсруулсан Монгол улсын хөгжлийн шинэ корридорын талаарх төслийг дэмжиж байна. Монгол улс өмнөх жилүүдэд хөгжлийн төлөвлөлтийг боловсруулахдаа хүн ам зүйн бүтэц, орон зүйн байршил болон эдийн засгийн нөөц боломжийг хооронд нь уялдаатай байдлаар боловсруулж байгаагүй нь ихээхэн учир дутагдалтай байсан. Энэ шалтгааны улмаас Алтанбулаг, Замын-Үүдэд чөлөөт бүс байгуулах төсөл нь өнөөг хүртэл бүрэн хэрэгжээгүй, үр ашгаа өгөөгүй байна. Санал болгож буй хөгжлийн корридор нь газар зүйн болон дэд бүтцийн байршил, ашигт малтмалын орд газрууд, хүн ам төвлөрсөн суурин газруудын хэтийн хөгжлийг харилцан уялдаатай байдлаар төлөвлөж байгаа нь тун зөв гэж үзэж байна (Ерөнхий сайдын зөвлөх).
- Тус судалгаанаас санал дэвшүүлж буй эдийн засгийн хөгжлийн корридор нь хэрэгжих боломж хангалттай байгаа гэж үзэж байна. Хөндлөн ногоон тэнхлэгийн корридорын хувьд авто замын бүтээн байгуулалт амжилттай хэрэгжиж байгаа, ногоон хөгжлийн бүс болон хөдөө аж ахуй, аялал жуулчлал хөгжих нөөц их байгаагаар санал нэг байгаа. Босоо тэнхлэгийн аж үйлдвэрийн корридорын хувьд ч Монгол, ОХУ, БНХАУ-ын 3 талт хэлэлцээрээр транзит тээврийн туршилт хийгдээд эхэлсэн, тээвэрлэлтийн хүчин чадал нэмэгдэж, цахилгаан болгох зэрэг төлөвлөлтүүд байгаа. Цаашид гадаад худалдаа нэмэгдэх нь гарцаагүй. Корридор дагуух бүс нутгийн ХАА боловсруулах үйлдвэрлэл, логистик, эрчим хүчний хөгжил зэрэг “Нэг бүс, нэг зам” хөтөлбөр гм бусад хөгжлийн санаачлагуудтай уялдуулах хөгжүүлэх боломжтой (Сангийн яам, Бодлогын газар).
- Тус судалгааны явцын тайлантай танилцсан. Хөндлөн тэнхлэгийн ногоон хөгжлийн корридор болон босоо тэнхлэгийн аж үйлдвэрийн корридорын үзэл баримтлалыг зөв зүйтэй гэж үзэж байгаа хэдий ч, одоогийн шинэ Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулах хэрэгтэй гэж бодож байна. Үйл ажиллагааны хөтөлбөрт хэд хэдэн тэргүүлэх чиглэлийн төслүүд тусгагдсан, үүнд зүүн бүсийн “Бичигт-Хөөт-Чойбалсан-ОХУ” чиглэлд төмөр замын төсөл орсон

байгаа. Үүний гол шалтаан нь, БНХАУ, ОХУ, Монгол улсын 3 талт тээвэрлэлтийн хэлэлцээр хийгдсэнээр, ОХУ болон БНХАУ хооронд эдийн засгийн корридор байгуулахаар хэлэлцэгдэж байгаа, түүнийг ашиглах гол зорилго байгаа, мөн бүс нутгийн аж үйлдвэрийн хөгжлийн нөөц, боломж анхаарал татаж байгаа. Өөрөөр хэлбэл, Чойбалсан хотын ойролцоох газрын тосны ордод түшиглэн, нефтийн үйлдвэр, цахилгаан станц барих төсөл бий. Түүнчлэн, Хөөтөд томоохон нүүрсний орд балгаа бөгөөд БНХАУ-ын хил хүртэлх Бичигт боомт хүртэлх төмөр зам барьснаар, энэ хавьд хөгжлийн корридор бий болох боломжтой. Энэхүү зүүн бүсийн шинэ хөгжлийн корридор байгуулагдах боломжтой гэж ойлгож байгаа (Үндэсний хөгжлийн газар).

- “Таван толгой-Сайншанд” чиглэлийн өмнөд бүсийн ашигт малтмалын хувьд, ойрын ирээдүйд хэрэгжиж хүндрэлтэй гэдэгтэй санал нэг байна. Сайтар хэлэлцэх шаардлагатай (Үндэсний хөгжлийн газар).
- Корридорын зарчмын хувьд хуучин Аж үйлдвэрийн яамнаас хэрэгжүүлж байсан судалгааны үр дүнтэй ижил байгаа тул дэвшүүлж буй саналыг дэмжиж байна. Уул уурхайн тухайд, хүнд үйлдвэрийг хөгжүүлэх чиглэлээр гаргасан Засгийн газрын бодлоготой уялдуулах хэрэгтэй болов уу. Эдийн засгийн корридор гэсэн ойлголт Монголд шинэлэг концепт тул цаашдын улсын хөгжлийн бодлого, орон нутгийн хөгжлийн бодлогод тусгаж явмаар байна (Үндэсний хөгжлийн газар).
- Тус судалгаагаар чухал бодлого хэмээн тусгагдсан ХАА-н үйлдвэрлэл, технологийн паркийн төсөл, шинэ Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт агуулга нь тусгагдсан бөгөөд, Үндэсний хөгжлийн газар хэрэгжүүлэх төслийн тэргүүлэх эрэмбээр жагсаагдсан байгаа. Одоогоор яам, тамгийн газруудаас хэрэгжүүлэх төслийн саналуудыг авч байгаа, Үндэсний хөгжлийн газар салбарын бодлого зохицуулах чиг үүрэгтэйн хувьд ХАА үйлдвэрлэл, технологийн паркийн хэрэгжилтэнд шаардагдах зохицуулалтыг хийнэ. Байршлын хувьд, Сэлэнгэ, Булган, Архангай аймагт эхэлж хэрэгжүүлэх боломжтой байгаа ч аль болох тус судалгаанаас санал дэвшүүлсэн хөгжлийн корридор дагуух бүс нутгаас сонгон шалгаруулах бодолтой байна. (Үндэсний хөгжлийн газар).

(6) “Ашигт малтмалын тээврийн корридор” болон “Хөгжлийн корридор”

Монгол улсын өмнөд бүсэд орших нүүрс, зэс зэрэг ашигт малтмалын нөөцийн үйлдвэрлэл, тээвэрлэлтийн системтэй холбогдох 2 ашигт малтмалын корридор байна. Нэг нь, Өмнөговь аймгийн Таван толгойн уурхай төвтэй, Дорноговь аймгийн Сайншанд хүртэлх нутгийг холбосон **Өмнөд бүсийн ашигт малтмалын тээврийн корридор** бөгөөд, нөгөө нь Зүүн бүсийн Дорнод аймгийн Чойбалсан хот төвтэй Сүхбаатар аймгийн Хөөт уурхайгаас БНХАУ-ын хилийн Бичигт боомт хүртэлх Зүүн бүсийн зүүн хойд корридор юм.

Эхний Өмнөд бүсийн ашигт малтмалын тээврийн корридорыг хөгжүүлэхэд эхний ээлжинд хэд хэдэн асуудлыг цэгцлэх хэрэгтэй. Энэ нь Таван толгой болон Оюу толгойн уурхайн үйлдвэрлэлтийн үйл ажиллагаа болон БНХАУ-ын зах зээл рүү тээвэрлэх тээврийн асуудал юм. БНХАУ-ын эдийн засгийн уналтаас үүдэн нүүрсний ханш уналтанд байгаа хэдий ч Монгол улсын эдийн засгийн хувьд үйлдвэрлэлтийн 90 ээс дээш хувь нь БНХАУ руу гарах нүүрс, зэсийн үр ашигтай тээвэрлэлтийн арга замыг бэхжүүлэх нь яаралтай шийдэх асуудал юм. Таван толгой болон Оюу толгой уурхайгаас Гашуун сухайт боомт руу хүртэлх шууд тээвэрлэлтийн систем (Баруун чиглэлийн төмөр зам)¹⁰ төмөр замын бүтээн байгуулалтаар энэхүү корридорыг үйл ажиллагаанд оруулж чадах эсэх юм.

Түүнчлэн, Таван толгойгоос Сайншанд хүртэлх Зүүн чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалт олон жил яригдаж ирсэн. Энэ нь Сайншандад төлөвлөгдсөн Таван толгой, Оюу толгойн нөөц баялагийг боловсруулах Аж үйлдвэрийн паркийн төсөл хэрэгжих эсэхээс шалтгаална. Судалгааны багийн орон нутагт хийсэн судалгаа болон дүн шинжилгээнээс богино болон дунд хугацаанд төлөвлөгдсөн хүнд үйлдвэр (кокжсон нүүрс, зэс хайлуулах үйлдвэр гм) байгуулах эдийн засгийн үндэслэл тодорхойлогдоогүй. Энэ корридор нь ирээдүйд, аж үйлдвэрийн корридор болон хөгжих эсэх нь олборлосон ашигт малтмалын нөөцөд нэмүү өртөг шингээсэн аж үйлдвэрлэл хөгжүүлж чадах үгүйгээс шалтгаалах хэдий ч, хилийн цаадах БНХАУ-ын аж үйлдвэрийн өрсөлдөөнийг харахад нэлээд хүндрэлтэй гэж хэлэхээс өөр аргагүй, урт хугацааны аж үйлдвэрийн бодлого шаардлагатай.

Нөгөөтэйгүүр, “Зүүн бүсийн зүүн хойд корридор”-ын тухайд, юун түрүүнд, Чойбалсан -Хөөт- Бичигт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтаар БНХАУ-ын зах зээл рүү холбогдох ашигт малтмал тээвэрлэх корридор байгуулан, дараа нь Чойбалсан хотоос ОХУ-тай холбогдох одоо байгаа төмөр замыг сэргээн засварласнаар БНХАУ, ОХУ-ыг холбох хоёр дахь босоо тээвэрлэлтийн корридор бий болно. ОХУ, БНХАУ, Монгол улсын хооронд хийгдсэн 3 талт хэлэлцээрээр Монголын талаас тавьсан гадаад худалдааны транзит тээврийн “Транзит Монгол” хөтөлбөр бий. Энэхүү хоёр дахь босоо тээвэрлэлтийн корридор бий болгосноор Монголын талд ашигтай нөхцөл байдал бий болно гэж найдлага тавигдаж байна.

Ерөнхийдөө эдийн засгийн корридор хөгжүүлэх үндсэн нөхцөл нь тогтвортой тээвэрлэлт логистикийн явуулах баталгаатай тээврийн систем бэхжүүлэх явдал билээ. Гэхдээ зөвхөн тээвэрлэлтийн бүтээн байгуулалт хийгдэх төдийгөөр түүнийг дагасан орон нутгийн аж үйлдвэрлэлийн үйл ажиллагааны ” **эдийн засгийн корридор**” бий болохгүй. Энэхүү корридорын бүс нутаг нь нүүрс, зэс, газрын тос болон молибден, уран зэрэг ашигт малтмалаар баялаг, урт хугацаанд шинэ ашигт малтмалын корридор болон хөгжих

¹⁰ Хүнд даацын ачааны машинаар тээвэрлэлт хийхээс өөр аргагүй, өндөр тээврийн зардал нүүрсний гадаад худалдаанд хүндрэл учруулж байгаа тул энэхүү төмөр замын төслийг яаравчлах шаардлагатай. Тус төмөр замын төслийг Монголын засгийн газрын 100% хөрөнгө оруулалттай ”Монголын төмөр зам”ТӨХК хариуцах болно.

бололцоотой. Бодитоор хөгжүүлэхэд түүнтэй уялдуулан хот байгуулалт, бусад аж үйлдвэрлэлийн төвлөрөлтэй холбох урт хугацаанд тотвортой хөгжих хөгжлийн хөрөнгө оруулалт зайлшгүй шаардлагатай.

Хүснэгт 6.6.1 Монгол улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр

Бологын тулгуур	Үйл ажиллагааны хөтөлбөр
<p>1. Эдийн засгийн хүндрэлийг даван туулах онцгой бодлого</p> <p>Эдийн засагт үүссэн хүндрэлийг богино хугацаанд даван туулж, макро эдийн засгийн тэнцвэрийг хангах, эдийн засгийн бүтцийг төрөлжүүлж, түүхий эдийн үнээс хэт хамааралтай байдлыг бууруулж, төлбөрийн тэнцлийн эрсдэлийг багасгах, дунд хугацаанд учирч буй өрийн дарамтыг бууруулах, эдийн засгийг дархлаатай болгох, улмаар эдийн засаг дунд хугацаанд тогтвортой тэлэх бодлогыг баримтална.</p>	<ol style="list-style-type: none"> 1. Эдийн засгийн хүндрэлийг богино хугацаанд даван туулах, тогтворжуулах хөтөлбөр боловсруулна. 2. Макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангаж, гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ. 3. Төсвийн нэгдмэл байдлыг ханган, төсвөөс гадуурх санхүүжилтийг зогсоож, хөрөнгө оруулалтын бодлого, төлөвлөлтийг боловсронгуй болгох замаар үр ашгийг нэмэгдүүлнэ. 4. Төсвийн сахилга батыг сайжруулж, үр ашиггүй зардлыг танах, хэмнэлтийн горимд шилжүүлэх замаар төсвийн алдагдлыг бууруулна. 5. Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалтыг үр дүнтэй, ард иргэдэд нээлттэй, ил тод болгоно. 6. Ард иргэд, аж ахуйн нэгж, улс орноо өрийн дарамтаас гаргаж, иргэдийн тогтвортой амьжиргааг дэмжин орлогыг нэмэгдүүлнэ. 7. Төрөөс захиалгаар гүйцэтгэсэн ажил үйлчилгээний хөлсөө авч чадахгүй байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын төлбөрийг барагдуулна. 8. Өр зээлийн нөхцөлийг хөнгөвчилж, үндсэн төлбөрийн хугацааг хойшлуулах чиглэлээр яриа хэлэлцээ хийж, улсын төсөвт тулгарч буй өрийн дарамтыг үе шаттайгаар бууруулна. 9. “Үнэ тогтворжуулах” хөтөлбөрийн хүрээнд олгосон зээлийн ашиглалтад үнэлэлт, дүгнэлт өгч, үр ашгийг дээшлүүлэх бодлого хэрэгжүүлнэ. 10. Хөгжлийн банкны бонд, зээлийн зарцуулалтыг дүгнэж, төсөл, хөтөлбөрт үнэлгээ хийж, зориулалтын бусаар ашигласан, хугацаа хэтэрсэн зээлийг буцаан төлүүлнэ. 11. Шинэ төрлийн татвар бий болгохгүй ба үндэсний үйлдвэрлэлийг дэмжих бодлогын хүрээнд тодорхой салбарт үйл ажиллагаа явуулж байгаа 1.5 тэрбум төгрөгөөс бага жилийн орлоготой аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг 1 хувь болгон бууруулна. 12. Аж ахуйн нэгжийн болон хувь хүний орлогын албан татварыг орлогын түвшингээс хамаарсан шатлалтай болгоно. 13. Хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлтийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй уялдуулах эрх зүйн орчинг бүрдүүлнэ. 14. Үндэсний хөрөнгө оруулагчдыг бүхий л талаар дэмжиж, эхний хөрөнгө оруулалтаа нөхөх хүртэл орлогын албан татвараас хөнгөлөх, чөлөөлөх эрх зүйн орчинг бүрдүүлнэ. 15. Эрх бүхий байгууллагуудаас үндэсний аж ахуйн нэгжүүдэд тавигдсан татварын актын хүү, торгууль, алданги, үндсэн татварын нөхөн төлбөр төлөх хугацааг сунгах, хаалгасан дансыг нь нээх зэргээр бизнес эрхлэгчдээ дэмжинэ. 16. Эдийн засгийн хүндрэлээс улбаалан ажил, орлого нь хумигдан, зээлээ төлж чадахгүйд хүрч, “Найдваргүй зээлдэгчдийн жагсаалт”-д бүртгэгдсэн аж ахуй нэгж, иргэдэд зээлээ эргэн төлж, зээлийн түүхээ сайжруулах боломж олгоно. 17. 5-аас доошгүй жил тасралтгүй үйл ажиллагаа эрхэлж, байнгын ажлын байр шинээр бий болгосон хөнгөн, жижиг, дунд бизнес эрхлэгчдийг урт хугацаатай, хөнгөлөлттэй зээлээр дэмжинэ. 18. Төрийн үйлчилгээний шимтгэл, төлбөрийн хэмжээг бууруулна. 19. Төрөөс бизнес эрхлэгчдэд олгож байгаа тусгай зөвшөөрлийн тоог гурав дахин цөөрүүлж, хүчинтэй байх хугацааг уртасган, давхардсан хяналт шалгалт, хүнд суртлыг арилгана. 20. Эдийн засгийн хүндрэлийг даван туулах, эмзэг байдлыг бууруулах, эрсдэлийг багасгах чиглэлээр олон улсын болон бүс нутгийн банк, санхүүгийн байгууллагуудтай нягт хамтран ажиллана. 21. Түншлэгч улс орон, олон улсын банк, санхүүгийн байгууллагуудтай зөвшилцөх уулзалтуудыг сэргээн зохион байгуулна. 22. Эдийн засгийн суурь үзүүлэлтүүд болон Монгол Улсын зээлжих зэрэглэлийг сайжруулж, гадаадын хөрөнгө оруулагчдын итгэлийг сэргээнэ. 23. “Монголд үйлдвэрлэл” хөтөлбөрийг хэрэгжүүлж, үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ.

	<p>24. “Эрдэнэс Монгол” компани болон Оюутолгой төслийн үйл ажиллагааг эрчимжүүлж, Тавантолгой, стратегийн ач холбогдол бүхий бусад ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулна.</p>
<p>2. Эдийн засгийн тогтворой өсөлтийг хангах бодлого</p>	<ol style="list-style-type: none"> 1. Монгол Улсын үндэсний нийт орлогыг нэмэгдүүлж, дундаж-дээгүүр орлоготой орнуудын эгнээнд буцаан оруулна. 2. Монгол Улсын Үйлдвэржилтийн газрын зургийг гаргаж, хүнд аж үйлдвэрийн хөгжлийн хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ. 3. Монгол Улсад үйлдвэрлэсэн уул уурхайгаас бусад салбарын бүтээгдэхүүний 50-аас дээш хувийг экспортод гаргаж буй аж ахуйн нэгжийг татварын бодлогоор дэмжинэ. 4. Иргэн бүрийн эзэмшиж буй 1072 хувьцааг амь оруулж, үнэ цэнэтэй болгоно. 5. Оюутолгой, Тавантолгой, Эрдэнэт зэрэг томоохон компаниудын үр ашгийг иргэн бүрд хүртээмжтэй байлгах бололцоог бүрдүүлнэ. 6. Томоохон төслийг хэрэгжүүлж буй аж ахуйн нэгжүүдэд олгох зээлийн хугацааг уртасгаж, хүүг бууруулах нөхцөлийг бүрдүүлнэ. 7. Иргэндээ ээлтэй, эдийн засагтаа үр өгөөжтэй банк санхүү, хөрөнгийн зах зээлийг хөгжүүлнэ. 8. Стандартчилал, хэмжил зүйн талаарх хууль тогтоомжийг олон улсын нийтлэг зарчимд нийцүүлэн шинэчилж, “Үндэсний чанарын хөтөлбөр”-ийг хэрэгжүүлнэ. 9. Бараа бүтээгдэхүүний зах зээлд өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, худалдаан дахь техникийн саад тогторыг багасгахад Стандартчилал, тохирлын үнэлгээний үр дүнг хүлээн зөвшөөрөх, хэрэглэх, ашиглах механизмыг оновчтой болгоно. 10. Үйлдвэрлэлд ашиглагддаг уур, ус, дулаан, цахилгааны тарифыг тогтвортой байлгаж, аажмаар бууруулах бодлого баримтална. 11. Малын гаралтай түүхий эдийг бэлтгэх, тээвэрлэх, боловсруулах нийлүүлэлтийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлнэ. 12. Чөлөөт бүсүүдийн үйл ажиллагааг эрчимжүүлж, гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг дэмжиж ажиллана. 13. Зах зээл дэх шударга өрсөлдөөнийг дэмжиж, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах хууль, эрх зүйн орчинг сайжруулна. 14. Дотоодын үйлдвэрлэлийг гааль, татварын бодлогоор дэмжинэ. 15. Экспортын нэг цонхны бодлого хэрэгжүүлж, гааль, татвар, мэргэжлийн хяналт зэрэг төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр, эсхүл нэг цэгт үзүүлж, чирэгдлийг багасгана. 16. “Итгэлийн зээл”-ийг олгож, жижиг, дунд үйлдвэрлэл, өрхийн аж ахуй, бичил бизнес эрхлэгчдэд дэмжлэг үзүүлнэ. 17. Хөдөө орон нутаг, алслагдсан бүс нутагт бизнес эрхлэлтийг дэмжих “Бүсийн хөнгөлөлт”-ийн бодлого хэрэгжүүлнэ. 18. Шатахууны үнийг дэлхийн зах зээлийн үнэтэй уялдуулан үнийн дарамтыг бууруулна.
<p>3. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ</p>	<ol style="list-style-type: none"> 1. Хүн амын хүнсний хангамжийг тогтворжуулах, стратегийн хүнсний нийлүүлэлтийн улирлын хамаарлыг бууруулах зорилгоор “Мах, сүүний анхдугаар аян”-ыг зохион байгуулж, хүн амыг эрүүл, аюулгүй бүтээгдэхүүнээр хангана. 2. Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн өрсөлдөх чадварыг дээшлүүлж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн экспортлох боломжийг бүрдүүлнэ. 3. Органик болон зохицуулах үйлчилгээтэй хүнсний эрх зүйн орчинг бүрдүүлж, энэ чиглэлийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх санхүү, хөрөнгө оруулалт, татварын бодлогыг хэрэгжүүлнэ. 4. Аймаг, нийслэл, сум, суурин газруудын хэрэгцээнд тохирсон орчин үеийн дэвшилтэт технологи бүхий бага, дунд оврын хүнсний боловсруулах жишиг загвар үйлдвэрийг байгуулахыг дэмжинэ. 5. Хүнсний аюулгүй байдлын бүртгэл, мэдээллийн нэгдсэн цахим санг бий болгоно. 6. Иргэдийн эрүүл, баталгаат хүнс хэрэглэх нөхцөлийг бүрдүүлж, хүнсний бүтээгдэхүүний бэлтгэл, боловсруулалт, хадгалалт, тээвэрлэлт, борлуулалтын тогтолцоог бий болгож, хүнсний аюулгүй байдлыг сайжруулна. 7. Дотоодын хүнсний бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулж, тахиа, гахай, зөгий, загасны аж ахуй зэрэг дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэн, бүтээгдэхүүний нийлүүлэлт, хүртээмжийг нэмэгдүүл
<p>4. Мал аж ахуйн чиглэлээр;</p>	<ol style="list-style-type: none"> 1. Мал аж ахуйн үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлэх, эдийн засгийн эргэлтийг сайжруулах, дэвшилтэт техник, технологийн шинэчлэлийг хийх, инновацийг

	<p>нэвтрүүлэх зорилгоор “Монгол мал” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлнэ.</p> <ol style="list-style-type: none"> 2. “Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”, “Монгол малчин”, “Малжуулах” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. 3. Бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуй, фермерийн аж ахуйг зохистой хослуулснаар мах, махан бүтээгдэхүүний экспортыг дэмжиж, жилд экспортлох хэмжээг 50 мянган тоннд хүргэж, малчин өрхийн орлогыг нэмэгдүүлнэ. 4. Мал аж ахуйн мэргэжилтнийг бэлтгэх, давтан сургах, мал аж ахуйн хөгжлийн талаарх олон улсын туршлагыг судлах, нэвтрүүлэх, “Малчдыг мэдлэгжүүлэх, мэдээллээр хангах” хөтөлбөр хэрэгжүүлнэ. 5. Мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдийг хөнгөлөлттэй зээл, хөрөнгө оруулалт, даатгал, татварын уян хатан бодлогоор дэмжих, малын гаралтай түүхий эдийн үнэ ханшийн уналтаас хамгаалах, малчдад ирж буй хүндрэлийг багасгахад чиглэгдсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих тусгай санг өргөжүүлж, малчин өрхийн орлого, амьжиргааны баталгааг хангана. 6. Малыг бүртгэлжүүлж, малын гаралтай түүхий эд бэлтгэлийн чанар стандартыг дээшлүүлж, гарал үүслийг тодорхой болгох системийг бүрдүүлнэ. 7. Малчдыг орон сууцны хөтөлбөрт хамруулах, нийгмийн асуудлыг шийдэх арга хэмжээ авна. 8. Мал эмнэлгийн албаны тогтолцоог олон улсын жишигт нийцүүлж, үйл ажиллагааны шуурхай, нэгдмэл байдлыг ханган, мал, амьтны гоц халдварт, халдварт, зооноз өвчнөөс урьдчилан сэргийлэх, өвчнийг хяналтад авах, тэмцэх стратегийг хилийн боомтуудыг түшиглэн бүсчлэн хэрэгжүүлж, мал аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг экспортлох боломжийг нэмэгдүүлнэ. 9. Малын тоог чанарт шилжүүлж ашиг шим, хүртээмжийг сайжруулах, генетикийн нөөцийг хамгаалах, үржил селекцийн ажлыг шинжлэх ухааны үндэслэлтэй явуулах, биотехнологийн ололтыг нэвтрүүлэх, шинэ үүлдэр, омгийг бий болгох, орон нутгийн мал үржлийн нэгжүүдийг чадавхжуулна. 10. Малын тэжээлийн үйлдвэрийг бүсчлэн байгуулах үйл ажиллагаанд зээлийн дэмжлэг үзүүлж, өвс тэжээлийн аюулгүй нөөцийг нэмэгдүүлнэ. 11. Хөдөөгийн хүн ам болон мал аж ахуйн усан хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор бэлчээрт худаг, хөв цөөрөм барьж байгуулан ашиглалт, хяналтыг сайжруулна. 12. Бэлчээрийн ашиглалтыг сайжруулах, нөхөн сэргээх, талхагдал, цөлжилтийг бууруулах, бэлчээрт хөнөөл учруулж буй мэргч амьтан, шавжтай байгаль орчинд халгүй, дэвшилтэт аргаар тэмцэнэ. 13. Мал аж ахуйн салбарын тогтвортой хөгжлийг хангахад чиглэгдсэн Малын генетик нөөцийн тухай, Мал, амьтны эрүүл мэндийн тухай, Мал аж ахуйн хөгжлийг дэмжих тухай хуулийг тус тус боловсруулж, эрх зүйн таатай орчинг бүрдүүлнэ. 14. Мал аж ахуй эрхлэх уламжлалт хэв маяг, мэдлэгийг хадгалах, баяжуулах, малын тоо, төрөл, сүргийн бүтцийн зохист харьцааг баримтлах, эрчимжсэн аж ахуйг төрөлжүүлэн хөгжүүлэх хөтөлбөр хэрэгжүүлнэ.„
<p>5. “АТРЫН-III аян”-ыг үргэлжлүүлэх хүрээнд</p>	<ol style="list-style-type: none"> 1. Эргэлтийн талбайн ашиглалтыг сайжруулж, газар тариалан, эрчимжсэн мал аж ахуй эрхлэх бүс нутгийг тогтоон үр тариа, төмс, гол нэрийн хүнсний ногоог 100 хувь, таримал тэжээлийн 50 хувийг дотоодын үйлдвэрлэлээр хангана. 2. Жимс жимсгэний нэр төрөл, үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, чацарганы үйлдвэрлэлийн нэгдсэн сүлжээ байгуулан, хүн амыг амин дэм бүхий жимс жимсгэнээр ханган, экспортын орлогыг нэмэгдүүлнэ. 3. Газрын үржил шим, үр өгөөж, таримал ургамлын үр үржүүлгийн аж ахуйг цогцолбор байдлаар хөгжүүлж, үрийн сорт чанарыг сайжруулах замаар га-аас авах ургацын хэмжээг нэмэгдүүлнэ. 4. Ургамал хамгааллын цогц арга хэмжээг төлөвшүүлж, тариалангийн талбайн хөрснийг элэгдэл, эвдрэлээс хамгаалж, үржил шимийг сайжруулах, таримлын зохистой сэлгээ, тэг элдэншүүлгийн технологийг үе шаттайгаар нэвтрүүлнэ. 5. Усны хайгуул, судалгаанд үндэслэн усалтын систем шинээр барьж, сэргээн засварлах, усалгааны дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэхийг дэмжиж, усалгаатай талбайн хэмжээг жил бүр нэмэгдүүлнэ. 6. Өвөл, зуны хүлэмжийн загвар, цогцолбор аж ахуйг хөгжүүлж, хот суурингийн хүн амыг шинэ ургацын ногоогоор тогтвортой хангана.

	<ol style="list-style-type: none"> 7. Газар тариалангийн зориулалттай дэвшилтэт техник, тоног төхөөрөмж, бордоо, ургамал хамгааллын бодисыг татварын бодлого, санхүүгийн лизингийн арга хэрэгслээр дэмжинэ. 8. Зоорь, агуулах, элеватор, үтрэмийн техник, тоног төхөөрөмжийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, хадгалалт борлуулалтын нэгдсэн тогтолцоог бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. 9. Тариалангийн даатгалын эрх зүйн орчинг бүрдүүлнэ
<p>6. “ҮНДЭСНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ” хөтөлбөрийн хүрээнд</p>	<ol style="list-style-type: none"> 1. Үйлдвэржилтийн 21:100 хөтөлбөрийг хэрэгжүүлж, импортыг орлох экспортын чиглэлийн тэргүүлэх болон жижиг, дунд үйлдвэрлэл, хоршоо, худалдаа, үйлчилгээний салбарын татвар, эрх зүй, бизнесийн таатай орчинг бүрдүүлж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хэмжээг нэмэгдүүлнэ. 2. Хөдөө аж ахуйн бараа, бүтээгдэхүүний үнийн зохицуулалтын эрх зүйн орчинг бүрдүүлнэ. 3. Хөнгөн, жижиг дунд үйлдвэр, хоршооны салбарт урт хугацаат хөрөнгө оруулалтын болон санхүү, зээлийн уян хатан бодлого хэрэгжүүлнэ. 4. Ноос, ноолуур, арьс ширэн түүхий эдийн бэлтгэл тээвэрлэлт, үндэсний үйлдвэрт тогтвортой нийлүүлэх тогтолцоог бүрдүүлж, түүхий эдийн санг бий болгоно. 5. Олон улсын худалдааны болон хөрш орнуудын боомтын бүсэд үйлдвэрлэл, худалдаа хөгжүүлэхийг дэмжинэ. 6. Хөнгөн, жижиг, дунд үйлдвэрийн салбарын боловсон хүчнийг бэлтгэх, сургах, давтан сургах тогтолцоог хөгжүүлж “Мэргэжилтэй ажилтан” хөтөлбөр хэрэгжүүлнэ. 7. Хөнгөн үйлдвэрийн салбаруудыг хөгжүүлэх зорилгоор зөвлөгөө, мэдээлэл, сургалт явуулах мэдээллийн болон инкубатор төвийг тухайн салбарын мэргэжлийн холбоодыг түшиглэн байгуулахыг дэмжинэ. 8. Гадаад орны өндөр болон дэвшилтэт технологи бүхий үйлдвэрийг франчайзаар оруулж нутагшуулан, хөнгөн, жижиг дунд үйлдвэрийн салбарт “Хөгжлийн загвар” үйлдвэр байгуулахыг дэмжинэ. 9. Хөнгөн үйлдвэрийн чиглэлээр дэлхийн тэргүүлэх, дэвшилтэт техник технологийн үзэсгэлэнг Монгол Улсад тогтмол зохион байгуулж, гадаад оронд зохион байгуулагдаж буй үйлдвэрийн тоног төхөөрөмж, бараа, бүтээгдэхүүний үзэсгэлэнд үйлдвэрлэгчдийг дэмжиж хамруулна. 10. Хөнгөн үйлдвэрийн парк байгуулж, салбарын үйлдвэрүүдийн хамтын ажиллагааг дэмжин, кластерыг бүртгэлжүүлэн бодлогоор дэмжинэ. 11. Хөдөө аж ахуйн биржээр арилжаалах бараа, түүхий эдийн нэр төрөл, тоо хэмжээг нэмэгдүүлж, үйл ажиллагааг боловсронгуй болгоно.
<p>7. Геологи, уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ</p>	<ol style="list-style-type: none"> 1. Монгол орны геологийн зураглал, ерөнхий эрэл, агаарын геофизик, геохими, гидрогеологи, геоэкологийн судалгааны ажлын хэмжээг нэмэгдүүлэх замаар уул уурхайн салбарын тогтвортой хөгжлийг дэмжинэ. 2. Олон улсын жишгийн дагуу Үндэсний геологийн алба, Үндэсний геомэдээллийн санг байгуулан, мэдээлэл түгээх үйлчилгээг хялбаршуулна. 3. Геологи, уул уурхайн салбарт хөрөнгө оруулалтыг татах эрх зүйн таатай орчинг бүрдүүлж, харилцан үр ашигтай төсөл, хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлнэ. 4. Уул уурхайн үйлдвэрлэл дэх төрийн оролцоог зохистой хэмжээнд байлгаж, Кадастрын бүртгэлийн системийг боловсронгуй болгож, тусгай зөвшөөрөл олгох үйлчилгээг хөнгөн шуурхай болгоно. 5. Газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын ажлыг эрчимжүүлж, нөөцийг өсгөнө. 6. “Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого”-ын 3.1.2-т заасан иргэд бичил уурхайн салбарт хууль ёсны бүтцээр хоршиж ажиллах чиглэлийг хэрэгжүүлэн холбогдох эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоно. 7. Уул уурхайн дэд бүтцийн хөгжлийн урт хугацааны төлөвлөлт боловсруулж, салбар хоорондын уялдааг сайжруулна. 8. Уул уурхайн судалгааны нэгж байгуулж, эрдэс баялгийн салбарт хөрөнгө оруулалтын таатай орчинг бий болгоно. 9. Хоёрдогч ашигт малтмал ашиглах эрх зүйн орчинг бий болгож, уурхайн нөхөн сэргээлт, хаалтыг олон улсын жишигт хүргэнэ. 10. “Алт-2” хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийг Монголбанкттай

	<p>хамтран шийдвэрлэнэ.</p> <ol style="list-style-type: none"> 11. Алтны олборлолтыг нэмэгдүүлж, бичил уурхай эрхлэгчдийн олборлосон алтыг худалдан авах эрх зүйн орчинг бүрдүүлнэ. 12. Газрын тосны олборлолтыг тогтвортой нэмэгдүүлэн, газрын тос боловсруулах үйлдвэр байгуулна. 13. Зэсийн баяжмал хайлуулах, цэвэршүүлэх үйлдвэр байгуулах ажлыг дэмжиж ажиллана. 14. Дархан, Сэлэнгийн бүсэд хар төмөрлөгийн цогцолбор байгуулах нөхцөлийг бүрдүүлнэ. 15. Нүүрс угаах, гүн боловсруулах үйлдвэр болон нүүрсний нийлэг хийн үйлдвэр байгуулахыг бодлогоор дэмжинэ. 16. Шингэрүүлсэн түлш, шатах тослох материалын үйлдвэр байгуулах ажлыг бодлогоор дэмжинэ. 17. Метал хийц, угсралтын үйлдвэрийг хөгжүүлнэ
<p>8. Дэд бүтцийн салбарын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ</p> <p>Барилга, хот байгуулалтын чиглэлээр:</p> <p>Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг хангасан хот, суурин газрыг төлөвлөж, байгаль орчин, хүний эрүүл мэндийн шаардлагад нийцсэн барилгын үйлдвэрлэлийг дэмжиж, аюулгүй, хүртээмжтэй орон сууцаар хангах төрийн бодлогыг боловсруулан хэрэгжүүлнэ.</p>	<ol style="list-style-type: none"> 1. Ипотекийн зээлийн нөхцөлийг хөнгөвчилж, зээлийн хөтөлбөрийг олон хувилбарт хэлбэрээр хэрэгжүүлэх бодлого баримталж, зээлийн цар хүрээ, хүртээмжийг нэмэгдүүлнэ. 2. Хүн амын орон сууцны хэрэгцээг хангах зорилгоор нэгдсэн бодлого боловсруулж, “Хямд өртөгтэй орон сууц” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. 3. Норм, нормативын баримт бичгийн тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэн шинэчилж, олон улсын норм, нормативын баримт бичгийг хэрэглэх орчинг бүрдүүлнэ. 4. Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төслийг бүс нутаг, бүлэг суурингийн тогтолцоог оновчтой тогтоох чиглэлээр үе шаттайгаар боловсруулна. 5. Газрын нэгдсэн бодлого, тогтолцоог бүрдүүлж, газар ашиглах, эзэмших, өмчлөх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоно. 6. Монгол Улсын нутаг дэвсгэрийг бүрэн зурагжуулах, шинэчлэх, геодезийн нэгдсэн сүлжээг бий болгох замаар орон зайн өгөгдөл, мэдээллийг нийтийн хэрэглээнд нэвтрүүлнэ. 7. Улаанбаатар хотыг хөгжүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлнэ. 8. Улаанбаатар хотыг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан “Гудамж”, “Дугуйн зам” дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлнэ. 9. Улаанбаатар хот, аймгийн төвүүдийн ногоон байгууламжийг 3 дахин нэмэгдүүлэх бодлого баримтална. 10. Улаанбаатар хот болон томоохон хотуудыг дахин төлөвлөж, хөгжүүлэх бодлогын хүрээнд барилга байгууламжийг шинэчлэх, гэр хорооллын дахин төлөвлөлтийн төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлж, агаарын бохирдлыг бууруулах нөхцөлийг бүрдүүлнэ. 11. Хот, суурин газруудад шинээр баригдах орон сууцны хорооллын инженерийн хангамжийн шугам сүлжээний техникийн шийдлийг хонгилын системээр төлөвлөн, үе шаттай хэрэгжүүлнэ. 12. Барилга байгууламжийн өөрийн өртгийг бууруулах, барилгын үйлдвэрлэлийн хугацааг уртасгах, барилгын жинг хөнгөрүүлэх, дулаан алдагдлыг бууруулах, галд тэсвэрлэлтийг сайжруулахад чиглэсэн барилгын материалын үйлдвэрлэлийг хөгжүүлэх бодлого боловсруулж хэрэгжүүлнэ. 13. Хот, суурин газруудын газар хөдлөлтийн үйлчлэлийн давтамж, эрчмийг шинэчлэн тогтоож, барилга байгууламжийн төлөвлөлтөд тусгах, ашиглагдаж буй барилга байгууламжуудын бат бэх, найдвартай байдлыг сайжруулах арга хэмжээг төлөвлөж, үе шаттай хэрэгжүүлнэ. 14. Нийтийн аж ахуйн талаар төрөөс баримтлах нэгдсэн бодлогыг хот, суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулж хэрэгжүүлнэ. 15. Улаанбаатар хотод шинээр төлөвлөж байгаа орон сууцны хорооллын унд-ахуйн хэрэглээний цэвэр усыг тусад нь төлөвлөх, гарсан бохир усыг саарал усны стандартын шаардлагад нийцүүлэн дахин боловсруулж, ариутгах татуургын системд технологийн зориулалтаар болон ногоон байгууламжийн усалгаанд ашиглах зэрэг техникийн шийдлийг зураг төсөлд тусгаж, хэрэгжүүлэх ажлыг эхлүүлнэ.

	<ol style="list-style-type: none"> 16. Хот, суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан гадаад, дотоодын хөрөнгө оруулалтаар Улаанбаатар хот болон бусад томоохон хот, суурин газрын цэвэрлэх байгууламжийг үе шаттай шинэчлэх ажлыг эрчимжүүлнэ. 17. Цэвэрлэх байгууламжаар цэвэрлэсэн ус болон хөрсний усыг үйлдвэрийн технологийн хэрэгцээнд ашиглах боломжийг бүрдүүлнэ. 18. Утасгүй интернетийн хүртээмжийг нэмэгдүүлж, амралт, зугаалгын бүс, номын санд ашиглах боломжийг бүрдүүлнэ. 19. Улаанбаатар хотын цэвэр усны хангамжийг сайжруулах ажлын хүрээнд Туул, Сэлбэ, Дунд голын урсацыг нэмэгдүүлж, эргийн дагуу олон нийтийн соёл, амралтад зориулсан тохилог орчныг бүрдүүлнэ. 20. Улаанбаатар хотын орон сууцны хороолол, нийтийн үйлчилгээний төвүүдийн дэргэд газар доорх болон давхар зогсоол барьж, авто зогсоолыг хоёр дахин нэмэгдүүлнэ. 21. Улаанбаатар хотын Сэлбэ, Баянхошуу дэд төвүүдийн инженерийн шугам сүлжээг барьж байгуулах ажлыг дуусгана.
<p>9. Эрчим хүчний салбарын чиглэлээр Улс орны эдийн засгийн аюулгүй байдлын үндэс болсон эрчим хүчний тогтвортой, найдвартай ажиллагааг бүрэн хангаж, экспортын чадамжтай болох нөхцөлийг бүрдүүлнэ</p>	<ol style="list-style-type: none"> 1. Улс орны эдийн засгийн аюулгүй байдал, тогтвортой хөгжлийн үндэс болсон суурь салбарын тасралтгүй, найдвартай ажиллагааг хангах зорилгоор ашиглалтад байгаа цахилгаан станцуудын хүчин чадлыг өргөтгөх, шинэчлэх ажлыг хэрэгжүүлнэ. /Чойбалсангийн ДЦС, Улаанбаатарын Гуравдугаар ДЦС/ 2. Монгол Улсын эрчим хүчний хангамжийн найдвартай байдал, өсөн нэмэгдэж байгаа хэрэглээг бүрэн хангах шинэ эх үүсвэрийг барих, Өмнөд говийн уул уурхайн цахилгааны хэрэглээг хангах Тавантолгойн уурхайн нүүрсээр ажиллах цахилгаан станцыг барих асуудлуудыг шийдвэрлэнэ. 3. Шивээ-Овоо, Тэвшийн говь болон бусад нүүрсний ордыг түшиглэн экспортын зориулалттай том чадлын цахилгаан станц, тогтмол гүйдлийн цахилгаан дамжуулах шугам барих төслийг эхлүүлнэ. 4. Сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийг зохистой харьцаагаар хөгжүүлнэ. 5. Бүс нутгийн эрчим хүчний систем, хүнд үйлдвэрүүд, том хэрэглэгчид, эрчим хүчний эх үүсвэрүүдийг холбосон цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцыг барьж, эрчим хүчний нэгдсэн систем байгуулах ажлыг үргэлжлүүлнэ. 6. Аймгийн төвүүд болон томоохон хот, суурин газарт дулааны станц, шугам сүлжээг шинээр барих, өргөтгөх, эрчим хүчээр бүрэн хангах ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ. 7. Сумын төвүүдийг төвлөрсөн цахилгаан системд бүрэн холбож дуусган сэргээгдэх эрчим хүч болон цэвэр технологид суурилсан төвлөрсөн инженерийн байгууламж буюу дулаан хангамж, цэвэр бохир усны сүлжээтэй болгох ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ. 8. Эрчим хүчний хэмнэлт, үр ашгийг дээшлүүлэх, алдагдлыг бууруулах, инновацийн түвшний шинэ техник технологи нэвтрүүлэх чиглэлээр тодорхой арга хэмжээ, төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. 9. Дулаан, цахилгааны үнийг тогтвортой байлгаж, цаашид үе шаттайгаар бууруулах бодлого баримтална. 10. Тавантолгой болон төвийн бүсийн нүүрсний ордуудад давхаргын хийн нарийвчилсан судалгааг хийж, ашиглах боломжтой нөөцийг тогтоох, орон нутгийн хийн хангамжид ашиглах загвар төсөл хэрэгжүүлэх, шинэ техник технологид үндэслэсэн нүүрсийг хийжүүлэх, утаагүй түлш үйлдвэрлэх дунд чадлын үйлдвэр барьж, хэрэглэгчдийг утаагүй түлшээр хангах төслийг эхлүүлж, агаарын бохирдлыг бууруулна.
<p>10. Зам тээврийн салбарын чиглэлээр: Эдийн засгийн өсөлтийг дэмжсэн, нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцсэн, аюулгүй, ая тухтай үйлчилгээ үзүүлэх зам, тээвэр, ложистикийн сүлжээг</p>	<ol style="list-style-type: none"> 1. Олон улс, хот хоорондын болон орон нутгийн чанартай авто замын сүлжээн дэх хатуу хучилттай авто замын сүлжээг өргөтгөж, бүх аймгийн төвийг нийслэл хоттой хатуу хучилттай авто замаар холбож дуусгах, Мянганы замын хэвтээ тэнхлэгийн хэсгийг үргэлжлүүлнэ. 2. “Тавантолгой-Гашуун сухайт”, “Хөөт-Бичигт” чиглэлийн төмөр замыг барьж ашиглалтад оруулна. 3. “Тавантолгой-Гашуун сухайт” чиглэлийн төмөр замаас Оюутолгойн салбар төмөр зам, “Шивээ хүрэн-Сэхэ” чиглэлийн боомтын төмөр замыг барьж дуусгана. 4. “Зүүнбаян-Ханги” чиглэлийн төмөр замын барилгын ажлыг эхлүүлнэ. 5. Улаанбаатар төмөр замын техникийн шинэчлэлт хийж нэвтрүүлэх чадварыг нэмэгдүүлж, “Богд Хан” төмөр замыг барьж байгуулах ажлыг эхлүүлнэ.

<p>өргөжүүлэн хөгжүүлнэ.</p>	<ol style="list-style-type: none"> 6. “Эрдэнэт-Овоот” чиглэлийн төмөр замыг барьж байгуулах ажлыг эхлүүлнэ. 7. Үндэсний болон олон улсын тээвэр, ложистикийн сүлжээг хөгжүүлж, “Хөшиг”-ийн хөндийд холимог тээвэр ложистикийн төв байгуулна. 8. Төрөөс агаарын тээврийн салбарт баримтлах бодлогод тулгуурлан орон нутгийн болон олон улсын нислэгийн тоог нэмэгдүүлэх, өрсөлдөөнийг дэмжих замаар тус салбарт үнэ тарифыг бууруулна. 9. Жижиг нисэх онгоц, нисдэг тэрэгний зах зээлийг хөгжүүлж, гамшгаас хамгаалах, хүнс, хөдөө аж ахуй, эрүүл мэндийн түргэн тусламжийн үйлчилгээ, иргэний агаарын тээвэр, аялал жуулчлалын чиглэлээр ашиглана. 10. Тээврийн салбарын олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлж, бүс нутгийн дэд бүтэц, тээврийн интеграцид нэгдэн орох замаар дамжин өнгөрөх тээврийг хөгжүүлнэ. 11. Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын гурван талт хамтын ажиллагааны механизмын хүрээнд Бүс нутгийн хамтын ажиллагааны төлөвлөлтийн төв байгуулж, дэд бүтцийн чиглэлээр урьдчилан тохиролцсон төслүүдийн ТЭЗҮ-ийг боловсруулж, зарим ажлыг эхлүүлнэ. 12. Далайн тээвэр, хөлөг онгоцны бүртгэлийн үйл ажиллагааг өргөжүүлж, дотоодын гол, мөрөн нууруудад байгаль орчинд ээлтэй аялал жуулчлалын аюулгүй усан замын тээврийг хөгжүүлнэ. 13. БНХАУ-ын Тяньжин хотын Дунзяны чөлөөт боомт бүсэд тээвэр ложистикийн төвийг байгуулна. 14. Эрэлтэд нийцсэн, хүрээлэн орчинд нээлтэй тээврийн ухаалаг систем нэвтрүүлнэ. 15. Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан автозамын сүлжээг сайжруулах зорилгоор Баянзүрх, Яармаг, Сонсголонгийн гүүр болон Улаанбаатар-Налайх чиглэлийн автозамыг шинээр барина. 16. Улаанбаатар хотын автозамын ачааллыг бууруулах, түгжрэлийг багасгах зорилгоор гүүрэн гарцуудыг шинээр байгуулан, тусгай замын автобус /BRT/-ыг нийтийн тээврийн үйлчилгээнд шинээр нэвтрүүлнэ.
------------------------------	--

Эх сурвалж: Монгол улсын Засгийн гаХүнд даацын ачааны машинаар тээвэрлэлт хийхээс өөр аргагүй, өндөр тээврийн зардал нүүрсний гадаад худалдаанд хүндрэл учруулж байгаа тул энэхүү төмөр замын төслийг яаравчлах шаардлагатай. Тус төмөр замын төслийг Монголын засгийн газрын 100% хөрөнгө оруулалттай “Монголын төмөр зам”ТӨХК хариуцах болно.

зрын үйл ажиллагааны хөтөлбөрөөс ЖАЙКА-ийн судалгааны баг

7 Нэгдсэн дүгнэлт болон зөвлөмж

Энэхүү бүлэгт, өмнөх бүлгүүдэд дурдагдсан хэлэлцүүлэг дээр тулгуурлан, Монгол улс дунд болон урт хугацаанд эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзэл баримтлалаа тодорхойлохын хамт шийдвэрлэвэл зохих асуудлуудыг тоймлохын зэрэгцээ, энэхүү судалгааны гол үзэл баримтлал болох "стратеги хөгжлийн корридорын зарчим" бодитой эсэх талаар дүгнэн, нийт улсын хэмжээний орон зайн хөгжлийн үндсэн чиг хандлагыг дэвшүүлнэ. Эцэст нь, тус судалгаагаар сайтар авч хэлэлцсэн аж үйлдвэр, зам тээврийн салбарын (ХАА, бүтээгдэхүүн үйлдвэрлэл, аялал жуулчлал, уул уурхайн үйлдвэрлэл, зам тээвэр, хотын дэд бүтэц) саналуудыг нэгтгэн, бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал талаас хэрэгжүүлэх шаардлагатай хөтөлбөр (зөвлөмж)-ийг дэвшүүлэх болно. 2014 оноос хойших Монгол улсын хүндхэн макро эдийн засгийн нөхцөл байдал ч УИХ-аар батлагдсан "Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030" хэрэгжүүлэхийн тулд шинэ Засгийн газраас авч хэрэгжүүлэх хөгжлийн төлөвлөлтөд анхаарах асуудлуудыг бодолцож үзсэн. Энэхүү бүлэгт дараах 3 асуудлыг тавьж байна.

7.1 Монгол улсын бүсчилсэн цогц хөгжлийн төлөвлөлтийн асуудлын тойм

1) Монгол улсын тогтвортой хөгжлийн хэтийн төлвийг үнэлэх SWOT дүн шинжилгээ

Өмнөх бүлгүүдэд Монгол улсын нийгэм, эдийн засгийн өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийн, аж үйлдвэрийн салбар тус бүрчлэн тулгарч буй асуудлуудыг тодорхойлсон хэдий ч, Монгол улсын хувьд ямар "давуу тал (S)", "сул тал (W)" байгаа, түүнчлэн санал дэвшүүлж буй хөгжлийн корридорын хувьд ямар "хөгжлийн боломж (O)" болон "хязгаарлагдах нөхцөл, аюул (T) байгаа эсэх талаар цэгцэлсэн. Хүснэгт 7.1.1 дүн шинжилгээний үр дүнг харуулав.

**Хүснэгт 7.1.1 Хөгжлийн корридорд түшиглэсэн Монгол улсын хөгжлийн
SWOT дүн шинжилгээ**

<p><u>Strengths (Давуу тал)</u></p> <ul style="list-style-type: none"> • Өргөн уудам нутаг дэвсгэр • Хүн амын аажим өсөлт • Эдийн засгийн хурдацтай хөгжлийн туршлага болон ядуурлын бууралт • Нийслэл Улаанбаатарт дунд хэмжээний хотын үйл ажиллагаа (функц)-ны төвлөрөл • Богино хугацаанд доройтож буй ч, үйлчилгээний салбар голлосон хөрөнгө оруулалтын боломж өсөж буй • БНХАУ, ОХУ гэсэн 2 том зах зээлийн дунд оршдог • Бүх нутгаар тархсан байгалийн болон уламжлалаа хадгалсан ХАА баялаг, нөөц • Эдийн засгийг залах баялаг ашигт малтмалын нөөц • Байгаль орчин, уламжлалт соёлын өв бүхий аялал жуулчлалын нөөц баялаг • Өндөр боловсролтой хүний нөөц 	<p><u>Weaknesses (Сул тал)</u></p> <ul style="list-style-type: none"> • Нийслэл Улаанбаатар хотын хүн ам, эдийн засгийн хэт төвлөрлөөс үүдсэн, хөдөө орон нутгийн доройтол, баян хоосны ялгаа • Улаанбаатар хотод үүссэн хэт төвлөрөл, автозамын түгжрэл зэрэг эдийн засагт халтай гадаад хүчин зүйлийн өсөлт • Орон нутаг хоорондын хөгжлийн ялгаа • Орон нутгийг холбосон төв зам болон орон нутгийн зам харилцаа хангалттай бус • Далайд гарцгүй хязгаарлагдсан нөхцөл, бараа нийлүүлэлтийн систем хангалтгүй байдлаас үүсэх бараа бүтээгдэхүүний үнийн өсөлт • Тээвэр, логистикийн олон улсын өрсөлдөөний уналт • Олон улсын зах зээлийн ханшнаас хамаарсан ашигт малтмалаас хараат эдийн засаг • Хятадаас хараат гадаад худалдаа • Сүүлийн үеийн макро эдийн засгийн нөхцөл байдал болон төсвийн алдагдал
<p><u>Opportunities (Боломж)</u></p> <ul style="list-style-type: none"> • Европ, Төв Азийн орнуудтай хамтын ажиллагаа өргөжүүлэн, тээвэрлэлтийн харилцаа холбоог бэхжүүлснээр шинэ зах зээлтэй болох • Япон улстай эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийн хэрэгжилтийн хүрээнд технологи нутагшуулах ажлыг эрчимжүүлэх • Авто замын бүтээн байгуулалтыг нэмэгдүүлэн орон нутгийн харилцаа холбоог дээшлүүлэх • ХАА, аялал жуулчлал зэрэг аж үйлдвэрийг төрөлжүүлэх замаар хөдөө орон нутгийн эдийн засгийг эрчимжүүлэх, тогтворжуулах • Орон нутгийн тулгуур төвүүдэд аж үйлдвэр хөгжүүлснээр ажлын байр нэмэгдүүлэх, нийгмийн үйлчилгээг сайжруулах зэргээр хот хөдөөгийн ялгааг арилгах 	<p><u>Threats (Аюул)</u></p> <ul style="list-style-type: none"> • Дэлхийн дулаарлаас үүдсэн цаг уурын өөрчлөлт (ган ихсэх), бэлчээрийн доройтол зэрэг байгаль цаг уурын эмзэг байдал • Хятадын эдийн засгаас хэт хараат байдал • Ашигт малтмалын бодлого буюу макро эдийн засгийн менежментийн алдаанаас үүдэх улсын эрсдэл ихэссэн • Тогтвортой хөгжлийг дэмжих эдийн засгийн дэд бүтцийг бэхжүүлэх эдийн засгийн шийдвэрийн хөрөнгө оруулалтын хоцрогдол • Хүн болон бараа эргэлт нэмэгдэхтэй уялдан халдварт өвчний эрсдэл нэмэгдэх (их хэмжээний малын хорогдол гм)

Эх сурвалж : ЖАЙКА-ийн судалгааны баг

Монгол улсад тогтвортой, жигд нийт улсыг хамарсан хөгжлийг хэрэгжүүлэхэд, олон давуу болон сул тал, боломж болон аюул оршиж байгаа. Түүнчлэн дээрх SWOT дүн шинжилгээнээс үр ашигтай хөгжлийн корридорийг хөгжүүл хэд хэдэн нөхцлийг анхаарах хэрэгтэй.


Юун түрүүнд, Давуу тал (Strengths) тай холбогдох 4 зүйл анхааруулмаар байна.

- Олон улсын зах зээлийн үнэ ханшийн нөлөөнд ордог хэдий ч, олон төрлийн ашигт малтмалыг ашигласнаар бат бэх суурьтай аж үйлдвэрлэлийг дунд болон урт хугацаанд хөгжүүлэх боломжийг агуулж байгаа. Эхний шатанд түүхий эдийн БНХАУ-руу хийх экспорт, дотоодын хэрэглээг хангах хэдий ч, 2 дахь шатанд БНХАУ-ын нэмүү өртгийн гинжин хэлхээтэй холбогдох боловсруулах үйлдвэрлэл бий болгох асуудал найдлага тавигдаж байна. 3 дахь шатанд БНХАУ-аас бусад улсын хөрөнгө, технологийн харилцаанд үндэслэсэн нэмүү өртгийн шингэсэн үйлдвэрлэл, үйлчилгээг бэхжүүлэх хэрэгтэй. Ингэснээр олон улсын зах зээлтэй холбогдох функцыг бэхжүүлэх, нэгдсэн хөгжлийн корридор байгуулах замаар эдгээр үйлдвэрлэлийг өндөр түвшинд хүргэх процессыг үр дүнтэй болгох боломжтой.
- Улаанбаатар хотын бүсийн эдийн засгийн төвлөрөл нь хот хөдөөгийн ялгааг үүсгэх хэдий ч эдийн засгийн үйл ажиллагаа буюу банк санхүү, мэдээллийн салбарын өндөр зэрэглэлийн үйлчилгээний функцгүй бол өрсөлдөгч Азийн бусад том хотуудтай хөрөнгө оруулалт, дэвшилтэт технологи татах тал дээр өрсөлдөж чадахгүй. Олон улсад өрсөлдөх чадварыг бэхжүүлэхэд өндөр түвшний хотын функцын төвлөрөл үүсгэх нь зайлшгүй байх ёстой нөхцөл юм.
- Уул уурхай болон бусад холбогдох уул уурхайн үйлдвэрлэл нь Монгол улсын эдийн засгийн гол хөдөлгүүр гэдэг нь тодорхой боловч, жигд, тогтвортой эдийн засгийг дэмжих өөр нэгэн хөдөлгүүр нь ХАА буюу МАА салбар юм. Бүх нутаг дэвсгэрээр тархсан байгаль орчин, уламжлалаа дагасан мал аж ахуй болон баялаг мал аж ахуйн нөөцийг өргөн хүрээнд ашиглах замаар Монгол улсын өсөлтийн хүч чадварыг хадгалах шаардлагатай. Үүний тулд, орчин үеийн зах зээлийг бий болгох, хүнсний нэмүү өртгийн гинжин хэлхээг бүрдүүлэх зэргийг хөгжлийн корридор хөгжүүлснээр амжилттай хөгжүүлэх боломжтой.
- Монголын ард түмний бичиг үсгийн боловсрол маш өндөр, түүнчлэн өндөр боловсролтой, шилдэг хүний нөөц ихтэй нь томоохон хөрөнгө баялаг бөгөөд орчин үеийн аж үйлдвэрлэл хөгжүүлэх том нөөц бололцоо билээ.

Дараа нь, Сул тал (Weakness) тай холбогдох 2 асуудлыг тавья.

- Хамгийн хурцадмал гэж хэлж болох сул тал бол ОХУ, БНХАУ-ын дунд байрлах, далайд гарцгүй гэсэн газар зүйн, геополитикийн нөхцөл юм. Иймд Монгол улсын Засгийн газар гуравдагч хөршийн бодлого баримтлан, БНСУ болон Японы алс дорнод Азийн зах зээлд ойртох найдлага тавьж байгаа хэдий ч экспорт, импорт хийхэд тээвэрлэлтийн зардал өндөр тул гуравдагч орон дахь Монголын бараа бүтээгдэхүүний өрсөлдөх чадвар сул байна. Ялангуяа, тээврийн ачаа даах чадвар багатай нүүрс болон ашигт малтмалын тээвэрлэлт хүндрэлтэй асуудал болоод байна.

- Түүнчлэн, ”бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн салбарын цалингийн түвшинг Азийн томоохон хотуудтай хийсэн харьцуулалт”-ын тухайд, 2014 онд ЖЕТРО явуулсан гадаадад салбартай Япон компаниудын цалингийн судалгааны дүнгээс томоохон 10 хотуудтай хийсэн харьцуулалтыг харахад (зураг 7.1.1) Улаанбаатар хотын ердийн техникийн ажилтны цалин Шанхай, Бээжин хотоос бага зэрэг доогуур боловч, АСЕАН-ийн орнууд буюу Өмнөд Азийн хотуудынхаас өндөр түвшинд байна. Мөн дунд зэргийн инженерийн цалинг харьцуулахад, Шанхай, Бээжин, Нью Дели, Бангкок хотуудаас доогуур хэдий ч бусад хотуудаас харьцангуй өндөр түвшинд байна. Цаашид, аж үйлдвэрийг өндөр технологитой болгох, нэмүү өртөг шингээхэд гадаадын хөрөнгө оруулалтыг өсгөх зайлшгүй хэрэгтэй тул, цалингийн түвшин доогуур өрсөлдөгч АСЕАН-ийн томхон хотуудтай өрсөлдөхийн тулд илүү давуу талаа нэмэгдүүлэх хэрэгтэй.



Эх сурвалж : Ази, Номхон далайн орнуудын Япон компаниудын цалингийн судалгаа (2014 он, ЖЕТРО)

Зураг 7.1.1 Азийн томоохон хотуудын цалингийн харьцуулалт

Боломж (Opportunities)-ийн тухайд, өмнө дурдсан давуу талыг ашиглан, сул талыг даван туулах асуудлыг үндэс суурь болгож байгаа бөгөөд дараах асуудлыг анхаарах хэрэгтэй.

- Хөгжлийн корридор бий болгох нь тээврийн дэд бүтцийг бэхжүүлэх асуудалтай нэг цөм нөхцөл болно. Төмөр замаар БНХАУ-ыг дамжин алс дорнод Азийн (БНСУ, Тайвань, Япон зэрэг) шинэ зах зээлд гарах боломж нээгдэнэ. Түүнчлэн, баруун бүсийн нутгаас Азийн хурдны 4 дүгээр замаар дамжин холбогдох Төв Азийн орнуудын зах зээл зэрэг Монгол улсын зах зээлийн эдийн засаг шинэ

түнштэй холбогдох боломж нээгдэнэ. ОХУ, БНХАУ, Монгол 3 улс хооронд 2016 оны 6 сарын 23-нд Эдийн засгийн корридор байгуулах хөтөлбөр чиглэлээр хамтран ажиллахаар тохиролцсон ба цаашид транзит ачаа тээврийн төмөр замын тээвэрлэлттэй холбогдох хэлэлцээрээр “Транзит Монгол” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхийн тулд ашигтай байр суурь олж авах хэрэгтэй.

- Газар тариалан, мал аж ахуй, хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн боловсруулах болон аялал жуулчлалын салбар хөгжүүлэх асар их өсөлтийн боломж байгаа нь “давуу тал” гэдгээрээ танигдаж байгаа хэдий ч, үүнийг тодотгон ашиглахын тулд, хувийн хэвшил тэргүүлсэн хөрөнгө оруулалт, технологи, мэдлэг буюу хүний харилцааг улам бүр бататгах шаардлагатай. Монгол улсад зах зээлийн үнэлгээ, арилжаагаар шилдэг компани шалгаруулах “Топ 20 индекс” байдаг шиг, хөрөнгө чадалтай шилдэг аж ахуйн нэгжүүд олширч, аж үйлдвэрийг төрөлжүүлэх, өндөр түвшинд хүргэхээр дотоод, гадаадын хөрөнгө оруулалт ирээдүйд өсөн нэмэгдэх болов уу. Японтой хийсэн Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр 2016 онд 6 сард албан ёсоор батлагдсан тул Японы хувийн хэвшил, хөрөнгө оруулагчид идэвхитэй ажиллаж эхэлнэ гэдэгт найдлага тавигдаж байна.

Эцэст нь Аюул (Threats)-ын тухайд байгалийн болон хүний хүчин зүйл гэсэн 2 тал дээр анхаарал хандуулж байна.

- Өмнө дурдсанчлан, хөдөө аж ахуйн салбарын нөөц боломж нь “Давуу тал” байгаа ч, ирээдүйн цаг уурын өөрчлөлтийн нөлөөгөөр бэлчээр, тариалангийн талбайн доройтол, усны нөөц ширгэх зэрэг эрсдэл үүсэх таамаглалтай байгааг илтгэх судалгааны дүн байгаа. Хөдөө аж ахуйг хөгжүүлэхийн зэрэгцээ байгаль орчны нөөц баялагийг хэрхэн хамгаалах, усны нөөцийн сэргээлтийг хэрхэн үр дүнтэй явуулах зэрэгт мэдлэг чадвар шаардагдана. Түүнчлэн, уламжлалт нүүдлийн мал аж ахуй нь “Эрүүл мал аж ахуй”-д саад учруулах халдварт өвчний эрсдэл дагуулдаг бөгөөд эдгээрт арга хэмжээ авах хэрэгтэй. “Халдварт өвчингүй эрүүл мал аж ахуй” бий болгох нь олон улсын зах зээлд хүрэх хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрлэл хөгжүүлэх үндсэн нөхцөл билээ.
- Монгол улсын эдийн засаг нь ашигт малтмалын нөөцөд тулгуурлан БНХАУ-ын эдийн засгаас хамааралтай байдаг тул, Засгийн газраас тэнцвэргүй макро эдийн засаг, төсвийн бодлого, ил тод бус төслийн менежмент явуулснаар 2014 оноос хойш бодитоор уналтанд орсон шиг, улс төр, засаглалын хүнд асуудлыг үүрэх болно. Энэхүү аюулыг давж гарахад ухаалаг төрийн удирдлага туйлын хэрэгцээтэй байна.

2) Монгол улсын бүсчилсэн хөгжлийн цогц төлөвлөлтийн асуудал, шийдвэрлэх үндсэн чиг хандлага

Өмнөх бүлгүүдийг нийтэд нь дүгнэн, хөгжлийн асуудал болон бодлого, шийдвэрлэх арга хэмжээг дараах хүснэгт 7.1.1 нэгтгэн харуулав. Шийдвэрлэх арга хэмжээ нь тулгуур төвийн хөгжил болон хөгжлийн корридорын тэнхлэг дагуух дэд бүтцийн хөгжлийг авч үзлээ.

Өнөөгийн байдал, асуудал	Бодлогын чиг хандлага	Шийдвэрлэх арга хэмжээ	
		Төв	Тэнхлэг
<p>Монгол улсын газарзүйн байршил</p> <ul style="list-style-type: none"> 2 том гүрний дунд оршдог Ази, баруун Европын орнуудтай харилцааг бэхжүүлэх 	<p>Глобал харилцааг бэхжүүлэх</p> <ul style="list-style-type: none"> Хилийн гадаад худалдаа, аж үйлдвэрийн хөгжил (FTZ) Агаарын тээвэр, төмөр замын сүлжээг бэхжүүлэх Олон улсад өрсөлдөх чадвар бүхий логистик сүлжээг бий болгох Хөндлөн чиглэлийн (зүүнээс баруун) хосолсон логистик систем хөгжүүлэх 	<ul style="list-style-type: none"> УБ хотын үйл ажиллагааг (функци) бэхжүүлэх Чөлөөт эдийн засгийн бүс, аж үйлдвэрийн төвийг бэхжүүлэх Олон улсын онгоцны буудал, хил орчмын олон улсын логистикийн төв байгуулах 	<ul style="list-style-type: none"> Босоо тэнхлэгийг бэхжүүлэх Хөндлөн тэнхлэгийг бэхжүүлэх
<p>Эдийн засгийн асуудал</p> <ul style="list-style-type: none"> Уул уурхай төвтэй эдийн засгийг төрөлжүүлэх (ХАА, боловсруулах үйлдвэр, аялал жуулчлал зэрэг) Тогтвортой эдийн засгийн өсөлтийн бодлого Ажлын байр нэмэгдүүлэх Шинэ зах зээлд ойртох, нээх ажлыг идэвхжүүлэх 	<p>Гадаадын хөрөнгө оруулалтын орчинг бүрдүүлэх</p> <ul style="list-style-type: none"> Гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих болон стратегийн салбарын хөрөнгө оруулалтыг дэмжих тогтолцоог бэхжүүлэх Гадаадын компанийн бизнесийн орчинг сайжруулах Гадаадын мэргэжилтэнүүдийн амьдрах орчинг бэхжүүлэх 	<ul style="list-style-type: none"> Уул уурхайн хөгжил Аж үйлдвэрийн паркийн хөгжил ХАА үйлдвэрлэл, технологийн паркийн хөгжил УБ хотын хүрээлэн буй орчинг сайжруулах 	<ul style="list-style-type: none"> Төмөр замын бүтээн байгуулалт Автозам болон тээвэрлэлтийн нэгдсэн систем бүрдүүлэх Агаарын замыг бэхжүүлэх
<p>Аж үйлдвэрийн хөгжлийн асуудал</p> <ul style="list-style-type: none"> Аж үйлдвэрийг төрөлжүүлэх, стратегийн аж үйлдвэрт чиглэсэн хөрөнгө оруулалт Дотоодын зах зээлийг хөгжүүлэх, бэхжүүлэх ХАА бүтээгдэхүүний чанар стандарт, тогтвортой нийлүүлэлт Хүнсний бүтээгдэхүүний холын зайн тээвэрлэлтийн систем МАА судалгаа, шинжилгээг сайжруулах Цогц аялал жуулчлалын хөгжил Импортыг орлох, нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэлийн тогтолцоо бүрдүүлэх төрийн дэмжлэг 	<p>Аж үйлдвэрийг төрөлжүүлэх</p> <ul style="list-style-type: none"> Уул уурхай (өндөр нэмүү өртөг шингээх, эрчим хүчний хосолсон үйлдвэрлэл) Аж үйлдвэр (Импортыг орлох бүтээгдэхүүн үйлдвэрлэл, баялагийг бүрэн ашиглах) ХАА (ноос, ноолуур, мах, сүү зэрэг) Аялал жуулчлал (Тусгай хамгаалалттай газрын менежмент, зам харилцаа, жуулчны бааз) 	<ul style="list-style-type: none"> Уул уурхайн орд орчмын төмөрлөгийн үйлдвэр, парк байгуулах УБ хотын ойролцоо аж үйлдвэрийн парк хөгжүүлэх ХАА аж үйлдвэрийн паркийн хөгжил Аялал жуулчлалын бүсийг бэхжүүлэх 	<ul style="list-style-type: none"> Орон нутгийн авто замын бүтээн байгуулалт Төмөр зам, автозамын бүтээн байгуулалт
<p>Орон нутгийн ялгаа</p> <ul style="list-style-type: none"> Өсөлтийн менежмент талын ялгаа Хотын өсөлт болон хөдөө орон нутгийн ялгаа Хотын ядуурлыг бууруулах арга хэмжээ Хотын дэд бүтцийг бэхжүүлэх Орон нутгийн нийтийн ахуйн үйлчилгээг сайжруулах Орон сууц, эмчилгээ үйлчилгээ, боловсрол, соёлын ялгаа 	<p>Орон нутгийн хөгжил</p> <ul style="list-style-type: none"> Орон нутгийн баялагийг бүрэн ашиглах Нэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх ХАА 6 шатлалт үйлдвэрлэлийг хөгжүүлэх (нэмүү өртгийн гинжин хэлхээ) Нутгийн үйлдвэрлэлийг хооронд нь уялдуулах, хослуулах 	<ul style="list-style-type: none"> Аж үйлдвэрийн паркийг холимог хөгжүүлэх Бүс нутаг, судалгаа шинжилгээний үйл ажиллагааг бэхжүүлэх ХАА биржийг бэхжүүлэх Тулгуур төв хотуудыг хөгжүүлэх 	<ul style="list-style-type: none"> Улсын замтай холбогдох орон нутгийн замын бүтээн байгуулалт
	<p>Тулгуур төвүүдийн хөгжил</p> <ul style="list-style-type: none"> Тулгуур төвүүдийн хотын үйл ажиллагааг бэхжүүлэх Ажлын байр бий болгох арга хэмжээ 	<ul style="list-style-type: none"> Орон сууц нийлүүлэлт Боловсрол, эрүүл мэнд зэрэг нийгмийн дэд бүтэц Хотын хүрээлэн буй орчинг бэхжүүлэх 	

Эх сурвалж : ЖАЙКА-ийн судалгааны баг

Зураг 7.1.2 Хөгжлийн асуудал, бодлогын чиг хандлага, шийдвэрлэх арга хэмжээ

2 дугаар бүлэг

Хавсралт материал

Хавсралт материал 2.2.1: Аймаг тус бүрийн хүн ам зүйн үзүүлэлт

Аймаг	Суурин хүн амын тоо (мянган хүн)	Суурин хүн амын тоо (мянган хүн)	Хүн амын өсөлт ба бууралтын түвшин 2010--2014	Төрөлт	Нас баралт	Байгалийн өсөлт	Гэрлэлт ¹	Салалт ¹	Дундаж наслалт (жилээр)
	2010	2014							
Нийт	2 653.8	2 937.9	2.1%	28	5.6	22.4	5.8	1.3	69.57
Баруун бүс	352.4	376.7	1.3%	28.8	5.5	23.3	12.6	0.7	
Баян-Өлгий	85.4	93.2	1.8%	31.4	5	26.4	17.5	0.8	72.76
Говь-Алтай	53.2	56.7	1.3%	24.9	5.3	19.6	7.4	0.7	68.84
Завхан	64.8	69.6	1.4%	27.1	5.9	21.2	7.9	0.7	69.19
Увс	72.8	75.7	0.8%	30.3	6	24.3	14	0.6	68.28
Ховд	76.2	81.5	1.4%	28.6	5.5	23.1	14.1	0.7	71.71
Хангайн бүс	515.2	567.4	1.9%	28.7	5.9	22.8	7.6	1.5	
Архангай	84.1	92.9	2.0%	29	5	24	7.5	0.7	70.54
Баян-Хонгор	75.8	82.9	1.8%	29.4	5.9	23.5	7.8	0.8	68.89
Булган	53.1	60.3	2.6%	25.5	5.5	20	6.6	1.3	72.3
Орхон	87.4	92.7	1.2%	28.8	6	22.8	8.2	3.5	70.83
Өвөрхангай	100.5	112.6	2.3%	28.8	5.6	23.2	5.5	0.9	69.32
Хөвсгөл	114.3	126.0	2.0%	29.4	6.9	22.5	9.6	1.4	65.79
Төвийн бүс	442.0	475.9	1.5%	27.3	5.1	22.2	7.5	1.7	
Говь сүмбэр	13.2	15.9	3.8%	32.2	5.4	26.8	6.1	2	72.86
Дархан-уул	90.9	97.3	1.4%	30.1	5.8	24.3	8.2	2.6	68.51
Дорноговь	58.2	63.5	1.8%	27	5.7	21.3	8.8	2.1	70.17
Дундговь	38.4	44.2	2.9%	27	5.7	21.3	6.1	1.3	73.22
Өмнөговь	61.1	59.7	-0.5%	25.6	5	20.6	6.4	1.3	71.44
Сэлэнгэ	96.1	105.3	1.8%	26.1	4.6	21.5	7.9	1.5	71.87
Төв	84.1	90.0	1.4%	26.5	4.4	22.1	7.1	1	72.06
Зүүн бүс	185.5	203.4	1.9%	28.6	5.9	22.7	9.3	1.3	
Дорнод	68.9	74.9	1.7%	29.4	6.1	23.3	9.2	1.6	68.41
Сүхбаатар	51.2	57.4	2.3%	28.3	6.4	21.9	11.4	1.2	71.78
Хэнтий	65.4	71.1	1.7%	28	5.3	22.7	7.7	1.1	70.94
Улаанбаатар	1 158.7	1 314.5	2.6%	27.5	5.6	21.9	8.9	2.6	71.24

Эх сурвалж : Статистикийн эмхтгэл 2014 он

Хавсралт материал 2.2.2: Аймаг тус бүрийн өрхийн тоо

Нэгж: мян.өрх / thous.household

Аймаг болон хот	2010	2014	2014	Change 2014/2010	2010		2014			Change bwt 2010-2014 (%)	
			Per. per HH		Хот	Хөдөө, орон нутаг	Хот	Хөдөө, орон нутаг	Хот (%)	Хот	Хөдөө, орон нутаг
Нийт	742.3	823.4	3.6	2.1%	463.7	278.6	537.7	285.7	65%	3.0%	0.5%
Баруун бүс	96.5	100.5	3.7	0.8%	29.6	66.9	32.8	67.7	33%	2.1%	0.2%
Баян-Өлгий	20.7	22.4	4.2	1.6%	7.0	13.7	7.9	14.5	35%	2.4%	1.1%
Говь-Алтай	15.7	15.8	3.6	0.1%	5.0	10.7	5.2	10.6	33%	0.8%	-0.2%
Завхан	20.1	20.5	3.4	0.4%	4.3	15.8	4.8	15.7	23%	2.2%	-0.1%
Увс	19.7	20.7	3.7	1.0%	6.2	13.5	7.5	13.2	36%	3.9%	-0.4%
Ховд	20.3	21.1	3.9	0.8%	7.1	13.2	7.4	13.7	35%	0.8%	0.7%
Хангайн бүс	158.6	165.5	3.4	0.9%	58.9	99.7	65.1	100.4	39%	2.0%	0.1%
Архангай	26.5	26.8	3.5	0.2%	5.5	21.0	5.6	21.2	21%	0.4%	0.2%
Баянхонгор	23.2	24.5	3.4	1.1%	7.8	15.4	8.8	15.7	36%	2.4%	0.4%
Булган	16.8	18.2	3.3	1.6%	4.0	12.8	4.1	14.1	23%	0.5%	2.0%
Орхон	24.4	26.0	3.6	1.3%	23.0	1.4	24.7	1.3	95%	1.4%	-1.5%
Өвөрхангай	32.6	33.0	3.4	0.2%	7.3	25.3	9.5	23.5	29%	5.4%	-1.5%
Хөвсгөл	35.1	37.0	3.4	1.1%	11.3	23.8	12.4	24.6	34%	1.9%	0.7%
Төвийн бүс	134.6	142.9	3.3	1.2%	57.9	76.7	62.7	80.2	44%	1.6%	0.9%
Говьсүмбэр	4.3	4.7	3.4	1.8%	2.6	1.7	2.8	1.9	60%	1.5%	2.2%
Дархан уул	28.3	28.0	3.5	-0.2%	23.4	4.9	23.3	4.7	83%	-0.1%	-0.8%
Дорноговь	17.8	19.2	3.3	1.5%	10.7	7.1	11.5	7.7	60%	1.5%	1.6%
Дундговь	13.1	13.5	3.3	0.6%	2.9	10.2	3.4	10.1	25%	3.2%	-0.2%
Өмнөговь	16.1	19.4	3.1	3.8%	5.6	10.5	7.2	12.2	37%	5.2%	3.0%
Сэлэнгэ	28.4	30.1	3.5	1.2%	8.2	20.2	9.8	20.3	33%	3.6%	0.1%
Төв	26.6	28.0	3.2	1.0%	4.5	22.1	4.7	23.3	17%	0.9%	1.1%
Зүүн бүс	58.2	61.7	3.3	1.2%	22.9	35.3	24.3	37.4	39%	1.2%	1.2%
Дорнод	21.6	22.4	3.3	0.7%	11.7	9.9	11.9	10.5	53%	0.3%	1.2%
Сүхбаатар	15.5	16.7	3.4	1.5%	4.3	11.2	4.9	11.8	29%	2.6%	1.0%
Хэнтий	21.1	22.6	3.1	1.4%	6.9	14.2	7.5	15.1	33%	1.7%	1.2%
Улаанбаатар	294.4	352.8	3.7	3.7%	294.4	-	352.8	-	100%	3.7%	-

Эх сурвалж : Статистикийн эмхтгэл 2014 он, 2013 он

Хавсралт материал 2.3.1 Аймаг тус бүрийн нийгмийн хөгжлийн үзүүлэлт

АЙМАГ БОЛОН ХОТ	Хүний хөгжлийн индекс	Жендерийн тэгш бус байдлын индекс	Сургуульд суралцагчдын индекс (GER) академик боловсрол 2014/2015		1000 төрөлтөнд ногдох нялхсын эндэгдэл			1000 төрөлтөнд ногдох 5 -аас доош насны хүүхдийн эндэгдэл			Дундаж наслалт (Жил)			Ажилгүйдлийн түвшин (%)			10000 хүнд ногдох гэмт хэргийн гаралт (18 наснаас дээш)		
			Бага анги /1-5-р анги/ анги/	Дунд анги /6-9-р анги/ анги/	2014	Changes 2014-2010	2010	2014	Changes 2014-2010	2010	2014	Changes 2010-2014	2010	2014	Changes 2010-2014	2010	2014	Changes 2014/2010	
																			2014
Нийт	0.748	0.294	103.6	100.3	20.2	15.1	-5.1	25.6	18.2	-7.5	9.9	7.9	-2.0	109	140	128%			
Баруун бүс	0.680	0.250	104.6	102.5	26.9	20.6	-6.4	35.2	23.9	-11.3	10.1	13.3	3.2	67	65	98%			
<i>Баян-Өлгий</i>	0.675	0.722	106.9	107.3	24.9	22.4	-2.4	36.2	25.2	-11.0	2.8	22.5	19.7	71	52	73%			
<i>Говь-Алтай</i>	0.675	0.813	102.6	98.7	22.3	22.6	0.3	28.9	24.8	-4.1	9.0	10.2	1.2	50	54	109%			
<i>Завхан</i>	0.685	0.261	104.3	100.2	27.7	20.9	-6.8	34.0	23.7	-10.4	14.8	4.0	-10.8	62	69	110%			
<i>Увс</i>	0.666	0.798	103.4	100.5	33.7	17.6	-16.1	43.5	21.6	-21.9	15.0	14.8	-0.2	88	80	91%			
<i>Ховд</i>	0.699	0.789	104.4	102.3	24.9	19.6	-5.3	30.8	24.4	-6.4	9.2	11.7	2.5	59	71	121%			
Хангайн бүс	0.774	0.795	103.7	99.4	25.3	13.4	-11.9	30.9	16.5	-14.4	11.9	6.8	-5.1	69	82	118%			
<i>Архангай</i>	0.674	0.794	99.4	93.0	25.1	11.2	-13.9	30.0	15.4	-14.6	7.0	3.9	-3.1	80	77	96%			
<i>Баянхонгор</i>	0.666	0.821	103.8	96.8	28.3	13.9	-14.4	35.1	18.1	-17.0	3.6	5.6	2.0	85	82	97%			
<i>Булган</i>	0.684	0.827	92.5	87.6	15.8	14.3	-1.5	19.0	16.4	-2.6	15.2	9.7	-5.5	62	87	140%			
<i>Орхон</i>	0.793	0.804	118.5	120.8	16.2	15.1	-1.1	20.0	16.9	-3.0	25.9	12.3	-13.6	84	90	107%			
<i>Өвөрхангай</i>	0.652	0.817	100.6	95.9	29.9	11.3	-18.6	34.9	14.3	-20.7	4.9	3.5	-1.4	61	67	110%			
<i>Хөвсгөл</i>	0.649	0.776	104.8	101.7	30.2	14.8	-15.5	38.6	17.8	-20.8	17.1	7.9	-9.2	51	88	171%			
Төвийн бүс	0.716	0.834	102.3	97.5	13.5	9.5	-4.0	17.4	11.9	-5.5	9.3	9.2	-0.1	107	127	119%			
<i>Говьсүмбэр</i>	0.742	0.346	106.1	102.3	2.9	6.0	3.2	5.8	6.0	0.3	14.3	5.5	-8.8	128	208	163%			
<i>Дархан-Уул</i>	0.741	0.832	115.5	112.2	9.7	6.7	-3.0	14.1	8.0	-6.1	11.0	9.3	-1.7	96	135	141%			
<i>Дорноговь</i>	0.703	0.834	102.0	97.9	23.8	11.7	-12.1	27.5	17.0	-10.5	15.8	13.6	-2.2	138	128	93%			
<i>Дундговь</i>	0.684	0.836	96.5	89.5	19.5	14.5	-5.0	26.7	17.2	-9.5	10.1	5.2	-4.9	76	89	117%			
<i>Өмнөговь</i>	0.730	0.827	104.3	100.7	22.4	17.9	-4.6	26.7	23.4	-3.3	15.4	11.3	-4.1	94	111	118%			
<i>Сэлэнгэ</i>	0.708	0.834	98.7	94.8	6.8	4.8	-2.0	10.6	6.6	-4.0	2.1	10.2	8.1	118	106	90%			
<i>Төв</i>	0.689	0.825	93.7	87.1	12.0	9.4	-2.6	14.0	9.9	-4.1	6.0	6.2	0.2	106	159	150%			
Зүүн бүс	0.704	0.833	103.3	99.2	19.3	12.5	-6.8	24.6	15.7	-8.8	10.5	13.1	2.6	106	109	103%			
<i>Дорнод</i>	0.723	0.842	105.3	103.5	20.5	8.8	-11.7	24.4	12.1	-12.3	12.3	10.8	-1.5	105	112	106%			
<i>Сүхбаатар</i>	0.697	0.821	100.8	97.0	20.5	17.3	-3.3	24.6	21.1	-3.5	13.8	10.1	-3.7	53	86	163%			
<i>Хэнтий</i>	0.687	0.832	103.1	97.3	17.1	12.9	-4.2	24.7	15.5	-9.3	4.2	17.7	13.5	150	126	84%			
Улаанбаатар	0.818	0.253	103.8	101.3	18.2	16.6	-1.6	23.3	19.8	-3.5	8.7	5.1	-3.6	141	194	137%			

Хавсралт материал 2.6.1: Бэлчээрийн мал аж ахуйтай холбоотой үндсэн мэдээлэл

Дараах судалгааны мэдээлэлд голлох болон нэмэлт мэдээллүүдийг онцлон авч танилцуулах болно.

1) Нүүдлийн мал аж ахуйн талаарх тойм судалгаа

- **Бэлчээрийн мал аж ахуйг өсгөн үржүүлэхэд чиглэсэн ерөнхий нөхцөл, байдал** : Эрт дээр үеэс мал бол нүүдэлчдийн өмч, хөрөнгө бөгөөд амжиргааных нь гол үндэс болж ирсэн. Өнөөг хүртэл өргөн уудам нутаг дэвсгэр дээр байгалийн өвс ургамалыг хэрэглэн “нүүдлийн” өөрөөр хэлбэл улирлаас шалтгаалан нүүдэллэж ирсэн уламжлалт системтэй. Энэ нь уг судалгааны явцад тодорхой болсон нэг том зүйл гэж хэлж болно. Энд нүүдлийн мал аж ахуй гэсэн үгэнд зориглон нэмэлт тайлбар хийсэн юм. Монголын мал аж ахуйн системийг илэрхийлэх үед хэрэглэх “Нүүдлийн мал аж ахуй” болон угаас хэрэглэж ирсэн “Нүүдлийн мал аж ахуй” гэсэн үгийн хооронд утгийн ялгаа, зөрүү гарч байна. Ер нь “Нүүдлийн мал аж ахуй”-н талаар олон янзийн тодорхойлолт байдгаас үндсэн үгийн утга санаа бол өвс ургамалыг эрэлхийлэн тогтсон хугацаа, газар нутагт баригдахгүй эсвэл хязгаарлагдахгүй дахин дахин нүүдэллэх процессыг хэлэх боловч (Blench, 2001
- ¹⁾ энэ нь Монголд уламжлагдаж ирсэн улирал болон хугацааны давтамж, хэв загвар байх мал аж ахуйн бүтэц, системтэй нийцэхгүй байна. Минато (2005²⁾ ажигласнаар нүүдлийн мал аж ахуй гэдэг бол илэрхийлэл нь тохиромжтой гэж үзэх ч нөгөө талаасаа Монголын олон судлаачинд “Нүүдлийн мал аж ахуй” гэсэн ухагдахууныг одоог хүртэл ашигласаар ирсэн. Бидний өгүүлж буй судалгаанд ч гэсэн энэ утгаар ашигласан. Одоогийн Монголын нүүдлийн хэлбэрийн мал аж ахуйн загварыг “Нүүдлийн мал аж ахуй” гэж тодорхойлж ирсэн. Ер нь дэлхий дахь мал аж ахуйн үйлдвэрлэлийн системийг ерөнхийдөө 11 төрөлд хуваан ангилдаг. (Sere and Steinfeld, 1995³) Энэ ангилалаар бол Монголын нүүдлийн мал аж ахуйг “Өвс ургамалтай дулаан, халуун бүсийн мал аж ахуйн үйлдвэрлэлийн ангилал” –д хамаарагдаж байна.

Монголын нүүдлийн мал аж ахуй бол 2013 оны статистик⁴ -ийн эмхтгэлд өгүүлсэнчлэн хөдөлмөр эрхлэх боломжтой хүн ам болох нийт 1 сая 198 мянган хүний 23.8 хувь нь нүүдлийн мал аж ахуй эрхэлдэг гэсэн тооцоо байна. Тэдний олонх нь малын тоо толгойг өсгөх, сүргийн бүтэц зохион байгуулалтыг сайжруулах болон үндсэн ажил нь байгалийн өвс ургамалд тулгуурлан малаа хариулж, улирлаас хамааран ямар нэг төлөвлөлтгүйгээр нүүдэллэдэг. Монголын уламжлалт мал сүрэг болох адуу, үхэр, хонь, ямаа, тэмээ гэсэн 5 хошуу малыг адгуулсаар ирсэн. Эдгээр мал сүргийнхээ мах, сүү, арьс, ноос болон аргалыг нь түлшинд хэрэглэхээс гадна адуу болон тэмээг голчлон уналага ачлагад хэрэглэсээр ирсэн. Японд бол эрчимжсэн буюу суурьшмал мал аж ахуйн үйлдвэрлэлийн тогтолцоотой. Өөрөөр хэлбэл тогтсон нэг газарт худалдаж авсан тэжээл, бордоог малдаа

¹ Blench, R. 2001. “You can’t go home again” Pastoralism in the new millennium. ODI, UK.

² Минато 2005 Монголын нүүдлийн мал аж ахуйн эдийн засгийн талаар

³ Sere and Steinfeld, 1995. World livestock production system: current status, issues, and trends. FAO, Rome.

⁴ Mongolian Statistical Yearbook 2013.

өгч өсгөж үржүүлэх, мах болон сүү зэргийг ашиглах бүтэцээр явагдаж ирсэн нь нүүдлийн мал аж ахуйгаас ялгарах онцлог юм.

- **Зун болон өвлийн ургамал, хөрс, өвсний төрөл:** Японы газар нутгаас ойролцоогоор 4 дахин том Монголын газар нутгийн 80 орчим хувь нь өвс ургасан тал, хээрээс бүрдсэн байдаг. Энэ өвс ургасан тал хээрийг Кёппенгийн цаг уурын бүсчлэлээр хойд хэсэг нь ой хээрийн, өмнө хэсэг нь говийн гэж 2 хуваасан байна. Гэвч хүмүүсийн яриа болон эх сурвалж зэргийг судлахад Монголын газар нутгийн өвс ургамалын онцлогоос нь хамаарч илүү нарийн хувааж үзэж байгаа нь тодорхой болсон. Өөрөөр хэлбэл нийт газар нутгийг ургамалын онцлогоос нь хамаарч 5-6 бүсэд хуваасан байна. Доорх материалд 6 төрөл бүсэд хувааж үзэжээ.

2.6.1.-1: Малын бэлчээрийг ургамалын онцлогоос нь хамаарч хувааж үзсэн байдал, хувь

Ургамалын онцлог	Хувь (%)
• Уулын тундрын	4.5
• Уулын тайгын	3.8
• Ой хээрийн	23.8
• Хээрийн	25.9
• Говь хээрийн	21.5
• Говийн	15.4
• (Бусад)	5.1

Эх сурвалж : Palmer, 1993. National Report: Mongolia, UNDP.

Уг судалгаанаас анхаарал татаж байгаа зүйл бол хойноос өмнө зүгийг чиглэх бүсэд дээр өгүүлсэн ургамалын ихэнх нь хамрагдаж байна. Тиймээс хойд хэсгээр уулын тундар ой хээрийн, төвийн хэсгээр хээрийн, өмнөд хэсгээр говийн зэрэг бүдүүн тоймоор хэсэгчлэн хувааж болно. Хөрсний хувьд ой болон хээрийн бүсэд хүрэн хөрс, говь хээрийн бүсэд хагас говь, цөлийн хөрс зонхилож байна. Мөн айл малын нягтшил ихтэй бүсэд хөрсний шүлтийн хэмжээ ихссэн үзүүлэлтэй байна (Фүжита, 2005⁵) Нөгөө талаас ургамалын шим тэжээлийг мал, бэлчээрт үзүүлэх үйлдвэрлэлийн хэмжээ, ашиг гэсэн өнцгөөс харахад уулархаг тайга болон хээрийн бүсэд өндөр, говийн бүс рүү орход шим тэжээл багасаж ирж байна. Түүнчлэн малын бэлчээрт үзүүлэх үйлдвэрлэлийн ашигт хугацаа нь хэдийгээр бүс нутгийн ялгаанаас хамаардаг хэдий ч үндсэндээ 5-9 сарын хооронд байна. Энэ хугацаанд ургасан өвс нь бүтэн жилийн турш хэрэглэх малын тэжээл болох учир Монголын нүүдлийн мал аж ахуйн нэг гол чухал онцлог гэж хэлж болохоор. Монголын тал хээрт ургах өвс ургамал нь нийт 2,000 давсан төрөл зүйлээс бүрдэг гэж үздэг боловч (Имаока 1988⁶) үнэндээ малын бэлчээрээс олж идэх өвсний төрөл нь ойролцоогоор 200

⁵ Фүжита. 2005. Цаг уур орчны өөрчилт болон хүний үйл ажиллагаа, Монголын нүүдлийн мал аж ахуйн үргэлжлүүлэн ашигласнаар гарах үр нөлөө. Киотогийн их сургууль

⁶ Имаока. 1988. Нэгдэлийн тойрсон байгалийн нөхцөлийн онцгой шинж чанар Монголын судалгаа 11 : 2~30.

орчим төрөл байна гэж үзсэн (Ёокохама 2011⁷). Энэ дотроос хамгийн өргөн тархсан байх нь Роасае болон хонин нүдэн цэцгийн төрөл юм. Роасае нь бол илүү тархсан байна. Уг судалгаа хийхэд энгийн малчинаас эхлээд олон хүмүүстэй уулзаж ярилцсан. Тэд “Монгол мал бол олон төрлийн өвс ургамлыг иддэг учир тэр нь малын тарга тэвээрэгт нөлөөлж байдаг” гэсэн тайлбарыг өгч байв. Мөн “Туршлагатай сайн малчин бол хэн байсан ч малын идэх дуртай соргог, шим тэжээлтэй өвсийг ажиглаж байдаг ба тэр нь хаана ургадагыг ерөнхийдээ мэддэг. Өвөлжилтийн бэлтгэх хийхэд ч томоохон нөлөө үзүүлдэг” гэж өгүүлж байв. Түүнчлэн олон өвс нь эмийн ургамалын төрөлд багтдаг гэж ярьж байсан.

- **Улирал тус бүрээрх нүүдлийн мал аж ахуйн бүтэц, зохион байгуулалт⁸(Малын аргал, хомоолыг ашиглах зэргийг багтаасан):** Энэ судалгаагаар Төв, Орхон, Архангай аймагуудыг сонгож нийт 5 малчны гэрт зочилсон ба түүнээс 4 айлаас нь судалгаа авч чадсан юм. Айлууд тус бүр 100-200 орчим толгой малтай дундаж давхрааны айл өрх бөгөөд (энэ талаар дараа дэлгэрэнгүй өгүүлэх) аль ч айл нь жилд 4 удаа, улирлаас шалтгаалан тогтсон маршрутаар нүүдэл хийдэг ба 1 удаагийн нүүдэллэх орон зай нь ойролцоогоор 12-15 км. Их цас унах, зуд болох зэрэг байгалын гэнэтийн өөрчилт байхгүй бол ерөнхийдөө энэ нүүдлийн маршрут, орон зай бараг өөрчлөгддөггүй. Харин Улаанбаатарыг тойрон орших Төв аймгаас авсан судалгаагаар ойрын жилүүдэд нүүдэллэх маршрут болон буух газарт өөрчилт орж байгаа талаар ярьсан. Учир нь өнөөг хүртэл нүүдэллэж ирсэн газарт тариан талбай болон зуслангийн байшин зэрэг баригдах болсон. Энэ нь малчид бус хот суурингаас өөр хүмүүс ирж ногоо тарих, байшин барих болсонтой холбоотой. Мөн малын ченжүүд маш олон малыг малчдаас худалдан авч өвөл эхлэхээс өмнө мал нядлах хугацаанд тааруулан хэдэн мянган малыг хот руу чиглэн туйварладаг гэсэн мэдээллийг сонссон. Нүүдэллэх тоо давтамж, хэв загвар, хэлбэрийн хувьд өвс ургамлын хэмжээ болон малын тоо толгойноос хамааран өөр өөр байдаг гэсэн нь бодитой санагдсан. Энэ удаагийн судалгаанд хамрагдсан аймгуудын аль аль нь Монгол улсын дотор малын бэлчээрт тааламжтай, өвс ус сайтай аймагууд байсан. Эдгээр аймагт байх айлууд нь ойролцоогоор жилд 4 удаагын нүүдэл хийдэг бол өмнөд хэсгийн говийн бүс зэрэгт 8-15 удаа нүүдэллэх малчид ч байдаг (Bruun, 1996⁹). Нүүдэллээс нүүдэл хоорондын зайны хувьд янз бүр байна. Адил бүс нутаг, аймгийн дотор нүүдэллэхэд ойролцоогоор 50 км-ээс дээш зайгаар нүүх малчид байхад маш богино зайнд нүүдэллэх малчин ч байна (Fernandez-Gimenez, 2006¹⁰). Эцэст нь гэрийн түлшинд хэрэглэх аргалын талаар дурдая гэж болож байна. Энэ удаа зочилсон нийт айл бүр малын баас буюу аргалыг түлш хэлбэрээр ашиглаж байсан. Зураг 2.6.1.1~2 дээр харагдаж байгаачлан хатаасан болон түүж ирсэн аргалаа гэрийн түлшинд хэрэглэж буй байдал

⁷ Ёокохама. 2011. Монголын тал хээрийн өвс, ургамал Токиогийн хөдөө аж ахуйн их сургууль 56: 203-211.

⁸ Малчидын нүүдэлтэй холбоотой газар зүйн онцлогийн талаар уг материалын 6 хэсэгт газар тариалангийн бүс нутгийн эзэмших тогтолцоо, хяналтын талаарх асуудал (Зураг 6.3.3)

⁹ Bruun, O. 1996. The herding household: economy and organization *In* Mongolia in transition. Bruun and Odgaard (eds.), Nordic Institute of Asian Studies, UK.

¹⁰ Fernandez-Gimenez, M. 2006. Land use and land tenure in Mongolia: A brief history and current issues. *USDA forest service proceedings RMRS-P-39*: 30-36.

Зураг 2.6.1. 1~2 : Нүүдэлчдийн орон сууц болох гэрт түлш хэлбэрээр аргалыг

ашиглах



1 : Малын саравчны дээвэр дээр салхинд хатааж буй байдал



2 : Зуухны дэргэд байх түлээний хайрцагт

Зураг : Жайка-ийн судалгааны баг

Зун болон өвлийн бэлчээрийг хянах бүтэц, зохион байгуулалт : Бэлчээрийг хянах асуудал бол бэлчээрийн одоо байгаа байдалтай шууд холбогдоно. Өөрөө хэлбэл энэ тодорхойлолт нь Монголд “хуучин бөгөөд шинээр гарч байгаа асуудал”-ын нэг юм. Малын бэлчээрийг хянах асуудал бол аль социалист нийгмийн төлөвлөсөн төлөвлөгөөт эдийн засгийн үед байсан. Энэ асуудлыг нэгдэл гэж тухайн үед ярьдаг байсан газар тариалан мал аж ахуйн хамтралын газарт харъяалагдан шийдвэрлэдэг байсан. Ихэнх малчид нэгдэлд орж нэгдлийн гишүүн болж зохион байгуулалтайгаар үйл ажиллагааг явуулдаг байв (Батуул 2004¹¹). Тухайлбал өвөлжилтийн бэлтгэл хангах үүднээс тогтсон бэлчээрийг бэлтгэх, өвс хадах зэрэг нь бодит жишээ юм. Өвлийн улирал урт, хатуу ширүүн Монголд ойролцоогоор намрын эхэн сараас эхлэн өвс гандаж эхэлсэн ба зуны хугацаанд малын бэлчээхгүй байх тодорхой газрыг бэлдэн тэрийгээ өвөлдөө ашиглан өвөлжөөгөө болгож ирсэн. Мөн зуны улиралд өтгөн урт ургасан өвсийг хадах, хадсан өвсөө хатаагаад өвөлжөөндөө болон өвс дутмаг газар нутгуудад тараах зэрэг нь нэгдлийн гол үүрэг ажлын нэг байв (Накамура 2013¹²). Гэвч иймэрхүү хэлбэрээр бэлчээрийг бэлдэх, ашиглах хяналтын тогтолцоо одоо бараг үгүй болсон. Хотын зах болон ойролцоох газар нутгуудад гэр хорооллын нягтшил, мөн үүнийг дагаад малын нягтшил ихсэх болсон. Түүнчлэн бүс нутагт бэлчээрийн даац хэтэрсний хор уршгаар бэлчээрийн хомсдол бий болж буй нь маш том асуудал болоод байна. Бэлчээрийн хомсдол, сүйдэл нь уулын налуу болон хөрсний эвдрэлтэй газар, авто замын дагуу, ус цөөрөм, мөн машин тогтмол зорчих газар зэрэгт маш хурдацтай явагдаж байна (Зураг 2.6.1.3~6). Энд нэмэлт тайлбар хийх зүйл бол бэлчээрийн даац хэтэрсэн явдал нь бэлчээрийн хомсдол сүйдлийн шууд шалтгаан нь болж байна гэж хэлж болохгүй. Тогтсон бэлчээрт малыг оруулан хариулах, богино хугацаанд бэлчээрийг солих өөрчлөх зэрэг нь үр дүнтэй бэлчээрийг хянах аргын нэг гэж бодож байна. Ингэснээр бэлчээрийг зөв зохистойгоор

¹¹ Батуул 2004. Монгол улсын газар тариалангийн талаарх товч , тойм : 1990оноос хойш зах зээлийн эдийн засагт шилжиж байх шилжилтийн үеийг голчлон авч үзсэн. Газар тариалангийн менежментийн судалгаа 30: 139-158.

¹² Накамура. 2013. Өвсийг хадах нөөцлөх талаарх Монголын социалист нийгмийн үеийн мал аж ахуйн талаарх судалгаа (5дугаар зүйл) Азийн эдийн засгийн судалгааны хүрээлэн

авч үлдэхэд сайн нөлөө үзүүлнэ гэж хэлж болно (Voisin, 1988¹³). Асуудлын гол нь хүн амын нягтшил ихсэх тусам халцарч үгүй болсон өвсийг дахин ургах хангалттай хугацаа өгч чадахгүй байгаа явдал. Уламжлалт нүүдлийн мал аж ахуй нь байгаль орчинд дээрхтэй адил хохирол учруулдаггүй байсанд оршино.

Ер нь бэлчээрийг үр дүнтэй ашиглах талаарх хууль, дүрэм журам монголд байдаг. Энэ удаагийн судалгаа явуулж байх үед ч гэсэн төр захиргааны ажилтанууд бэлчээрийг үр дүнтэй ашиглах талаар онцгойлон ярьж байв. Уг хууль дүрэмд бэлчээр ашиглахтай холбоотой ямар нэг асуудал үүсэж байгаагүй, үүслээ гэж бодоход тэрийг нь малчидын зүгээс үл биелүүлэх явдал байдаг гэсэн өнгө аястай тайлбарыг хийж байв. Үнэндээ бол хуулийг биелүүлэхгүй байна гэдэг нь бодит үнэнд ойрхон ба түүний цаад шалтгаан нь малчдын зүгээс үл биелүүлэх гэхээсээ илүүтэй угаасаа ийм хууль, дүрэм байдгийг сайн мэдэхгүй түүнчлэн тэдний хооронд ойлголтын зөрүү зэрэг байдагтай холбоотой (Fernandez-Gimenez and Batbuyan, 2004¹⁴).

Зураг 2.6.1.-3~6 : Бэлчээрийн хомсдол, сүйдэл ихсэж буй газар



3 : Бэлчээр сүйдсэн уулын налуу



4 : Хөрсний эвдрэл



5 : Авто замын дагуу



6 : Ачааны машины мөр


Зураг : Жайка-ийн судалгааны баг

- **Малчдын давхрага болон хувь харьцаа** : Малчидын давхрага гэдэг нь малчидын маллах малын тоо толгой. Зураг 2.6.1. бол 2013 оны статистикийн эмхтгэлд тулгуурлан боловсруулсан график бөгөөд малын тоо толгой бүрээр малчидын тархацын хувийг илэрхийлсэн байна. 50 дээш 500 доош толгой малтай малчин нийт 70 дээш хувийг эзэлж байна. Дундаж давхрааны малчин энэ бүсэд орно. Нөгөө талаас мөн 2013 оны

¹³ Voisin, A. 1988. Grass productivity. Island Press, USA.

¹⁴ Fernandez-Gimenez, M. and Batbuyan, B. 2004. Law and Disorder: Local Implementation of Mongolia's Land Law. *Development and change* 35: 141-165.

статистикийн эмхэтгэлд Монголын малын тоо толгой бол хамгийн их өссөн үедээ 45 саяд хүрсэн¹⁵, зураг дээрх малын тоо толгой тархалтаас ч гэсэн тайлж унших боломжтой. 500 дээш толгой малтай малчин нийт 15 хувьд хүрэхгүй байна. Тэдэнд 20 орчим сая мал хамрагдаад байгааг тооцоолж болно. Энэ мэт нэг хэсэг малчидын малын тоо ихсэж байгаа нь бэлчээрийн хомсдолын үүсгэх шалтгаан болж байна. Энэ нь бэлчээрийн сүйдэл, хомсдолд ч холбоотой гэсэн санааг уг судалгаагаар олон хүмүүсээс сонсож байв.



Эх сурвалж: Монгол улсын статистикийн эмхэтгэл, 2013

Зураг 2.6.1: 2013 оны малын тоо толгойд тулгуурлаж гаргасан малчдын хувь, харьцаа

- **Зун болон өвлийн бэлчээрийн нөхцөл байдал:** Энэ талаар бол өмнө дурьдсан “Зун болон өвлийн бэлчээрийг хянах бүтэц, зохион байгуулалт” гэсэн сэдэвтэй ерөнхийдөө ойролцоо агуулгатай ба онцгойлон хэлэх зүйл бол яам, тамгийн газар болон орон нутгийн мал эмнэлгийн газар, малчдаас малыг худалдаж авах ченжүүд зэрэг хүмүүстэй уулзаж ярилцсаны үндсэн дээр гаргасан судалгааны материал юм. Монголд социалист систем задран унаснаас хойш өнөөг хүртэл орон нутаг болон бусад газруудаар бэлчээрийг хайнга, гамгүй ашиглаж байна. Энэ хандлага нь хотын ойролцоох бүсийн бэлчээр ашиглалтаас тод харагдана. Энэ нь явсаар бэлчээрийн хомсдол, сүйдэлтэй холбогддог. Тиймээс бүс нутгийн түвшний шийдвэр гаргалт зайлашгүй шаардлагатай гэж бодож байна. Энэ шийдвэр нь жишээлбэл газрыг хувьчлах, шууд захиргаадалтын хэлбэрээ хязгаарлах гэж хэлэх хуучин арга барилаар тэмцэх үр дүн муутай. Өмнө өгүүлсэнчлэн захиргаадалтаар хязгаарлахын үр дүн муутайн жишээ Өвөрмонгол юм (Fernandez-Gimenez and Batbuyan, 2004¹⁶; Li and Hao, 2011¹⁷). Газрыг хувьчласнаас гарах

¹⁵ “Монголын мэдээ” 526 дугаарт 2015 оны жилийн эхний хагаст малын нийт тоо 70 сая орчимд хүрсэн. Өөрөөр хэлбэл 2013 оны үеийн малын тоо хамгийн их өссөж шинэ дээд амжилт тогтоосон. Энэ богино хугацаанд улам их өссөн үзүүлэлттэй байна.

¹⁶ Fernandez-Gimenez and Batbuyan, 2004. *op.cit.*

сөрөг үр дагавар бол хашаа, хайс татаснаар мал бэлчээрлэх талбай багасаж, хашаанаас гадуурх газар нутагт л мал бэлчих болно. Ингэснээр нийт бэлчээр нь хумигдаж, нийтийн бэлчээр талбай хомсдож, бэлчээрийн төлөө өрсөлдөх хандлагатай болно (Taylor, 2006¹⁸). Ер нь газар өмчлөлт гэж хэлж буй ч гэсэн үнэндээ малчид хашаа хатган эргэн тойрныг эрхшээлдээ оруулж буй зүйл биш юм. Тэдэнд эдийн засгийн ашиг бага, дээр нь хил хязгаар, зааг нь тодорхой бус болж ирэх тул эцсийн дүндээ өөр хүн түүнийг нь ашиглаад дуусдаг, дээр нь бэлчээрийг сүйтгэх хандлагатай болдог (Фүжита.2013¹⁹). Үнэндээ Монголын өргөн уудам нутгийг харахад энэ өргөн уудам нутаг дэвсгэрт тархан сууж амьдарч байгаа малчид тус бүрийн газраа хуваан зааглан авч тэндээ хашаа татах үйлдэл хийнэ гэдэг үнэндээ санаанд буухгүй байна. Тиймээс Оники болон Коногаяа (2004²⁰) нарын өгүүлж байгаачлан бэлчээрийг хамтран эзэмших, ашиглах явц хэрэгжсэнээр малчидын хувьд давуу тал болох арга хэтэрхий хийсвэр. Дараа өгүүлэх судалгааны материалд энэ талаар өөрөөр хэлбэл эдийн засгийн аргатай холбогдох санаа, концепцийг оруулан үзэх болно

- **Зудны улмаас хорогдох малын эндэгдэлийн шалтгааныг судлах (Хүйтэн дулаан, салхи, өвс бэлчээрийн хомсдол) :** Сүүлийн жилүүдэд Монголд зудын хохирол нэлээд ихсэж 2002 оны зуднаар ойролцоогоор 4 сая орчим, 2009 оны зуднаар 11 сая тоо толгой мал хорогдсон (FAOSTAT). Энэ тоонууд бол тухайн үеийн Монголын нийт мал сүргийн ойролцоогоор 14 хувь болон 25 хувьтай тэнцэж байна. Жишээлбэл одоогийн Япон улсын нийт үхрийн тоо толгой ойролцоогоор 4 сая орчим, энэ тоотой харьцуулж үзэхэд тухайн үеийн зуднаар маш том хохирол амссан байна гэж хэлж болно. Ийм их хэмжээний мал сүрэг зөвхөн нэг өвлийн зуднаар хорогдсон. Зуд гэдэг нь цаг уурын маш том өөрчлөлт, өөрөөр хэлбэл цочир хүйтрэл, дээр нь цасны хэмжээ зэрэг нь шууд холбоотой гэж үзэж байгаа хэдий ч бидний энэ удаагийн судалгаанаас дүгнэж үзэхэд зуднаас болж гарсан хор хохирлыг нэмэгдүүлж байгаа хамгийн том хүчин зүйл бол малчид өөрсөдтэй нь холбоотой асуудал юм. Энэ судалгаа бол голчлон малчидтай уулзаж ярилцсан материал дээр тулгуурлаж байгаа ба зудны хохирлыг хамгийн багаар амсах боломжтой эсэх нь зуднаас хамгаалах арга хэмжээ өөрөөр хэлбэл өвөлжилтийн бэлтгэлээ сайн хангасан байна уу үгүй юу гэдэг асуудал юм. Бодит агуулгыг харахад:

- Өвөлд хэрэглэх газар нутаг, өвөлжөөгөө сайтар судлах, бэлдэх: Мал бэлчээрлүүлэхэд идэш тэжээл хангалттай байх газар, нарны элч, тусгал сайн тусах газар, салхи багатай нөмөр нөөлөг газар зэрэг
- Өвлийн хугацаанд хэрэглэх өвс тэжээлийн бэлтгэл : Өвс бэлтгэх ажил хамгийн чухал нь. Намрын хугацаанд өвөлдөө бэлдэх, хадлан хийх явдал. Энэ мэдээж их

¹⁷ Li and Hao. 2011. Grazing resources and grassland degradation in Northern China. *J. Resour. Ecol.* 2: 286-288.

¹⁸ Taylor, J. L. 2006. Negotiating the grassland: the policy of pasture enclosures and contested resource use in Inner Mongolia. *Human Organization* 65: 374-386.

¹⁹ Фүжита. 2013.

²⁰ Оники болон Коногаяа. 2004. Монгол дахь тал хээрийг хамгаалах нүүдлийн мал аж ахуйн менежментийг хөгүүлэх талаар. Олон улсын газар тариалан, ойн аж ахуйн хамтын нийгэмлэг 27: 8-20.

хөдөлмөр шаардагдсан ажил (Зураг 2.6.1.-7)

- Хашаа, хороогоо сайтар бэлдэх : Салхи бага нэвтрэх нөмөр өвөлжөө сонгосон хэдий ч ямар ч салхи, шуурга нэвтэхгүй газар гэж байдаггүй. Тиймээс салхинаас хамгаалахын тулд хашаа хороогоо сайтар бэлдэх үүний дотроос малын саравч зэрэг нь зайлашгүй шаардлагатай (Зураг 2.6.1.-8)
- Өвлийн идэш, мал нядлагаа: Ихэнх малчид өвлийн түрүүчээр идэшэндээ хэргэлэх хэлбэрээр тодорхой хэмжээний малыг гаргадаг. Энэ нь хатуу ширүүн өвлийн түрүүчээр малын тоог бага хэмжээгээр цөөлснөөр мал хариулах ажлыг хөнгөвчлөх, малын гарз хохирлыг багасгах гэсэн 2 талын үр дүн гарч байна гэж хэлж болно

Дээр өгүүлсэнчлэн энэ мэт өвлийн бэлтгэлийг бага хийдэг, эсвэл бүр хийдэггүй малчид зуднаар их хэмжээний малын гарз хохирол амсаж байна. Иймээс сүүлийн жилүүдийн зудны хохирлын хэмжээ их байгаа нь дээрх асуудлуудтай холбоотой. Яагаад зарим малчид өвлийн бэлтгэлийг сайтар хийхгүй байгаа талаар малчидтай ярилцахад “Сүүлийн үеийн малчдын дунд өвлийн бэлтгэлийг сайтар хангахгүй хүн олон болсон мөн бэлчээрийн сайтар мэдэх малчидын тоо багассан”. Энд өгүүлэх “Сүүлийн үеийн малчид” гэж зах зээлийн эдийн засагт шилжсэний дараагаас гэнэт нэмэгдэх болсон шинэ залуу малчдын давхаргыг зааж буй нь лавтай. Монгол социалист тогтолцоо задран унасны дараа нэгдлийн мэдэлд (төрийн) байсан малыг хувьчилсан явдал нь тэнд ажиллаж байсан хүмүүс зэрэгт мал шилжиснээр тэд шинэ малчид болсон. 1990 онд 75,000 өрх байсан малчидын тоо 2002 онд хүрэхэд ойролцоогоор 200,000 өрхөд хүрсэн байна (Мори, Бүрнээ-баатар 2000²¹). Тэдний олонх нь мал маллагааны нарийн арга ухаан, мэдлэгийг сайтар эзэмшээгүй (Janzen, 2005²²). Мөн өвлийн бэлтгэлийг хангалттай хийдэггүй, малын тоо толгойг нэмэх тал дээр илүү анхаарлаа хандуулдаг (Фүжида, 2013²³). Эдгээр зүйлс нь зудны хохирлыг улам ихэсгэх шалтгаан болж байна. Малын тоо толгой ихтэй малчид зуданд өртөх, хохирол илүү амсах хандлага байна (Батуул 2005²⁴). Зуд болсноор гарах хохирлын цаад шалтгаан нь цаг ууртай холбоотой гэхээсээ илүү зохиомол шалтгаан, өөрөөр хэлбэл зах зээлийн эдийн засгийн давалгаанд автагдсан орон нутгийн социалист эдийн засгийн нөхцөл байдал нь ихээхэн холбоотой гэж үзэж болохоор байна.

²¹ Мори, Бүрнээбаатар. 2002. Махны түгээлт, хуваарилалтын хувьсгал, төлөвлөлт Нүүдлийн мал аж ахуй Монголын эдийн засгийг өөрчлөх өдөр Токио

²² Janzen, J. 2005. *op. cit.*

²³ Фүжита. 2013.

²⁴ Батуул. 2005. Монголын нүүдлийн менежментийн тархалт болон зуднаас хамгаалах талаарх судалгаа. Газар тариалангийн менежментийн судалгаа 31: 1-21.

Зураг 2.6.1.-7~8 : Өвөлжилтийн бэлтгэл (хадсан өвс болон малын хашаа, саравч)



7 : Бухалдсан өвс



8 : Салхинаас хамгаалсан малын хашаа, саравч

Зураг : Жайка-ийн судалгааны баг

- **Малыг зарж, борлуулах улирал:** Өмнө өгүүлсэнчлэн Монголд малын зарж, борлуулахад тодорхой хэмжээгээр улирлаас хамааралтай, улирлаас шалтгаалж байдаг. Энд өгүүлэх агуулга бол малчид болон малын ченж, хүнсний зах дээр мах борлуулагчид, мах үйлдвэрлэгчдын холбоо, хамаарал бүхий төрийн байгууллагууд зэрэгтэй уулзаж ярилцсан материалыг нэгтгэн дүгнэсний үр дүн юм. Хуучин нэгдэл байх үед өвөл эхлэхээс өмнө нэгэн зэрэг мал нядалгаа эхлүүлдэг байсан. Ихэнхдээ малыг олон тоогоор нядлах хугацаа нь 8-12 сард төвлөрч хийгдэг байв. Малчдаас малыг худалдан авах, малын төрөл, тоо хэмжээний зэргээс хамаарч хугацаа нь янз бүр байна. Өөрөөр хэлбэл малыг малчидаас авах хугацаа нь ерөнхийдөө өвлийн хатуу ширүүн улирал дуусаж, өвс нөгөө урган, мал тарга тэвээр авч эхлэх үетэй холбогдож байна. Энэ удаагийн судалгаанд оролцсон малын ченжийн яриагаар бол мал бол өвөл дунджаар 20-40 хувь биеийн жингээ алддаг. Тиймээс малыг амьдын жингээр авах нь өвлийн үед хэцүү, махны чанар, тарга тэвээргийн хувьд ч сайн биш учраас зарж байгаа талдаа ч гэсэн худалдан авч байгаа талдаа ч гэсэн давуу тал бага байдаг гэсэн үг. Мөн мал нядалгааны газрын хүмүүстэй уулзаж байхад 12 сараас 3 сар хүртэл үйл ажиллгааа бараг явагддаггүй. 3 сарын сүүлээс малчид малаа зарж эхэлдэг. Энэ хонь болон ямаагаа малчид эхлэн зардаг. Учир нь хонь болон ямаа нь амьдын жингээ бод мал болох үхэр адуу зэргээс бага алддаг тул хавар эрт зарж эхэлдэг. Үүний дараа 6-7 сар орчмоос бод малыг зарж эхэлдэг (Зураг 2.6.1.-9). Ер нь малчдаас худалдан авсан малыг бүгдийг тэр дор нь маханд хэрэглэх, нядлах гэсэн үг биш юм. Мэдээж худалдаж авсан малаа туувирлах, зуны үед тарга тэвээр авхуулах зэргээр жинг нь нэмэн 8 сараас хойш нядлах явдал ч байна. Хонь болон ямааг 3-4 сард ноосыг нь авч ноолуурыг нь самнадаг. Эндээс гарах ашиг (Ямааны ноолуур) бол малчдын хувьд гол бэлэн мөнгөтэй болох боломж. (Зураг 2.6.1.-10) Малыг зарж, борлуулахад бол нэг талаас малын төрөл болон өвсний нөхцөл байдал, улирлаас хамаардаг бол нөгөө талаас өөр нэг онцлох хүчин зүйл нь намрын улирал, сартай хамаатай юм. Энэ нь бол 9 сард эхлэх сургуультай холбоотой. Малчидын хүүхдүүд 9 сард сургуульд явах тул сурах бичиг зэргийг худалдан авахад бэлэн мөнгө зайлшгүй шаардлагатай болдог нь малыг зарах, борлуулах бас нэг шалтгаан болж байна


Зураг 2.6.1.-9~10 : Адууг тээвэрлэж буй байдал



9 : Адууг тээвэрлэж буй байдал (9 сар)

Зураг : Жайка-ийн судлагааны баг

Ямаа самнаж буй байдал



10 : Ямаа самнаж буй байдал (3 сар)

- **Малчид болон хэрэглэгчдийн талаарх судалгаа:** Мал аж ахуйтай холбоотой мэдлэг, туршлагын талаар судалгаа хийх явцад аль болох олон хүнтэй уулзаж, ярилцахыг хичээсэн. Юуны түрүүнд малчдын цаашдын мал маллагааны талаар “Ирээдүйд монголын мал аж ахуй ямар чиг баримжаагаар хөгжих ёстой вэ?” , “Төлөвлөсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжсэнээс хойших өөрчлөлт, нөхцөл байдал ямар зүйл, юу гол тулгамдаж буй асуудал болоод байна” зэрэг асуудлуудаар уулзаж ярилцсан. Гэвч эдгээр асуудлууд нь малчдын хувьд хэтэрхий том , өргөн хүрээтэй байсан учир асуултаа улам жижиглэн илүү бодит энгийн асуулт болгосон. Энэ нь “Сүүлийн жилүүдэд уламжлалт мал аж ахуйгаас эрчимжсэн, фермерийн мал аж ахуйд шилжих шаардлагатай гэх санаа бодолтой хүмүүс олон байна. Энэ талаар таны санал, бодол”, “Сүүлийн үед танд тулгамдаж буй асуудал, шийдвэрлэхэд бэрхшээлтэй асуудлууд байна уу” зэрэг асуудлаар ярилцав.. Үр дүнг нь нэгтгэсэн байдлаар танилцуулахад өмнөх асуулт болох “Эрчимжсэн мал аж ахуй талаарх утгыг сайтар ойлгохгүй байна. Малчид бид хувьд уламжлалт арга барилаасаа татгалзаж чадахгүй. Энэ арга барилаас өөр арга барилыг эзэмшихэд хэцүү гэж бодож байна” гэсэн хариулт, дараагийн асуултын хариулт нь “ Малаас гарах түүхий эд, сүү цагаан идээ зэргийн үнэ нь тогтмол бус, ер нь буурах хандлагатай” гэсэн тайлбар байв. Олон удаа дурдаж байгаачлан нүүдлийн мал аж ахуй дээр суурилсан үйлдвэрлэлийн систем нь монголын тал хээр онцлогт нийцэж байгаа, энэ арга барил зөв зүйтэй гэж үзэх малчид олон байна зэрэг нь зөвтгөх шалтгаан бол биш. Гэвч нөгөө талаас Монгол бол социалист эдийн засагаасаа салж чадаагүй, дэлхийн хэмжээнд үүсээд байгаа цаг уурын өөрчилт зэрэг томоохон хүчин зүйлүүдийн өөрчилтөнд ороод байна (Фүжита, 2013²⁵) Уламжлалт мал маллагааны арга барилыг цаашид үргэлжлүүлэн бэлчээр нутгаа ашиглахад бол тийм ч амар биш, олон асуудал урган гарч ирж байна. Судалгаанд хамрагдсан малчид бүгд 70 дээш хувийг эзлэх дундаж давхрагын малчид байсан. Тэд “Бид мал маллахаас өөр зүйл хийж чадахгүй” гэсэн хандлага, яриа хүчтэй гарч байсан нь санааг зовоож байна.

²⁵ Фүжита. 2013..

Тиймээс орчны талаарх зөв мэдлэг, чадвартай шинэ гэгээгрүүлэгч, удирдагч гарч ирэх шаардлагатай. Ойрын жилүүдэд нэг хэсэг малчдын малын тоо толгой хэтэрхий ихэснээр малчидын малаа хариулах бэлчээрийн хэмжээ дагаад ихсэж тодорхой газрыг эзэмших зэрэг хандлагууд гарч байна (Онодэра, 2009²⁶). Дунд хэмжээний малтай өрхүүд улам хүнд, бэрхшээлтэй байдалд орох орох хандлагатай болж байна. Ийм нөхцөл байдалд орж байгаа талаар 2 дахь асуултны хариултанд ч гарч байсан. “Малаас гарах түүхий эд, сүү цагаан идээний үнийн бууралтанд анхаарах” болон социалист систем задран унасны дараа юуны түрүүн малын тоо толгой өсгөх тал дээр илүү анхаарал тавих болсон (Фүжита 2013²⁷) зэрэг нь ямар нэг байдлаар дээрх асуудалтай холбогдож байна.

Түүнчлэн, малаас гарах түүхий эд, сүү цагаан идээг хэрэглэх талаар олон хүмүүс, багаар бодоход суурин, хот газрын иргэдийн ихэнх нь Монгол газар нутаг, бэлчээрт өсөж, идээшсэн малыг туйлын эрүүл хүнс гэж ойлгох, үнэлэх үнэлгээ өндөр байна. Гэвч энэ үнэлгээ нь шинжлэх ухааны үндэслэл дээр тулгуурлан гарсан зүйл гэхээсээ илүү “Монголын газар нутаг, бэлчээрт идээшин өссөн мал бол бусад гадаад орны нэмэлт гэжээл зэрэг байгалын бус аргаар таргалуулсан малтай харьцуулахад илүү, эрүүл байхаас аргагүй” гэсэн ямар ч судалгаа шинжилгээн дээр бус сохороор итгэх итгэл үнэмшил дээр тулгуурласан дүгнэлт хүчтэй байна.

2) Малын эрүүл ахуйн талаарх судалгаа

- **Монгол малын эрүүл ахуйн талаар хууль, дүрэмтэй холбоотой мэдээлэл (нүүдэллэх орон зай, хязгаар зэргийг багтаасан) :** Монголд Японы мал, амьтны эрүүл ахуйн хуультай адил, төстэй хууль дүрэм байдаг. Энэ хууль нь 5 бүлэг16 зүйл, мөн ойролцоогоор 150 орчим жижиг дүрэм, журмаас бүрдэж, малын эрүүл ахуйтай холбоотой дүрэм, журмыг хамааруулсан байна. Уг хуульд аймаг хооронд болон улс хооронд (Орос, Хятадтай залгах хил орчмын нутаг) гарах малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар нэлээд тодорхой, бодитиор хэрэгжүүлэх хуулийг оруулсан байна. Гэвч хил орчмын малын эмч болон малын эмч нарын семинар, сургалтнаас сонссон хэрэгжилтийн байдал бол хангалттай биш гэсэн сэтгэгдэлтэй үлдсэн. Ерөнхийдөө Монгол улсын дотор малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тогтолцоо, хэрэгжилт доогуур байдаг гэж уулзсан хүмүүс ярьж байсан.
- **Монгол улс дахь малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлж буй бодит нөхцөл байдал :** Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар улсаас гаргасан хууль, дүрэм байхын зэрэгцээ нэлээд нэгдмэл системтэй гэж харж болох боловч бодит орон нутагт бол нэлээд ойлголтын зөрүү байна. Жишээ нь малын эмч нарын хурал, семинарт оролцоход “ Монголд амьд хэлбэрээр экспортонд гаргах малын тоо 2010 онд гарсан шүлхийгээс хойш ерөнхийдөө зогссон” , Монголын хүнс хөдөө аж ахуйн яамд харьяалагдах ОИЕ-ийн албан өрөөнд ярилцсан ярианд “ Монгол улсын дотор амьдаар

²⁶ Онодэра. 2009. Монгол малчидын тал хээрийн талаарх орчны ухамсар , газрын ашиглалт. Хоккайдогийн их сургууль.

²⁷ Фүжита. 2013.

шилжүүлэхийг хүлээн зөвшөөрөөд байгаа нь Сүхбаатар аймгийн морьноос өөр мал бол хориотой” гэсэн тайлбар байсан. Гэвч Дорнод аймгийн малын эмчийн ярианд тус аймгаас морийг ч гэсэн бусад аймаг руу амьдаар шилжүүлж байгаа гэж ярьсан. Энэ нь улсын дотор байгаа төр, захиргааны байгууллагуудын хоорондын мэдээлэл дамжуулалт, хэрэгжүүлэлт хангалттай бус байгааг харж болохоор байна.

Хил орчмоор малын халдварт өвчнөөс хамгаалах нөхцөл байдал хэр байгаа талаар өгүүлэхэд Монголын хилийн хашаа, багана шон бол хангалттай, төгс гэж хэлхээргүй нөхцөлд байна. Өмнө өгүүлсэнчлэн Монголын эдийн засагт үзүүлэх нөлөө гэсэн утгаараа шүлхий бол маш ноцтой өвчин юм. Өвчний суурь болох шүлхийн вирус бол тархалт нэлээд хурдан, олон төрлийн дамжуулагчаар (шүлс, тоос шороо, бохир зүйл зэрэг) дамжин халдварладаг. Халдвар тархалтын хүрээ мөн өргөн (Mikkelsen *et al.*, 2003²⁸) .Тиймээс Монголын хилийн хашаа, тор нь халдвараас хамгаалах, халдварыг зогсоох зэрэгт ямар нэг үр дүн, ач тусаар бага (Зураг 2.6.1.-11) Жишээ нь Японд бол шүлхий гарсан тохиолдолд малын хөдөлгөөнийг 10-20 км радиусаар хязгаарладаг.

2015 оны 9 сард хил орчмын бүсд малын халдварт өвчнөөс сэргийлэх талаар нэлээд үр дүнтэй хурал болж өндөрлөсөн. Тэр нь ОИЕ-аас зохион байгуулсан Монгол, БНХАУ, ОХУ 3 улсын хооронд малын эрүүл ахуйн талаарх гэрээ, хэлэлцээрийг байгуулсан. Уг гэрээнд шүлхий болон бусад малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг 3 улс хамтран авах талаар дурдагдсан байна. Энэ дотроос хамгийн сонирхол татаж бүхий зүйл нь ирээдүйд гарч болзошгүй малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, 3 улсын дотор малын гаралтай бүтээгдэхүүний экспорт, импортыг чөлөөтэй болгох, халдварт өвчнийг судлах, түүнээс сэргийлэх үүднээс чөлөөт бүсийг бий болгох санаа байлаа. Бидний судалгааны үр дүнд Монголын талд санал болгож буй эдийн засгийн онцгой бүсийн төсөл, концепт ч (үндсэн материалын 5.3) гэсэн дээрхтэй санаа адил, төстэй зүйл юм. Монголын хувьд ч гэсэн энэ санаа, концепт олон давуу зүйл, ашиг байна харж байгаа. Монголын Хүнс хөдөө аж ахуйн яамны харьяа ОИЕ-ийн албан өрөөнд болсон ярианаас дурдахад ОХУ-тай хиллэх хилийн зурваст 3 газар , БНХАУ-тай хиллэх хилийн зурваст 7 газар Чөлөөт бүсийг байгуулахаар болсон.

²⁸ Mikkelsen, T., Alexandersen, S., Astrup, P., Champion, H. J., Donaldson, A. I., Dunkerley, F. N., Gloster, J., Sørensen, J. H., and Thykier-Nielsen, S. 2003. Investigation of airborne foot-and-mouth disease virus transmission during low-wind conditions in the early phase of the UK 2001 epidemic. *Atmospheric Chemistry and Physics* 3: 2101–2110.

**Зураг 2.6.1.-11~12 : Хилийн төмөр хашаа болон Төв аймгийн
мал эмнэлэгийн байр**



11 : Хилийн орчмын бүс (Замын Үүд)

Зураг : Жайка-ийн судалгааны баг



12 : Төв аймгийн мал эмнэлэгийн байр

- **Хөдөө, орон нутаг дахь малын эрүүл ахуйн тогтолцооны талаар, бодит байдал**
Вакцин тарилгын нөхцөл зэргийг багтаасан: Сүүлийн жилүүдэд Монголд малын эрүүл ахуйн тогтолцоонд бага зэрэг өөрчлөлт орж байна. Гэхдээ хуучин нэгдлийн үеийн бүтэц, тогтолцоог үргэжлүүлсэн байдалтайгаар явж байна. Товчхондоо, Монголын 21 аймгийн төвд аймгийн мал эмнэлэгийн газар гэх нэгдсэн байгууллага байдаг. Мөн мал эмнэлэг, үржлийн нэгж нь 347 сум бүрт байна. Энэ байгууллага нь Японы нийслэл, муж бүрт байх мал, амьтны даатгал, эрүүл ахуйн газартай ойролцоо гэж хэлж болно. Өөрөөр хэлбэл тухайн орон нутагт байх мал, амьтныг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, шаардлагатай үед үзэж оношлох зэрэг багтана. Сумын мал эмнэлэгийн газарт ойролцоогоор 1-3 орчим малын эмч ажилладаг ба ажлын байрны хэмжээ нь янз бүр байна. Өөрийн гэсэн байртай мал эмнэлэг, үржлийн нэгж байхад төр захиргааны байрны 1 өрөөг ашиглаж үйл ажиллагаагаа явуулж буй газар ч байна. Жишээлбэл энэ удаагийн судалгаагаар очсон Төв аймгийн мал эмнэлэгийн хувьд (Зураг 2.6.1.-12) мал эмнэлэг, үржлийн нэгж нь сумынхаа тоотой адил 27 байсан. Ер нь 1-3 хүний орон тоотой, малын эмчид ажиллаж байна. Тэдний гол ажил нь томилогдож очсон газартаа хувийн байгууллагуудын малын эмч нартай хамтарсан хэлбэрээр халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг явуулдаг. Вакцин, тарилга болон малын хялгасан хорхойн туулга эм²⁹ зэргийг өгөх үйл ажиллагааг голлон хийж байгаа нь бол хувийн байгууллагуудын малын эмч нар байна. Ер нь хувийн байгууллагын малын эмч нарын ажил бол бодит талбар дээр явагдах нь олон. Харин мал эмнэлэг, үржлийн нэгжийн ажил нь албан өрөө, оффист явагдах нь олон. Хувийн байгууллагын малын эмч нарын дундаж норм нь 300 орчим малчныг хариуцахын дээр жилд 30,000-40,000 толгой малд ямар нэг хэмжээгээр эмнэлэгийн арга хэмжээ авдаг байна. Энэ удаа 26 хувийн байгууллагын малын эмч нараас судалгаа авах боломж олдсон. “Одоогийн хийж байгаа ажилдаа сэтгэл хангалуун байдаг уу” гэсэн асуултанд бүгд Тийм гэж хариулсан бол “ Авч байгаа цалиндаа сэтгэл хангалуун байна уу” гэсэн асуултанд Тийм гэж хариулсан хүн нэг ч

²⁹ 2013 оны Монгол улсын статистикийн шар номонд шүлхий, бруцеллээс зэрэг гол халдварт өвчний вакцина, тарилгад хамрагдаад байгаа малчид болон туулга эмийнд хамрагдсан малчидыг харьцуулахад тус тус 60.3 хувь, 46.2 хувьтай байна. Мэдээж энэ тоо бол чамлахааргүй тоо юм

байсангүй.

Өнөөдөр Монголд малын эрүүл ахуйн асуудал нэлээд тулгамдаж буй асуудалын нэг болж байна. Доорх хүснэгт нь малчид, малын эмч, аймгийн мал эмнэлэгийн газар (Төв болон Дорнод аймаг), Малын эмч нарын хурал, семинар, мах үйлдвэрлэгчдийн холбоо, эсгий, утас үйлдвэрлэгчдийн холбоо, Монголын улсын их сургууль болон Махны ченж нараас авсан судалгаанд үндэслэн гаргасан зүйл юм (Хүснэгт 2.6.1).

Хүснэгт 2.6.1.-2 : Малын эрүүл ахуйн асуудал дээр тулгамдаж буй асуудлууд

Асуудал		Бодит байдал дээр байгаа халдварт өвчин болон бусад	Авах арга хэмжээ
1	Халдварт өвчин	• Шүлхий	Вакцинжуулалт
		• Бруцеллёз	Тогтсон хугацаанд үзлэг / Вакцин
		• Адууны сахуу	Шалгарал
2	Шимэгч хорхой	• Хамуу	Туулга эм
		• Арьсны шимэгч хорхой	
3	Хүнс тэжээлийн дутагдал	• Витамин	Витамин төрөл
		• Эрдэс ус	Эрдэс ус төрөл
4	Бусад	• Төл малын эрүүл ахуйн асуудал (өсөлт)	Техник, технологийн удирдамж, зааварыг түгээх, дэлгэрүүлэх
		• Мал, амьтанд хэрэглэх эмийг ашиглах дүрэм журмын хэрэгжилт хангалтгүй	

Эх сурвалж : Жайка-ийн судалгааны баг

Дээрх хүснэгт дотроос эдийн засгийн алдагдалд орох өнцгөөс харсан ч гэсэн халдварын тархалт, хамрах хүрээ нь өргөн гэсэн утгаар нь харсан ч гэсэн хамгийн түрүүнд шийдвэрлэхгүй бол болохгүй нь шүлхий юм. Энэ өвчний тархалтын хурд болон Монгол улсын газар нутгийн байдал, нөхцөл зэргээс харахад Японы адил халдварт өвчин тархаас өмнө сэргийлэх, зогсоох боломж маш бага юм. Жишээ нь халдварыг бүрэн таслан зогсоох арга зэрэг нь бодит бус учраас хэрхэн энэ өвчнийг хяналтандаа байлгах вэ гэдэг асуудал хамгийн чухал. Тиймээс хөрш улсуудтай хамтран ажиллах, өмнө нь бичсэнчлэн чөлөөт бүсийг бий болгох зэрэг нь бодит авах арга хэмжээ юм.

Малчидтай уулзаж ярилцаж байхад малын эмч нараас халдварт өвчний талаарх анхааруулах яриа, сургалт бараг хийдэггүй гэж ярьж байсан.

Монголд хэд хэдэн халдвар тээгч шимэгч хорхой өөрөөр хэлбэл адууны гуур зэрэг нь өргөн тархсан³⁰. Энэ мэт орон нутагт мэдээлэл хомс явдал зэрэг нь нүүдлийн мал аж ахуйн бүтээмжийг багасгах хандлагатай болж байна. Ер нь тухайн орон нутгийн малын эмч нарыг хөгжүүлэх, боловсруулах зэрэг нь цаашид маш их анхаарах сэдэв болж байна.

³⁰ Монгол малын үндсэн нянгийн төрлийн өвчний судалгаа, оношлох аргын талаар төсөлд суурилсан судалгааны тайлан.

Мөн хүснэгтэнд байгаа мэдээлэл дотороос нэмэлт тайлбар хэрэгтэй нэг мэдээлэл бол мал, амьтанд хэрэглэх эмийн ашиглалтын дүрэм, журмын хэрэгжилт хангалтгүй байгаа талаар юм. Энд жишээ нь тарилга, антибиотик зэргийг малд хийсний дараа тодорхой хугацаанд гаргахгүй байх шаардлагатай. Үүний хэрэгжилт хангалтгүй. Малын хувьд малаас гарах сүү болон махыг ашиглах гол зорилгоор тэжээдэг учраас хүнсний бүтээгдэхүүнд ашиглах аюулгүй байдлын өнцгөөс харах нь чухал. Тиймээс эм бүрт уулгасны дараа гаргахыг хориглосон тодорхой, тогтсон хугацааг сайтар баримтлах шаардлагатай. Японд ч гэсэн ийм зүйл мөрдөгддөг. Иймээс малын эмч нарын заавар, зөвөлгөө мэдлэг дутуу, эсвэл малчид зүгээс хэт назгайрах үл тоох зэрэг шалгаанаар сайтар мөрдөгдөхгүй байна. Ер нь “Бэлчээрт өвс идэж өссөн эрүүл мал” тэндээс гарсан түүхий эд, сүү цагаан идээ нь аюулгүй гэсэн хандлага үеэ өнгөрөөж байгааг ойлгох хэрэгтэй.

Эцэст нь хөдөө, орон нутаг дахь малын эрүүл ахуйн тогтолцоо, бүтцийн талаар шинэчлэл гэж хэлж болохуйц нэгэн зүйлийн талаар дурдая. Өмнө нь өгүүлсэнчлэн “ Монголын мал аж ахуйн хөтөлбөр” –ийн дотор цаашид бэлчээрийн мал аж ахуйд шинэчлэлийг гол зорилгоо болгон янз бүрийн арга , аргачилал, шинэлэг зүйлүүдийг санал болгож байна. Тэндээс анхаарал татаж байгаа нь малын индексжүүлсэн даатгал (Цаг уурын индексжүүлсэн даатгал)³¹ юм. Энэ нь нүүдлийн мал аж ахуй цаг уурийн нөлөөллөөс хамааралтай аж ахуй тул малын индексжүүлсэн даатгалын бий болсон нь зөв зүйтэй зүйл гэж бодож байна. Нөгөө талаас малчид тэрний төлөө мөнгө төлөн, бодитогоор даатгалд хамрагдах уу үгүй юу гэсэн асуулт анхаарал татаж байна. Гэвч өнгөрсөн жилийн мэдээлэл дээр тулгуурлан даатгалын компаниудын үйл ажилгааны үр дүнгээс харахад нийт малчин өрхийн 6.9 хувь болох ойролцоогоор 10,000 орчим өрх уг даатгалд хамрагдсан, даатгалын гол субъект болох малын тоо бол 2 сая 660 мянган толгой (нийт малын 5 хувь)-д хүрсэн байна.³² Үүн дотороос хонь болон ямааг даатгуулах хандлага их байна.³³ Энэ хандлага нь хэдийгээр дөнгөж эхлэлийнхээ шатанд байгаа хэдий ч малчдын эрсдлийн менежментийн талаарх ойлголтонд өөрчлөлт орж байна гэж хэлж болохоор байна.

³¹ Малын индексжүүлсэн даатгалын онцлог нь даатгалын мөнгөний төлөлт нь бусад даатгалтай адил хохирол хэмжээнд тулгуурлан шийдвэрлэх бус өмнө тогтоосон цаг агаарын байдлаас (индекс) хамаарах. Маш энгийн индекс бол бороо орох хэмжээ. Жишээ нь нэг аймаг, аль эсвэл сумд дундажаар орох борооны тогтсон хэмжээнээс бага орвол бодитоор хохирол амсах уу үгүй юу гэдэгт хамааралгүй даатгалын мөнгө бол гишүүд бүр адилаар төлөгдөх систем.

³² Монголын мэдээ. 2015. 530: 4.

³³ Даатгалд хамрагдсан малын хувь харьцаа: Ямаа=47.6 хувь, хонь=42.7 хувь, Үхэр=6.7 хувь, Адуу=2.7 хувь, тэмээ=0.23 хувь. Энд ямаа болон хонины эзлэх хувь их байгаа талаар даатгалын компаний ажилтнаас тодруулахад нэг талаас үхэр болон адуу тай харьцуулахад даатгалын үнэ хямд нөгөө талаас угаасаасаа ямаа болон хонь малын тоо толгойтой харьцуулахад ихээхэн хувийг эзлэдэг тул ямар нэгэн хохиролд өртөх магадлал их учир даатгалд ихээр хамруулж байгаа

Хавсралт материал 2.7.1: Хүйтний улиралд хүнсний ногоо болон жимсийг тариалж ургуулах

Хувийн компаний жишээ

【Жишээ. 1】 Төв аймагт байх хүнсний ногоо, жимсийг тариалж ургуулах болон борлуулж буй хувийн хэвшил. Монгол аргаар барьсан (хүлэмжийн хэмжээ өөр өөр 10m×50m гол хэсэг) 35 орчим хүлэмж. Энэ дотроос 7-н хүлэмжинд 2014 оны өвөл гүзээлзгэнэ, бууцай, лууван, өргөст хэмх зэргийг тарьж ургуулан, борлуулсан байна. Тулгамдаж буй асуудал бол дулааны зардал нэлээд өндөр болж байна. Цаашид 2015 оны өвлийн тариалалтын талаар ямар арга хэмжээ авах талаар судлаж байна.



Эх сурвалж : Жайка-ийн судалгааны баг

Зураг 2.7.1-1 Хүнсний ногоо, жимс тариалах, худалдаалах компаний хүлэмж

【Жишээ 2】 Японы хүнсний ногооны үйлдвэрийн тоног төхөөрөмж, гидропоник тариалалтай холбоотой зураг төсөл, барилгын ажил, тариалалтын техник технологийн зааврын дагуу Улаанбаатар хотын захад хүнсний ногооны талбайн хэмжээ 400м², үйлдвэрлэх багтаамж 150~250kg/ барилгыг барьж байгуулсан. Өдөрт тогтмол үйл ажиллагаа явуулдаг. Навчит хүнсний ногооны 6 (Ногоон навч, шанцайны ургамал, бууцай, mint, sunny lettuce, romaine lettuce) төрлийг тарьж ургуулан худалдаалж байна. Борлуулах газар томоохон ресторан, супер маркет юм. Тухайн газар дээр нь шууд худалдаалах болон өөрийн компаний контейнертэй машинаар тээвэрлэх үйлчилгээ үзүүлж байна.



Эх сурвалж : Жайка-ийн судалгааны баг

Зураг 2.7.1- Хүнсний ногооны үйлдвэр

3 дугаар бүлэг

Хавсралт материал : Эдийн засаг, аж үйлдвэртэй холбогдсон дүн шинжилгээ, Монгол улсын эдийн засгийн бүтэц

Энд Монголын үндэсний статистикийн хорооноос гаргасан аж үйлдвэртэй холбоотой мэдээлэлд (2013 он, 20 салбар) тулгуурлан Монголын эдийн засгийн бүтцийн онцлогийг үйлдвэр болон эрэлт хэрэгцээний талаас нь дүн шинжилгээ хийн, түүний нөлөөллийн үр дүнг судлан гаргав.

1) Эдийн засгийн бүтцийн онцлог

1 дүгээр хүснэгтэд эцсийн болон завсрын үеийн эрэлт хэрэгцээ гэсэн 2 хэсэг байх ба завсрын үеийн эрэлт хэрэгцээ нь 30 хувь, эцсийн эрэлт хэрэгцээ нь 70 хувийг эзлэж байна. 2 дугаар хүснэгтэд эцсийн эрэлт хэрэгцээний бүтцийг харьцуулахад экспорт 30 хувь гэсэн харьцангуй өндөр үзүүлэлт гарч байна. Ялангуяа уул уурхайн хувьд 80 хувь нь экспорт эзэлж байгаа нь дээрх үзүүлэлтэд нөлөөлөх гол хүчин зүйл болж байна.

Хүснэгт 1 Эцсийн болон завсрын эрэлт хэрэгцээний бүтцийн хувь, харьцуулалт

	Завсрын үе	Эцсийн	Нийлбэр
Газар тариалан, ой, усны аж ахуй	36%	64%	100%
Уул уурхай	7%	93%	100%
Үйлдвэрлэл	27%	73%	100%
Цахилгаан эрчим хүч, газ, хөргөлтийн систем	91%	9%	100%
Цэвэр бохир ус, хог боловсруулах, засвар үйлчилгээ	70%	30%	100%
Барилгын салбар	20%	80%	100%
Бөөний болон жижиглэн, машин засвар	41%	59%	100%
Тээвэр, агуулах	52%	48%	100%
Зочид буудал, нийтийн хоолны үйлчилгээ	45%	55%	100%
Холбоо харилцаа	47%	53%	100%
Санхүү, даатгал	86%	14%	100%
Үл хөдлөх хөрөнгө	25%	75%	100%
Шинжлэх ухаан технологи, судалгаа	54%	46%	100%
Нийтийн үйлчилгээ	75%	25%	100%
Олон нийттэй харилцах алба, батлан хамгаалах, нийгмийн хангамж	9%	91%	100%
Боловсрол	2%	98%	100%
Эрүүл мэндийн даатгал, нийгмийн халамж	7%	93%	100%
Урлаг, энтертаймент	15%	85%	100%
Бусад үйлчилгээ	13%	87%	100%
Бусад	0%	100%	100%
Завсрын хэрэглээний нийлбэр хувь	31%	69%	100%

Эх сурвалж : Монголын статистикийн хорооны мэдээлэлд үндэслэн Жайка-ийн судалгааны баг боловсруулав

Хүснэгт 1 Эцсийн эрэлтийн задаргаа (бүтцийн хувь, харьцуулалт)

	Эцсийн хэрэглээний зарлага	Дотоодын нийт үндсэн хөрөнгийн бүрдүүлэлт	Экспорт	Нийлбэр
Газар тариалан, ой, усны аж ахуй	30.1%	59.4%	10.5%	100.0%
Уул уурхай	1.8%	18.4%	79.9%	100.0%
Үйлдвэрлэл	67.0%	8.1%	24.9%	100.0%
Цахилгаан эрчим хүч, газ, хөргөлтийн систем	97.3%	2.1%	0.7%	100.0%
Цэвэр бохир ус, хог боловсруулах, засвар үйлчилгээ	71.8%	2.9%	25.3%	100.0%
Барилгын салбар	2.0%	96.3%	1.7%	100.0%
Бөөний болон жижиглэн, машин засвар	54.1%	32.5%	13.4%	100.0%
Тээвэр, агуулах	46.5%	4.4%	49.1%	100.0%
Зочид буудал, нийтийн хоолны үйлчилгээ	77.1%	1.1%	21.8%	100.0%
Холбоо харилцаа	87.0%	0.8%	12.2%	100.0%
Санхүү, даатгал	89.6%	0.0%	10.4%	100.0%
Үл хөдлөх хөрөнгө	99.9%	0.1%	0.1%	100.0%
Шинжлэх ухаан технологи, судалгаа	23.1%	15.3%	61.7%	100.0%
Нийтийн үйлчилгээ	90.6%	1.3%	8.0%	100.0%
Олон нийттэй харилцах алба, батлан хамгаалах, нийгмийн хангамж	100.0%	0.0%	0.0%	100.0%
Боловсрол	99.4%	0.0%	0.6%	100.0%
Эрүүл мэндийн даатгал, нийгмийн халамж	98.7%	0.5%	0.8%	100.0%
Урлаг, энтертаймент	99.7%	0.1%	0.2%	100.0%
Бусад үйлчилгээ	89.3%	0.1%	10.6%	100.0%
Бусад	100.0%	0.0%	0.0%	100.0%
Завсрын хэрэглээний нийлбэр хувь	42.8%	27.4%	29.8%	100.0%

Эх сурвалж : Үндэсний статистикийн хорооны мэдээлэлд үндэслэн Жайка-ийн судалгааны баг боловсруулав

Хүснэгт 2 Эцсийн эрэлтийн задаргаа (Аж үйлдвэрийн бүтэцээрх хувь, харьцуулалт)

	Эцсийн хэрэглээний зарлага	Дотоодын нийт үндсэн хөрөнгийн бүрдүүлэлт	Экспорт
Газар тариалан, ой, усны аж ахуй	6.7%	20.6%	3.4%
Уул уурхай	1.0%	16.2%	64.7%
Үйлдвэрлэл	21.6%	4.1%	11.5%
Цахилгаан эрчим хүч, газ, хөргөлтийн систем	0.8%	0.0%	0.0%
Цэвэр бохир ус, хог боловсруулах, засвар үйлчилгээ	0.5%	0.0%	0.2%
Барилгын салбар	0.6%	47.2%	0.8%
Бөөний болон жижиглэн, машин засвар	10.2%	9.6%	3.6%
Тээвэр, агуулах	5.9%	0.9%	8.9%
Зочид буудал, нийтийн хоолны үйлчилгээ	2.1%	0.0%	0.8%
Холбоо харилцаа	3.4%	0.0%	0.7%
Санхүү, даатгал	1.3%	0.0%	0.2%
Үл хөдлөх хөрөнгө	11.0%	0.0%	0.0%
Шинжлэх ухаан технологи, судалгаа	1.1%	1.2%	4.4%
Нийтийн үйлчилгээ	1.4%	0.0%	0.2%
Олон нийтэй харилцах алба, батлан хамгаалах, нийгмийн хангамж	12.3%	0.0%	0.0%
Боловсрол	11.6%	0.0%	0.1%
Эрүүл мэндийн даатгал, нийгмийн халамж	5.3%	0.0%	0.1%
Урлаг, энтертаймент	1.2%	0.0%	0.0%
Бусад үйлчилгээ	2.0%	0.0%	0.3%
Бусад	0.0%	0.0%	0.0%
Нийлбэр	100.0%	100.0%	100.0%

Эх сурвалж : Үндэсний статистикийн хорооны мэдээлэлд үндэслэн Жайка-ийн судалгааны баг боловсруулав

Завсрын нэмэлт хэрэглээ болон нэмүү өртгийн харьцааг нийт аж үйлдвэрийн салбар тус бүрээр харахад нэмүү өртөг үйлдвэрлэсэн процент нь 63 хувьтай байна. Газар тариалан, ой, усны аж ахуйн нэмүү өртөг 78 хувь, уул уурхай 65 хувь, үйлдвэрлэл 47 хувь болж байна. Мөн үйлдвэрлэл, нэмүү өртгийн хэмжээг оруулан дээрх 3 салбарыг нэгтгэн дүгнэхэд нийт 42 хувийг эзлээд байна. Нэмүү өртгийн хэмжээний бүтцээс харахад газар тариалан, ой, усны аж ахуй 15.1 хувь, уул уурхай 16.8 хувь болж

томоохон хувийг эзлэж байна. Дотоодын эрэлтэнд эзлэх импортын хэмжээг үзэхэд уул уурхайн импорт нэлээн өндөр байна. Өөрөөр хэлбэл уул уурхайн үйлдвэрлэлийн хувьд импортоос хамаарах хамаарал хүчтэй байна.

Хүснэгт 4 Үйлдвэрлэлийн хэмжээ болон нэмүү өртгийн бүтэц

	Үйлдвэрлэлийн хэмжээ	Нэмүү өртөгийн хэмжээ
Газар тариалан, ой, усны аж ахуй	11.8%	15.1%
Уул уурхай	16.6%	16.8%
Үйлдвэрлэл	13.6%	9.8%
Цахилгаан эрчим хүч, газ, хөргөлтийн систем	2.9%	1.6%
Цэвэр бохир ус, хог боловсруулах, засвар үйлчилгээ	0.7%	0.5%
Барилгын салбар	9.3%	5.8%
Бөөний болон жижиглэн, машин засвар	10.6%	13.3%
Тээвэр, агуулах	6.0%	5.0%
Зочид буудал, нийтийн хоолны үйлчилгээ	1.5%	1.2%
Холбоо харилцаа	2.1%	2.4%
Санхүү, даатгал	3.4%	4.6%
Үл хөдлөх хөрөнгө	5.1%	6.8%
Шинжлэх ухаан технологи, судалгаа	3.1%	2.6%
Нийтийн үйлчилгээ	2.0%	1.3%
Олон нийттэй харилцах алба, батлан хамгаалах, нийгмийн хангамж	4.4%	4.6%
Боловсрол	4.0%	5.0%
Эрүүл мэндийн даатгал, нийгмийн халамж	1.7%	2.1%
Урлаг, энтертаймент	0.5%	0.5%
Бусад үйлчилгээ	0.8%	0.9%
Бусад	0.0%	0.0%
Нийлбэр	100.0%	100.0%

Эх сурвалж : Үндэсний статистикийн хорооны мэдээлэлд үндэслэн Жайка-ийн судалгааны баг боловсруулав

Хүснэгт 3 Завсрын хэрэглээ болон нэмүү өртөгийн бүтцийг аж үйлдвэрийн салбар тус бүрээр харьцуулсан байдал

	Завсрын хэрэглээ	Нэмүү өртгийн хэмжээ	Дотоодын бүтээгдэхүүний хэмжээ
Газар тариалан, ой, усны аж ахуй	22%	78%	100%
Уул уурхай	35%	65%	100%
Үйлдвэрлэл	53%	47%	100%
Цахилгаан эрчим хүч, газ, хөргөлтийн систем	70%	30%	100%
Цэвэр бохир ус, хог боловсруулах, засвар үйлчилгээ	61%	39%	100%
Барилгын салбар	54%	46%	100%
Бөөний болон жижиглэн, машин засвар	23%	77%	100%
Тээвэр, агуулах	44%	56%	100%
Зочид буудал, нийтийн хоолны үйлчилгээ	48%	52%	100%
Холбоо харилцаа	28%	72%	100%
Санхүү, даатгал	19%	81%	100%
Үл хөдлөх хөрөнгө	19%	81%	100%
Шинжлэх ухаан технологи, судалгаа	45%	55%	100%
Нийтийн үйлчилгээ	58%	42%	100%
Олон нийттэй харилцах алба, батлан хамгаалах, нийгмийн хангамж	35%	65%	100%
Боловсрол	24%	76%	100%
Эрүүл мэндийн даатгал, нийгмийн халамж	21%	79%	100%
Урлаг, энтертаймент	33%	67%	100%
Бусад үйлчилгээ	37%	63%	100%
Бусад	0%	100%	100%
Нийлбэр	37%	63%	100%

Эх сурвалж : Үндэсний статистикийн хорооны мэдээлэлд үндэслэн Жайка-ийн судалгааны баг боловсруулав

Хүснэгт 6 Импортын хувь хэмжээ болон дотоодын хэрэглээ хангасан хувь хэмжээ

	Импортын хэмжээ	Дотоодын хэрэглээ хангасан
Газар тариалан, ой, усны аж ахуй	4.3%	95.7%
Уул уурхай	88.0%	12.0%
Үйлдвэрлэл	15.4%	84.6%
Цахилгаан эрчим хүч, газ, хөргөлтийн систем	8.4%	91.6%
Цэвэр бохир ус, хог боловсруулах, засвар үйлчилгээ	7.4%	92.6%
Барилгын салбар	33.5%	66.5%
Бөөний болон жижиглэн, машин засвар	6.4%	93.6%
Тээвэр, агуулах	46.5%	53.5%
Зочид буудал, нийтийн хоолны үйлчилгээ	15.4%	84.6%
Холбоо харилцаа	21.2%	78.8%
Санхүү, даатгал	6.9%	93.1%
Үл хөдлөх хөрөнгө	2.3%	97.7%
Шинжлэх ухаан технологи, судалгаа	26.6%	73.4%
Нийтийн үйлчилгээ	13.4%	86.6%
Олон нийттэй харилцах алба, батлан хамгаалах, нийгмийн хангамж	8.5%	91.5%
Боловсрол	4.5%	95.5%
Эрүүл мэндийн даатгал, нийгмийн халамж	18.0%	82.0%
Урлаг, энтертаймент	4.2%	95.8%
Бусад үйлчилгээ	7.4%	92.6%
Бусад	0.0%	100.0%

Эх сурвалж : Үндэсний статистикийн хорооны мэдээлэлд үндэслэн Жайка-ийн судалгааны баг боловсруулав

2) Эрэлтийн дотоодын үйлдвэрлэлд нөлөөлсөн үр дүн

Энд нийт салбарын эрэлтийн өсөлт нь дотоодын үйлдвэрлэлд нөлөөлсөн үр дүнг харуулна. Хүснэгт 7 -д салбар тус бүрийн эрэлтийн өсөлт нь салбарын үйлдвэрлэлтэнд хэр зэрэг нөлөө үзүүлж байгааг урвуу матрицын коэффициентээр нэгтгэн гаргасан. Урвуу матрицын коэффициентийг ашиглаж салбар тус бүрийн дотоодын бүтээгдэхүүн, нэмүү өртөг, импортонд нөлөөлж буй үр дүнг шалгаж үзсэн.

Юун түрүүнд аж үйлдвэрийн хоорондын харьцангуй нөлөөллийг үзэхийн тулд нөлөөлийн болон мэдрэмжийн коэффициентийг ашиглан хариу тооцоог гаргасан (Хүснэгт 8). Энэ үр дүнгээс харахад “Цахилгаан эрчим хүч, газ, хөргөлтийн систем” болон “Цэвэр бохир ус, хог боловсруулах, засвар үйлчилгээ”-ний нөлөөллийн коэффициент нь тус бүр 1.471 , 1.325 гэсэн нөлөөллийн чадамж нь өндөр, ”Үйлдвэрлэл”, “Цахилгаан эрчим хүч, газ, хөргөлтийн систем”, ”Бөөний

болон жижиглэн, машин засвар” зэрэг салбаруудад мэдрэмжийн коэффициент өндөр гарч байгаа нь бусад салбаруудаас хамаарах хамаарал, нөлөөлөлд автагдах нь хялбар салбарууд юм.

Зураг 1 дээрх хоёр коэффициентын нэгтгэн гаргасан ба ингэснээр нийт салбар бүрийн онцлогыг харах боломжтой болсон. График 1-ийг стандарт үзүүлэлт болгон 4 хуваан үзэхэд, I бол нийт аж үйлдвэрт нөлөөлөх нөлөө хүчтэй эсвэл нөлөөнд өртөмтгий салбар бөгөөд, “Цахилгаан эрчим хүч, газ, хөргөлтийн систем” болон “Үйлдвэрлэл” зэрэг хамаарч байна. Ялангуяа “Цахилгаан эрчим хүч, газ, хөргөлтийн систем” нь бусад салбараасаа хол давуу, аль ч коэффициентэд үзүүлэлт нь өндөр байна. II бол нөлөөлөх хүч бага хэдий ч нөлөөнд өртөмхий салбарууд болох “Бөөний болон жижиглэн, машин засвар”, “Санхүү, даатгал”, “Газар тариалан, ой, усны аж ахуй” багтаж байна. III бол нөлөөлөх хүч ч нөлөөнд орох нь ч бага салбар болох “Уул уурхай” орж байна. Аж үйлдвэрийн дотоодын бүтээгдэхүүнд нөлөөлөх үр дүн талаас харахад уул уурхай нь бусад аж үйлдвэрүүдтэй харьцуулахад нөлөөллийн коэффициент нь бага болохыг харж болно. Эцэст нь IV бол нөлөөлөх хүч нь өндөр ч нөлөөлөл авах хэмжээ нь бага салбар болох “Барилгын салбар”, “Буудал, нийтийн хоолны үйлчилгээ” багтаж байна.

Хүснэгт 4 Урвуу матрицын коэффициент

	Газар тариалан, ой, усны аж ахуй	Уул уурхай	Үйлдвэрлэл	Цахилгаан эрчим хүч, газ, хөргөлтийн систем	Цэрэр болон ус, нөөг боловсруулал, засвар үйлчилгээ	Барилгын салбар	Бөөний болон жижиглэн, машин засвар	Төгрөг, алт, мөнгө	Булга, зөөл, хувийн үйлчилгээ	Хялбар тариалан	Самуц, даатгал	Уламжлалт үйлдвэр	Шинжлэх ухаан, технологийн салбар	Нийтийн үйлчилгээ	Олон нийтийн зардал, хялбар, бөгөөд хөгжлийн салбар	Боловсрол	Эрдэмтлэмж, технологийн салбар	Урлаг, нийтийн үйлдвэр	Бусад үйлчилгээ	Бусад	Нийт
1 Газар тариалан, ой, усны аж ахуй	1.07892	0.01231	0.27743	0.02589	0.01456	0.03518	0.00428	0.00599	0.08809	0.00877	0.00307	0.00294	0.01286	0.01198	0.01174	0.02586	0.01470	0.01161	0.01738	0.00000	1.00449
2 Уул уурхай	0.00993	1.00235	0.00995	0.01224	0.00437	0.00384	0.00070	0.00383	0.00337	0.00189	0.00082	0.00247	0.00417	0.00144	0.00164	0.00120	0.00120	0.00110	0.00000	0.00000	1.00254
3 Үйлдвэрлэл	0.01160	0.04126	1.00004	0.07893	0.03658	0.10340	0.01433	0.01971	0.16987	0.03003	0.00987	0.00967	0.04419	0.03183	0.02852	0.05655	0.03459	0.03009	0.05117	0.00000	1.00794
4 Цахилгаан эрчим хүч, газ, хөргөлтийн систем	0.00798	0.02510	0.02677	1.74797	0.25609	0.04990	0.02144	0.01931	0.05353	0.03851	0.03788	0.02832	0.05325	0.12085	0.09324	0.07827	0.09432	0.14358	0.03663	0.00000	2.89705
5 Цэрэр болон ус, нөөг боловсруулал, засвар үйлчилгээ	0.00486	0.00624	0.00468	0.08209	1.30249	0.00982	0.00204	0.00300	0.01176	0.00536	0.00424	0.00330	0.00654	0.01371	0.00727	0.00878	0.01365	0.01587	0.00448	0.00000	1.91085
6 Барилгын салбар	0.00349	0.04253	0.00797	0.04722	0.01466	1.09012	0.00616	0.00738	0.01312	0.00874	0.00420	0.03892	0.01480	0.01167	0.01094	0.00738	0.00600	0.01262	0.00887	0.00000	1.35401
7 Бөөний болон жижиглэн, машин засвар	0.02647	0.00519	0.00501	0.00524	0.03823	0.13630	1.02287	0.10936	0.07692	0.04760	0.01426	0.01423	0.05072	0.05023	0.02947	0.02709	0.04591	0.02475	0.02871	0.00000	1.95329
8 Төгрөг, алт, мөнгө	0.01430	0.05074	0.01978	0.03139	0.04530	0.03603	0.05898	1.11109	0.02319	0.01767	0.01691	0.00952	0.00390	0.00024	0.02317	0.02039	0.01027	0.01653	0.03123	0.00000	1.00699
9 Булга, зөөл, хувийн үйлчилгээ	0.00328	0.01683	0.00408	0.00378	0.00877	0.00916	0.00897	0.00977	1.00645	0.01109	0.00931	0.00181	0.01912	0.02099	0.00770	0.00757	0.00700	0.02399	0.01737	0.00000	1.19162
10 Хялбар тариалан	0.00314	0.00990	0.00981	0.01013	0.00900	0.02576	0.01401	0.02626	0.01334	1.03238	0.01791	0.00803	0.00405	0.00894	0.02628	0.01240	0.00993	0.01827	0.02247	0.00000	1.36405
11 Самуц, даатгал	0.00778	0.00626	0.03849	0.01838	0.14548	0.03591	0.03018	0.05872	0.02350	0.01572	1.04417	0.00846	0.03360	0.06435	0.01361	0.01681	0.01085	0.01135	0.04302	0.00000	1.76518
12 Уламжлалт үйлдвэр	0.00702	0.00976	0.00889	0.00480	0.01027	0.01514	0.02776	0.01321	0.04006	0.03692	0.02827	1.07206	0.03113	0.07791	0.01560	0.00871	0.01362	0.02963	0.05474	0.00000	1.80269
13 Шинжлэх ухаан, технологийн салбар	0.00771	0.01472	0.00922	0.00978	0.01144	0.01769	0.01217	0.01939	0.02444	0.02329	0.02304	0.00987	1.06174	0.05433	0.11699	0.01650	0.01280	0.02585	0.04107	0.00000	1.81239
14 Нийтийн үйлчилгээ	0.00665	0.01861	0.00840	0.01725	0.02809	0.01584	0.01621	0.04717	0.04214	0.03448	0.01310	0.01327	0.06033	1.10783	0.07596	0.00618	0.00598	0.01732	0.01992	0.00000	1.50848
15 Олон нийтийн зардал, хялбар, бөгөөд хөгжлийн салбар	0.00950	0.00549	0.00209	0.00404	0.00872	0.01500	0.00364	0.00738	0.01351	0.01113	0.00103	0.00253	0.01561	0.01099	1.00341	0.00524	0.01292	0.00203	0.01472	0.00000	1.14743
16 Боловсрол	0.00918	0.00239	0.00954	0.00978	0.00958	0.00109	0.00049	0.00062	0.00113	0.00754	0.00192	0.00070	0.00163	0.00152	0.00165	1.00187	0.00083	0.00268	0.00426	0.00000	1.03240
17 Эрдэмтлэмж, технологийн салбар	0.00021	0.00171	0.00118	0.00070	0.00059	0.00493	0.00146	0.00393	0.00130	0.00203	0.00046	0.00034	0.00131	0.00119	0.00057	0.00050	1.00000	0.00080	0.00590	0.00000	1.02970
18 Урлаг, нийтийн үйлдвэр	0.00009	0.00074	0.00016	0.00029	0.00027	0.00034	0.00041	0.00141	0.00055	0.00051	0.00019	0.00022	0.00470	0.00213	0.00370	0.00033	0.00018	1.04722	0.00050	0.00000	1.00390
19 Бусад үйлчилгээ	0.00032	0.00094	0.00098	0.00133	0.00119	0.00120	0.00082	0.00302	0.00093	0.00354	0.00026	0.00032	0.00106	0.00254	0.00096	0.00105	0.00053	0.00150	0.04306	0.00000	1.06655
20 Бусад	0.00000	0.00000	0.00000	0.00000	0.00000	0.00000	0.00000	0.00000	0.00000	0.00000	0.00000	0.00000	0.00000	0.00000	0.00000	0.00000	0.00000	0.00000	0.00000	0.00000	1.00000
Нийт	1.29918	1.38084	1.49878	2.18116	1.93714	1.62178	1.24712	1.46806	1.60709	1.33858	1.22622	1.22150	1.52466	1.71222	1.44239	1.31074	1.30929	1.48784	1.44738	0.00000	1.00000

Эх сурвалж : Үндэсний статистикийн хорооны мэдээлэлд үндэслэн Жайка-ийн судалгааны баг боловсруулав.

Хүснэгт 5 Нөлөөллийн болон мэдрэмжийн коэффициент

	Нөлөөллийн коэффициент	Мэдрэмжийн коэффициент
Газар тариалан, ой, усны аж ахуй	0.858	1.138
Уул уурхай	0.944	0.720
Үйлдвэрлэл	1.091	1.305
Цахилгаан эрчим хүч, газ, хөргөлтийн систем	1.471	1.981
Цэвэр бохир ус, хог боловсруулах, засвар үйлчилгээ	1.325	1.033
Барилгын салбар	1.109	0.926
Бөөний болон жижиглэн, машин засвар	0.853	1.336
Тээвэр, агуулах	1.004	1.140
Зочид буудал, нийтийн хоолны үйлчилгээ	1.099	0.815
Холбоо харилцаа	0.913	0.933
Санхүү, даатгал	0.839	1.207
Үл хөдлөх хөрөнгө	0.835	1.028
Шинжлэх ухаан технологи, судалгаа	1.043	1.035
Нийтийн үйлчилгээ	1.171	1.066
Олон нийттэй харилцах алба, батлан хамгаалах, нийгмийн хангамж	0.986	0.785
Боловсрол	0.896	0.706
Эрүүл мэндийн даатгал, нийгмийн халамж	0.889	0.704
Урлаг, энтертаймент	0.997	0.728
Бусад үйлчилгээ	0.990	0.729
Бусад	0.684	0.684

Эх сурвалж : Үндэсний статистикийн хорооны мэдээлэлд үндэслэн Жайка-ийн судалгааны баг боловсруулав.

болж, үйдвэрлэлийн салбарын хувьд эцсийн хэрэглээний зарлагад нөлөөлөх нөлөөллийн коэффициент нь хамгийн өндөр байна. Ингэснээр хөрөнгө оруулалт болон хэрэглээг нэмэгдүүлснээр тухайн салбаруудын үйлдвэрлэлээ нэмэхэд гол үр дүнг үзүүлэх юм.

Аж үйлдвэрийн салбаруудыг хооронд нь харьцуулахад бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийн коэффициент нь хамгийн өндөр нь бол уул уурхайн салбар дараагийнх нь үйлдвэрлэлийн салбар, газар тариалан, ой, усны аж ахуйн салбар гэсэн дэс дараалалтай байна. Дээр бичсэнчлэн уул уурхайн салбар бол экспортоос ихээхэн хамаарч байна. Хэрэглээ болон хөрөнгө оруулалтыг нэмэх нь газар тариалан болон үйлдвэрлэлийн салбарт үр ашигтай

Хүснэгт 6 Үйлдвэрлэлтэнд нөлөөлөх хамаарал

		Үйлдвэрлэлтэнд нөлөөлөх хамаарал (%)			
		Эцсийн хэрэглээн ий зарлага	Дотоодын нийт үндсэн хөрөнгийн бүрдүүлэлт	Экспорт	Нийлбэр
1	Газар тариалан, ой, усны аж ахуй	38.56	45.00	16.44	100.00
2	Уул уурхай	0.73	2.88	96.39	100.00
3	Үйлдвэрлэл	57.43	13.61	28.95	100.00
4	Цахилгаан эрчим хүч, газ, хөргөлтийн систем	62.00	15.37	22.63	100.00
5	Цэвэр бохир ус, хог боловсруулах, засвар үйлчилгээ	55.26	15.32	29.42	100.00
6	Барилгын салбар	5.63	84.06	10.31	100.00
7	Бөөний болон жижиглэн, машин засвар	44.81	30.93	24.26	100.00
8	Тээвэр, агуулах	32.64	10.04	57.32	100.00
9	Зочид буудал, нийтийн хоолны үйлчилгээ	55.71	7.65	36.64	100.00
10	Холбоо харилцаа	65.84	12.08	22.07	100.00
11	Санхүү, даатгал	39.77	21.34	38.89	100.00
12	Үл хөдлөх хөрөнгө	89.68	4.31	6.01	100.00
13	Шинжлэх ухаан технологи, судалгаа	38.02	13.37	48.61	100.00
14	Нийтийн үйлчилгээ	59.18	10.98	29.83	100.00
15	Олон нийттэй харилцах алба, батлан хамгаалах, нийгмийн хангамж	93.94	2.84	3.22	100.00
16	Боловсрол	97.96	0.29	1.75	100.00
17	Эрүүл мэндийн даатгал, нийгмийн халамж	93.56	2.93	3.51	100.00
18	Урлаг, энтертаймент	94.10	1.20	4.70	100.00
19	Бусад үйлчилгээ	84.37	1.73	13.90	100.00
20	Бусад	100.00	0.00	0.00	100.00
	Нийлбэр	43.15	22.01	34.84	100.00

Эх сурвалж : Үндэсний статистикийн хорооны мэдээлэлд үндэслэн Жайка-ийн судалгааны баг боловсруулав.

Хүснэгт 7 Үйлдвэрлэлтэнд нөлөөлөх коэффициент

		Үйлдвэрлэлтэнд нөлөөлөх коэффициент			
		Эцсийн хэрэглээний зарлага	Дотоодын нийт үндсэн хөрөнгийн бүрдүүлэлт	Экспорт	Нийлбэр
1	Газар тариалан, ой, усны аж ахуй	0.1284	0.2345	0.0787	0.1426
2	Уул уурхай	0.0034	0.0211	0.6494	0.2009
3	Үйлдвэрлэл	0.2205	0.0818	0.1597	0.1644
4	Цахилгаан эрчим хүч, газ, хөргөлтийн систем	0.0511	0.0198	0.0268	0.0353
5	Цэвэр бохир ус, хог боловсруулах, засвар үйлчилгээ	0.0116	0.0050	0.0089	0.0090
6	Барилгын салбар	0.0148	0.3450	0.0388	0.1123
7	Бөөний болон жижиглэн, машин засвар	0.1344	0.1451	0.1045	0.1284
8	Тээвэр, агуулах	0.0558	0.0268	0.1406	0.0732
9	Зочид буудал, нийийн хоолны үйлчилгээ	0.0236	0.0051	0.0223	0.0181
10	Холбоо харилцаа	0.0393	0.0113	0.0189	0.0256
11	Санхүү, даатгал	0.0386	0.0324	0.0542	0.0415
12	Үл хөдлөх хөрөнгө	0.1284	0.0097	0.0124	0.0613
13	Шинжлэх ухаан технологи, судалгаа	0.0329	0.0181	0.0605	0.0371
14	Нийтийн үйлчилгээ	0.0328	0.0095	0.0237	0.0237
15	Олон нийттэй харилцах алба, батлан хамгаалах, нийгмийн хангамж	0.1167	0.0055	0.0057	0.0532
16	Боловсрол	0.1114	0.0005	0.0029	0.0487
17	Эрүүл мэндийн даатгал, нийгмийн халамж	0.0445	0.0022	0.0024	0.0204
18	Урлаг, энтертаймент	0.0124	0.0002	0.0009	0.0057
19	Бусад үйлчилгээ	0.0198	0.0006	0.0047	0.0101
20	Бусад	0.0004	0.0000	0.0000	0.0002
	Нийлбэр	1.2209	0.9745	1.4160	1.2116

Эх сурвалж : Үндэсний статистикийн хорооны мэдээлэлд үндэслэн Жайка-ийн судалгааны баг боловсруулав.

Нэмүү өртгийн нөлөөллийн үр дүнгийн өнцгөөс харахад нэмүү өртөгийн нөлөөллөөс хамаарах хамаарал нь эцсийн хэрэглээний зарлагад хамгийн их, жишээлбэл үйлдвэрлэлийн салбарт 57 хувь, бөөний болон жижиглэнгийн салбар 45 хувь байна. Экспортоос хамаарах хамаарал ихтэй уул уурхайн бүтээгдэхүүний 96 хувь нь гадгашаа гарч байна. Газар тариалан, ой, усны аж ахуйн салбар бол дотоодын нийт үндсэн хөрөнгийн бүрдүүлэлтээс хамаарах хамаарал нь өндөр байна (Хүснэгт 11).

Нэмүү өртөгт нөлөөлөх коэффициент нь бүтээгдэхүүн үйлдвэрлэх коэффициенттэй адил экспорт нь нэлээд өндөр, эцсийн хэрэглээний зарлага, дотоодын нийт үндсэн хөрөнгийн бүрдүүлэлт гэсэн дэс дараалалаар явж байна. Экспортыг нэмэгдүүлэх нь

GDP өсөлтөнд хамгийн үр дүнтэй . Мөн үйлдвэрлэлийн нөлөөлөлтэй адил эцсийн эрэлтийг нэгтгэн харахад уул уурхайн салбарт нөлөөллийн коэффициент нэлээд өндөр, дараа нь газар тариалан, ой, усны аж ахуйн салбар , бөөний болон жижиглэнгийн салбар, үйлдвэрлэлийн салбар гэсэн дэс дараалалтай байна. Гэвч өмнө нь бичсэнчлэн экспорын талаас илүү хувийг уул уурхайн салбар эзлэж байгаа учир уул уурхайн экспорт эдийн засгийн хөгжилд үзүүлэх нөлөө нэлээд өндөр байна. Голлох салбар хэтэрхий гадаад эрэлтээс хамаарсан гажуу бүтэцтэй болж байгааг дээрх аж үйлдвэрийн дүн шинжилгээр тодорхой болж байна.

Хүснэгт 8 Нэмүү өртөгт нөлөөлөх хамаарлын хэмжээ

		Нэмүү өртөгт нөлөөлөх хамаарлын хэмжээ (%)			
		Эцсийн хэрэглэний зарлага	Дотоодын нийт үндсэн хөрөнгийн бүрдүүлэлт	Экспорт	Нийлбэр
1	Газар тариалан, ой, усны аж ахуй	38.56	45.00	16.44	100.00
2	Уул уурхай	0.73	2.88	96.39	100.00
3	Үйлдвэрлэл	57.43	13.61	28.95	100.00
4	Цахилгаан эрчим хүч, газ, хөргөлтийн систем	62.00	15.37	22.63	100.00
5	Цэвэр бохир ус, хог боловсруулах, засвар үйлчилгээ	55.26	15.32	29.42	100.00
6	Барилгын салбар	5.63	84.06	10.31	100.00
7	Бөөний болон жижиглэн, машин засвар	44.81	30.93	24.26	100.00
8	Тээвэр, агуулах	32.64	10.04	57.32	100.00
9	Зочид буудал, нийтийн хоолны үйлчилгээ	55.71	7.65	36.64	100.00
10	Холбоо харилцаа	65.84	12.08	22.07	100.00
11	Санхүү, даатгал	39.77	21.34	38.89	100.00
12	Үл хөдлөх хөрөнгө	89.68	4.31	6.01	100.00
13	Шинжлэх ухаан технологи, судалгаа	38.02	13.37	48.61	100.00
14	Нийтийн үйлчилгээ	59.18	10.98	29.83	100.00
15	Олон нийттэй харилцах алба, батлан хамгаалах, нийгмийн хангамж	93.94	2.84	3.22	100.00
16	Боловсрол	97.96	0.29	1.75	100.00
17	Эрүүл мэндийн даатгал, нийгмийн халамж	93.56	2.93	3.51	100.00
18	Урлаг, энтертаймент	94.10	1.20	4.70	100.00
19	Бусад үйлчилгээ	84.37	1.73	13.90	100.00
20	Бусад	100.00	0.00	0.00	100.00
	Нийлбэр	44.36	21.26	34.38	100.00

Эх сурвалж : Үндэсний статистикийн хорооны мэдээлэлд үндэслэн Жайка-ийн судалгааны баг боловсруулав.

Хүснэгт 9 Нэмүү өртөгт нөлөөлөх коэффициент

		Нэмүү өртөгт нөлөөлөх коэффициент			
		Эцсийн хэрэглээний зарлага	Дотоодын нийт үндсэн хөрөнгийн бүрдүүлэлт	Экспорт	Нийлбэр
1	Газар тариалан, ой, усны аж ахуй	0.0998	0.1822	0.0611	0.1108
2	Уул уурхай	0.0022	0.0138	0.4237	0.1311
3	Үйлдвэрлэл	0.1042	0.0387	0.0755	0.0777
4	Цахилгаан эрчим хүч, газ, хөргөлтийн систем	0.0155	0.0060	0.0081	0.0107
5	Цэвэр бохир ус, хог боловсруулах, засвар үйлчилгээ	0.0045	0.0020	0.0034	0.0035
6	Барилгын салбар	0.0069	0.1603	0.0180	0.0522
7	Бөөний болон жижиглэн, машин засвар	0.1031	0.1113	0.0801	0.0985
8	Тээвэр, агуулах	0.0310	0.0149	0.0781	0.0406
9	Зочид буудал, нийтийн хоолны үйлчилгээ	0.0123	0.0026	0.0116	0.0094
10	Холбоо харилцаа	0.0284	0.0082	0.0137	0.0185
11	Санхүү, даатгал	0.0314	0.0264	0.0441	0.0338
12	Үл хөдлөх хөрөнгө	0.1047	0.0079	0.0101	0.0500
13	Шинжлэх ухаан технологи, судалгаа	0.0180	0.0099	0.0331	0.0203
14	Нийтийн үйлчилгээ	0.0137	0.0040	0.0099	0.0099
15	Олон нийттэй харилцах алба, батлан хамгаалах, нийгмийн хангамж	0.0757	0.0036	0.0037	0.0345
16	Боловсрол	0.0847	0.0004	0.0022	0.0370
17	Эрүүл мэндийн даатгал, нийгмийн халамж	0.0350	0.0017	0.0019	0.0160
18	Урлаг, энтертаймент	0.0084	0.0002	0.0006	0.0038
19	Бусад үйлчилгээ	0.0125	0.0004	0.0030	0.0063
20	Бусад	0.0004	0.0000	0.0000	0.0002
	Нийлбэр	0.7923	0.5943	0.8820	0.7648

Эх сурвалж : Үндэсний статистикийн хорооны мэдээлэлд үндэслэн Жайка-ийн судалгааны баг боловсруулав.

4 дүгээр бүлэг: Хавсралт материал

Хавсралт материал 4.1.1 Аймаг болон аймгийн төвийн хөгжлийн бодлого, төлөвлөгөө

	Баруун бүс					Хангайн бүс
	Баян-Өлгий аймаг	Говь-Алтай аймаг	Завхан аймаг	Увс аймаг	Ховд аймаг	
	<p>Баруун бүсийн хөгжлийн хөтөлбөр үндсэн үзэл баримтлал: Хүрээ эрхэмтэн дээдлэн, байгаль орчмыхоо онцлолт зомцсон, мэдлэг, мэдээллийн технологи, шинжлэх ухааны ололтод суурилсан, өндөр өсөлттэй, өөрийгөө гэтгэдэг, оновчтой бүтэц бүхий эдийн засагтай бүс болоход оршиж байна. I үе шат (2006-2010)-ны эцэст бизнесийн үйл ажиллагаа идэвхжиж, эдийн засгийн өндөр өсөлтийг хангах тааламжтай нөхцөл бүрдэхийн зэрэгтээ экспортын үйлдвэрлэл, үйлчилгээ өргөжиж, эдийн засгийн бүтэц аажим үйлдвэрийн эзлэх байр суурь сайжирч, эрдэс баялагийн үйлдвэрлэл, үйлдвэрлэл, технологийн парк, худалдаа, эдийн засгийн чөлөөт бүсүүд байгуулагдах, дотоодын нийт бүтээгдэхүүний жилийн дундаж өсөлт 20.0 хувиас доошгүй байх боломжтой байна. Ялангуяа Баян-Өлгий аймгийн Асгатын мөнгөний, Завхан аймгийн Баян-Айргийн эсэ, алтны, Ховд аймгийн Мянгадын газрын ховор элементийн зэрэг эрдэс баялагийн орд газруудад түшиглэсэн олборлох үйлдвэрүүд ашиглагддаг орсноор Баруун бүсийн эдийн засгийн хөгжилд томоохон өөрчлөлт гаргах болно. Мөн түүнчлэн Доргоной болон Тайширын усан хамилсан станц, хэвтээ, босоо гэнхсэгийн авто зам ашиглагддаг орно. Дотоодын нийт бүтээгдэхүүнд аж үйлдвэрийн салбарын эзлэх хувийн жил 9 дахин өсөж, ялангуяа уул уурхайн үйлдвэрлэл өндөр ач холбогдолтой байх болно. Энэ үе шатанд хүн амын ядуурлыг Мянгааны хөгжлийн зорилгод дэвшүүлсний дагуу 1998 оны түвшингээс 30 хувиар бууруулах боломж бүрдэнэ. II үе шат (2011-2015 он)-ны эцэст эдийн засгийн бүтэц ихсэхэн сайжирч, дэвшилтэт техник, технологи, менежмент бүхий үйлдвэрлэл, технологийн паркийн үйлдвэрлэл, үйлчилгээ олон мэдлэгт суурилсан эдийн засгийн үндэс суурь тавигдах ба өмнөх шатанд байгуулагдсан уул уурхайн болон боловсруулах салбарын үйлдвэрүүдийн үйл ажиллагаа жилдэхийн зэрэгтээ Говь-Алтайн Талын мөлтсийн алтны орд зэрэг өндөр үр ашгтай үйлдвэрүүд шивсгэр ашиглагддаг орох болно. Бүсийн дотоодын нийт бүтээгдэхүүн жилд дунджаар 9.7 орчим хувиар тогтвортой өсөх төлөвтэй байна. Бүсийн аж үйлдвэрийн бүтээгдэхүүний жилийн дундаж өсөлт 11.7 хувьтай байгаа байна. Ажилгүйдэл эрс багасч, ядуурал 1998 оны түвшингээс 2 дахин бууран нийгмийн олон асуудлыг бүс биеэ даан шийдэх боломж бүрдэнэ.</p>					
Хүн ам (мян.хүн)*1	93.2	56.7	69.6	75.7	81.5	
Хүн амын нягтшил (хүн/км2) *2	2.1	0.4	0.9	1.1	1.1	
Сумын тоо*2	13	18	24	19	17	
ДНБ(100 сая MNT) *2	3040,480	2239,634	3268,263	2969,937	3030,016	
Аж үйлдвэр (ДНБ)*3 1) ХАА 2) Аж үйлдвэр, барилга 3) Худалдаа, зочид буудал, нийтийн хоол 4) Тээвэр, мэдээлэл, холбоо 5) Банк, санхүү, бизнес 6) Бусад	41.2% 12.5% 13.1% 6.8% 6.7% 19.8%	57.9% 6.7% 6.1% 1.4% 7% 20.9%	63.9% 13.4% 2.8% 1.6% 5.2% 13.1%	50.2% 12.5% 9.7% 2.6% 7.2% 17.8%	49.5% 15.1% 6.8% 3.3% 5.7% 19.6%	
Аймгийн урт хугацааны хөгжлийн бодлогын бичиг баримт, батлагдсан он	Баян-Өлгий аймгийн хөгжлийн хөтөлбөр (2010-2021) 2009 онд батлагдсан.	Говь-Алтай аймгийн хөгжлийн цогц бодлого 2006 онд батлагдсан	Завхан аймгийн нэгдсэн бодлого (2009~2021) 2008 онд батлагдсан	Увс аймгийн хөгжлийн стратегийн хөтөлбөр 2008 онд батлагдсан.	Ховд аймгийн хөгжлийн стратеги (2015-2025) 2014 онд батлагдсан	Архангай 2
Аймгийн урт хугацааны хөгжлийн чиг хандлага	1 үе шат (2010~2016) ДНБ 18% доошгүйгээр өсөөгийн зэрэгтээ, экспортын үйлдвэрлэл, аялал жуулчлалын эзлэх байр суурь нэмэгдэнэ. Ажилгүйдлийн түвшин 20% буурна. II үе шат (2016~2021) ДНБ дундаж өсөлт 20% доошгүй болж, экспортын бүтээгдэхүүн үйлдвэрлэл нэмэгдэж, орчин үеийн аж үйлдвэр -ХАА гэсэн загварт шилжинэ.	1) Аймгт мянгааны хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлж, хүнийг бүх талаар хөгжүүлэнэ. 2) Өрсөлдөх чадвартай, экспортын баримжаатай үйлдвэрлэл,үйлчилгээг хөгжүүлэнэ. 3) Зам тээвэр, эрчим хүч, мэдээлэл холбооны дэд бүтцийг хөгжүүлэнэ. 4) Аймгийн төв, сумдын төвүүдийг хөгжүүлж хот, хөдөөгийн хөгжлийн түвшний ялгааг багасгана. 5) Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон чадавхийг бий болгон нөлжилтийг сааруулж, экосистемийн гэнхвэрт байдлыг хадгална.	1) Аймгт мянгааны хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлж, хүнийг бүх талаар хөгжүүлэнэ. 2) Өрсөлдөх чадвартай, экспортын баримжаатай үйлдвэрлэл,үйлчилгээг хөгжүүлэнэ. 3) Зам тээвэр, эрчим хүч, мэдээлэл холбооны дэд бүтцийг хөгжүүлэнэ. 4) Аймгийн төв, сумдын төвүүдийг хөгжүүлж хот, хөдөөгийн хөгжлийн түвшний ялгааг багасгана. 5) Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон чадавхийг бий болгон нөлжилтийг сааруулж, экосистемийн гэнхвэрт байдлыг хадгална.	1. Оюунлаг хүний хөгжлийг хангах 2.Санхүүгийн удирдлага хяналтыг сайжруулан, бие даан өөрийгөө санхүүжүүлэх нөхцөл бүрдүүлэх 3.ХАА, байгалийн гэрэлтэй экспортын баримжаатай боловсруулах аж үйлдвэр хөгжүүлэх 4. Уул уурхай, ашигт малтмалын олборлох, боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлэх 5. Эрчимжсэн МАА, газар тариалан, аялал жуулчлал хөгжүүлэх,бренд бүтээгдэхүүн тэй болох 6. Эрчим хүч, зам тээвэр гм дэд бүтцийн үйлчилгээг хүртээмжтэй болгож хөгжлийн орчин бүрдүүлэх 7. Хөрш болон дэлхийн өндөр хөгжилтэй орнуудын шинжлэх ухаан, технологийн ололтыг импортлох зорилтыг эрхэмлэх 8. Байгалийн гэнхвэрийг хадгалж зохицтой ашиглаж, нөхөн сэргээхэд чиглэсэн бодлогыг иргэдийн оролцоонд	1) Хүн амын тогтвортой өсөлт 2) Боловсрол, эрүүл мэнд 3) Олон үндэстэн астын өлгий Алтай нутгийн эдийн засаг, соёл, аялал жуулчлалын төв болно 4) Байгаль орчинтой зохицон амьдарна 5) Иргэдэн нээлттэй ухаалаг засаглал бий болгох 6) Амьдрах орчин 7) Уламжлалт МАА,үйлдвэрлэлийн тогтвортой хөгжил 8) Аж үйлдвэрийн кластер хөгжил 9) Дэд бүтцийн хөгжил	1) Аймгт мянгааны хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлж, хүнийг бүх талаар хөгжүүлэнэ. 2) Өрсөлдөх чадвартай, экспортын баримжаатай боловсруулах аж үйлдвэрлэл, аялал жуулчлалын төв болно 4) Байгаль орчинтой зохицон амьдарна 5) Иргэдэн нээлттэй ухаалаг засаглал бий болгох 6) Амьдрах орчин 7) Уламжлалт МАА,үйлдвэрлэлийн тогтвортой хөгжил 8) Аж үйлдвэрийн кластер хөгжил 9) Дэд бүтцийн хөгжил
Аймгийн дунд хугацааны хөгжлийн хөтөлбөр	Засаг даргын 2012-2016 оны мөрийн хөтөлбөр (2013 он ИТХ 77 тогтоол)	Аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн чиг хандлага 2015 он (2014 он 12 сард батлагдсан)	Завхан аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн чиг хандлага 2014 он	Увс аймгийн хөгжлийн стратегийн хөтөлбөрийн хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө	2013 онд аймгийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулагдсан	
Аймгийн дунд хугацааны хөгжлийн чиг хандлага	1.Ажлын байр, орлого нэмэгдүүлэх 2.Эрүүл мэнд 3.Боловсрол 4.Тайван нийгэм, орчин Эрх чөлөөт иргэд	1.Орон нутгийн төсвийн үр ашгийг нэмэгдүүлэх, нл тод байлгах, дотоод аудит сайжруулах 2.Туегай аж үйлдвэрийн хөгжлийн дэмжлэг (уул уурхай, ХАА, хүнсний боловсруулалт, хот байгуулалт) 3. Байгаль орчин хамгаалал 4.Нийгмийн хөгжил	1.Эдийн засгийн бодлого 2.Дэд бүтэцХот байгуулалт, сумын хөгжил 3.Нийгмийн хөгжил 4.Орон нутгийн засаг захиргаа 5.Байгаль орчин, хууль эрх зүй, батлан хамгаалах			
Аймгийн төв	Өлгий хот	Алтай хот (Есөнбулаг сум)	Улиастай хот (Улиастай сум)	Улаангом хот (Улаангом сум)	Ховд хот (Ховд сум)	Цэндэрлэг
Аймгийн төвийн хүл ам	30,404	19,053			26,343	
Аймгийн төвийн ДНБ						
Аймгийн төвийн голлох аж үйлдвэр	Барилга (тоосго, хөнгөн аж үйлдвэр (хүнсний боловсруулалт)					
Аймгийн төвийн ерөнхий төлөвлөгөөний боловсруулалтын байдал	2013 оны улсын төсөв (явц 90%)	2014 оны улсын төсөв (явц 90%)	2005 онд боловсруулагдсан	2014 оны улсын төсөв (явц 40%)	2013 оны улсын төсөв (явц 90%)	2008 онд бол
Аймгийн төвийн ирээдүйн хүн амын таамаглал						
Аймгийн төвийн ерөнхий төлөвлөгөөний хөгжлийн чиг хандлага						
Бусад	ET тодотгол хийгдэж буй					

Монгол Улсын Бүсчилсэн Хөгжлийн Нэгдсэн Судалгаа
Эцсийн тайлан (дэлгэрэнгүй)

	Хангайн бүс						Төвийн бүс
	Архангай	Баянхонгор	Булган	Орхон	Өвөрхангай	Хөвсгөл	Говьсүмбэр
	<p>Хангайн бүсийн хөгжлийн хөтөлбөрийн үндсэн үзэл баримтлал : Хангайн бүсийн эдийн засгийн тогтвортой түргэн хөгжүүлэх, эдийн засгийн салбарын бүтцийг боловсруулах болгоно. 1 үе шат(2006-2010) Бизнес эрхлэх таатай орчин бүрдүүлж, бүсийн дотоодын нийт бүтээгдэхүүний жилийн дундаж өсөлтийг 10 хувьд хүргэнэ. Хангайн бүсийн хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн одоогийн бүтэц зохион байгуулалтыг зах зээлийн эрэлт шаардлагад нийцүүлэн боловсруулах болж, менежментийг сайжруулана. Бүсийн мал аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хэмжээ 2005 онтой харьцуулахад жилд дундаар 10 хувиар өснө. Бүсийн хүн амын гурилын хэрэгцээний 70 хувь, төмс, хүнсний ногооны хэрэгцээг өөрийн үйлдвэрлэлээр бүрэн хангана. 2 үе шат (2011~2015) Бүсийн аж үйлдвэр, үйлчилгээний салбарын бүтээгдэхүүний хэмжээг тогтвортой нэмэгдүүлж, эдийн засгийн салбарын бүтцийг улам боловсруулах болгоно. Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг эрчимжүүлж, материал, түүхий эдэл гүн боловсруулалт хийж, зах зээлд өрсөлдөх чадвартай эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хэмжээ, нэр төрөл нэмэгдэнэ. Бүсийн эрдэс түүхий эдийн нөөц, баялгийг эдийн засгийн эргэлтэд шат дараалан оруулж, уул уурхайн салбарын бүсийн хөгжилд оруулах хувь нэмрийг нэмэгдүүлнэ. Аялал жуулчлалын бүх төрлийг хөгжүүлж, бүсийн эдийн засагт салбарын эзлэх байр суурийг нэмэгдүүлж, үйлчилгээний чанар, менежментийг нь олон улсын стандартын түвшинд хүргэж сайжруулана. Байгаль орчинд хөргүй, үр ашгатай эрчим хүчний техник, технологи нэвтрүүлж, үйлдвэрлэл, хэрэглээний үр ашгийг дээшлүүлнэ.</p>						
Хүн ам (мян.хүн)*1	92.9	82.9	60.3	92.7	112.6	126	
Хүн амын нягтшил (хүн/км2) *2	1.7	0.7	1.2	118.0	1.8	1.3	
Сумын тоо*2	19	20	16	2	19	23	
ДНБ(100 сая MNT) *2	3939,147	3314,914	3157,387	11975,584	3897,185	4639,855	900
Аж үйлдвэр (ДНБ)*3							
1) ХАА	63.8%	57.2%	65.9%	1.5%	52.9%	50.9%	24
2) Аж үйлдвэр, барилга	13.5%	10.5%	15.3%	86.1%(бизнес)	13.9%	17.5%	42
3) Хуудалдаа, зочид буудал, нийтийн хоол	2.8%	6.6%	1.4%	5%	6.5%	8.9%	5
4) Тээвэр, мэдээлэл, холбоо	1.6%	3.6%	0.9%	2.7%	3.1%	2.6%	0
5) Банк, санхүү, бизнес	1.6%	6.3%	4.7%	1%	7.2%	6.3%	8
6) Бусад	16.7%	15.8%	11.9%	3.7%	16.3%	13.8%	18
Аймагын урт хугацааны хөгжлийн бодлогын бичиг баримт, батлагдсан он	Архангай аймагын хөгжлийн стратеги (2011-2021) 2011 онд батлагдсан	Баянхонгор аймагын хөгжлийн хөтөлбөр (2006-2020) 2006 онд батлагдсан	Булган аймагын хөгжлийн цогц бодлого(2010-2021) 2010 онд батлагдсан	Орхон аймагын хөгжлийн цогц бодлого(2009-2021) 2009 онд батлагдсан	Өвөрхангай аймагын хөгжлийн бодлого (2007-2015) 2006 онд батлагдсан	Хөвсгөл аймагийн нийгэм, эдийн засгийн хөгжүүлэх хөтөлбөр (2008-2015) 2008 онд батлагдсан	Говьсүмбэр аймагын цогц бодлого 2010 онд
Аймагын урт хугацааны хөгжлийн чиг хандлага	1) Аймагт мянганы хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлж, хүнийг бүх талаар хөгжүүлнэ. 2) Өрсөлдөх чадвартай, экспортын баримжаатай үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлнэ. 3) Зам тээвэр, эрчим хүч, мэдээлэл холбооны дэд бүтцийг хөгжүүлнэ. 4) Аймагийн төв, сумдын төвүүдийг хөгжүүлж хот, хөдөөгийн хөгжлийн түвшний ялгааг багасгана. 5) Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицон чадавхийг бий болгон цөлжилтийг сааруулж, экосистемийн тэнцвэрт байдалыг хадгална.	1) Эдийн засгийн тогтвортой хөгжил, ядуурлыг бууруулах 2) ЖДҮ, дэд бүтэц, хот байгуулалт, аялал жуулчлал хөгжүүлэх 3) Боловсрол, соёл 4) МАА, газар тариалан, байгаль орчин, газрын харилцааны хөгжил 5) Эрүүл мэнд, спорт, нийгмийн хамгаалал	1) Аймагт мянганы хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлж, хүнийг бүх талаар хөгжүүлнэ. 2) Өрсөлдөх чадвартай, экспортын баримжаатай үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлнэ. 3) Зам тээвэр, эрчим хүч, мэдээлэл холбооны дэд бүтцийг хөгжүүлнэ. 4) Аймагийн төв, сумдын төвүүдийг хөгжүүлж хот, хөдөөгийн хөгжлийн түвшний ялгааг багасгана. 5) Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицон чадавхийг бий болгон цөлжилтийг сааруулж, экосистемийн тэнцвэрт байдалыг хадгална.	1) Аймагт мянганы хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлж, хүнийг бүх талаар хөгжүүлнэ. 2) Өрсөлдөх чадвартай, экспортын баримжаатай үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлнэ. 3) Зам тээвэр, эрчим хүч, мэдээлэл холбооны дэд бүтцийг хөгжүүлнэ. 4) Аймагийн төв, сумдын төвүүдийг хөгжүүлж хот, хөдөөгийн хөгжлийн түвшний ялгааг багасгана. 5) Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицон чадавхийг бий болгон цөлжилтийг сааруулж, экосистемийн тэнцвэрт байдалыг хадгална.	1) Уул уурхайн үйлдвэрлэл 2) Бэлчээрийн МАА хадгалж, эрчимжсэн МАА төв суурин газар дагуулан хөгжүүлэх 3) Усалгаатай газар тариаланг түлжүү эрхлэн, үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ. 4) Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийг сэргээн хөгжүүлэх 5) ЖДҮ хөгжүүлэх 6) Аялал жуулчлалыг хөгжүүлэх 7) Иргэн бүрийн сурч боловсрох нөхцлийг хангаж, чанартай боловсрол эзэмшүүлнэ 8) Эрүүд аж төрөх нөхцөлийг бүрдүүлнэ	1) Аймагт мянганы хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлж, хүнийг бүх талаар хөгжүүлнэ. 2) Өндөр технологи, мэдээлэл, био, нано технологи, тээвэр, санхүүгийн зуучлал, уул уурхай, ХАА бүтээгдэхүүнийг боловсруулахад чиглэсэн үйлдвэрлэл үйлчилгээ 3) Сэргээгдэх эрчим хүч хөгжүүлэх 4) Стратегийн орд газруудыг ашиглан, орчин үеийн боловсруулах үйлдвэр хөгжүүлэх 5) Сумын дэд бүтцийг хөгжүүлэх 6) Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох 7) Авиалгал, хүнд суртлаас ангид, ид, тэд, харилцаатай тогтолцоог бүрдүүлнэ.	1) Аймагт мянганы хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлж, хүнийг бүх талаар хөгжүүлнэ. 2) Өрсөлдөх чадвартай, экспортын баримжаатай үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлнэ. 3) Зам тээвэр, эрчим хүч, мэдээлэл холбооны дэд бүтцийг хөгжүүлнэ. 4) Аймагийн төв, сумдын төвүүдийг хөгжүүлж хот, хөдөөгийн хөгжлийн түвшний ялгааг багасгана. 5) Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицон чадавхийг бий болгон цөлжилтийг сааруулж, экосистемийн тэнцвэрт байдалыг хадгална.
Аймагын дунд хугацааны хөгжлийн хөтөлбөр							Говьсүмбэр аймагын хөгжлийн хөтөлбөр (2003-2020) 2003 онд батлагдсан
Аймагын дунд хугацааны хөгжлийн чиг хандлага			1) ХАА 2) Аж үйлдвэр 3) Аялал жуулчлал 4) Дэд бүтэц 5) Банк, санхүү				1) Нүүрсний уурхайн үйлдвэрлэл, хийн үйлдвэрлэл 2) Бүтээгдэхүүнийг боловсруулах эрчим хүч, технологийн хөгжүүлэлт, нөхцөл байдалын боловсруулалт
Аймагын төв	Цэндэрэг хот (Эрдэнэбулган)	Баянхонгор сум	Булган хот (Булган сум)	Эрдэнэт хот (Баян-Өлгий сум)	Арвайсээр хот	Мөрөн хот	Чайр хот
Аймагын төвийн хүн ам				97,367			11
Аймагын төвийн ДНБ							
Аймагын төвийн гэгдэх аж үйлдвэр				уул уурхай, хүнд үйлдвэр			
Аймагын төвийн ерөнхий төлөвлөгөөний боловсруулалтын байдал	2008 онд боловсруулагдсан	2013 оны улсын төсөв (явц 70%)	2012 онд боловсруулсан	2005 онд боловсруулсан	2009 онд боловсруулагдсан	2011 онд орон нутгийн төсвөөр боловсруулсан (явц 70%)	2014 онд боловсруулсан (явц 70%)
Аймагын төвийн ирээдүйн хүн амын таамаглал							2020 оны хүн амын таамаглал
Аймагын төвийн ерөнхий төлөвлөгөөний хөгжлийн чиг хандлага				Уул уурхайн мэдлэг, технологийн төв болох хөгжих			
Бу сад				ЕТ тодотгол хийгдэж буй		Тариалан сумын эдийн засаг, нийгмийн хөгжлийн хөтөлбөр (2007-2015) 2007 батлагдсан	

**Монгол Улсын Бүсчилсэн Хөгжлийн Нэгдсэн Судалгаа
Эцсийн тайлан (дэлгэрэнгүй)**

	Төвийн бүс							Улаанбаатар	Үүн бүс
	Говьсүмбэр	ДарханУул	Дорноговь	Дундговь	Өмнөговь	Сэлэнгэ	Төв		
	<p>Төвийн бүсийн хөгжлийн гол стратеги нь хүнээ эрхэмтэж дээдэлсэн, байгаль орчныхоо онцгогт зохиосон, мэдлэг, мэдээллийн технологи, шинэчлэх ухааны ололтод суурилсан, өндөр өсөлттэй, өөрийгөө тэтгэдэг, өнөрчтөй бүтэц бүхий эдийн засагтай бүс болоход оршиж байна. 1 үе шат (2006-2010 он)-ны эцэст бизнесийн үйл ажиллагаа идэвхжиж, эдийн засгийн өндөр өсөлтийг хангах тааламжтай нөхцөл бүрдэхийн зэрэгтээ экспортын үйлдвэрлэл, үйлчилгээ өргөжиж, эдийн засгийн бүтэцтэй аж үйлдвэрийн эзлэх байр суурь нэмэгдэж, үйлдвэрлэл, технологийн парк, худалдаа, эдийн засгийн чөлөөт бүсүүд байгуулагдаж, дотоодын нийт бүтээгдэхүүний жилийн дундаж өсөлт 25-аас доошгүй хувь байх боломжтой байна. Ялангуяа Оюутолгой, Цагаансуваргын эс, алт, мөнгөний, Сэлэнгийн Төмөртэйн төмрийн хүдрийн, Тавантолгойн нүүрсний орд газруудыг өнөрчтөй эзэмшиж эхэлснээр аж үйлдвэр, түүний дотор уул уурхайн үйлдвэрлэлийн эдийн засгийн өсөлтөд зүүрэх нөлөөлөл өндөр байх болно. Энэ үе шатад хүн амын ядуурал 1998 оны түвшингээс 30 хүртэл хувиар буурах боломжтой.</p> <p>II үе шат (2011-2015 он)-ны эцэст эдийн засгийн бүтэц ихсэхэн сайжирч, дэвшилтэт техник, технологи, менежмент бүхий үйлдвэрлэл, технологийн паркийн үйлдвэрлэл, үйлчилгээ өсч, уул уурхайн болон боловсруулах салбарын зарим үйлдвэрүүд ашиглалтад орж, мэдлэгт суурилсан эдийн засгийн үндэс суурь тавигдан, дотоодын нийт бүтээгдэхүүн жилд дундаар 20 орчим хувиар өсч, ажилгүйдэл, ядуурал эрс буурна. Энэ үе шатад ядуурал 1998 оны түвшингээс 2 дахин буурах боломжтой.</p>								
Хүн ам (мян.хүн)*1	15.9	97.3	63.5	44.2	59.7	105.3	90.0	1,314.5	
Хүн амын нягтшил	2.9	30.3	0.6	0.6	0.4	2.6	1.2	290.0	
Сумын тоо*2	3	4	14	15	15	17	27	9	
ДНБ(100 сая MNT) *2	900,135	4158,708	3305,105	2290,325	5745,309	5861,230	4843,489	133298,797	
Аж үйлдвэр (ДНБ)*3 1) ХАА 2) Аж үйлдвэр, барилга 3) Худалдаа, зочид буудал, нийтийн хоол 4) Тээвэр, мэдээлэл, холбоо 5) Банк, санхүү, бизнес	24.4% 42.4% 5.6% 0.5% 8.5% 18.6%	13.3% 39.7% 15.5% 3.4% 11.4% 16.7%	63.9% 13.4% 2.8% 1.6% 5.2% 13.1%	62.5% 9.8% 4.6% 2.5% 6.5% 14.1%	19.9% 59.5% 3.7% 4.9% 5.3% 6.8%	33.7% 43.6% 4.7% 2.9% 5.8% 9.4%	65.9% 12.7% 3.7% 0.8% 5.9% 11.0%	0.4% 36.2% 25.9% 10.6% 16.5% 10.3%	
Аймгийн урт хугацааны хөгжлийн бодлогын бичиг баримт, батлагдсан он	Говьсүмбэр аймгийн хөгжлийн ноц бодлого (2010-2021) 2010 онд батлагдсан	Дархан-Уул аймгийн хөгжлийн ноц бодлого (2009-2021) 2009 онд батлагдсан	Дорноговь аймгийн хөгжлийн мастер төлөвлөгөө (2011-2021) 2011 онд батлагдсан	Дундговь аймгийн 2020 он хүртэлх хөгжлийн бодлого (2003-2020) 2003 онд батлагдсан	Байгалийн баялаг—Сайн засаглал—Хөгжсөн Өмнөговь аймгийн хөгжлийн хөтөлбөр (2010-2020) 2009 онд батлагдсан	Сэлэнгэ аймгийн хөгжлийн хөтөлбөр (2007-2021) 2007 онд батлагдсан	Төв аймгийн хөгжлийн хөтөлбөр (2008-2023) 2008 онд батлагдсан		Дорнод аймгийн хөгжлийн хөтөлбөр 2009 онд батлагдсан
Аймгийн урт хугацааны хөгжлийн чиг хандлага	1) Аймгт мянган хөгжлийн зорилгуудыг хэрэгжүүлж, хүнийг бүх талаар хөгжүүлэх. 2) Өрсөлдөх чадвартай, экспортын баримжаатай үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэх. 3) Зам тээвэр, эрчим хүч, мэдээлэл холбооны дэд бүтцийг хөгжүүлэх. 4) Аймгийн төв, сумдын төвүүдийг хөгжүүлж хот, хэдөөгийн хөгжлийн түвшний ялгааг багасгах. 5) Уур амьсгалын өөрчлөлтөд даасан зохиосон чадвартай бай болгон нөлөөллийг сааруулж, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгана.	1) Ядуурал, ажилгүйдлийг бууруулах, нийгмийн халамж, боловсрол, эрүүл мэндийн тогтоомж сайжруулах 2) Аж үйлдвэрлэлийн хөгжил (уул уурхайн боловсруулах үйлдвэр, барилгын материал гм аж үйлдвэрийн парк, ХАА, аялал жуулчлал) 3) Дэд бүтэц, хот байгуулалт 4) Байгаль орчны бохирдлыг бууруулах, байгалийн гамшиг, уур амьсгалын өөрчлөлт, нөлөөллийн сааруулах нөлөөллийг сааруулах	1) Хүнд аж үйлдвэр, уул уурхайн олборлох, боловсруулах үйлдвэрлэл, эрчимжсэн мал аж ахуй, хоршоо, ЖДҮ, зам тээврийн үйлчилгээ, аялал жуулчлалын салбарыг түлхүү хөгжүүлэх 2) Нийгмийн үйлчилгээний байгууллагуудын хүчин чадлыг өргөтгөх, үйлчилгээний чанар, хүргэмжийг дээшлүүлэх 3) Хүрээлэн байгаа орчны аюулгүй тогтвортой байдлыг хангах 4) Төрийн албаны төлөвшлэж, түүний нэ тод, нээлттэй, шударга, шуурхай байдлыг хангах	1) Дундговь аймгийн төвийн бүсийн дэд төв болгон хөгжүүлэх 2) Мэдээллийн технологийг байнгын хэрэгцээ болгох 3) Ашигт малтмалын судалгаанд нөөц болон ашиглалтыг нэмэгдүүлэх 4) Байгалийн баялгийн нөөцөөд түшиглэн экологид халгүй, экспортын чиглэлтэй үйлдвэрлэл хөгжүүлэх 5) Аялал жуулчлалыг дэд бүтцийг бие даасан салбар болгон хөгжүүлэх 6) Эрчим хүчний хэрэглээний үр ашгийг дээшлүүлэх 7) Бүсүүдийн хооронд үйлдвэрлэл, үйлчилгээний хөршилт, торьлолтой, эвчлэлтэй бай болгох	1) Уул уурхайн боловсруулах үйлдвэрийн хөгжил 2) Барилгын материал үйлдвэрлэл 3) Эрүүл МАА, сүүн бүтээгдэхүүн, эрүүл хүнс үйлдвэрлэл 4) Дэд бүтцийн хөгжил 5) Эрүүл ахуй 6) Орон суудуулласт 7) Хот хаягдал, биомассын эрчим хүч 8) Хүний хөгжил, байгаль орчны хамгаалал, тогтвортой хөгжил 9) Мэдээллийн технологийн боловсрол, аж үйлдвэр 10) Төвэрлэх байгууламж, рсайсл, эко	1) Эдийн засаг хөгжил 2) Нийгмийн бодлого 3) Байгаль орчны хамгаалал, ашиглалт 4) Засаглал 5) Хөтөлбөрийн хэрэгжилт, хяналт, үнэлгээ	1) Эдийн засаг хөгжил 2) Нийгмийн бодлого 3) Байгаль орчны хамгаалал, ашиглалт 4) Засаглал 5) Хөтөлбөрийн хэрэгжилт, хяналт, үнэлгээ	1) Хүний хөгжил 2) Аж үйлдвэржил 3) Дэд бүтцийн хөгжил 4) Тулгуур хотын хөгжил 5) Галзад харилцаа 6) Аялал жуулчлал	
Аймгийн дунд хугацааны хөгжлийн хөтөлбөр	Говьсүмбэр аймгийн 21 зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөр (2003-2020) 2003 онд батлагдсан	Дархан-Уул аймгийн ХАА салбарыг 2021 хүртэл хөгжүүлэх нэгдсэн бодлого 2009 онд батлагдсан	Дорноговь аймгийн бүсчилсэн хөгжлийн хөтөлбөр 2002 онд батлагдсан	Дундговь аймгийн хүн амын өсөлтийг дэмжих бодлого (2009-2015) 2009 онд батлагдсан					
Аймгийн дунд хугацааны хөгжлийн чиг хандлага	1) Нүүрсний уурхайн технологи сайжруулах, хөийн үйлдвэр байгуулах 2) М А А гаралтай бүтээгдэхүүний ЖДҮ-ийн дэмжлэг 3) Бэлчээрийн доройтол, нөлөөллийн эсрэг ногоон бүс байгуулах, нөхөн сэргээлт, хот дахин боловсруулах үйлдвэр	Хосолсон буюу эрчимжсэн М А А ферм хөгжүүлэх, үр тариа, хүнсний ногоо, гэжээхийн үйлдвэрийн дотоодын хэрэгцээ хангалтын түвшинг өсгөх, Х А А н цаг уурын судалгаа, шинжилгээг үйлдвэрлэлтэй хослуулах, эрдсийн бууруулах технологи нэвтрүүлэх.		1) Байгалийн гамшигаас хамгаалах, бэлчээрийн доройтлоос сэргийлэх 2) Хүний хөшллийг дэмжих 3) уул уурхай, ХАА боловсруулах, 4) аж үйлдвэр, үйлчилгээний үндсэн дэд бүтцийг бэхжүүлэх 5) боловсрол					
Аймгийн төв	Чойр хот	Дархан хот	Сайншанд хот	Мандалговь хот	Даланзадгад сум	Сүхбаатар хот	Зуунмод хот		Чой
Аймгийн төвийн хүн ам	11,600	76,428	22,011	13,894	21,600	22,693	15,397		
Аймгийн төвийн ДНБ		1.60%					1.90%		
Аймгийн төвийн голдох аж төлөвлөгөөний	2014 онд боловсруулагдсан (2013 оны улсын төсөв)	2005 онд боловсруулагдсан	АХБ тусламжаар 2014 онд боловсруулсан (явц 90%)	2014 оны улсын төсөв (явц 90%)	2013 оны улсын төсөв (явц 70%)	2013 онд боловсруулагдсан (2012 оны төсөв)	2013 оны төсөв (явц 90%)		2014 оны төсөв (явц 90%)
Аймгийн төвийн ирээдүйн хүн амын таамаглал	2020 оны хүн амын таамаг 30 мянган хүн				2030 оны хүн амын таамаг 60 мянган хүн				
Аймгийн төвийн ерөнхий төлөвлөгөөний хөгжлийн чиг					Даланзадгад хотын ерөнхий төлөвлөгөө 2030				
Бусад		2013 оны улсын төсвөөр боловсруулах хүсэлт тавьсан (гэрээг шилсэн)			Сумын ЕТ тодотгоо хийгдсэн				Сумын төвийн ЕТ

Монгол Улсын Бүсчилсэн Хөгжлийн Нэгдсэн Судалгаа
Эцсийн тайлан (дэлгэрэнгүй)

	Зүүн бүс		
	Дорнод	Сүхбаатар	Хэнтий
Хүн ам (мян.хүн)*1	74.9	57.4	71.1
Хүн амын нягтшил (хүн/км2) *2	0.6	0.7	0.9
Сумын тоо*2	14	13	18
ДНБ(100 сая MNT) *2	6195,311	3827,839	3472,943
Аж үйлдвэр (ДНБ)*3			
1) ХАА	21.7%	46.4%	61.3%
2) Аж үйлдвэр, барилга	58.5%	36.8%	13.6%
3) Хуудалдаа, зочид буудал, нийтийн хоол	4%	1.8%	5%
4) Тээвэр, мэдээлэл, холбоо	1.1%	0.6%	1.1%
5) Банк, санхүү, бизнес	4.7%	4.3%	5.4%
6) Бусад	9.9%	10%	13.6%
Аймгийн урт хугацааны хөгжлийн бодлогын бичиг баримт, батлагдсан он	Дорнод аймгийн хөгжлийн ноцт бодлого (2009-2016) 2009 онд батлагдсан	Сүхбаатар аймгийн хөгжлийн хөтөлбөр (2007-2015) 2007 онд батлагдсан	Хэнтий аймгийн хөгжлийн ноцт бодлого (2010-2021) 2009 онд батлагдсан
Аймгийн урт хугацааны хөгжлийн чиг хандлага	1) Хүний хөгжил 2) Аж үйлдвэржилт 3) Дэд бүтцийн хөгжил 4) Тулгуур хотын хөгжил 5) Гадаад харилцааг өргөжүүлэх 6) Аялал жуулчлалыг хөгжүүлэх	1) Эдийн засгийн хөгжил 2) Нийгмийн хөгжил 3) Байгалийн ноц, байгаль орчин хамгаалал 4) Хүн амын нутагшил, суурьшил, хот байгуулалт 5) Хөтөлбөрийн хэрэгжилт	1) Аймгт мянганы хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлж, хүнийг бүх талаар хөгжүүлнэ. 2) Өрсөлдөх чадвартай, экспортын баримжаатай үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлнэ. 3) Зам тээвэр, эрчим хүч, мэдээлэл холбооны дэд бүтцийг хөгжүүлнэ. 4) Аймгийн төв, сумдын төвүүдийг хөгжүүлж хот, хөдөөгийн хөгжлийн түвшний ялгааг багасгана. 5) Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон чадавхийг бий болгон дэлхийн гэрээг сааруулж, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгална.
Аймгийн дунд хугацааны хөгжлийн хөтөлбөр			
Аймгийн дунд хугацааны хөгжлийн чиг хандлага			
Аймгийн төв	Чойбалсан хот (Хэрлэн сум)	Баруун урт хот	Чингис хот (
Аймгийн төвийн хүн ам	41,700	17,463	19,230
Аймгийн төвийн ДНБ			
Аймгийн төвийн голлох аж үйлдвэр			
Аймгийн төвийн ерөнхий төлөвлөгөөний боловсруулалтын байдал	2014 оны төсөв (явц 40%)	2014 оны төсөв (явц 40%)	2014 оны төсөв (гэрээ цуцлагдсан)
Аймгийн төвийн ирээдүйн хүн амын таамаглал			
Аймгийн төвийн ерөнхий төлөвлөгөөний хөгжлийн чиг хандлага			
Бусад	Сумын төвийн ЕТ 2013 боловсруулагдсан		ЕТ боловсруулагдаж буй

5 дугаар бүлэг: Хавсралт материал

Хавсралт материал 5.2.1 Мал аж ахуйтай холбоотой мэдээлэл

- **Мах бэлтгэл:** Монгол улсын мах бэлтгэл, өөрөөр хэлбэл хүнсний зориулалтын мах боловсруулах үйлдвэр нь угтаа социализмын үед нэгдсэн системтэйгээр үйл ажиллагаа явуулдаг байсан улсын үйлдвэрүүдийн нэг юм. Тухайн үеийн мах бэлтгэл нь малчдын малыг нэгдлийн удирдлагаар өвлийн өмнө нэгдсэн мах бэлтгэлд оруулдаг байсан бөгөөд үүгээрээ дотоодын хэрэгцээгээ хангаад зогсохгүй, гадагшаа экспортлодог байсан. Монгол улсын аж үйлдвэрийн томоохон салбарын нэг байсан (Жайка, 2005
- ¹). Өнөөгийн байдлаар нэгдэл шиг томоохон хэмжээний мах бэлтгэлийн байгууллага байхгүй хэдий ч, Монгол улсын хэмжээнд нийтдээ 45 мах бэлтгэлийн үйлдвэр, энгийн боловсруулалт хийдэг жижиг хэмжээний мах махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхэлдэг цехүүдийг нийлүүлж тооцвол нийтдээ 145 мах боловсруулах байгууламж байна². Эдгээрээс хамгийн том үйлдвэр нь Мах Импекс юм. Уг үйлдвэр нь нэгдлийн үед улсын үйлдвэр байсан ба хувийн хэвшилд шилжиж дахин үйл ажиллагаа явуулж эхэлсэн³. Зах зээлийн дараа шинээр байгуулагдсан үйлдвэр ч бий. Энэ удаагийн судалгаагаар Мах импекс, шинээр байгуулагдсан Мах маркет мөн хэд хэдэн жижиг мах боловсруулах цехэд хийсэн судалгаанаас дүгнэж үзэхэд, үйлдвэрүүдийн цаашдын нийтлэг зорилт нь бүтээгдэхүүн экспортлох байлаа. Энэ талаар судалгаанд хамрагдсан ХХААЯ, Монголын махны холбоод ч нэг байр суурьтай байгаа юм⁴. Үүний жишээ нь сүүлийн үед ОХУ болон БНХАУ цаашлаад Казакстан, Арабын орнууд руу хийх экспортын хэлэлцээр тохиролцоонд хүрсэн явдал юм⁵. Гэсэн хэдий ч бодит байдал дээр цаашид экспорт явуулхад хуулийн эрх зүйн орчиноо сайжруулах, малын эрүүл мэндийн асуудал гэх мэт шийдэх шаардлага бүхий хэд хэдэн нөхцөл байгааг онцлон тэмдэглэх нь зүйтэй. Ялангуяа өнөөгийн Монгол улсаас малын гаралтай бүтээгдхүүн экспортлох тохиолдолд, импортлогч талын улсын нэн тэргүүнд болгоомжлох зүйл нь шүлхий өвчны асуудал юм. Энэхүү асуудлын талаар цаашид дэлгэрэнгүй авч үзнэ. Товчхондоо зөвхөн шүлхий өвчин гэлтгүй, малын эрүүл мэндэд нөлөө бүхий халдварт өвчин тархдаг Монгол улсын хувьд, цаашдаа өөрсдийн малын гаралтай бүтээгдэхүүнийг гадагш экспортлоход хориг хязгаарлалт тавигдах гол асуудал нь

¹ Жайка. 2005. Монгол улсын хүнсний мах боловсруулалт, бүтээгдхүүний дамжлага технологийн суурь судалгаа. Жайка.

² МОНЦАМЭ. 2015. 526: 3.

³ Шинээр байгуулагдсан мах маркет компанийн захирал болох 30 орчим насны залуухан эмэгтэй, урьд нь Мах импекс компанийн ажилтан байсан нь сонирхолтой

⁴ Экспортыг нэмэгдүүлэх талаар, төрөөс мал аж ахуйд явуулах арга хэмжээний томоохон хөтөлбөр. болох “Монгол мал хөтөлбөр”-д ч онцлон тусгагдсан.

⁵ МОНЦАМЭ. 2015. 526: 3, 532: 3.

малын халдварт өвчин юм. Нөгөөтэйгүүр Монгол улсын малын тоо толгойн өсөлт нь анхаарууштай асуудлын нэг болоод байгаа бөгөөд цаашдаа дотоодын хэрэгцээгээ хангах цаашлаад экспортоо нэмэгдүүлэх нь малын тэнцвэрт байдлыг хадгалах, бэлчээр талхлалтын асуудал талаасаа ч тун чухал арга хэмжээ юм. Мэдээж малын эрүүл мэндтэй холбоотой томоохон асуудтай тулгараад байгаа ч, экспортоо нэмэгдүүлэх нь Монголын мал аж ахуйг хөгжүүлэх нэн чухал гарц хэмээн ойлгож байна. Тиймээс энэхүү судалгааны хөдөө аж ахуйн хэсэгт энэ тухай дахин тэмдэглэнэ.

- **Томоохон фермийн талаарх судалгаа:** Сүү сүүн бүтээгдэхүүн нь Монгол малчдын уламжлалт хүнсний нэг юм. Мөн зөвхөн үнээний сүү төдийгүй, айргаар алдартай гүүний саам цаашлаад хонь, ямаа, тэмээ гэх мэт таван хошуу малын сүүг ашигладаг. Сүүгээр бяслаг тарагнаас эхлээд аарц, өрөм, ааруул гэх мэт олон төрлийн бүтээгдэхүүн боловсруулдаг. Фермийн салбарын голлогч бүтээгдэхүүн нь үхрийн сүү юм. Ферм ч мөн адил нэгдлийн үед голлох салбарын нэг байсан. 1980 онд дундажаар саалийн үнээний тоо 400 гаруйтай улсын ферм нийт улсын хэмжээнд 39 газар үйл ажиллагаа явуулж байсан (Түвшинбат, Нимүна.2008⁶). Гэвч тухайн үед ч сүүгээрээ дотоодын хэрэгцээгээ бүрэн хангаж чаддаггүй байсан ба одоо ч байдал өөрчлөгдөөгүй болно. Монголын сүүний үйдвэрлэлд улирлын нөлөө их байдаг. Намраас хаврын эхэн хүртэл мал идэш багатай байдаг тул ихэнх малчид саалиа зогсоодог. Улмаар сүү үйлдвэрлэгчийн сүү нийлүүлэлтийн үнэ огцом өөрчлөгдөж байдаг. Энэ удаагийн судалгаанд хамрагдсан Монголын сүү сүүн бүтээгдэхүүний судалгаа шинжлэх ухааны холбооны мэдээллээр, өнөөгийн сүүний үнэ, сүүний нийлүүлэлт ихэсдэг зуны улиралд хамгийн багадаа 400 төгрөг (2 ам.доллар) хүртэл унаж, нийлүүлэлт багасдаг өвлийн улирал 1.000 төгрөг (0.5 ам.доллар) хүртэл өсдөг байна. Улмаар өвлийн улирлын сүүний нийлүүлэлтийн дутагдлыг нөхөхийн тулд хуурай сүү импортлодог ба устай хольж дахин боловсруулж орлуулдаг ба тухайн үйлдвэрлэлийг сүүний компани явуулдаг. Тиймээс улсаас сүү хангамжийг нэмэгдүүлэх тал дээр анхаарч ажиллаж байгаа ба Монгол мал хөтөлбөрийн⁷ хүрээнд 2014 онд Франц Герман улсаас холстэйн, монтбэрт сүүний чиглэлийн үүлдрийн үхэр 700 толгойг импортлосон. Мөн сүүлийн жилүүдэд сүүний фермүүд нэмэгдэж байгаа ба жижиг фермүүдыг нийлүүлж тооцвол нийтдээ 500 гаруй ферм үйл ажиллагаа явуулж, 80 хувь нь төвийн бүсэд төвлөрсөн байдалтай байна (2011⁸). Энэ удаагийн судалгаанд хамрагдсан Улаанбаатар хотын

⁶ Түвшинбат, Нимүна, 2008. Зэх зээлийн эдийн засгийн өөрчлөлт ба Монголын хөдөө аж ахуйн өөрчлөлт. *хөдөө орон нутгийн судалгаа* 106: 96-107.

⁷ Тус тайлангийн 2-р бүлэг 5.1

⁸ Promar Consulting. 2011. Монгол улсын хөдөө аж ахуйн салбар, хөдөө аж ахуйн талаар төрөөс баримталж буй арга хэмжээний судалгаа, дүн шинжилгээ. 2010 оны чөлөөт худалдааны хэлэлцээр, судалгааны ажил

ойролцоох жижиг сүүний фермүүд ч дээрх 80 хувьд багтана гэж таамаглагдах бөгөөд эдгээр фермүүдийн нэг онцлог нь Монфреш гэх компаний гишүүд юм. Гишүүд 4 сараас 10 сар хүртэл сүүгээ нийлүүлдэг боловч өвлийн улиралд ихэнх нь саалиа зогсоодог. Нийтдээ сүүгээ нийлүүлдэг 400 гишүүдийн дотроос өвөл сүү нийлүүлдэг нь 30 хүрдэггүй. Мөн эдгээр гишүүд малчид сүү нийлүүлэх улиралдаа тааруулж, жилд хийх нүүдлээ 3 болон 11 сард 2 удаа хийдэг нь онцлууштай хэрэг юм. Учир нь ийм хэлбэрийн мал аж ахуй нь бэлчээрээ зүй зохистойгоор ашиглах нөгөөтэйгүүр эрчимжсэн мал аж ахуйн эргэлтэнд оролцож байгаагаараа цаашдын Монголын мал аж ахуйн хөгжлийн хувьд маш чухал үндэс гэж бодож байна.

Мөн томоохон фермүүд ч үйл ажиллагаа эрхэлдэг ба энэ удаагийн судалгаагаар томоохон фермүүдийн төлөөллийг судалгаандаа хамруулсан. Байршил нь мөн л Улаанбаатар хотын ойролцоо байх ба Уул уурхайн бизнес эрхэлдэг Нүүдэлчин группийн ферм юм. Нүүдэлчин ферм нь өмнө дурьдсан 700 шилмэл үүлдэрийн үхрээс хүлээн авсан газруудын нэг юм. Өнгөрсөн жил Франц улсаас 155 толгой монтбэрт үүлдэрийн үхрийг агаарын тээврээр импортолсон. Маллагааны хувьд бэлчээрт гаргадаг боловч нүүдэлдэггүй орчин үеийн эрчимжсэн хэлбэрийн ферм юм. (зураг 5.2.1.1-2) Нэг өдрийн саалийн хэмжээ нь ± 2.5 тонн, өвлийн улиралд ± 8 тонн. Улирлын хамааралтай сүүний гарцын ялгаа нь өмнө нь дурьдсан улирлаас хамаарах сүүний үнийн өөрчлөлтөнд тааруулж, өвөл сүүний үнэ өссөн үед сүүний гарц их байхаар төл авах хугацаагаа тохируулсан байна. Энэхүү зохицуулалтыг хийхийн тулд, хангалттай хэмжээний хадлан, үр тарианы тэжээл (заримыг нь худалдаж авдаг)-ийг жилээр нь бэлтгэх хэрэгтэй болдог.

Зураг 5.2.1.-1~2 : Нүүдэлчин фермийн байр, саалийн байгууламж



1 : Тэжээлийн шугам бүхий байр



5

2 : Нэгжийн хяналт бүхий цахилгаан саалтуур

Зураг : Судалгааны баг

Бүс нутагт зохицсон таван хошуу малаас бусад тусгай ангилалын мал амьтдын тухай судалгаа:

Судалгаа эхлэхээс өмнө Малчид таван хошуу малаас гадна өөр мал тэжээж мал аж ахуй эрхлэлтээ төрөлжүүлэх боломжтой эсэх талаар судалж байлаа. Гэвч бодит байдал дээр өмнө дурьдсан нүүдэлчин малчдын хувьд гахай, шувууны аж ахуй, туулай гэх мэт бага амьтад тэжээх нь тэжээлийн хангамж, бага хэмжээний байр сав гэх мэт асуудлыг бодолцож үзвэл бодит байдалтай дүйцэхгүй нь судалгааны явцад тодорхой болсон. Гэсэн хэдий ч Монголд суурин хэлбэрийн гахай, тахиа, цаа буга, илжиг, балт зөгий, туулай гэх мэт амьтдын аж ахуй байдаг. 2013 оны мэдээллийг хүснэгт 5.2.1.-1-ээс харвал гахай, тахиа нэмэгдсэн нь илт байна. Монгол улсын хувьд малаас бусад тэжээвэр амьтад тэжээх нь нүүдэлчдэд тохирох төрөл зүйл биш хэдий ч, Улаанбаатар, бусад хот суурийн газруудад эрэлт хэрэгцээ нь нэмэгдэж байгаа, мөн одоогоор дийлэнх хэсгийг нь импортоор авч байгаа учир цаашдын мал аж ахуйн хөгжлийн үүднээс авч үзвэл, анхаарал хандуулах нь зүйтэй сонголт гэж хэлж болхоор байна. Энэ ч утгаараа судалгаанд хамрагдсан НВЦ болон Түмэн шувуут гэх тахианы фермүүд нь сүүлийн үеийн дэвшилтэт арга барилаар үйл ажиллагаа явуулж байна. Аль аль нь Улаанбаатар хотоос 1 цагийн зайтай газар байрладаг ба НВЦ нь 300 мянган өндөглөгч тахиа, Түмэн шувуут нь 1500 өндөглөгч тахиатай. Мөн цаашдын хэрэгцээ эрэлт нэмэгдэж байгаа учир аль аль нь тахианыхаа тоог нэмэгдүүлэх төлөвлөгөөтэй байна. Мөн хоёр компанийн тулгараад байгаа нийтлэг асуудал нь одоогоор ихэнх хувийг импортоор авч байгаа тэжээл, түүний зардлыг хэрхэн буулгах тухай юм. Өөрөөр хэлбэл тэжээлийн дотоодын үйлдвэрлэл тогтворжоогүй байгаа нь малчдын хувьд ч чухлаар тавигдаж байгаа нь Монголын мал аж ахуйн нийтлэг асуудал болохыг харуулж байна (Комияма 2007⁹). Тэжээлийн хэрэгцээг дотооддоо үйлдвэрлэж бага зардлаар тэжээл нийлүүлдэг дотоодын сүлжээ бий болгох нь олон үйлдвэрлэгчийн хүсэл гэж хэлж болохоор байна. Судалгааны сүүлийн хэсэгт дээр дурьдсан малаас бусад тэжээвэр амьтад тэжээснээр малчдын мал аж ахуйн төрлийг нэмэгдүүлэх тал дээр, тусгай ангиллын амьтад тэжээхээс өөр хэлбэрээр буюу хүнсний ногоо тариалах Дэлхийн банк болон FAO-ын төсөл нь явагдаж эерэг үр дүнтэй¹⁰.

⁹ Комияма 2007. Монгол улсын эрчимжсэн малын үзүүлэлт. Монгол улсын ургамлын өөрчлөлтийн талаарх семинар, Цүкүба их сургууль

¹⁰ World Bank. Mongolia integrated livestock-based livelihoods support project.

Хүснэгт 5.2.1.-1 : Тусгай ангиллын мал амьтны аж ахуйн үзүүлэлт

Төрөл зүйл	2010 он	2011 он	2012 он	2013 он
• Гахай	24,842	30,397	40,421	51,864
• Цаа буга	1,344	1,396	1,421	1,574
• Илжиг	99	198	75	51
• Туулай	736	1,110	1,533	1,262
• Тахиа (×1,000)	425	596	469	489
• Балт зөгий (үүрээр)	1,628	896	2,128	3,677

Эх сурвалж : Mongolian Statistical Yearbook 2013.

Хавсралт материал 5.5.1 :Элсэнашуудай технологийг Монголд хэрэгжүүлсэн жишээ, Шороотой шуудай ашигласан малын байрны тухай

Монголын малчид банз эсвэл томоохон чулуу зэргийг ашиглаж малын саравчаа, байраа барьдаг хийдэг. Энэхүү арга нь хөдөлмөр ихээр шаарддагаас гадна, төдийлөн хүйтнээс хамгаалж чаддаггүй учир зудаар малаа олон тоогоор алддаг. Энэ асуудлыг шийдэх зорилготой эхэлсэн туршилтын төсөл нь Хирошима их сургуулийн мастерийн олон улс судлалын факультет (Харуюки Ямамото Профессор) 2011 оноос төв аймгийн Баян-өнжүүл суманд туршилт явуулах санал хүлээн авч, Монголын төрийн бус байгууллага (Clean Energy nongovernmental Organization (CEO)-ын хамтын ажиллагаа, UNDP-ын бичил сангийн (Global Environment Facility (GEF) Small Grants Programme)-с санхүүжиж зуднаас сэргийлсэн шуудайн ашигласан аргаар малын байр 5-ыг барьсан байна.

Шороо бэлтгэл, байриа барихдаа нутгийн иргэдийг түлхүү оролцуулж, шороо бэлтгэлээ ойр орчмын газраас хүрзээр тодорхой хэмжээ (2 см-с бага хэмжээ)-тэйгээр савлана. Гурилын шуудайг (ус нэвтрүүлнэ) угааж ашиглана. Шороотой шуудайгаа хана болгон өрж гадна талаар нь төмөрлөнө. Хамгийн сүүлд нь зуурмагаар (нарны хэт ягаан туяанаас сэргийлж 5 см гаруй зузаан шавардана) шаварддаг, тун хялбар арга юм.

(Зураг)



Зургийг:Харуюки Ямамото Профессор

Шороотой шуудай ашиглаж барьсан байр нь, шороотой шуудайгаа дээш эгц хана болгож өрхөд хүндрэлтэй байдаг. Гэсэн хэдий ч судалгаанаас үзхэд -30 градусын хүйтэн орчинд ямар нэгэн асуудал гараагүй байна. Байрыг малчдад ашиглаж байгаа ба 10 жил ашиглах боломжтой гэж үзэж байна. Малчид ч нь сэтгэл хангалуун байна.

6 дугаар бүлэг Хавсралт материал

Хавсралт материал 6.3.1 : Хөдөө аж ахуйн газар ашиглалтын газрын систем

(1) Бэлчээрийн төлөв байдал, чанарын хянан төлөвлөлт

Газрын тухай хуулийн 58 дугаар зүйлд, газрын төлөв байдал болон чанарын хяналтын талаар тусгагдсан байдаг ба тухайн хуулийн 58.9-д Тариалангийн газарт газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаатай холбоотой үнэлгээний тухай “Тариалангийн тухай хуулиар” зохицуулахаар тусгасан байна. Тариалангийн тухай хуулийн 5 дугаар зүйлд тариалангийн газрын төлөв байдал, хөрсний чанар хяналт үнэлгээг 5 жилд нэг удаа хэрэгжүүлнэ гэж заасан. Агрохими, агрофизикийн шинжилгээний дүнгээр хөрсний төлөв байдал, чанарыг тодорхойлно. Үнэлгээний зардлын тухайд Газрын тухай хуулийн 58.7-д Газар эзэмшигч, ашиглагч нь газрынхаа төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг өөрийн хөрөнгөөр, анх удаа иргэн аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшил, ашиглалтад олгож байгаа болон бусад газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг улсын буюу орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ гэж заасан. Гэсэн хэдий ч бодит байдал дээр төсвийн хязгаарлалттай учир хэрэгждэггүй.

Хувь хүн болон албан байгууллага нь өөрийн хөрөнгөөр, хувийн байгууллагад хөрсний чанартай холбоотой агрохими, агрофизикийн судалгаа хийлгэх хүсэлт гаргаж хэрэгжүүлэх боломжтой. Мөн бэлчээрийн хяналттай холбоотой журам 2015 оны 5 сард батлагдаж, хяналтын арга зүйг боловсронгуй болгож, тусгай программ ашиглаж зурагнаас хөрсний төлөв байдал, ургамлын бүтэц, хөрсний элэгдлийн төвшинг хэмжих боломжтой болсон.

Тариалангийн зориулалт бүхий газруудыг 2 жилийн хугацаанд ашиглаагүй тохиолдолд улсад буцаах заалттай байдаг ч тухай бүрт хэрэгждэггүй. Том хэмжээний тариалангийн зориулалтын газар олонтой ч тариалалт явуулдаггүй байгууллага олон байдаг.

(2) Тариалангийн газрын эрх, бүртгэл

Тариалангийн газар ашиглалттай холбоотой ашиглах эрхийг, хүсэлт хүлээн авсан сумын тамгын газар нь газар ашиглалтын төлөвлөгөөтэй уялдуулан хэлэлцэнэ. Хурлаар хүлээн зөвшөөрөгдвөл газар хариуцсан мэргэжилтэн газар ашиглалтын төлөвлөгөөнд нэгтгэж, сумын засаг дарга тушаал гаргана.

Хүсэлт гаргаснаас хойш газар ашиглах хүртэл 1 сар орчим зарцуулагдана. Газар ашигласны төлбөр төлөх боловч өөр татвар байхгүй. Газрын албан татвар байдаг ч зөвхөн газар эзэмшигчид ноогддог. УИХ-ын 1997 оны 52-р тогтоолоор газрын үнэлгээ, ашиглалтын төлбөртэй холбоотой журам батлагдсан.

(3) Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын систем

Бэлчээр, газрын асуудал эрхэлсэн улсын хэмжээний байгууллага нь барилга хот байгуулалтын яам, Газрын Харилцаа, Геодези Зураг Зүйн Газар, Аймгийн газрын асуудал эрхэлсэн байгууллага нь аймгийн ГХГЗЗГ болон хот байгуулалтын хэлтэс, сумдад газрын асуудал хариуцсан мэргэжилтэн ажилладаг. Газар ашиглалтын зөвшөөрөл, хүчингүй болгохтой холбоотой асуудлаар дэд бүтэц хөгжсөн газар өөрөөр хэлбэл суурин газрын газартай хамааралтай асуудлаар хотын засаг дарга, аймгийн засаг дарга нар тухайн жилийн газар төлөвлөлт, хотын ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн төлөвлөгөөтэй уялдуулан шийдвэрлэнэ. Түүнээс бусад газартай холбоотой асуудлыг дүүргийн засаг дарга, сумын засаг дарга нар тухайн жилийн газар ашиглалтын төлөвлөгөөтэй уялдуулан шийдвэрлэх эрхтэй байдаг. Аймгийн газар төлөвлөлтийн дагаж шийдэгддэг сумын газар төлөвлөлт нь сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлаар, аймгийнх бол аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлаар тус тус шийдэгддэг.

(4) Эзэмшүүлэх газрын хэмжээтэй холбоотой заалт

Газрын тухай хуулийн 29.3-т Багийн иргэдийн нийтийн хурлын санал, сумын ИТХ-ын шийдвэрийг үндэслэн, тариалангийн газрыг газар тариалангийн салбарт олон жил тогтвортой ажилласан иргэнд гэр бүлийнх нь хамтын хэрэгцээнд зориулан Засгийн газраас тогтоосон журмын дагуу давуу эрхээр эзэмшүүлж болно. Нэг иргэнд давуу эрхээр эзэмшүүлэх тариалангийн газрын хэмжээ нь үр тарианы зориулалтаар 100 га хүртэл, төмс, хүнсний ногооны зориулалтаар 5 га хүртэл байна. Аж ахуйн нэгжид үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхэд зориулан эзэмшүүлэх газрын дээд хэмжээг Засгийн газар тогтооно (Газрын тухай хууль 29.6) 2003 оны 28-р тогтоолоор батлагдсан.

(5) Бэлчээр, түүнийг зохистой ашиглах, хамгаалах

Газрын тухай хуулийн 52-т Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тухайн нутгийн онцлог, бэлчээрийг ашиглаж ирсэн уламжлал, зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх шаардлагыг харгалзан өвөлжөө, хаваржаа, зуслан, намаржаа, отрын нөөц нутаг гэсэн ерөнхий хуваарийн дагуу газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусган батална. Зуслан, намаржаа болон отрын бэлчээрийг баг, хот айлаар хуваарилж нийтээр ашиглана. Тухайн жилийн бэлчээрийн гарц, иргэдийн саналыг харгалзан өвөлжөө, хаваржааны бэлчээрийг малаас чөлөөлөх, мал оруулах хугацааг сум, дүүргийн Засаг дарга тогтоож, баг, хорооны Засаг дарга, иргэд мөрдөж хэрэгжүүлнэ. Өвөлжөө, хаваржааны тодорхой нутаг бэлчээрийг талхлагдахаас хамгаалах, нөхөн сэргээх зорилгоор тухайн бүс нутгийн онцлог, бэлчээр ашиглаж ирсэн уламжлал, газрын даац, чадавхийг харгалзан, багийн иргэдийн нийтийн хурлын саналыг

үндэслэн сумын Засаг дарга малчдад болзол, гэрээний дагуу хэсэг бүлгээр ашиглуулж болно гэж заасан.

(6) Тухайн бүс нутгийн байгаль орчин, нийгэм, эдийн засгийн нөхцөл байдлыг харгалзан азрын зохицуулалтын онцлог

Тус хуулийн 52.4-т Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ нь байгаль орчин, нийгэм, эдийн засгийн нөхцөл байдлыг харгалзан нутаг дэвсгэртээ бэлчээрийн болон суурин мал маллагааны бүс нутгийг тогтоож болно гэж заасан. Мөн 52.5-т Эрчимжсэн суурин мал аж ахуй эрхлэх болон тэжээвэр амьтныг өсгөн үржүүлэх зорилгоор хашсан бэлчээрийг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад улирал харгалзахгүй тодорхой болзол, гэрээний дагуу ашиглуулж болно гэж заасан.

(7) Бэлчээр тойрсон маргааныг шийдвэрлэх

Бэлчээр ашиглах асуудлаар гарсан аливаа маргааныг багийн иргэдийн нийтийн хурлаар хэлэлцэж зохицуулна. Эс тохиролцсон тохиолдолд сумын Засаг дарга шийдвэрлэнэ (Газрын тухай хууль 52.10), Байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюулын улмаас өөр аймаг, сумын нутаг дэвсгэрт нүүдэллэх шаардлага гарвал тухайн шатны Засаг дарга нар уг асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ. Хэрэв тохиролцохгүйд хүрвэл уг асуудлыг дээд шатны Засаг дарга буюу Засгийн газар шийдвэрлэнэ (Газрын тухай хууль 52.8). Ган, зуд болон бусад байгалийн гамшиг тохиолдсон үед ашиглах сум дундын отрын нөөц нутаг, түүний заагийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймаг дундын отрын нөөц нутаг, түүний заагийг орон нутгийн удирдлагын хүсэлтийг харгалзан Засгийн газар тогтооно (Газрын тухай хууль 52.9).

Бэлчээр ашиглах асуудлаар гарсан аливаа маргаан сүүлийн жилүүдэд багасч байгаа ба өөр хоорондоо ярилцаж тохиролцох замаар шийдэгддэг.